



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



# ХУУЛЬ ЁС ДЭЭДЛЭХ ЁС

ХУУЛЬ ЗҮЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА, ОНОЛ,  
ПРАКТИКИЙН СЭТГҮҮЛ



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

# хууль дээдлэх ёс

Хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаа, практикийн улирал тутмын сэтгүүл

2015 он, Цуврал 3 (53)

11 - 20

Улаанбаатар хот 2015

## СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

<b>Ж.Амарсанаа</b>	<i>Академич</i>
<b>Б.Амарсанаа</b>	<i>Хүүль зүйн доктор</i>
<b>Ж.Батзандан</b>	<i>Хүүль зүйн доктор</i>
<b>Ж.Баярицэг</b>	<i>Хүүль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга</i>
<b>Б.Боллбаатар</b>	<i>Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга</i>
<b>Ж.Бямбадорж</b>	<i>Хүүль зүйн доктор</i>
<b>Д.Ганбат</b>	<i>Улсын Их Хурлын Хүүль зүйн байнгын хорооны дарга</i>
<b>Б.Гүнбилэг</b>	<i>Хүүль зүйн доктор</i>
<b>Д.Дорлигжав</b>	<i>Хүүль зүйн сайд</i>
<b>Ц.Зориг</b>	<i>Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч</i>
<b>О.Мөнхсайхан</b>	<i>Хүүль зүйн доктор</i>
<b>С.Нарангэрэл</b>	<i>Академич</i>
<b>Ч.Өнөрбаяр</b>	<i>Хүүль зүйн доктор</i>
<b>Д.Солонго</b>	<i>Хүүль зүйн доктор</i>
<b>Х.Тэмүүжин</b>	<i>Улсын Их Хурлын гишүүн</i>
<b>Ж.Эрдэнэбулган</b>	<i>Хүүль зүйн доктор</i>
<b>П.Цагаан</b>	<i>Монгол Улсын Ерөнхий тогтолцоогоо Тамгын газрын дарга</i>
<b>Ш.Цогтоо</b>	<i>Хүүль зүйн доктор</i>
<b>Ч.Энхбаатар</b>	<i>Хүүль зүйн инженерийн ухааны доктор</i>

*Ерөнхий эрхтэгч*

**Э.Батбаяр**

*Хариуцлагатай нарийн бичгийн дарга*

**Б.Гончигсумлаа**

*Хэвлэлийн эхийн*

**Д.Мөнхжаргал**

Улсын бүртгэлийн дугаар: 279  
ISSN:2226-9185  
Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс  
эрхлэн гаргав. Жилд 5 дугаар гарна.

Хаяг: Улаанбаатар - 46,  
Чингэлтэй дүүрэг, Чингис хааны талбай-7  
Утас: +(976)-11-315735  
Факс: 315735  
Вэб хуудас: [www.legalinstitute.mn](http://www.legalinstitute.mn)  
Цахим хаяг: [lawjournal@legalinstitute.mn](mailto:lawjournal@legalinstitute.mn)

## EDITORIAL BOARD

<b>J.Amarsanaa</b>	<i>Academician</i> <i>(LL.D)</i>
<b>B.Amarsanaa</b>	
<b>J.Batzandan</b>	<i>(Ph.D)</i>
<b>J.Bayartsetseg</b>	<i>State Secretary, Ministry of Justice of Mongolia</i>
<b>B.Boldbaatar</b>	<i>Secretary General, the Secretariat of the State Great Hural of Mongolia</i>
<b>J.Byambadorj</b>	<i>(Ph.D)</i>
<b>D.Ganbat</b>	<i>Chairman, the Standing Committee of Law of the State Great Hural of Mongolia</i>
<b>B.Gunbileg</b>	<i>(Ph.D)</i>
<b>D.Dorligjav</b>	<i>Minister of Justice</i>
<b>Ts.Zorig</b>	<i>Chief Justice, Supreme Court of Mongolia</i>
<b>O.Munkhsaikhan</b>	<i>(LL.D)</i>
<b>S.Narangerel</b>	<i>Academician</i>
<b>Ch.Unurbayar</b>	<i>(Ph.D)</i>
<b>D.Solongo</b>	<i>(Ph.D)</i>
<b>Kh.Temuujin</b>	<i>Member of the State Great Hural of Mongolia</i>
<b>J.Erdenebulgan</b>	<i>(Ph.D)</i>
<b>P.Tsagaan</b>	<i>Head, the Office of the President of Mongolia</i>
<b>Sh.Tsogtoo</b>	<i>(Ph.D)</i>
<b>Ch.Enkhbaatar</b>	<i>(Sc.D)</i>

*Editor-in-Chief*

**E.Batbayar**

*Acting Assistant Editor*

**B.Gonchigsumlaa**

*Designed by*

**D.Munkhjargal**

State Registration Number:279  
ISSN: 2226-9185  
The National Legal Institute  
publishes this law review five times  
per year.

Address: Ulaanbaatar-46, Chingeltei District,  
Chinggis khaan Square -7  
Phone:+(976)-11-315735  
Fax: 315735  
Website: [www.legalinstitute.mn](http://www.legalinstitute.mn)  
E-mail: [lawjournal@legalinstitute.mn](mailto:lawjournal@legalinstitute.mn)

# АГУУЛГА

## ХУУЛЬ ТӨРӨХИЙН ӨМНӨ /ОНЦЛОХ ӨГҮҮЛЭЛ, ЯРИЛЦЛАГА/

Хорьж мөрдөх нь эрүү шүүлтийн бусад хэлбэрийн хүчин зүйл болох нь	9
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимиийн эрхлэгч, Хууль зүйн доктор, профессор Д.Баярсайхан	
<b>Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх</b> Удирдлагын академийн дэд профессор, Хууль зүйн доктор /Dr.jur/ Д.Сүнжид	16
<b>Ирээдүй хойчийн эрх ба үндсэн хууль</b> Онтгонтэнгэр Их Сургуулийн Бизнесийн эрх зүйн тэнхимиийн эрхлэгч, (LL.M) Р.Очирбал	24
<b>ЭРХ ЗҮЙ, СЭТГЭЛГЭЭ: ҮЗЭЛ БОДОЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ</b>	
Хөдөлмөрийн эрх зүйн харилцаан дахь хууль зүйн хариуцлага, тэдгээрийн онцлог	34
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Иргэний эрх зүйн тэнхимиийн ахлах багш, Хууль зүйн доктор С.Болормаа	
Хууль зүйн дээд боловсролын эрх зүйн зохицуулалт Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Бодлогын судлаач Э.Уянга	40
<b>ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ, АСУУДАЛ</b>	
Үндсэн хуулийн 7 нэмэлт, өөрчлөлт ба Үндсэн хуулийн нэмэлтэд хориглох, хязгаарлах хэм хэмжээ	50
Үндсэн хуулийн цээшийн гишүүн, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, Хууль зүйн доктор, профессор Ш.Цогтоо	
<b>Улс төрийн намд тавих шүүхийн хяналт</b> Өмгөөвлийн "Эм Жэй Эл атторнейс" ХХН-ийн партнер өмгөөвөгч П.Баттуплаа	58
Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам Өвөрхангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Сугар	65
<b>ЭРХ ЗҮЙН СУДАЛГАА, ТОЙМ, ҮР ДҮН</b> Монгол Улсын олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх асуудал Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн бодлогын судалгааны тооч тайлан	74

---

**БНХАУ дахь "Их засаг" судлалын төлөв**

94

Өвөрмонголын их сургуулийн Хууль зүйн сургуулийн Үндэстний хууль тогтоомж судлалын төвийн эрхлэгч, түүхийн ухааны доктор, хууль зүйн ухааны доктор, профессор Д.Наранцогт

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвийн  
Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан

**ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА****О Научных предпосылках введения новых и правовой оценке  
действующих уголовно-правовых запретов**

106

Маркунцов Сергей Александрович, к.ю.н., доцент, доцент кафедры  
уголовного права Национального исследовательского университета  
«Высшая школа экономики» (г. Москва)

**Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгчийг  
заавал оролцуулах нь**

114

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант Ч.Ичинхорлоо

---

# CONTENT

---

## BEFORE CREATING A LAW (UNDERLINE ARTICLE AND INTERVIEW)

<b>Detained Investigation is a Factor of other type of Severe Punishment</b> <i>Bayarsaikhan.D.( Ph.D). Professor, Head of the Public Law Department, School of Law, National University of Mongolia</i>	9
<b>Suspend the Implementation of Administrative Act</b> <i>Sunjid.D. D.jur. Associate Professor, Academy of Management</i>	16
<b>Future Generation's right and the Constitution</b> <i>Ochirbal.R. MA. Head of the Business Law Department, Ogontenger University</i>	24

## LEGAL THOUGHTS: REFLECTION

<b>Legal Liabilities and its Characters on Relations of Labor Law</b> <i>Bolormaa.S. (Ph.D), Senior Lecturer, Private Law Department, School of Law, National University of Mongolia</i>	34
<b>Legislation on His/her Education of Law</b> <i>Uyanga.E. Policy Researcher, National Legal Institute</i>	40

## IMPLEMENTATION OF LAW, EFFICIENCY AND ISSUES

<b>Seven Amendments to the Constitution, Prohibitible and Permittable Norms in the Constitution Amendments</b> <i>Tsogtoo.SH. (Ph.D). Professor, School of Law, National University of Mongolia, Member of Constitution court of Mongolia</i>	50
<b>Judicial Review to the Political Party</b> <i>Battulga.P. Partner-Advoacle, MGL Attorneys LLP</i>	58
<b>Regulation on Amendment to the Constitution</b> <i>Sugar.B. Judge, First-Instance Administrative Court, Uvurkhangai province</i>	65

## LEGAL RESEARCH OVERVIEW

<b>Issues on Court Applications of International Treaties of Mongolia</b> <i>Brief Result of the Policy Research, National Legal Institute</i>	74
---	----

---

**Perspective of the "Ikhzasag" Study in the People's  
Republic of China**

94

*Narantsogt.D, Ph.D in Law and History, Professor, Head of the Center for  
Legislation of Nationality, School of Law, University of Inner Mongolia*

*Enkh-Amgalan.B, Senior Policy Researcher, National Legal Institute*

**INTERNATIONAL EXPERIENCE**

**Premise of the Introduction of New Scientific and Legal  
Assessment of the Existing Criminal Law Prohibitions**

106

*Sergey Markuntsov, Candidate of Law Science, Leading Professor,  
Department of Criminal Law, Faculty of Law, the National Research University  
Higher School of Economics, Moscow, Russia*

**Compulsory Attendance of Advocate to the Criminal Procedures**

114

*Ichinkhorloo.CH, MA Candidate, School of Law, National University of Mongolia*

## ХОРЬЖ МӨРДӨХ НЬ ЭРҮҮ ШҮҮЛТИЙН БУСАД ХЭЛБЭРИЙН ХҮЧИН ЗҮЙЛ БОЛОХ НЬ

(Эрүүсийн процесс дахь хүний эрхийн асуудал)



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нууцийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, Хууль зүйн доктор, профессор Д.Баярсайхан

### Нэг. Эрх зүйн шалгуур ба хорьж мөрдөх ажиллагаа

Хүний эрхийн үнэт зүйлсийг эрүүгийн процессын арга, хэрэгслээр хамгаалах шаардлагатасын нэмэгдэл, гэмт хэргийг шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчин шинчлэгдэн өөрчлөгдсөөр ирэв.

Шүүхээр гэм буруу нь нотлогдоогүй үед эрүүгийн журмаар шалгагдаж буй хэснийг ч сэжиг таамгаар буюу урьдчилан яллах хандлагаар хорьж мөрдөх нь хүний халдашгүй эрхийн суурь зарчмыг ноцтой зөрчсөн хэлбэр болно. Үүнийгч НҮБ-ын түвшинд хүлээн зөвшөөрөх болсны дээр хөгжингүй оруунд ч энд анхаарч хандах болжээ. Ялангуяа цагдан хорих, мөрден мешгех замаар гэм бурууг нь тулган хүлээлгэх, зөвхөн байцаалтад тулгуурлан нотлох ажиллагааг хэрэгжүүлэх нь эрүү шүүлтийн орчныг бүрдүүлэх хүчин зүйл болохыг нийтлэг жишигийн түвшинд хүлээн зөвшөөрсөн байдал.<sup>1</sup>

Түүнчлэн НҮБ-аас дэмжиж 2007 онд гаргасан "Дэлхийн эрүүгийн процессын загвар хууль"-нд эрүүгийн хэргийн нотлох ажиллагаанд хүний эрхийн хүлээн зөвшөөрэгдсэн суурь зарчмуудыг хангах, хуулийн дагуу тодорхой баримтат эх сурвалжийгээр мөрдөн мэшгэх, цагдан хорихыг хориглох, баривчлах, албадан саатуулах эсэхийг шүүхийн урьдчилсан хяналт, хэлзлүүлгийн үндсэн дээр зөвшөөрч шийдвэрлэх ёстойг эрх зүйн хэм хэмжээ болгон тусгасан байна.

Хорьдугаар зууны эхэн үеэс авторитари дэглэмийн мөн чанарыг илэрхийлсэн эрүү шүүлтийн шинэ үеийн арга хэлбэр нэвтэрсэн ба байцаалтад тулгуурлаж цагдан хорих замаар хэргийг өөрөөр нь хүлээлгэх, хетлэн байцаах, ял тулгах, шүүхээр нотлогдоогүй байхад гэмт хэрэгтэн мэтээр хүнлэг бусаар доромжилж харьцах зэрэгзэр хүний эрхийн зарчимд харш процесс ажиллагааг олон жил явуулж ирсэн байдал.<sup>2</sup>

Дэлхий II дайнаас хойш хүнлэг ёсны хандлага сэргэж, үндэсний болон олон улсын хэмжээнд хамгаалагдаж ирсэн боловч авторитари дэглэмийн эрүү шүүлтийн хуучин уламжлал олон оронд хэвээр хадгалагдаж, шүүхийн өмнө шатны нотлох ажиллагаанд байцаалтыг гол арга болгосноор гэм бурууг бодитоогоор шалган үнзлэх зарчим алдагдаж, мөрдөн байцаалтын процесс яллах чиг үүрэгтэйгээр хэрэгжиж, шүүхээр нотлогдохоос өмнө урьдчилан яллах нөлөөлөл бүхий

<sup>1</sup> Олон улсын гарээ, хэлэлцээрийн эмчтэл Эрүүгийн эрх зүйн хуулийн байцаан шинтэж эрх зүйн (МУИС ХЭС ) УБ 2012

<sup>2</sup> М.А.Чельцов. Курс советского уголовного процесса М., 1957; Доказывание в уголовном процессе: Традиции и современность. Под ред. В.А.Власихина М., 2000

тогоол, шийтгэвэр, протоколуудыг<sup>3</sup> гарган, хэрэглэж иржээ. Эдгээр нь хэдийгээр шүүхээс өмнөх шатанд гэмт хэрэг мөн эсэхийг илрүүлэх, мөрдөн шалгах чиг үүрэг бүхий процесс боловч яллагдах гэм буруутай гэдгийг урьдчилан тогтооход чиглэгдэх учиргүй билээ.

Эрүү шүүлт бол хуульд зөвшөөрөгдсөнөөс гадуур, хүнлэг бусаар харьцах, хууль бус аргын нэг бөгөөд эрүүгийн процессад илрэхдээ хэргийг тулган хүлээлгэх замаар байцаалтыг хөтөлж явуулах, мэдүүлгийг айлан сүрдүүлэх замаар албадан гаргуулж авах, баримт, нотолгоогүйгээр ял тулгах, дарамт шахалт үзүүлэх зэрэг шүүд ба шууд бус хэлбэрээр илрэдэг.

Ялангуяа шууд баривчлах арга хэмжээг урталь болгон мөрдөн байцаалтыг явуулах, цагдан хорих явдлын нийтлэг журам болгон түгээмэл хэрэглэх, хорьж мөрдөх ажиллагааг хэт сунжуулсан, олон удаа хугацааг нь сунгах зэрэг нь эрүү шүүлтийн хүчин зүйлтэй шүүд бус холбогдсон байдал.

Хорьж мөрдөх ажиллагааны эрх зүйн дагуух болон эрх зүйн бус хоёр талт мөн чанарыг тусгадаг хэдий ч нийтлэг байдлаар түгээмэл хэрэгжсэнээр энэ нь серег үр дагаврыг аяндаа бий болгодог. Өөрөөр хэлбэл хорьж мөрдөх замаар нотлох ажиллагааг зонхилох практик болгон хэрэглэх нь эрх зүйн бус процесс болно.<sup>4</sup>

Схем 1: Онолын хувьд хорьж мөрдөх ажиллагааны агуулгыг эрх зүйт ёсны шаардлага талаас нь харьцуулж авч үзвэл:<sup>5</sup>

№	Хорьж мөрдөх байцаан шийтгэх ажиллагаа (эрх зүйн бус)	Мөрдөх, хорих хянан шийдвэрлэх ажиллагаа (эрх зүйн дагуух)
1	Цагдан хорих, албадан саатуулах арга хэмжээг нийтлэг журам болгон (100%) хэрэглэдэг;	Цагдан хорих арга хэмжээг онцгой тохиолдолд хязгаарлагдман хурзэнд хэрэглэнэ.
2	Байцаалтыг нотлох ажиллагааны үндсэн гол арга язж үзнэ;	Нотлох ажиллагаанд байцаалтын бус олон аргыг түгээмэл хэрэглэнэ.
3	Эрүү шүүлтээс ангид байх, шүүхээр нотлогдоогүй үед гэм буруугүйд тооцогдох эрх хязгаарлагдман;	Эрүү шүүлтээс ангид байх эрх баталгаатай хэрэгжинэ.
4	Баривчлах, албадан саатуулах, цагдан хорих арга хэмжээ шүүхийн хяналтаас гадуур хэрэгжинэ.	Цагдан хорих, баривчлах эсэхийг нотлох баримт, эх сурвалжид үндэслэн шүүхийн хэлэпцүүлгээр хэлэлцэж, хянаж шалгасны үндсэн дээр шийдвэрлэнэ.

Хорьж мөрдөх ажиллагааны эрх зүйн шалгуур нь Үндсэн хуулиас гадна НҮБ-аас гарсан конвенц, зарчмууд зэрэг олон улсын баримт бичгүүдэд тусгалаа олсон байдал. Голлох эх сурвалжийг тоймлон хэрэглэвэл:

- Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пакт (НҮБ, 1966);
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн зэрэг конвенц (НҮБ, 1984);
- Аливаа хэлбэрээр саатуулагдсан, хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмууд (НҮБ, 1988);
- Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд (НҮБ, 1955/1977);
- Хоригдлуудтай харьцах зарчмууд (НҮБ, 1990);
- Хууль сахиулах албан тушаалтны зан үйлийн хууль (НҮБ, 1979);

<sup>3</sup> Мөрдөн байцаагийн яллагдагчаар татсан тогоол, яллагдагчийн байцаа протокол, прокурорын яллас дүгнэлт гэх мэт.

<sup>4</sup> Zuckerman A., *Principles of Criminal evidence.*, OUP, 2009. p.78-79

<sup>5</sup> Concentrate evidence. John Spencer. Oxford University press. 2013. p.91-93

7. Дэлхийн эрүүгийн процессын загвар хууль (2008);

8. Эрүүдэн шүүлтийн талаарх НҮБ-ын тайлан, зөвлөмж (1996-2014) гэх мэт.

Эдгээрээс цагдан хорих арга хэмжээг түгээмэл буюу үндэслэлгүйгээр авч, хэрэгжүүлэх нь эрүү шүүлтийн бусад хэлбэрийн хүчин зүйл болохыг нь заасан зарим баримт бичгүүдийг дурдах нь чухал.<sup>6</sup>

"НҮБ-ын 1999 оны 1244 тоот удирдамж"-д: "... Хүнд биш хэрэг үйлдэсэн этгээдийг удаан хугацаа гар цагдан хорих нь хүнийг айлган сурдуулэх, сэтгэл санааг нь шаналган зовоо, хүнлэг бус харьцах хэлбэр болно." гэж дурдсан бол "Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пакт"-ын 9-р зүйлийн 3-т: "... Цагдан хорих арга хэмжээг нийтлэг журам болгон хэрэглэж болохгүй." гэж заажээ.

НҮБ-аас 1988 онд баталсан "Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмыудын цогц"-ын 21-р зарчмын 1-т: "... Саатуулагдсан болон хоригдсон этгээдийн байдлыг хэргийг нь хүлээлгэх, өөрийн эсрэг мэдүүлэг өгөх, өөрийг нь илчлэх зорилгоор ашиглахыг хориглоно." гэж заасан байна.

Дээр дурдсан болон холбогдох эх сурвалжийг баримт бичгүүдэд шүүхийн өмнөх шатанд гэм буруугаа хүлээсэн, хохирол, төлбөрөө төлхөө илрэхийлсэн хүний заавал цагдан хорих албагүй гэдгийг нэг бус удаа тэмдэглэсэн байдаг.

Ер нь хорьж мөрдхөн ажиллагаанд хүнлэг бус харьцахыг хориглоно гэдэг нь хоригдож саатуулагдсан хүний эрх нь хязгаалагдсан серег байдлыг нь далимдуулж өдөөн хатгах, ятгах, хууран мэхлэх, басамжлан доромжлох зэрэг хэрэгээ хүлээхэд хүргэх дарамт шахалт бүхнийг хориглоно гэсэн үг юм.

Байцаалт буюу мэдүүлгэн нотлох баримт гаргуулах ажиллагаа нь ихэнхдээ мөрдөн байцаачийн субъектив хүсэл зоригийн дагуу хөтөн удирдах асуухад чиглэгдсэн процессын голлох хэлбэр болж уламжлагдаж ирсэн ажээ. Угаасаа Выщинский хэргийг өөрөөр хүлээлгэх онол буюу байцаалтыг хөтөн явуулах зарчим нь эрүүдэн шууголт хэрэглэх орчныг аяндаа бий болгодог байна.

Эдүгээ эрх зүйт ёсиг дээдэлдэг хөгжингүй улс орнуудад гэрчийг байцаах, нүүрэлдүүлэн байцаах, сэжигтэн, яллагдагчийн мэдүүлгийг шалгах ажиллагаа зөвхөн шүүх хуралдаан дээр явагддаг ба энэ нь хорьж, мөрдөх шаардлага, хүрээг хязгаарлах хүчин зүйл болно.

Сүүлийн жилүүдэд АНУ, Герман, Франц, Итали, Швед, Канад, Австрали зэрэг Өрнөдийн ихэнх орнууд эрүүгийн процессын хуулиудаа хүний эрхийн олон улсын стандарт, зарчмуудад нийцүүлэх талаар мэдэгдэхүйц өөрчлөлт хийсэн байдаг. Ялангуяа байцаалтыг албадан мэдүүлэг гаргуулах замаар хөтөлж явуулсан, хэрэг тулган хүлээлгэсэн зэрэг эрүү шүүлтийн шинжтэй зөрчил гаргасан, энэ талаар гомдол мэдүүлсэн нь нотлогдсон үед тухайн байцаалтыг хүчингүйд тооцож, улмаар тийнхүү гаргуулсан мэдүүлгийг нотлох чадваргүй гэж үзэд байна.<sup>7</sup>

Цагдан хоригдож буй хүний эрүү шүүлтээс ангиid эрх нь олон улсын нийтийн эрх зүйн жишиг болж тогтсон суурь зарчмуутдай бөгөөд эдгээр нь ямар ч үед шууд үйлчлэх агуулгыг илрэхийлдэг. Тодруулан авч үзвэл:

#### Суурь зарчим 1:

Мөрдөн байцаалтад шалгагдаж буй хэнийг ч нотлох баримтгүйгээр таамаг, сэжигт үндэслэн "сэжигтэн, яллагдагч" гэж тооцож, шүүхийн бус журмаар урьдчилан яллаж болохгүй.

<sup>6</sup>Д.Баярсаикан. Эрүүгийн процессын эрх зүй. У.Б., 2014. 227-р тап.

<sup>7</sup>Criminal procedure a worldwide study., ed. Craig M. Bradley. CA 2007. p.101-105

### **Суурь зарчим 2:**

Шүүхээр гэм буруу нь нотлогдоогүй хэн боловч Үндсэн хууль, олон улсын гэрээгээр олгогдсон иргзний эдлэх ёстай эрхийг хууль гарсан эсэхээс үл хамааран баталгаатай эдлэх ёстай.

### **Суурь зарчим 3:**

Шүүхийн өмнөх шатанд хоригдож буй яллагдагч аюулгүй, тэжээллэг хоол, хүнсээр хангагдах, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах, мэдээлэл авах, өмгөөлөгч авах, гэр бүлийн гишүүдтэйгээ уулзах, захидаар харилцах, нотлох баримт гаргаж өгөх, өөрийгөө өмгөөлөх, нэр төрөө хамгаалуулах эрхтэй бөгөөд эдгээр эрхийг баталгаатай эдлүүлэх ёстай.

### **Суурь зарчим 4:**

Мерден байцаалтад хоригдон шалгаждаг буй хүнийг эрх зүйн хязгаарлалтад байгаа нөхцөл, байдлаар нь онцлон үзэж, дарамт шахалт үзүүлж болохгүй.

### **Суурь зарчим 5:**

Албан тушаалын гэмт хэрэгт холбогдуулан цагдан хоригдсон хүнийг эрхэлж буй албан тушаал болон байгууллага, бизнесийн нэр хүндийг нь гутаах, дарамтлах нелөө үзүүлж болохгүй.

### **Суурь зарчим 6:**

Цагдан хорих үндэслэл болон түүнийг суплах нөхцөл, журам нь хуулийн нарийвчилсан процедур бүхий зохицуулалттай байх ёстай.<sup>6</sup>

### **Суурь зарчим 7:**

Зайлшгүй цагдан хоригдох

шаардлагагүй хүнийг нэн даруй суплах ёстай.

### **Суурь зарчим 8:**

Хорж мөрдөх, цагдан хорих ажиллагаа нь хуульд заасан маш тодорхой үндэслэлийн дагуу шүүхээр урьдчилан хэлэлцэж, зөвшөөрсөн нотлох баримтын үндсэн дээр онцгой тохиолдолд хязгаарлагдмал хүрээнд хэрэгжих ёстай.

Эдгээр суурь зарчмууд нь эрүүгийн процессын харилцаанд хүний эрхийн шаардлагыг тусгахад чиглэгдсэнээс гадна орчин үед хорж, мөрдөхөд чиглэгдсэн аливаа ажиллагаанд эрх зүйн ямар шалгуур, нөхцөлүүд байх ёстайг урьдчилан тодорхойлсон стандарт үзүүлэлтүүд юм. Энэ талаар НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос гаргасан удаа дараагийн тайлан, зөвлөмжүүдэд тусгагдаар иржээ.<sup>9</sup>

Хорж мөрдөх ажиллагаа нь хүний эрхээр хязгаарлаж гдаг энэхүү мен чанарыг онолын өдийгүй практикийн түвшинд ойлгож, ухамсарлах шаардлагатай юм.

### **Схем 2: Хорж мөрдөх ажиллагаа хүний эрхээр хязгаарлагдах нь:**

Позитив хамаарал	Негатив хамаарал
Хуулийн дагуу эрх зүйн үндэслэлтэйгээр хэргийн онцлог, бодит шаардлагад нийцүүлж ноцтой хэргийн хувьд онцгийн тохиолдолд тодорхой, хугацаа, хязгаарлалтын хүрээнд цагдан хорих нь (25-35 хувь) хүний эрхийн зөрчил болон эрүү шүүлтэд үл хамаарна.	Хуулийн хэт ерөнхий, тодорхой бус заалтыг үндэслэн нотлох баримттүйээр хэт хавтгайруулан, ихэнх хэргийн хувьд түгээмэл байдлаар баривчилж болон цагдан хорих нь (85-100 хувь) эрүү шүүлт болон хүний эрхийн зөрчилд шуда ба шуд бус хамаарлтай.

<sup>6</sup> Монгол Улсын хувьд "оргон зайлж болзошгүй" гэсэн хэт субъектив нөхцөл, сэжиг таамгаар цагдан хорьдог нь нэлээд ноцтой үр дагавартай бөгөөд нэгэнт цагдан хоригдсон хүнийг суплах талвар эрх зүйн тодорхой зохицуулалт ёнөө хэр байхгүй байна. (Д.Б.)

<sup>7</sup> ХЭҮК, АРГ. Эрүү шүүлтийн эсрэг олон улсын эрх зүйн эх сурвалж ба үндэсний илтгэлүүд. Нэгдсэн Үндэстний Байгууллагасаа ёгсөн зөвлөмжүүд. У.Б. 2015

Хорж мөрдөх ажиллагааны эрх зүйн үндэслэл, нөхцөлүүд нь үндэсний эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжоор хяглаарлагдахгүйн дээр олон улсын эрх зүйн гэрээ, конвенцийн агуулга, зарчмыг улам бүр тусган хэрэгжих болсон билээ.

Хоёр. Монгол Улсын ЭБША дахь хүний эрхийн зарим тулгамдсан асуудлын хувьд:

2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн агуулга нь ялах ажиллагаанд илүү тулгуурласан байдал нь өнөөгийн цаг үе, хүний эрхийн шаардлагатай илт зөрчилдөх болсон байна. Үүнийг товчоор илэрхийлбэл, нотлох ажиллагааны дахь ялах ба өмгөөлөх талын тэнцвэргүй харьцаа, мэтгэлцэх зарчим нэвтрээгүй шүүн таслах ажиллагааны догматик хуучинсаг орчин, эрүүгийн хэргийн хувь заяаг мөрдөн байцаагчийн цуглуулж, бүрдүүлсэн хавтаст хэргийн хэмжээнд хэргийг урьдчилсан уншсаны үндсэн дээр шийдвэрлэдэг зэрэг гажуудалтай, зохисгүй практик х: «шиж тогтсонтой холбон тайлбарлаж болно.<sup>10</sup>

Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссоос 2015 онд гаргасан ("Монгол Улсадах хүний эрх, эрхчөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэл"-д: "...Хүнд, онц хүнд гэмт хэргийн сэжигтнүүд шууд баривчил болохоор хуульчилсан нь хүний халдашгүй эрх зөрчигдэх шалтгаан болж байна. ... Оргон зугтахыг завдсан гэдэг нь субъектив байдлаар тодорхойлгоход үндэслэл бөгөөд нотолгоогоор бус, харин тогтоопд дурдах төдийгөөр хэрэглэдэг."<sup>11</sup> гэжээ. Түүнчлэн удаан хугацаагаар цагдан хорих, байр сэлгүүцэн өөрчилж цагдан хорих, шүүхийн өмнөх шатанд сэжигтэн, яллагдагчийг мөрдөн шалгах ажиллагаанд эрүүдэн шүүх, албадан хэрэг хүлээлгэх явдал бүрэн

арилаагүйн дээр эрүү шүүлттэй холбоотой гомдолууд буурахгүй гарсаар байгаа тухай тэмдэглэжээ.

Монгол Улсад цагдан хорих арга хэмжээг олон сараар хэт хавтгайруулан түгзэмэл хэрэглэж байгаа нь шүүхээр нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцогдох зарчимд ноцтой харшилж байгаагийн дээр шүүхийн өмнөх шатанд эрүү шүүлтийн нөхцөл байдлыг шууд бусаар бий болгох хүчин зүйл болж байна.

Судалгаанаас үзүүлэд жилд дунджаар цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сэжигтэн, яллагдагчдын 44,5 хувь нь хүндэвтэр (хүнд биш) хэрэгт холбогдсон хүмүүс байгаа нь анхаарал татах байна. 2014 оны шүүн таслах ажиллагааны тайландаа тусгагдсаныар шүүх 3721 сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих зөвшөөрөл олгосноос 1815 хүнийг сэжигтнээр, 1906 хүнийг яллагдагчар цагдан хорьсон байх ба үүнээс 1512 буюу 42 хувийг "оргон зайлж болзошгүй" гэсэн үндэслэлээр цагдан хорьсон байна.<sup>12</sup> Түүнчлэн зарим баримт дурдвал, Монгол Улсын ХЭҮК-оос 2015 оны 1-р сард ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461-р ангид хийсэн шалглалаар цагдан хориждож буй сэжигтэн, яллагдагчийн хувийн хэрэгт хийсэн үзлэгт 29 яллагдагч, шүүгдэгчийг цагдан хорих тухай хууль ёсны хүчин төгөлдөр шийдвэр байхгүй байв.<sup>13</sup> Монгол Улсын хувьд жилд дунджаар 21000 гэмт хэргэ цагдаагийн байгууллагад бүртгэгдэж, 6600 орчим ялтан хорих ял эдэлж, 5600 гаруй сэжигтэн, яллагдагч баривчлах болон цагдан хорих арга хэмжээ авагддаг гэсэн судалгаа бий.<sup>14</sup>

<sup>10</sup> УДШ-ийн Шүүн таслах ажиллагааны тайлан. УБ., 2015.

<sup>11</sup> Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс. Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөний бийдлийн талаарх 14 дэх илтгэл. УБ., 2015. 47-р тал.

<sup>12</sup> ЦЭГ-ын Мэдээлэл судалгааны төв. Судалгааны тайлан 2003-2013. УБ., 2014.

Цагдан хорих арга хэмжээ нь эрх зүйн мөн чанарын хувьд ял шийтгэл биш төдийгүй заавал авах ёстой арга хэмжээ биш юм. Гол нь ноцой гэмт хэрэг үйлдсэн зарим этгээдийг мөрдөн байцаах ажиллагаанд саад хийхээс сэргийлэх онцгой тохиолдолд түр хугацаанд авдаг арга хэмжээ юм. Монгол Улсын хувьд энэ нь олон сараар, олон удаа хугацааг нь сунгаж, үргэлжилсэн байдлаар түгээмэл хэрэглэгддэг арга хэмжээ болж (30 сар хүртэл) тогтсон нь харамсалтай. Ер нь хорьж цагдах замаар нотлох ажиллагааг явуулах бус, харин нотлогдсоны үндсэн дээр шаардлагатай үед хорьж цагдах тогтолцоонд шилжих нь зайлшгүй юм.

Манай ЭБША-ны журам, түүнд нийцсэн мөрдөн байцаалтын практикаас үзэхэд хүндэтвэр гэмт хэргийн сэжигтнийг хойшилуулшгүйгээр буюу шүүгчийн зөвшөөрөлгүйгээр оргон зугтахыг завдсан гэх үндэслэлээр баривчлах арга хэмжээг авдаг нь нотлох баримтгүйгээр шүүхийн хянaltaас гадуур хүний эрхэнд халдах нөхцөлийг бүрдүүлж буй явдал гэж үзэхээс өөр аргагүй. Түүнчлэн мөрдөн байцаалт дуусаж шүүхэд шилжүүлсэн хэргийг тухайн шүүхээс дахин нэмэлт мөрдөн байцаалт явуулахаар буцаадаг нь эрүү шүүлтэй тэмцэх, түүнийг багасгах нөхцөлийг хязгаарлах хүчин зүйл болж байна.<sup>15</sup>

НҮБ-ын Эрүүдэн шүүх хорооны зөвлөмж болон "Эмнэсти Интернэйшнл" олон улсын байгууллагын санал, уриалга, зөвлөмжийг Монгол Улс хүлээн авч, хэрэгжүүлэх явдал зарим талаар хангалтгүй, эрүү шүүлтэй тэмцэхэд чиглэгдсэн эрх зүйн орчныг бүрэн зохистойгоор бүрдүүлж чадаагүй нь хүний эрхийн олон улсын байгууллагудын олон талт судалгаанаас харагддаг.

<sup>15</sup> Солонгос ба Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх тогтолцоо: Тулгамдсан асуудал ба сориит. ЭШ-ний хурал. УБ., 2015.

"Эмнэсти Интернэйшнл"-ийн 2014 оны Хүний эрхийн төлөв байдлын тайлангаас үзэхэд "... Монгол Улсад эрүүдэн шүүх болон ... хорьж мөрдэгдэж буй хүмүүстэй хүнлэг бусаар зүй бус харьцсан хэргүүдийг цагдаагийн байгууллага шалгах болсон нь ийм төрлийн хэргийг хараат бусаар шалгах механизм дутагдсан байгааг харуулж байна."<sup>16</sup> Гэж тэмдэглэжээ. Энэ нь 2014 оны 1-р сарын 24-ний өдрийн хуулиар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 26.1-р зүйлийг хүчингүй болгосноор Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба татан буугджад тухайн албаны ихэнх нь цагдаагийн байгууллагад шилжсэнтэй холбоотой юм.

Монгол Улсын ХЭҮК-т 2014 онд хүлээн авсан нийт 710 гаруй гомдлын 330 буюу 46.5 хувийг хорих анги болон цагдан хорих байранд хоригдох буй сэжигтэн, яллагдагч, ялтан нараас гаргасан гомдол дангаар эзэлж байгааг анхаарч үзэх ёстой.<sup>17</sup>

Энэ өгүүллийн агуулга нь зайлшгүй тохиолдолд цагдсан хорьж, мөрдөн байцаалт явуулж буй хууль ёсны процесс ажиллагааг бүхэлд нь үгүйсгэх зорилгогүй гэдгийг цохон тэмдэглэх нь зүйтэй.

Харин Монгол Улс дахь хорьж мөрдөх ажиллагааг олон улсын гэрээ, конвенц, нийтлэг жишигийн зарчмуудтай харьцуулж, хүний эрхийн талаас нийтийг зорьсныг онцолбол зохино.

Эрүүгийн процесс дахь хүний эрхийн стандарт, зарчмуудыг нарийвчлан няяталж үзэхэд сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих, эрх чөлеөг хязгаарлах гол үндэслэл нь гарцаагүй бодит нөхцөл байдалд, тэр тусмаа нотлогдсон бодит байдалд тулгуурлах ёстой болохос ирээдүйд бий болж болзошгүй байдлыг

<sup>16</sup> Эмнэсти Интернэйшнл. 2014 оны Хүний эрхийн төлөв байдлын тайлан. (англи хэл дээр). 2015.

<sup>17</sup> Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс. 14 дэх илтгэл. УБ., 2015. 11-р тал.

урьдчилан тааж, сэжиг таамгийг үндсэн шалтгаан болгож болохгүй гэсэн үзэл санаа тусгагдсан байдаг.

Эцэст нь тоймлон дүгнэвэл, хорж мөрдөх ажиллагаа нь шүүхийн өмнөх шатанд заавал авах ёстой зайлшгүй процесс биш бөгөөд түүнийг эрх зүйн үндэслэлгүйгээр, хуулийн зорилго, агуулгад нийцүүлэхгүйгээр субъектив сэжиг, таамгаар хэрэгжүүлэх нь хүний эрхийн стандарт, зарчмыг зөрчихэд хүргэдэг. Өөрөөр хэлбэл цагдан хорих замаар байцаалтад тулгуурлан хорж мөрдөх ажиллагааг дийлэнх хэргийн хувьд хавтгайруулж, түгээмэл хэрэглэх нь хүний эрхийн зөрчил төдийгүй, эрүү шүүлтийн бусад хэлбэрийн хүчин зүйл болох үр дагавар байдаг.

Иймд эрүүгийн процессын бүхий л харилцаанд хүний эрхийн зарчмыг туштай хангах чиглэээр холбогдох хууль тогтоомжийг өөрчлөн боловсронгуй болгох, үндэслний хуулиудыг олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх, мөрдөн бэйцагч, прокурор, шүүгч, хуульчдын сэглэгээг шинэчлэх зэргээр тулгамдсан слон асуудлыг цаг үеийг нь олж, оновчтой шийдвэрлэх шаардлагатай юм.

#### **Санаалын хувьд:**

1. 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг бүхэлд нь хүчингүй болгон Эрүүгийн процессын суурь хуулиудыг нийтлэг жишигийн дагуу шинээр боловсруулж батлах (Эрүүгийн хэргийн мөрден шалгах болон эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиуд);

2. Цагдан хорих нөхцөл журмыг олон улсын хүний эрхийн конвенцид нийцүүлж одоогийн тогтолцоог өөрчлөн шинэчлэх, хүндрүүлэх нөхцөлтэй хүнд болон онц хүнд гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон хүнд шүүхийн урьдчилсан зөвшөөрлийн үндсэн дээр онцгой тохиолдолд буюу хягаарлагдмал хүрээнд хэрэглэх замаар өөрчлөлт

оруулан хуулийн төсөлд тусгах;

3. "Сэжигтэн" болон "Оргон зайлж болзошгүй", "Оргон зайлхыг завдсан" гэх мэт ойлголтыг хуулийн заалтаас хасах;

4. Хүндбишгэмт хэрэгт холбогдсон хүн гэм буруугаа хүлээж, хохирол төлбөрөө төлхөө баталж, илэрхийлсэн тохиолдолд хорж мөрдөхгүйгээр хялбаршуулсан журмаар буюу шүүхэд шилжүүлэхгүйгээр шийдвэрлэх эрх зүйн үндэслэл, орчныг шинээр бий болгон хуульчлах;

5. Нотлох баримтыг зөвхөн шүүхээр үнэлүүлэх тогтолцоог бий болгох, яллагач болон өмгөөлөгч мэтээлэн нотлох замаар цуглулж, бэхжүүлсэн баримт сэлтийг шүүх үнэлдэг зарчимд шилжих (Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор нотлох баримтыг үнэлж байгаа нь буруу бөгөөд эрүү шүүлт үүсгэх нөхцөлийг бий болгодог);

6. Хоригдон мөрдөгдж буй этгээдийн эрх зүйн байдлыг хүний эрхийн зарчимд нийцүүлж, эрх нь хягаарлагдсан байдлын сөрөг хүчин зүйлийг буруулах замаар боловсронгуй болгон хуульчлах;

7. Эрүүгийн хэргийн баримт сэлтийг шүүхийн өмнөх шатанд байцаалтад голлон тулгуурлах замаар мэдүүлгэн нотолгоог хэт үнэлэн явуулж байгааг өөрчлөн байцаалтаас бусад нотолгооны арга хэлбэрийг өргөн хэрэглэх журмыг бий болгох;

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нар төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн агуулга, зарчмыг шинээр батлагдах эрүүгийн процессын хуулиудад бүрэн тусгаж, эрүүдэн шүүхтэй тэмцэхэд чиглэдсэн эрх зүйн орчныг бий болгох г.м.

## ЗАХИРГААНЫ АКТЫН БИЕЛЭЛТИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ



*Удирдлагын академийн дэд профессор,  
Хууль зүйн доктор /Dr.Jur// Д.Сүнжид*

Монгол улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1-д Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх талаар зохицуулсан бөгөөд шүүгч захирамж гаргаж, маргаан бүхий захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхээр заасан байдаг, уг хуулийн 45 дугаар зүйлийн 45.3-д Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлсэн шүүгчийн захирамж нь тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна.

Энэ зүйлийн зохицуулалт нь захиргааны хэргийн шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулж, урьдчилсан байдлаар нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг шүүхийн тур хамгаалалтад авч байна гэсэн уг юм. Гэхдээ энэ нь шүүхэд гаргаж буй нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагаас ихээхэн хамаардаг учир зөвхөн маргаан бүхий захиргааны актыг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлд л шүүх өөрийн санаачилгаар, талуудын хүснэгтээр захиргааны актыг биелэлтийг түдгэлзүүлж болно. Энэ нэхэмжлэлийн шаардлагаас өөр, жишээ нь захиргааны актыг илт хүчин төгөлдөр

бусад тооцуулахаар нэхэмжлэлийн шаардлагатай байхад энэ арга хэмжээг хэрэглэхгүй. Учир нь энэ нь угассаа гарах ёсгүй акт байхтай холбоотой<sup>1</sup> гэж Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тайлбарнажээ.

Захиргааны актыг түдгэлзүүлэхийн гол тулгуур санаа нь маргаан бүхий захиргааны акт, өөрөөр хэлбэл иргэнд үүрэг хүлээлгэсэн, эсхүл эрхийг нь хягаарласан захиргааны актын биелэлтийг түр зогсоход оршино. Учир нь захиргааны актыг гаргаж байгаа байгууллага тодорхой зорилго, чиг үүрэгтэй байдаг. Захиргааны байгууллагаас гаргасан акт нь биелж байж уг зорилгодоо хүрэх боломжтой байна.<sup>2</sup>

Захиргааны хэргийн шүүхээс маргаан бүхий захиргааны шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэх эрхийг ийнхүү хуулиар олгосон нь хүний эрхийг захиргааны хууль бус үйл ажиллагаанаас шуурхай, цаг алдалгүй хамгаалах боломжийг бий болгож байгаа хэрэг юм. Захиргааны хэргийн шүүхээс захирамжаар түдгэлзүүлсэн захиргааны актын Ж нь: Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн 2011 оны долдугаар сарын 9-ний өдрийн 1075 дугаартай захирамжаар иргэн С.Нямдааад газар эзэмшиж эрх олгосон захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхээр шийдвэрлэх, хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэлх хугацаанд маргаан бүхий газар дээр аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглосон байхад барилгын ажил гүйцэтгэж тус бүр нь 16 давхар 3 орон сууцны барилга

<sup>1</sup> Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар, 2009 он, 144 дахь тал

<sup>2</sup> Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар, 2009 он, 356 дахь тал

барьж дуусгасан, уг барилгуудыг бусдын газар дээр эзэмшигчийн зөвшөөрлийг авалгүй, барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгогдоогүй байхад барьсан болох нь хэрэгт цугласан бичмэл нотлох баримтуудаар тогтоогдооныг дурдсан байна.<sup>3</sup> Ж нь 2: 2015.03.13-ний өдөр "Түүчээ тэрэг" ХХК-ийн нэхэмжлэлтэй, Ашигт малтмын газарт холбогдох тусгай зөвшөөрлийн маргаан бүхий захирагааны хэргийн нэхэмжлэгчээс гаргасан маргаан бүхий захирагааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай хүснэгтийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд Захирагааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1-д заасныг удирдлага болгон маргаан бүхий захирагааны актын биелэлтийг түдгэлзүүлж шийдвэрлэв, Ж нь 3: 2. 2014. 11. 24-нд "Си Си Эф петролеум" ХХК-ийн нэхэмжлэлтэй, Уул уурхайн яам, Газрын тосны газарт холбогдох төндерийн маргаан бүхий захирагааны хэрэгт нэхэмжлэгч талаас гаргасан гэтэн биелэлтийг түдгэлзүүлэх хүснэгтийг хэлэлцээд Захирагааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1-д заасныг удирдлага болгон нэхэмжлэгчээс гаргасан хүснэгтийг хангаж шийдвэрлэв.

Гэвч хуульд тусгайлан заасан зарим тохиолдолд шүүхэд хянагдаж буй захирагааны шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэх эрхгүй байдаг. Тухайлбал, Байгаль орчны яам<sup>4</sup>-наас баталсан "Газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авах тухай" журам. Учир нь Захирагааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд "хэм хэмжээ тогтоосон захирагааны шийдвэр (дүрэм, журам гэх мэт)" –ийн биелэлтийг шүүх зөвхөн тухайн салбарын хуульд түдгэлзүүлж болохоор зохицуулсан нөхцөлд түдгэлзүүлэх, түүнээс бусад

<sup>3</sup> [http://www.supremecourt.mn/index.php?option=com\\_content&view=article&id=1868%3A2014-02-20-00-50-29&catid=26%3A2010-11-10-08-10-56&Itemid=138](http://www.supremecourt.mn/index.php?option=com_content&view=article&id=1868%3A2014-02-20-00-50-29&catid=26%3A2010-11-10-08-10-56&Itemid=138)

<sup>4</sup> 2060 оны нэршлээр

тохиолдолд түдгэлзүүлэх эрхгүй хэмжээн заасан байдаг.<sup>5</sup> Учир нь хэм хэмжээ тогтоосон акт нь зөвхөн нэхэмжлэгчийг хамаараад зогсохгүй ихэнх тохиолдолд тодорхой бус тооны хүмүүсийг хамаарна. Тиймээс нэг нэхэмжлэгчээс түүний хүчингүй болгуулах шаардлага гаргасан тохиолдолд захирагааны актыг биелэлтийг түдгэлзүүлж болохгүй гэж үздэг байна.<sup>6</sup>

Монгол улсын хуульд заасан "түдгэлзүүлэх" талаар зохицуулсан тохиолдлыг үзэхэд ихэвчлэн тусгай зөвшөөрөл, эрх олгосныг түдгэлзүүлэх тухай зохицуулдаг байна. Харин хэм хэмжээ тогтоосон актын биелэлтийг түдгэлзүүлэх талаар тухайнлан зохицуулсан хуулийн зохицуулалт одоогоор байхгүй байна.

Захирагааны актыг биелэлтийг түдгэлзүүлж болохгүй тохиолдол аль ч улсад байдаг нь түгээмэл байна. Монгол улсын Захирагааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 46 дугаар зүйлд доорх дөрвөн тохиолдлыг заажээ, Үндэс:

–захирагааны актын биелэлтийг түдгэлзүүлэх нь бусдын амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөнд ноцтой, хуулийн этгээдэд илт хохирол учруулахаар бол;

–иргэн, хуулийн этгээдээс албан татвар, төлбөр, хураамж гаргуулах тухай акт бол;

–захирагааны журам зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэсэн болон уг зөрчлийг таслан зогсох тухай захирагааны хяналтын байгууллага, албан тушаалтын шийдвэр бол;

–хууль тогтоомжид заасан тохиолдолд үл маргалдах журмаар биелүүлэх бол.

Хуульд заасан тодорхой нөхцөлд захирагааны актын биелэлтийг түдгэлзүүлэхэд хуульд харшлах эсэхийг

<sup>5</sup> <http://tsogol.blogspot.ru/2013/02/zahirgaanii-hergiin-shuuuh-buuji-erh.html>

<sup>6</sup> ХБНГУ-д хэм хэмжээ тогтоосон актын талаар нэхэмжлэлийн давж заандах шатны шүүхд шууд хянуулдаг.

шүүхээс тогтоодог.<sup>7</sup> Эрх зүйн хамгаалах ёстай ашиг сонирхол, эрхэд учирч буй аюулыг зайлцуулахын тулд захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх боломжгүй байвал шүүхээсийн шийдвэр гаргаж болохгүй юм. Ж нь: Захиргааны байгууллагаас нурах аюултай байшинд нэвтрэхийг хориглож хүн орохооргүй болгон бэхлэх тухай гаргасан шийдвэр.<sup>8</sup> Мэн татвар, хураамж, төлбөрийг шаардсан захиргааны актын биелэлтийг шүүхээс түдгэлзүүлэх эрхгүй. Энэ зохицуулалтаар нийтийн үйл ажиллагааны шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг баталгаажуулсан байна. Түүнээс гадна захиргааны акт биелэгдсэн дараа хэрэг захиргааны акт хууль зөрчсөн болох нь шүүхээр тогтоогдож хүчингүй болсон бол захиргааны байгууллагаар хохирлын нөхөн төлүүэл нь хүндэтэй биш, нэхэмжлэгчид запруулах боломжгүй тийм хэмжээний хохирол учруулахгүй.<sup>9</sup>

Хуулийн заалт, түүний тайлбарсаас үзэхэд захиргааны актыг түдгэлзүүлэх эсэх шийдвэр гаргахдаа дараах нөхцөлийг урьдчилан шалгахаар байна. Үүнд:

1. Үүрэг хүлээлгэсэн, эрхийг хязгаарласан захиргааны акт байх,

2. Маргаан бүхий захиргааны акт байх

3. 46 дугаар зүйлд заасан түдгэлзүүлж болохгүй нөхцөл байдал бий эсэх

4. Нэхэмжлэгч иргэнд сүүлд нь запруулах боломжгүй хохирол учрах нөхцөл байдал байгаа эсэх / Нийтийн ашиг сонирхол, хувийн ашиг сонирхлыг харьцуулан үнэлэх/

ХБНГУ-ын Захиргааны шүүхийн журмын тухай хуульд "Захиргааны актын биелэлтийг хойшлуулах" болон "Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх" хоёр ялгаатай ойлголтыг тодорхойлжээ. Хуульд<sup>10</sup> зааснаар зааснаар захиргааны актын талаар давж заалдах гомдол буюу захиргааны актыг хүчингүй болгуулах шаардлага бүхий нэхэмжлэлийг шүүхэд гаргасан тохиолдолд **захиргааны актын биелэлтийг "хойшлуулах"** үр дагавартай байна. Энэ нь эрх зүйг хэлбэржүүлэх буюу эрх зүйн харилцаа байгааг тогтоолгох захиргааны актын тухайд мён түүнчлэн давхар үйлчлэлтийг захиргааны актын тухайд хэрэглэгдэнэ. Захиргааны актын биелэлтийг хойшлуулах үр дагавар нь үүсэхгүй дөрвөн тохиолдлыг хуульд тусгайлан нэрлэсэн байна. Үүнд: 1. хураамж, төлбөр, татварыг шаардах захиргааны акт бол.

2. Цагдаагийн албан хаагчаас хойшлуулшгүй үед шаардлагатай арга хэмжээ авах тухай шийдвэр бол.

3. Холбооны буюу муж улсын хуулиар гуравдагч этгээдээс хөрөнгө оруулсан тухай, эсхүл шинээр ажлын байрыг бий болгосон тухай захиргааны актад давж заалдах гомдол юм уу нэхэмжлэл гаргасан бол

4. Нийтийн ашиг сонирхол, эсхүл оролцогчийн зонхилох ашиг сонирхлын үүднээс актыг батлан гаргасан захиргааны байгууллагаас эсэвл гомдлыг хянан шийдвэрлэсэн дээд шатны захиргааны байгууллагаас шууд хэрэгжүүлэхээр журамласан бол захиргааны акт шууд биелэгдэнэ. Энэхүү хуульд заасан захиргааны актын биелэлтийг хойшлуулж болохгүй дээрх дөрвөн нөхцөл үүссэн бол үндэслэл бүхий шийдвэрийг бичмэл хэлбэрээр холбогдох байгууллагаас гаргах ёстай байна. Гамшгийн буюу аюултай нөхцөл байдлын үед нийтийн

<sup>7</sup> Цэргийн алба хаяг зарлан дуудах хуудас, амьтны тахлаас хамгаалах хорио цээр тогтоог тухай шиндвэрийн биелэлтийг түдгэлзүүлэхийг ХБНГУ-д хориглодог байна.

<sup>8</sup> Захиргааны хэрэг хянан шиндвэрлэх тухай хуулийн тайлбар, 2009 он, 357 дахь тап

<sup>9</sup> Захиргааны хэрэг хянан шиндвэрлэх тухай хуулийн тайлбар, 2009 он, 357 дахь тап

<sup>10</sup> Захиргааны шүүхийн журмын тухай хууль, 80 дугаар зүйл

ашиг сонирхлыг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор амь нас, эрүүл мэнд, өмчид шууд заналхийлсан аюулыг зайлцуулах арга хэмжээ авч буй тохиолдолд захирагааны актад үндэслэл заавал шаардахгүй. Захирагааны актyg батлан гаргасан захирагааны байгууллага, гомдлыг хүлээн авч хянан шийдвэрлэсэн дээд шатны захирагааны байгууллагаас захирагааны актын үйлчлэлийг хойшлуулах дурдсан дөрвөн нөхцөл байхгүй бол захирагааны актын биелэлт хойшлогдоно. Захирагааны акт хууль ёсоор гарсан эсэх талаар шийдвэрлэх эрх бүхий байгууллагад “үндэслэлтэй эргэлзээ” байгаа тохиолдолд, захирагааны акт нийтийн ашиг сонирхолд нийцэхгүй тохиолдолд түүний үйлчлэлийг хойшлуулж болно. Хэрэв урьдчилан хянан шийдвэрлэх шатаанд уг асуудлыг шийдвэрлээгүй бол захирагааны хэргийн шүүхэд нэхэмжлэгчээс энэ талаар хүсэлтээ өгч шийдвэрлүүлж болно. Шүүхээс хүсэлтийн тагуу захирагааны актын биелэлтийг хэсэгчлэн буюу бүрэн хойшлуулж, эсхүл үйлчлэлийг нь эргэж сэргээж болно. Хэрэв захирагааны акт шууд биелэгдсэн байгаа бол шүүхээс захирагааны актын биелэлтийг цуцлахаар шийдвэрлэж ч болно. Захирагааны актын үйлчлэлийг хойшлуулсан үйлчлэлийг сэргээхэд аюулгүй байдал, бусад хамаарах ач холбогдол бүхий нөхцөл байдлыг харгалзан тодорхой хугацааг зааж болдог байна. Шүүхээс захирагааны актyg хойшлуулах хүсэлтийн талаарх шийдвэрийг шүүх хурлын шийдвэр гарпал хугацаанд өөрчилж эсвэл цуцлах боломжтой. Оролцгочоос өөрийн буруугүй үйл ажиллагааны улмаас шүүхийн шийдвэрээр өөрчлөгдсөн буюу цуцлагдсан захирагааны актын үйлчлэлийг сэргэх талаар хүсэлт гаргах эрхтэй. Захирагааны актын шийдвэрийн биелэлтийг хойшлуулах асуудлыг шийдвэрлэх цаг хугацааны хувьд яяралтай, хойшлуулшигүй

тохиолдолд тус шүүхийн удирдлагаас шийдвэр гаргана.

Хоёр дахь ойлголт болох **Захирагааны актын биелэлтийг түдгэлзүүлэх нь** нэхэмжлэгчид учрах хохирлоосуурьдчилан сэргийлэх эрхийн хамгаалалтын арга хэрэгсэл тэж үздэг. Хэрэв бодит байдалд нэхэмжлэгчийн эрхийг хэрэгжүүлэхэд түүний одоогийн нөхцөл байдал, эрх зүйн байдал нь өөрчлөгдхөх, дордохуйц хундрэлтэй нөхцөл үүсэх эрдэл бодитой байгаа бол шүүхээс талуудын хүсэлтээр энэ асуудлыг шийдвэрлэж болно.<sup>11</sup> Энэхүү шүүхийн шийдвэр нь маргаан бүхий эрх зүйн харилцаа, ялангуяа үргэлжилсэн эрх зүйн харилцааны тухайд түүний улмаас нэхэмжлэгчид үүсэх сэрг талаас зайлсхийх, бодитой заналхийлж буй аюулас зайлсхийх, эсхүл шаардлагатай өөр үндэслэл байгаа бол “тур зуур” эрхийг хамгаалан зохицуулах ач холбогдолтой байдаг. Ийм шийдвэрийг анхан шатны шүүхээс гаргана. Хэрэв давх заалдах шатны шүүхэд хэрэг байгаа үед ийм хүсэлт гаргавал давж заалдах шатны шүүхийн удирдлагаас хэрхэйг шийдвэрлэх боломжтой.

Заримдаа эрх зүйн урьдчилсан хамгаалалтын дээрх хоёр тохиолдлыг хооронд нь ялгахад бэрхшээлтэй байдаг. Захирагааны актын үйлчлэлийг хойшлуулах нь үндсэндээ захирагааны актын эрх зүйн үйлчлэл чиглэсэн / хаяглагдсан/ этгээдэд үүрэг хүлээлгэх агуулгатай бөгөөд түүнээс гаргасан гомдол, эсхүл захирагааны актыг хүчингүй болгуулах нэхэмжлэл бүхий захирагааны хэрэгт үйлчилнэ. Бусад тохиолдолд ялангуяа захирагааны актаас үйлчилгээ үзүүлэх, эсхүл бусдын хүсэлтийг хангаж захирагааны акт гаргаж байгаа бол захирагааны хэргийн нэхэмжлэлийн ямар нэг тэрлөөр бус нэг удаагийн захирамжилсан шийдвэр гаргах тухай хүсэлтээр шийдвэрлэнэ.

<sup>11</sup> ХБНГУ-ын Захирагааны шүүхийн «күрмын тухай хууль 123 дугаар зуилийн 1 дэх заалт»

Ийм төрлийн нэг удаагийн захирамжилсан шийдвэр буюу захирагааны актыг түдгэлзүүлэх шийдвэр гаргуулах тухай хүсэлтийг Захиргааны хэргийн шүүхэд оролцогчоос гаргаж болно. Харин үүрэг хүлээлгэсэн захирагааны актыг хүчингүй болгуулахаар гомдол буюу нэхэмжлэл гаргаж байгаа тохиолдолд захирагааны актын биелэлтийг хойшлуулах үр дагавар үүснэ.<sup>12</sup> Энэ нь мөн давхар үйлчлэлтэй захирагааны актад хамаатай. Эрх зүйн үйлчлэл чиглэсэн этгээдэд үүрэг хүлээлгэхийн сацуу гуравдагч этгээдэд эрх эзлүүлэхээр, эсвэл эсрэгээрээ эрх зүйн үйлчлэл чиглэсэн этгээд эрх эдэлж, гуравдагч этгээд үүрэг хүлээхээр зохицуулалттай **захиргааны актыг давхар үйлчлэлтэй** гэж үзнэ. Ж нь: барилга барих тусгай зөвшөөрөл олгоход хүсэлт гаргасан этгээдэд эрх олгож байгаа, харин хөршүүд нь хүлээн зөвшөөрч, тодорхой хэмжээгээр хэвийн амьдралд нь таатай бус нөлөө үзүүлэхийг тэвчих үүрэгтэй болдог.

Захиргааны актыг хойшлуулах тохиолдолд захирагааны акт баталсан байгууллага түүнийг биелүүлэхийг түр хүлээнэ. Ялангуяа албадан биелүүлэх арга хэмжээ авч болохгүй гэсэн уг юм. Энэ нь захирагааны актыг биелэлтийг гүйцэтгэх ёстой **этгээдийг** түр хугацаанд үүрэг хүлээлгэхгүй байгаа хэлбэр болно. Харин шүүхийн шатны эрх зүйн үрьдчилсан хамгаалалтыг баталгаажуулах хэлбэр биш юм.

Хуульд зааснаар эсвэл захирагааны байгууллагын тусгай журмаар захирагааны актын үйлчлэлийг хойшлуулах нехцэл байдал нь арилсан бол захирагааны актыг биелүүлнэ. Энэ нехцэлд захирагааны актад гомдол буюу нэхэмжлэл гаргасан байсан ч захирагааны актыг биелүүлэх үүрэгтэй болно.

Захиргааны акт батлагдсан үеэс цаг, хугацааны хувьд гомдол гаргах,

<sup>12</sup> ХБНГУ-ын Захиргааны шүүхийн журмын тухай кууль 80.1

эсхүлнэхэмжлэл гаргаснаар захирагааны актын биелэлтийг хойшлуулах үйлчлэл эхэнэ. Захиргааны маргаан бүхий актыг захирагааны хэргийн шүүхээс цуцлахгүйгээр хэвээр үлдээн шийдвэрлэсэн үед, эсхүл нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан бол, энэ тухай шийдвэр гарснаар захирагааны актын биелэлт хойшлуулах хугацаа дуусгавар болно. Захиргааны хэргийн шүүхээс нэхэмжлэлийг татгалзсанараа захирагааны актын биелэлтийг хойшлуулах үйлчлэл дууссан бол уг захирагааны актын үйлчлэлийг үргэлжүүлэхээр дээд шатны шүүхээс тогтоож болно.

Тухайн актыг батлан гаргасан байгууллага, эсвэл дээд шатны байгууллага нь захирагааны актын биелэлтийг түдгэлзүүлэх эрхтэй. Гэхдээ захирагааны хэргийн шүүхэд талуудас ийм хүсэлт гаргахын өмнө үрьдчилан хянан шийдвэрлэх шатны журмаар заавал дамжихыг шаарддаггүй. Харин төлбөр, хураамж, тавартай холбоотой захирагааны актыг түдгэлзүүлэх хүсэлт гаргаж байгаа бол үрьдчилан хянан шийдвэрлэх ажиллагаа хийгдсэн байхыг заавал шаарддаг. Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэгүй захирагааны шүүхийн шийдвэрт гомдол гаргах тухайд Захиргааны шүүхийн журмын тухай хуулийн дагуу ерөнхий хүсэлт гаргах эрхийн дагуу захирагааны шүүхэд биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлт гаргах боломж нь талуудад нээлттэй байна.

Захиргааны акт хэдийнээ биелэгдсэн байгаа бол захирагааны хэргийн шүүхээс **захиргааны актын биелэлтийг цуцлах тухай** захирамж гаргаж болно. Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх ажиллагаа явагдаж бай үед тухайн захирагааны акт биелэгдсэн нехцэлд ч цуцлах тухай захирамж гаргана. Хэрэв захирагааны хэргийн шүүхээс эргж сэргээсэн, эсвэл тодорхойлон тогтоосон тохиолдолд уг маргаан бүхий захирагааны актын

үйлчлэл сэргэнэ. Захиргааны байгууллагаас актын биелэлтийг хойшлуулах талаар маргаантай байсан ч шүүхээс биелэлтийг түдгэлзүүлэхээр журамлаж болно. Энэ нь захиргааны хэргийн оролцгчийн эрх зүйн урьдчилсан хамгаалалт юм. Захиргааны байгууллага захиргааны актыг хэдийнээс биелүүлээд дуссан, цуцлах тухай шийдвэр захиргааны хэргийн шүүхээс гаргаад эрх зүйн үр дагавар өөрчлөгдхөөрөгүй бол оролцгчийн эрхийг актыг түдгэлзүүлэн хамгаалах шаардлагагүй. Харин талууд хууль бус захиргааны актын улмаас нэхэн олговор авах, эрх зүйн үр дагаврыг зайлцуулахыг захиргааны байгууллагаас шаардах эрхтэй.

Захиргааны хэргийн шүүхээс захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай хүсэлтийг маш шуурхай шийдвэрлэхийг эрмэлзэх ёстай. Учир нь энэ нь ЯАРАЛТАЙ ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД хамаардаг юм. Хүсэлтийн талаар заавал бичгээр шийдвэрлэн. Нехцэл байдлыг тодруулах шаардлагатай гэж шүүхээс үзсэн тохиолдолд л тусгайлан хурал хийж амаар хэлэлцэх эсэхийг шүүх шийдвэрлэх эрхтэй байна. Тиймээс хүсэлт өгч нэхэмжлэгчээс өөрийн үндэслэлээс аль болох бүгдийг тайлбарлаж, нотлохыг зөвлөдөг. Энэ үе шатанд нотлох баримтыг заавал бүрэн цуглуулах үргийг шүүхээс хүлээдэггүй, өөрт нь байгаа баримтын хүрээнд шийдвэр гаргадаг. Тиймээс хүсэлт өгч байгаа этгээдээс өөрийн хүсэлтийн үндэслэл, таамаглалаа баталгаажуулах нотлох баримтыг / бичмэл болон бусад хэлбэрийн нотлох баримт, гэрчигийн асуултаг/ бүгдийг нь өгөх ёстай. Нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх шүүхийн ажиллагаанаас ялгаатай нь бодит байдал чухам юу болсныг эцэслэн тогтоогогоогүй нехцэлд шүүхээс түүнийг **бодитой үнэн байж болох** нехцэл, байдлыг үнэлэн захиргааны актын биелэлтийг

түдгэлзүүлэх хүсэлтийг шийдвэрлэн.

Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх нь нэг төрлийн богиноосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааболно. Тиймээс бодит нехцэл байдал болон эрх зүйн нехцэлгүнээслэн, нийтийн ашиг сонирхол болон хувийн ашиг сонирхлыг харьцуулан үнэлнэ. Нийтийн ашиг сонирхлын үүднээс ач холбогдолтой, бодит болон эрх зүйн үндэслэл нь илэрхий хууль ёсны хувийн ноцтой ашиг сонирхол ногөө талд нь байхгүй тохиолдолд захиргааны актыг шууд хэрэгжүүлэх нь зүйтэй болно. Хүсэлтийг хянан шийдвэрлэх явцад илэрхий хууль бус болохыг тогтоож чадахгүй, холбогдох нотлох баримтыг бүрэн бүрдүүлсэн нехцэлд хууль ёсны байдлыг үнэлэхээр бол захиргааны актыг шууд биелүүлснэр **нийтийн болон хувийн ашиг сонирхлын тухайд ямар үр дагавартайг шүүхээс харьцуулан үнэлж**, шийдвэр гаргана. Татвар, төлбөр, хураамжийн тухайд онцлог заалт үйлчлэх талаар дээр тайлбарласан билээ. Захиргааны байгууллагын шууд гүйцэтгэх яаралтай арга хэмжээний тухай шийдвэр хууль зүйн үндэслэлтэй бичгээр гарцаад зогсохгүй, хойшлуулшгүй нехцэл байдал үнэхээр байсан эсэхийг шалгана.

Хэрэв шүүхийн удирдлагаас нэг шүүгчид даалгаагүй бол захиргааны актыг түдгэлзүүлэх хүсэлтийг гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй шийдвэрлэн. Аюулгүй байдал, бусад холбогдох нехцелөөс хамааруулан хойшлуулсан захиргааны актыг нехцэл байдал арилсан тохиолдолд сэргээж болно. Захиргааны шүүхийн шийдвэр албажсанаас хойш захиргааны хэргийн оролцгочоос 2 долоо хоногийн дотор бичгээр гомдол гаргах эрхтэй. Дээд шатны шүүхээс уг гомдлыг хянан шийдвэрлэх ба гомдол гаргаж буй талаас нэг сарын дотор өөриин гомдлыг нотлох үндэслэл, тайлбарaaа өгнө. Ингэхдээ гол нь анхан шатны шүүхийн

шийдвэрлийг өөрчлөх буюу цуцлах ямар үндэслэл байгааг тодорхой тайлбарлана. Давж заалдах шатны шүүхээс уг гомдолыг зөвхөн тайлбарын хүрээнд л шийдвэрлэх тул гомдол гаргачийн үндэслэл, тайлбар нь маш чухал юм.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.7-д зааснаар "хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай гэх үзвэл захиргааны байгууллага, албан тушаалтнаас дахин шинэ акт гартал захиргааны уг актыг түдгэлзүүлэн шийдвэрлэх эрхтэй" гэсэн энэхүү зохицуулалт нь нэхэмжлэгчид учрах хохирлоос урьдчилан сэргийлэх эрх зүйн хамгаалалтын арга хэрэгсэл бус захиргааны хэргий шүүхийн шийдвэрийн нэг төрөл юм. Иймээс Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар зүйл, 70 дугаар зүйлийн 70.2.7 дахь заалтыг хооронд нь ялгаатай байдлыг ойлгох шаардлагатай. Ж нь: "Жигүүр гранд" ХХК-ий нэхэмжлэлтэй, Нийслэлийн засаг даргад холбогдох газрын маргаан бүхий захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1, 70.2.7 дахь хэсгийг удирдлага болгон Нийслэлийн засаг даргын 2013 оны 9 дүгээр сарын 5-ны едрийн А/828 дугаар захирамжийн иргэн С.Амарбаясгаланд холбогдох хэсгийг түдгэлзүүлж, захиргааны шинэ акт гаргахыг даалгаж шийдвэрлэв.

Нэгтгэн дүгнэхэд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45,46 дугаар зүйлд заасан Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх заалтыг хэрэглэхэд дараах тодорхойгүй асуудлууд байгааг анхаарч, нэгдмэл ойлголтой байх шаардлагатай байна. Үүнд:

-Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 46

дугаар зүйлийн 46.1-д захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй дөрвөн нөхцөл нь хууль хэрэглэгчдэд тодорхой ойлгомжтой эсэх нь зргэлзээ төрүүлэхээр байна. Шүүхийн шийдвэрийн цахим сангийн хайлтын мэдээллээс үзэхэд ЗХХШТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг баримтлан захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхгүй тухай шийдвэрлэсэн нь түгээмэл илрэцтэй байна. Ингэхдээ хууль хэрэглэгчдээс "бусдын амь бие, зруул мэнд, эд хөрөнгөнд ноцтой, хуулийн этгээдэд илт хохирол учруулахаар" нөхцөл байдалд юу ойлгох. Ямар жинлүүрээр, ямар зарчмаар шийдвэр гаргах нь ойлгомжтой эсэх нь тодорхойгүй хэвээр байна. Ялангуяа давхар үйлчлэлтий захиргааны актын тухайд гуравдагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын талаар дүгнэлт хийж байгаа байдал нь үндэслэлтэй эсэх нь тодорхойгүй байна. Тиймээс захиргааны хэргийн шүүхээс хянан шийдвэрлэгдсэн нийт хэрэгт захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхэд баримталсан хуулийн үндэслэлийн талаар дун шинжилгээ нэгдсэн дүгнэлт хийх нь энэ талаар цаашдын зохицуулалтыг шийдвэрлэхэд ач холбогдолтой.

-Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхэд урьдчилан шалгах нөхцлийн талаар өмнө дурдсан ЗХХШТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасан нөхцөл бий эсэхийг шалгахаас гадна "үүрэг хүлээлгэсэн, эрхийг хязгаарласан захиргааны акт байх, маргаан бүхий захиргааны акт байх, нэхэмжлэгч иргэнд сүүлд нь залруулах боломжгүй хохирол учрах нөхцөл байдал байгаа эсэх /Нийтийн ашиг сонирхол, хувийн ашиг сонирхлыг харьцуулан үнэлэх/" талаар нэгдмэл ойлголт, аргачлал, зарчим, үнэлзмж шүүхэд төлөвшүүлэх нь зүйтэй байна.

Үүнээсгэднадараах зохицуулалтыг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх

тухай хуулийн шинэчилсэн найруулгад зохиистой байдлаар оруулах боломжийг судлах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

-Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актын тухайд ЗХХШТХ-ийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь заалт нь бусад хуульд уг асуудлыг тусгаагүй тохиолдолд хэрэглэх боломжгүй байгаа тул үр нөлөөтэй байдлаар бусад хууль тогтоомжтой уялдуулан зохицуулах,

-Захиргааны актад гомдол, нэхэмжлэл гаргасан тохиолдолд захиргааны актын эрх зүйн үйлчлэл зогсох эсэх талаар шинээр хуулиар зохицуулах /хойшлуулах үйлчлэл/.

-Хууль бус захиргааны акт болох нь тогтоогдож шүүхээр шийдвэр гарсан тохиолдолд дараа нь нэхэн олговорын зохицуулалтыг нарийвчлах.

---ооо---

## ИРЭЭДҮЙ ХОЙЧИЙН ЭРХ БА ҮНДСЭН ХУУЛЬ



**Отгонтэнгэр Их Сургуулийн Бизнесийн  
эрх зүйн тэнхмийн эрхлэгч, (LL.M)  
Р.Очирбал**

Бид ёнгөрсөн үеийн түүхийн алдаа оноог дэнслэхийн тулд бус харин ирээдүй хойчийн төлөө зөв шийдвэр гаргахын тулд ухаалаг байх ёстой. "Эдүгээг чухалчлан ирээдүйтэй зэгүйчлэх төрийн бодлогын үр дагавар нь ирээдүй хойчид шийдвэрлэх боломжгүй олон асуудлыг бий болгоно" гэгдэг ухамсарлах нь бидний үеийн үүрэг, хариуцлага юм.

Тиймээс ч хүний эрхийн ойлголтын хүрээ хязгаар ирээдүй хойчийн эрхийн агуулгаар улам бүр өргөжих байна. Ирээдүй хойчийн эрх нь төрийн бодлого, шийдвэрийн хууль ёсны эсэхийг шалган тогтоох чухал үзүүлэлтийн нэг болохыг дэлхийн улс орнууд төдийгүй олон улсын түвшинд нийтлэг хүлээн зөвшөөрч байна.

Үйлдвэрлэл, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх Монгол Улсын төрийн бодлого, хувийн секторын идэвхтэй үйл ажиллагаа нь байгаль, экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулж, байгалийн болон соёлын өв уламжлал устан үгүй болох,

орон нутгийн уугул иргэдийн ахуй амьдралын онцлог шинжийг алдагдахад хүргж байгаа тул ирээдүй хойчийн эрхийг хуулычлан хамгаалах зайншгүй шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Иймд ирээдүй хойчийн эрхийг гадаад улс орон олон улсын түвшинд хэрхэн хамгаалсан байдлыг судлан өөрийн улсын энэ талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санаалыг дэвшүүлэх зорилгоор энэхүү сэдэмж бичлэгийг танилцуулж байна.

### **Нэг. Ирээдүй хойчийн эрхийн онолын асуудал:**

Ирээдүй хойчийн эрх гэх ойлголтыг хувь зүйн хувьд хүлээн зөвшөөрөх асуудал онолын хувьд ихээхэн маргаан үүсгэж байжээ. Тэдний эрхийг хүлээн зөвшөөрөх гүй байх томоохон шалтгааны нэг нь futurity problem буюу тэд хүний ертөнцөд хараахан төрж мэндлээгүй явдал юм.<sup>1</sup> Гэсэн хэдий ч хүн төрөлхтэн ирээдүй хойчийн өмнө ёс суртахууны үүрэг, хариуцлага хүлээн ёстай гэсэн үзэл баримтлал өнөөг хүртэл няцаагдаж чадаагүй юм. Бүхий л цаг үед, бүхий л нэхцел байдалд тухайн нийгмийн гишүүд ирээдүй хойчийн төлөө ёс суртахууны үүрэг, хариуцлага хүлээн ёстай гэсэн үзэл санааг эрдэмтэд бүрэн хүлээн зөвшөөрч байна<sup>2</sup>. Английн эрдэмтэн Парфит өөрийн бүтээлдээ "Хэрэв би газар дор хагархайшил булах аваас 100 жилийн дараа миний дээрх үйлдлийн улмаас хойч үеийн хүүхдүүд бэртэх болно" гэсэн оновчтой

<sup>1</sup> Jens Saugstad, Moral responsibility towards future generations of people, Utilitarian and Kantian ethics compared. <http://folk.uio.no/jenssa/Future%20Generations.htm>

<sup>2</sup> Jessica Godofsky, Future generations and the right to survival. A Deontological analysis of the moral obligations of present to future people, TCNJ Journal, Volume XII, April, 2010

зүйрлэлийг бичсэн байна.<sup>3</sup>

Харин хүний байгалийн эрх

/natural right/ болон иргэний эрхийн /civil right/ агууллын ялгаатай байдал нь ирээдүй хойчийн эрхийг тодорхойлох чухал хүчин зүйл болох талаар зарим эрдэмтэд онцлон тэмдэглэжээ. Ардчилсан нийгэмд хүний эрхийн агуултыг тодорхойлох гол онол нь нийгмийн гэрээний онол бөгөөд АНУ-ын эрдэмтэн Мартин Голдинг "Нийгмийн гэрээг иргэд сайн дурын үндсэн дээр хүсэл зоригто илэрхийлэн байгуулдаг. Нэгэнт ирээдүй хойч нийгмийн гэрээний тал бодит утгаараа биш тул нийгмийн бүрэлдэхүүнд хамаарахгүй. Энэ агуулгаараа тэдний хувьд иргэний эрхийн асуудлыг хөндөх боломжгүй. Харин хүний төрөл зүйл болохын хувьд байгалийн буюу жам ёсны эрхийг хангахад тухайн нийгмийн гишүүд ирээдүй хойчийн эмнэ ёс суртахууны уург хүлээх ёстой" гэжээ.<sup>4</sup>

Гадаад улс ортуудын эрх зүйн зохицуулалт, олон улсын гэрээ конвенцийг судлан үзэхэд байгаль орчин, экологийн тэнцвэрт байдлыг хангах болон угуул иргэдийн эрхийг хамгаалах, соёлын эрхийн хүрээнд ирээдүй хойчийн эрхийн агуултыг тодорхойлж байна.

**Хоёр. Ирээдүй хойчийн эрхийн талаарх гадаад улс орнуудын Үндсэн хуулийн зохицуулалт болон олон улсын эрх зүйн зохицуулалт**

Монгол Улсын Үндсэн хуулийн Оршил хэсгийн Монголын ард түмний

Parfit, Derek (1984). *Reasons and Persons*. Oxford: Clarendon Press. p 356 Jens Saugstad, Moral responsibility towards future generations of people: Utilitarian and Kantian ethics compared. <http://folk.uvu.no/jensa/Future%20Generations.htm>

Jessica Godofsky, Future generations and the right to survival: A Deontological analysis of the moral obligations of present to future people. TCNJ Journal, Volume XII, April 2010

Parfit, Derek (1984), *Reasons and Persons*. Oxford: Clarendon Press. p 356

\* Martin Golding (1972). Limited Obligation to Future Generations. p 357-360

эрхэм зорилгыг тодорхойлсон хэсгээс ирээдүй хойчийн эрхийн талаарх зарим утyg тайлбарлан гаргах боломжтой. Харин ирээдүй хойчийн эрхийг хууль зүйн хувьд тухайлан баталгаажуулсан заалт Үндсэн хуульд хараахан байхгүй байна.

Ирээдүй хойчийн эрхийг хууль зүйн хувьд баталгаажуулажгүйгээр тэдний эрхийг бодитоор хангаж, хамгаалах боломжгүй тул дэлхийн зарим улс орнууд өөрийн Үндсэн хуульд холбогдох зохицуулалтыг бэхжүүлсэн байна. Тухайлбал:

- 2011 онд шинэчлэн батлагдсан Бүгд Найрамдах Унгар Улсын Үндсэн хуулийн Оршил хэсэгт: "Бид өөрсдийн өв уламжлал, дахин давтагдашгүй хэл, соёл, үндэстний амьдралын ахуй соёл, хүний гараар бүтээгдсэн болон бүтээгдэгүй байгалийн баялгаа хадгалан, хамгаална. Бид өөрсдийн үеийн үүрэг хариуцлагаяа ухамсарлан материалыг баялаг, оюуны болон байгалийн баялгаа арвилан хэмнэж, ирээдүй хойч үеийн амьдралын нөхцөлийг хамгаалах... зорилгын хүрээнд шинэ мянганыг эхлүүлж байна."

- АНУ-ын Пенниселвани мужийн Үндсэн хуулийн 27.1-д: "Хүн бүр цэвэр агаараар амьсгалах, цэнгэг ус уух, байгаль, шинжлэх ухаан, түүхийн болон хүрээлэн байгаа орчны үнэт зүйлсийг хадгалан авч үлдэх эрхтэй. Пенниселванийн байгалийн баялаг бүхий л хүний, түүнчлэн ирээдүй хойч үеийн нийтийн эмч байна. Эдгээр эмчийг итгэмжлэн хариуцсан этгээд нь бүхий л хүн үр ашигийг хүртэх боломжтой байдлаар хадгалж, хамгаална."<sup>5</sup>

- Швед Улсын Үндсэн хуулийн 2 дугаар зүйлд: "Нийтийн институт /Public Institutions/ нь өнөө болон ирээдүй хойчид үр ашигтай байх хүрээлэн бий орчныг хангах зорилтын хүрээнд тогтвортой хөгжлийг дэмжин ажиллах

\* The Widener School of Law's Environmental and Natural Resources Law Clinic, A Citizen's Guide to Article 1.527 of the Pennsylvania Constitution, 2010

үүрэгтэй.”<sup>6</sup>

- Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын Үндсэн хуулийн 24 дүгээр зүйлд: “Хүн бүр өнөө үеийн болон ирээдүй хойчид үр ашигтай байгаль орчны тааламжтай нөхцөлөөр хангагдах эрхтэй. Агаарын бохирдол, экологийн доройтлоос урьдчилан сэргийлэх, байгаль орчны хамгаалах, экологийн тогтвортой хөгжлийн хангах, эдийн засаг болон нийгмийн зүй ёсны хөгжлийг хангах зорилтуулэн байгалийн баялгийг ашиглана.”<sup>7</sup>

- Бүгд Найрамдах Чех Улсын Үндсэн эрх, Эрх чөлөөний Хартийн Оршил хэсэгт: “Хүний жам ёсны эрх, иргзний эрхийн халдашгүй байдлыг хангах, эрхзүйн ноёрхлыг бэхжүүлэх,.. ирээдүй хойчийн амьдралын хувь заняны төлөөх үүрэг хариуцлагыг ухамсарлан... Чех болон Словак Үндэсний зөвлөлөөс Үндсэн эрх, эрх чөлөөний Хартийг батлав”<sup>8</sup> хэмээн тунхаглажээ.

- Бельгий Улсын Үндсэн хуулийн 7 дугаар зүйлд: “Холбооны улс, бүлэг, засаг захиргааны нэгжээс хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өнөө болон ирээдүй хойчийн нэгдмэл сонирхлыг харгалzan нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжлийн хангана.”<sup>9</sup>

- Андорра Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт: “Андоррагийн ард түмэн бүрэн эрхт, бие даасан байдлаар өөрдийн тусгаар тогтолцоо хэрэгжүүлнэ. Ард түмний хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг нээгчдээс хүн төрөлхтөний нийтлэг эрх ашиг, дэлхий өртөнцийн нэгдмэл байдлыг хангах, ирээдүй хойчийн

амьдрах орчинд тохиорохуйц байдлаар байгаль орчныг хамгаалах... зорилгоор Үндсэн хуулийг баталж байна.”<sup>10</sup>

- Бүгд Найрамдах Аргентин Улсын Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлд: “Иргэн бүр хүн хөгжих таатай нөхцөл бүхий зруул, тэнцвэртэй байгаль орчинд амьдрах эрхтэй бөгөөд ирээдүй хойчид хохиролгүй байдлаар өнөөгийн хэрэгцээгээ ханганд үйл ажиллагаа явуулна.”<sup>11</sup>

- Болив Улсын Үндсэн хуулийн 9-д: “Төрийн үндсэн зорилго, чиг үүрэг нь Байгалийн баялгийг төлөвлөгөөтэй ашиглах, хариуцлагыг баталгаажуулах, хөгжил болон үр дүнд тулгуурласан аж үйлдвэржилтийг урамшуулах, өнөө үе болон ирээдүй хойчийн сайн сайхан тусын тулд байгаль орчныг хадгалан авч үлдэнэ.”<sup>12</sup>

- Бутаны Вант Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд: “Өнөө болон ирээдүй хойчид үр ашгаа өгөх хаант улсын байгалийн баялаг, хүрээлэн байгаа орчны өмчлөг нь нь бүхий л Бутанчууд байгаа”<sup>13</sup> хэмээн тус тус зохицуулжээ.

Дээрх улс орнуудад ирээдүй хойчийн эрхийг Үндсэн хуулийн түвшинд хулээн зөвшөөрч, эрх зүйн хэм хэмжээгээр баталгаажуулсанар териин бодлого, шийдвэр, үйл ажиллагаа ирээдүй хойчийн эрхийн талаарх Үндсэн хуулийн зохицуулалтыг зөрчсөн гэх үндэслэлээр иргэд шүүхэд загаа маргаан өдүүлэх, шаардах эрхээ хэрэгжүүлэх өргөн эрх, боломжийг олж авах давуу талтай юм. Өөрөөр хэлбэл, териин эрх бүхий байгууллага, албан тушаалтын эсрэг Үндсэн хуулийн түвшний маргаан үүсгэх боломжийг ард түмэнд олгосноор Үндсэн хуулийн шүүхээс Үндсэн хуулиар хамгаалагдсан

<sup>6</sup> Constitution of Sweden, 1975 <http://www.wipo.int/wipolex/en/details.jsp?id=11805>

<sup>7</sup> Constitution of the Republic of South Africa, 1996 <http://www.thehda.co.za/uploads/images/unpan005172.pdf>

<sup>8</sup> Charter of Fundamental Rights and Freedoms as component part of constitutional order of the Czech Republic, Nr. 162/1998 Coll.

<sup>9</sup> The Constitution of Belgium, 14 February 1994, <http://home.scarlet.be/dirkvanheule/comdocs/ConstitutionBelgium/ConstitutionBelgium.htm>

<sup>10</sup> Constitution of the Principality of Andorra. 02 February 1993

<sup>11</sup> Constitution of the Argentine Nation. [www.wipo.int](http://www.wipo.int)

<sup>12</sup> Bolivia (Plurinational State of)’s Constitution, 2009

<sup>13</sup> The Constitution of the Kingdom of Bhutan, 18 July 2008 [www.wipo.int](http://www.wipo.int)

ирээдүй хойчийн эрхийг хамгаалах боломжтой болно.

Гэхдээ ирээдүй хойчийн эрхийг Үндсэн хуулийн түвшинд хамгаалаад зогсохгүй тэдний эрхийг хангаж, хамгаалах механизмыг бурдуулэх нь ихээхэн чухал юм. Ирээдүй хойчийн эрхийг хамгаалах зорилгоор парламентын болон парламентын бус тусгай хороо, комисс байгуулах, омбудсман томилох гэх зэрэгзэр ирээдүй хойчийн эрхийг хамгаалах механизмуудыг улс орнууд өөрийн онцлогт тохируулан бурдуулсан байна. Тухайлбал: Бразил, Чили, Финланд, ХБНГУ зэрэг улсад парламентын хороо, Израйл, Шинэ Зеланд, Канад зэрэг улсад тусгай комиссар ирээдүй хойчийн эрхийг хамгаалах чиглэлээр байгуулагдсан байна. Зарим улс орнуудын туршлагаас дурдвал:

- Бразил Улсад 2004 онд Байгаль орчин, тогтвортой хөгжлийн парламентын комиссийн байгуулагдсан байна. Уг комисс нь байнгын ажиллагаатай бөгөө, байгаль орчин, тогтвортой хөгжлийн талаарх хууль тогтоомжийн санал боловсруулах, хяналт тавих, уг асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэг, мэтгэлцэн, семинар зохион байгуулах, байгаль орчин, тогтвортой хөгжлийн талаар Засгийн газраас гарсан шийдвэр болон хязгаарлалтын зэрэг иргэдийн едуулсан өргөдөл, гомдлыг хүлээн авах, байгаль орчны хууль тогтоомжийн талаар санал, дүгнэлт гаргах эрхтэй байна.

- Финланд Улсад 2000 оноос эхлэн Ирээдүйн төлөө хороо гэх байнгын ажиллагаатай парламентын хороо байгуулагдсан байна. Уг байнгын хороо байгуулагдааас өмнө байнгын бус ажиллагаатай хороо 1990-ээд оноос эхлэн үйл ажиллагаа явуулж байжээ. Ирээдүй болон ирээдүй хойчийн асуудал нь төрийн байгууллагуудын бодлого, үйл ажиллагаанаас зарим тохиолдолд гадуур хамгаалалтгүй байдаг нь уг хороог байгуулах гол

шалтгаан болсон байна.<sup>14</sup> Тус хороо нь улс төрийн янз бүрийн намын төлөөлөл бүхий 17 парламентын гишүүнүүн бүрэлдэхүүнтэй бөгөөд хамаарах асуудлын хүрээнд парламентын шийдвэр боловсруулах, холбогдох асуулт, асуулгад парламентын байр суурийг тодорхойлох, хөгжлийн загвар боловсруулах, судалгаа хийг гэх зэрэг бүрэн эрхтэй. Ирээдүйн хороо нь байгаль орчин, эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт, шинжлэх ухаан, технологи зэрэг өөрийн үйл ажиллагааны салбараар судалгааны тайлланг тогтмол гаргадаг. 1993 онд "Урт хугацааны ирээдүй", 1996 онд "Финланд болон Европын ирээдүй", 1997 онд "Үнэнч байдал болон Эр зориг-Хариуцлагатай, итгэл даахийц Финланд", 2001 онд "Тэнцвэртэй хөгжил-2015", 2004 онд "Бүх наасны иргэдэд эзлтэй нийгэм", 2009 онд "Хорт хийг багасгахын төлөөх Финланд", 2013 онд "Нийгмийн халамжийн тогтвортой хөгжил" зэрэг нийт 7 тайлланг боловсруулаад байна.<sup>15</sup>

- ХБНГУ нь 2001 онд Тогтвортой хөгжлийн парламентын байнгын хороог байгуулж байсан бол 2006 онд Тогтвортой хөгжлийн асуудлаарх парламентын зөвлөлийг байгуулсан байна. Улс төрийн намуудын төлөөлөл болох 17 гишүүнээс бүрдэх уг зөвлөл нь "Өнөөдөрийн төлөө маргаашийг золиосолж болохгүй" гэсэн үндсэн зарчмын хүрээнд тогтвортой хөгжлийг хангах замаар өнөө үеийнхийн ирээдүй хойчийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагыг сайжруулах зорилготой. Уг зөвлөл нь дараах түвшинд үйл ажиллагаагаа явуулдаг. Үүнд: 1) Холбооны Засгийн газрын Үндэсний тогтвортой хөгжлийн стратегид мониторинг хийх, дэмжлэг үзүүлэх, 2) Европын тогтвортой хөгжлийн стратеги буюу Европын түвшин дэх Холбооны Засгийн газрын тогтвортой хөгжлийн бодлогод мониторинг хийх, дэмжлэг үзүүлэх.

<sup>14</sup> Paula Tiihonen, Committee for the Future – A new institution to discuss the future in Finland.

<sup>15</sup> <http://web.eduskunta.fi>

3) Нэгдсэн Үндэстний байгууллагын түвшний Холбооны Засгийн газрын тогтвортой хөгжлийн бодлогод мониторинг хийх, дэмжлэг үзүүлэх зэрэг болно.<sup>16</sup> Түүнчлэн тогтвортой хөгжлийн бодлогын асуудлаар холбооны улсын бусад байгууллагын үйл ажиллагаанд мониторинг хийх, дэмжлэг үзүүлэх, хэлэлцүүлэг өрнүүлэх, хянан шалгах, үнэлэх гэх зэрэг харьцангуй өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг байна.

- Шинэ Зеланд Улсад Байгаль орчны асуудлаарх парламентын тусгай комиссар ирээдүй хойчийн ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй байна. 1986 онд батлагдсан Байгаль орчны тухай хуулиар Байгаль орчны чиглэлээр хараат бус, бие даасан омбудсман буюу комиссарыг бий болгосон нь дэлхийн улс орнуудад тэргүүлэх туршлагад тооцогддог. Комиссар 5 жилийн хугацаатай томилогддог бөгөөд түүний чиг үүрэг нь: 1) Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын байгууллагын үйл ажиллагааг хянах, үр дүнг төлөөлөгчдийн танхимд тайлгаха, 2) Нийтийн эрх мэдлийн байгууллагын байгаль орчны асуудлаарх төлвлөлт, мөнөжмент үр дүнгүй байгаа зэсхийг мөрдэн шалгах, үйл ажиллагааны дутагдлыг хэрхэн засварлах талаар зөвлөгөө өгөх, 3) Байгаль орчинд хохирол учирсан, эсхүл учирч болзошгүй байдлыг мөрдэн шалгах, урьдчилан сэргийлэх болон нөхөн сэргээх асуудлын талаар зөвлөгөө өгөх, үр дүнгийн талаар Төлөөлөгчдийн танхимд тайлгаха, 4) Төлөөлөгчдийн танхим, байнгын хорооны хүсэлт, бусад өргөдлийн дагуу холбогдох хууль болон байгаль орчны асуудлаар тайлан боловсруулах, 5) Төлөөлөгчдийн танхимиын чиглэмжийн дагуу байгаль орчинд хохирол учирсан, эсхүл учирч болзошгүй байдлыг мөрдэн шалгах 6)

<sup>16</sup> Motion 18/559: Establishment of the Parliamentary Advisory Council on Sustainable Development. [www.bundestag.de](http://www.bundestag.de)

Байгаль орчны талаарх мэдээллийг нэгтгэх, олон нийтэд түгээх, 7) Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих гэх зэрэг болно.<sup>17</sup>

- Унгар Улсад 2008 онос эхлэн Ирээдүй хойчийн асуудлаарх парламентын тусгай комиссар / Parliamentary Commissioner for Future Generations/ үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Green Ombudsman хэмээн нэрлэх энэхүү комиссарын зэрэгцээ Иргэний эрхийн комиссар, Үндэсний болон үндэсний цөөнхийн эрхийн комиссар, Хүний үндсэн эрхийн комиссар зэрэг тусгай комиссарууд ажилладаг. Байгаль орчин болон өнөө үе, ирээдүй хойчийн эрх ашигийг хамгаалах зорилгын хүрээнд байгуулгадсан Ирээдүй хойчийн комиссар нь эрхлэх асуудлын хүрээнд хууль тогтоох байгууллагад зөвлөмж, зөвлөгөө өгөх, байгаль орчны талаарх хууль болон бодловын баримт бичиг боловсруулахад оропцох, санал дүгнэлт гаряах, ирээдүй хойчийн эрх зөрчигдсөн асуудлаар Үндсэн хуулийн шүүх болон ердийн шүүхэд зарга мэдүүлэх гэх зэрэг харьцангуй өргөн эрх мэдэлтэй. Хэдийгээр заавал үйлчлэх шийдвэр гаргах эрхгүй боловч байгаль орчны маргаантай асуудлыг шийдвэрлэх хувилбар санал болгох зэрэгээр төрийн байгууллага, иргэний нийтэй, төрийн бус байгууллагад дэмжлэг үзүүлэн ажилладаг. Сургалт, семинар зохион байгуулах, байгаль орчны асуудлаар гаргасан өргөдлийг хүлээн авч холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтэд дун шинжилгээ хийх, олон улсын эрх зүйн хэм хэмжээг үндэсний хууль тогтоомж, орон нутгийн байгууллагын шийдвэрт тусгуулах талаар нөлөөлөх зэрэг эрх мэдлийг хэрэгжүүлнэ. 2012 онд тус улс Үндсэн хуулиа шинэчлэн боловсруулахдаа ирээдүй хойчийн эрхийг өргөн хүрээнд хамгаалах зорилгын хүрээнд маш

<sup>17</sup> Environment Act 1986, No127, article 16 <http://www.legislation.govt.nz/act/public/1986/0127/latest/DLM98975.html>

тодорхой зохицуулалтуудыг Үндсэн хуульдаа бэхжүүлсэн байна. Энэ нь ирээдүй хойчийн комисар байгаль орчин, соёл, өв хөрөнгө болон амьтны төрөл зүйлийг хамгаалах зэрэг өргөн хүрээнд ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн нь бусад улс орны зохицуулалтаас эрс ялгадах онцлог болж байна.<sup>18</sup>

Ирээдүй хойчийн эрхийг эрх зүйн түвшинд бэхжүүлэх, хамгаалах хүчин чармайлт олон улсын түвшинд хурдаатай өсөж байна. Энэ чиглэлд Нэгдсэн Үндэстний байгууллага, түүний төрөлжсөн байгууллагууд тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг. НҮБ-ын дурмийн оршил хэсэгт “НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ УЛС ТҮМЭН БИД. бидний үед хүн төрөлхтөнд хоёр удаа өгүүлшгүй гай зөвлөгөөн чуруулсан дайны гамшигаас хойч үеийнхийн ангижруулах, хүний үндсэн эрх, хувь хүний нэр төр, үнэ цэнд итгэх итгэл болон эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд түүнчлэн том, жижиг үндэстэн адил тээги эрхтэй хэмээх итгэлийг дахин сэргээх, илүү эрх чөлөөтэй байдалд нь йогийн дэвшлийг урагшлуулах, амьсгалын түвшинг сайжруулахад тус дөхөм үзүүлэх зорилгоор...”Нэгдсэн Үндэстэн” гэдэг нэр бүхий олон улсын байгууллагыг үүссээр үүссэн байгуулав” хэмээн зааснаас үзэхдээ ирээдүй хойчийн эрхийг хамгаалах зорилт нь НҮБ-ын үйл ажиллагааны салшгүй хэсэг байна.

НҮБ-аас баталсан хүний эрхийн суурь баримт бичиг болох Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эдийн засаг нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад ирээдүй хойчийн эрхийг тусгайлан хамгаалсан заалт байхгүй хэдий ч энэ чиглэлийн хариццааг зохицуулахад үндсэн эх сурвалж болж байна.

**Харин ирээдүй хойчийн эрхийг олон улсын түвшинд хамгаалах**

- *Marcel Szabó Deputy-Commissioner for Fundamental Right. The Way Forward: Protecting Future Generations through the Institution of Green Ombudsman, 24 April 2013, [www.futurejustice.org](http://www.futurejustice.org)*

асуудлыг чухалчилсны үр дүнд хэд хэдэн бодлогын баримт бичиг, гэрээ, конвенц батлагдсан байна. Тухайлбал: Соёлын болон байгалийн өвийн аль нэг хэсэг доройтох буюу устах угүй болох нь дэлхийн улс гүрнүүдийн өвийг үгүйрүүлэх аюултай байгаа тул байгалийн болон соёлын өвийг хүлээн авах, хүртэх, үнзлэх талаарх ирээдүй хойчийн эрхийг хангаж, хамгаалах зорилгоор НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллагын 17 дахь удаагийн бага хурлаас “Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах конвенц”-ийг 1972 онд баталсан байна. Түүнчлэн Хүн, байгалийн орчны талаарх 1972 оны Стокгольмын тунхаглал, Биологийн төрөл зүйлийн тухай конвенц (1992), Ур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын ерөнхий конвенц (1992), Ур амьсгалын өөрчлөлтийн тухай Ерөнхий конвенцийн Киотогийн протокол (1997), Угуул нутгийн ард иргэдийн эрхийн тунхаглал (2007) гэх зэрэг гэрээ, Конвенциудыг олноор дурдаж болно.

НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллагын 29 дэх удаагийн бага хурлаас 1997 оны 11 дүгээр сарын 12-нд баталсан “Өнөө үеийнхийн ирээдүй хойчийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагын тунхаглал”<sup>19</sup> нь ирээдүй хойчийн эрхийг хамгаалах тулгуур баримт бичигт зүй ёсоор тооцогдож байна. Уг тунхаглал нь дараах агуулга бүхий нийт 11 зүйлээс бүрддэг. Эдгээрт:

- Нэгдгээр зүйл: Өнөө үеийнхэн нь өнөө болон ирээдүй хойчийн олон талт ашиг сонирхол болон хэрэгцээг хамгаалах, хангах үүрэг хүлээн.

- Хоёрдугаар зүйл: Өнөө үеийнхэн болон ирээдүй хойчийн хүний эрх, үндсэн эрх чөлөөнд зохих анхаарлаа хандуулж, улс төр, эдийн засаг болон нийгмийн эрхийг хангуулах

- Declaration on the Responsibilities of the Present Generations towards Future Generations, adopted on 12 1997 by the General Conference of UNESCO at its 29<sup>th</sup> session

олон талт сонголттой байж соёлын болон шашны онцлогийг ирээдүйд хадгалах боломжийг олгоно.

- Гуравдугаар зүйл: Өнөө үеийнхэн нь хүний нэр тэр, алдар хүндийг зохих ёсоор хүндэтгэж хүн төрөлхтөнийг үеийн үед оршин тогтох нөхцлийг бурдуулнэ. Иймээс хүний амь нас, амьдрах эрхийн аливаа халдлагаас ангид байна.

- Дөрөвдүгээр зүйл: Өнөө үеийнхэн нь ирээдүй хойчдоо хүний үйл ажиллагааны үр дүнд бий болсон нөхөж баршгүй хохирол учруулсан дэлхийг хүлээлгэж өгч болохгүй. Ирээдүй үедээ дэлхийг өв залгамжуулахдаа үе болгон дэлхийн ашигт малтмал, экосистемийн хортой өөрчлөлтөөс хамгаална. Шинжлэх ухаан болон техникийн хөгжлийг ухамсартайгаар ашиглана. Дэлхийд хор уршиг учруулж болохгүй.

- Тавдугаар зүйл: Ирээдүй хойчид дэлхийн экосистемийн баялгийг ашиглах боломжийг бурдуулэхийн тулд өнөө үеийнхэн нь тогтвортой хөгжлийг эрхэмлэсэн дэлхийд амьдрах, оршин тогтох нөхцлийг бурдуулж байгаль орчны чанар бүрэн бүтэн байдлыг хангана. Өнөө үеийнхэн нь дэхийн байгаль орчны бохирдолоos хамгаалах, ирээдүй хойчийн зруул, эсэн мэнд орших байдалд аюул учруулах аливаа үйлдлээс татгалзана. Өнөө үеийнхэн нь хүний амьдрал, хөгжлийг тэтгэхэд шаардлагатай ашигт малтмалыг ирээдүй үедээ хадгалах ёстой. Өнөө үеийнхэн нь том хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ цаашид учирч болох эрсдэлийг тооцно.

- Зургадугаар зүйл: Хүний нэр төрийг хүндлэх үндсэн дээр хүний генийг хамгаалж, биологийн онцлогийг харгалzan үзнэ. Шинжлэх ухаан, техникийн хөгжил нь хүн төрөлхтэн болон байгалийн төрөл зүйлд хор уршиг, нөхөгдөшгүй хохирол учруулж болохгүй.

- Долдугаар зүйл: Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн өнөө үе нь ирээдүй хойчийн соёлын онцлогийг хадгалана. Өнөө үеийнхэн нь бичмэл болон бичмэл бус соёлын өвийг хадгалах, хамгаалах, хойч үедээ залгамжуулах үүрэгтэй.

- Наймдугаар зүйл: Өнөө үеийнхэн ирээдүй хойчийн нийтлэг өвийг олон улсын эрхийн дагуу бусадад хор уршиг учруулахгүй нөхцөлд ашиглах боломжтой.

- Есдүгээр зүйл: Өнөө үеийнхэн нь ирээдүй хойчдоо углэр жишээ болж ирээдүй хойч биднээс суралцах боломжийг бурдуулэн, энх тайванаар орших, олон улсын эрх зүйн хүрээнд хүний эрх, эрх чөлөөг хамгаална. Өнөө үеийнхэн ирээдүй хойчид нүүрлэж болох дайны гамшигаас сэргийлнэ. Үүний тулд зэвсэгт мөргөлдөөн болон бусад түрэмгийллийн хэлбэрээс зайлсхийн зэвсгийг хүмүүнлэг зарчмын эсрэг хэрэглэж болохгүй.

- Аравдугаар зүйл: Өнөө үеийнхэн нь ирээдүй хойчид тогтвортой хөгжил, эдийн засаг, нийгмийн хөгжил, хувь хүн, хамт олны хөгжлийг хослон хөгжүүлэх, ашигт малтмалаа зохистой, үр дүнтэй ашиглаж, ядуураас сэргийлнэ. Боловсрол нь хувь хүн болон нийгмийг хөгжүүлэх чухал хэрэгсэл юм. Боловсрол нь энх тайван, шударга ёс, хамтран ойлголцол, тэгш эрх, өнөө болон ирээдүй үеийн ашиг сонирхлыг харгалзахад ашиглана.

- Арван нэгдүгээр зүйл: Өнөө үеийнхэн нь ялгаварлан гадуурхалтын ямар нэгэн хэлбэрийг ирээдүй хойч үед буй болгох бүхий л үйлдэл болон арга хэмжээнээс татгалзана хэмээн тус тус заажээ.

Дээрх тунхаглалын агуулга, зохицуулалт, үзэл санаа нь ирээдүй хойчийн эрх ашигийг хамгаалах талаарх үндэсний эрх зүйн зохицуулалтыг боловсруулахад улс орнуудад жишиг хандлага болж байна.

Нэгдсэн Үндэстний байгууллагаас гадна бусад хүний эрхийн олон улсын байгууллагууд ирээдүй хойчийн эрхийг хамгаалах ўлсэд хүчин чармайлт гарган ажиллаж байгааг бид дутуу үнэлж болохгүй. Тухайлбал:

- Эх дэлхийн ирээдүйн төлөө зөвлөл /The World Future Council/ нь дэлхийн хөгжил, өөрчлөлтөд чухал хувь нэмэр оруулсан таван тивийн улс төрчид болон иргэний нийгмийн байгууллага, урлаг болон бизнесийн 50 төлөөлгөөс бүрдсэн олон улсын түвшинд ўл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага бөгөөд ХБНГУ-ын хуулийн дагуу ўл ажиллагаа явуулдаг. Цаг уур болон эрчим хүч, Тогтвортой Экосистем, Тогтвортой эдийн засаг, Ирээдүй ба шударга ёс, Энхтайван болон зэвсэглэлээс ангид нийгэм гэх зэрэг үндсэн таван чиглэлээр ўл ажиллагаа явуулдаг. Ўл ажиллагааны хүрээнд олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, бодлогын судалгаа шинжилгэх хийх, арга зүйн зөвлөгөө өгөх, сург ult, сурталчилгаа явуулах, нөлөөллийн чанартай ўл ажиллагааг олноор хэрэгжүүлдэг нь дэлхийн улс орнуудын түвшинд зохиц үр дүнгээ өгөөд байна. Тухайлбал: Сэргээгдэх эрчим хүчний үр дүнтэй тогтолцоог бий болгох замаар байгаль орчин, эко системийг хамгаалах томоохон арга хэмжээг олон улсын хэмжээнд зохион байгуулсны үр дүнд сэргээгдэх эрчим хүчний талаарх олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлж, эрчим хүчиний тариифын талаарх эрх зүйн зохицуулалтыг бий болгох чиглэлээр тэргүүлэн ажиллаж байна. 2013 оны байдлаар 60 гаруй улс оронтой дээрх чиглэлээр хамтран ажиллах, олон улсын бодлого боловсруулах чиглэлээр идэвхтэй ажиллаж байна. Түүнчлэн 2009 онд Сэргээгдэх эрчим хүчиний Африкийн холбоо /African Renewable Energy Alliance/ байгуулсан. Томоохон хотуудын цаг уурын өөрчлөлтийн экспертийн комисс байгуулах, хууль

тогтоогчдод зориулсан тогтвортой хөгжлийн талаар шийдвэр гаргах 7 зарчмыг боловсруулах. Ирээдүй хойчийн хүний эрхийн омбудсмэн болон ирээдүй хойчийн зэрэг гэмт хэргийн талаарх зохицуулалтыг бий болгох, Талхан танк, буу зэвсэглэлийн зэрэг тогтвортой хөгжлийг боловсруулах гэх зэрэг ўл ажиллагаа нь ирээдүй хойчийн эрхийг дэлхийн түвшинд хамгаалах талаарх тус зөвлөлийн санаачлан хэрэгжүүлсэн ажил болно.<sup>20</sup>

- Ирээдүй хойчийн төлөөх змэгтэйчүүдийн конгресс /Women's Congress for future Generations/ хэмээх төрийн бус байгууллага 2012 онд АНУ-ын Юта муржийн Маоб хотод байгуулгасан бөгөөд ирээдүй хойчийн амьдралын таатай нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө ўл ажиллагаа явуулдаг. Байгуулгадаад удаагүй байгаа хэдийч уг байгууллагаас 2012 онд "Ирээдүй хойчийн эрхийн тунхаглал болон Өнөө үеийн үүрэг хариуцлагын билл" хэмээн баримт бичгийг боловсруулсан байна. Уг баримт бичгийн гол зорилго нь эрүүл, хүмүүнлэг, үзэсгэлэнт эх дэлхийг ирээдүй хойчид өвлүүлэн үлдээх явдал бөгөөд 1) цэвэр, эрүүл байгаль орчны талаарх хувь хүн, бүлэг, ирээдүй хойчийн эрх, 2) Байгаль орчноо хадгалан үлдэх эрх 3) өөрийгөө төлөөлөх, тодорхойлох эрх, 4) нутаг орноо эцэг өвгөдөөс өвлүүлэн үлдээсэн төрөлх чанаараар нь хадгалан авч үлдэх эрх, 5) Тогтвортой эдийн засаг бүхий байгаль орчны эрх, 6) Энх тайвнаар амьдралын үлдээх эрхийг тунхагласан байна. Харин 1) Эх дэлхийн тогтолцоо, хүн төрөлхтөнийн амьдралыг нэр төртэйгээр үргэлжлүүлэх, 2) ирээдүй хойчийг хамгаалах ўл ажиллагаа явуулах, 3) эдийн засаг, засаглал болон нийгмийн зохицтой тогтолцоог бий болгох, 4) хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, 5) угуул нутгийн иргэдийн дуу хоолойг сонсох, 6) Байгаль орчин, экзологиян тэнцвэрт байдлын хангах, 7) алдаа-

<sup>20</sup> [www.worldfuturecouncil.org](http://www.worldfuturecouncil.org)

-гаа хүлээн зөвшөөрч, засварлах, 8) ирээдүй хойчийн эрхийг хүндэтгэх гэх зэрэг өнөө үеийнхний хүлээх үүрэг. Хариуцлагыг тунхагласан байна.<sup>21</sup>

Эмэгтэйчүүдийн конгресс 2014 онд "Ирээдүй хойчийн усны эрх ба өнөө үеийнхний үүрэг" хэмээх тунхаглалыг гаргажээ.

- Ирээдүй хойчийн эрхийн төлөө сан: Европын их, дээд сургуулийн оюутан залуусын санаачилгаар ХБНГУ-д 1996 онд байгуулжсан уг байгууллага нь ирээдүй хойчийн эрхийг хамгаалах, ялангуяа эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, чуулга уулзалт зохион байгуулах чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага юм. Уг сангийн санаачилгаар "Хүн төрөлхтний үе хоорондын шинэ гэрээ", "Тогтвортой бодлогын шалгур", "Үндсэн хуулийн 50 жилийн ой: юу үлдэв, ирээдүй хэрхэх вэ?", "Хүн төрөлхтний ирээдүй", "Ирээдүй хойчийн эрх", "Хүн төрөлхтний үе хоорондын шударга ёс" гэх зэрэг олон улсын семпозиум зохион байгуулсан байна.<sup>22</sup>

Ирээдүй хойчийн эрх ба Монгол Улсын өнөөгийн байдал:

Дэлхийн улс орнуудад хандлага болон хүлээн зөвшөөрөгдсөн тогтвортой хөгжлийн үзэл баримтлал манай улсад бодлогын түвшинд нэвтрээд нэлээдгүй олон жил болсон бөгөөд тодорхой үр дүнд хүрсэн хэмээн дүгнэдэг.

Монгол Улс тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөрийг 1994-1998 онд боловсруулж Монгол Улсын Засгийн газраас 1998 оны 5 дугаар сард баталсан. Түүний залгамж болгон "Мянганы хөгжлийн зорилтод суурилсан

<sup>21</sup> A Declaration of Rights for Future Generations, and a Bill of Responsibilities for those Present, 2012

<sup>22</sup> [www.intergenerationaljustice.org](http://www.intergenerationaljustice.org)

Үндэсний хөгжлийн цогц бодлого"-ыг 2008 онд батлан хэрэгжүүлж байна.<sup>23</sup> Дээрх бодлогын баримт бичиг болон түүнтэй уялдан гарсан бусад баримт бичиг нь Монгол Улсын ирээдүй хойчийн эрхийг хамгаалахад чухал ач холбогдолтой нь гарцаагүй. Харин дээрх бодлогын баримт бичигт ирээдүй хойчийн эрх хийгээд өнөө үеийнхэн ирээдүй хойчийн өмнө ямар үүрэг, хариуцлага хүлээх талаарх шууд, ойлгомжтой бөгөөд тодорхой илэрхийлэгдсэн бодлого байхгүй байна.

Ирээдүй хойчийн эрх чухалчлан яригддаг салбарын хууль тогтоомж тухайлбал, Газрын тухай хууль, Газрын хэвлэлийн тухай хууль, Газрын тосны тухай хууль, Концессийн тухай хууль, Ойн тухай хууль, Усны тухай хууль, Агаарын тухай хууль, Амьтны тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд ирээдүй хойчийн эрхийг хамгаалах талааф шууд, ойлгомжтой бөгөөд тодорхой илэрхийлэгдсэн зохицуулалт байхгүй байна.

Харин Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 1 дүгээр зүйлд: "Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл мэнд, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүй үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялагийг зохицстай ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино" хэмээн заасан бол Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Төсвийн удирдлагыг хэрэгжүүлээд Үндэсний баялагийг хүн ам, нийгмийн бүлэг болон өнөө ба хойч үеийнхэнд

<sup>23</sup> Эрхэлсэн зохицчийн профессор, доктор Б.Хүндрэж, Монголын тогтвортой хөгжлийн хөтөлбөр: Ажыц, дэвшил, бэрхшээл, хэтийн зорилго. Үлаанбаатар хот. 2012 он.

шударга, тэнцвэртэй хуваарилах зарчмыг баримтална" хэмээн заасан нь ирээдүй хойчийн эрхийг эрх зүйн хувьд бэхжүүлсэн шууд агуулга бүхий дэвшилттэй заалт болно.

### Дүгнэлт, санал

"Хүний нийгэм оршин байгаа үед хүний эрх, эрх чөлөө хэмээх ойлголт ёне мөнхөд байх болно. Харин хүний эрхийг хамгаалах ойлголт нь ёнөө цагт амьдарч байгаа хүн бурийн эрхийг хамгаалах агуулгаас илүү өргөн хүрээтэй бөгөөд хүн төрөлхтний ирээдүй хойчийн эрхийг хамгаалах утгыг илэрхийлнэ" гэсэн хандлага дэлхийн улс орнуудад хурдаатай түрж байна. Эдгээг чухалчлан ирээдүйг зэгүйчлэх төрийн бодлого, бизнесийн байгууллагын үйлдлийн хорт уршгаар байгаль, экологийн сүйрэл газар авч, байгалийн болон соёлын өв уламжлал угийрэн цөврө, ахуй амьдралын болон соёлын онцлог, ялгаа бүхий байдал хумиджад байна. Иймээс улс үндэстэн, олон улсын байгууллагын түвшинд ирээдүй хойчийн : рхэд түшиглэсэн ёнөө үеийнхний үүрэг, хариуцлагын асуудлыг хөндөж, зохих амжилтад хүрчээ.

Ирээдүйг үүгүйсгэх, ирээдүй хойчийн эрхийг үл хүлээн зөвшөөрөх шууд хандлага байхгүй хэдий ч ирээдүй хойчийн эрх зөрчигдех тохиолдол Монгол Улсад цөөнгүй тохиолдох байна. Иймд манай улсын хувьд дэлхийн улс орнуудын нийтлэг хандлага, олон улсын эрх зүйн зохицуулалтад нийцүүлэн Ирээдүй хойчийн эрхийг Үндсэн хууль болон салбарын хууль тогтоомжийн түвшинд

хүлээн зөвшөөрөх шаардлагатай.

Ирээдүй хойчийн эрхийг Үндсэн хуулийн түвшинд хуульчлан бэхжүүлснээр дараах үр дүнд хүрнэ. Үнд:

- Төрийн байгууллагаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх, хууль тогтоомж, бодлогын баримт бичиг боловсруулахдаа ирээдүй хойчийн эрхийг хүндэтгэн сахих хууль зүйн үргийг хүлээнэ.

- Төрийн байгууллага, албан тушаалтын шийдвэр, үйл ажиллагаа нь Үндсэн хуульд бэхжүүлсэн ирээдүй хойчийн эрхэд үл нийцэн болон зөрчсөн тохиолдолд иргэн Үндсэн хуулийн цэцэд өргөдөл, мэдээлэл гаргах боломж нөхцөл бүрдэнэ.

- Байгаль орчин, эх дэлхийн болон ирээдүй хойчийн эрхэд үндэслэсэн тогтвортой хөгжлийн бодлого батлагдах, хэрэгжих хууль зүйн орчин бүрдэнэ.

- Ирээдүй хойчийн өмнө хүлээн зөвхөн үеийн нийгмийн гишүүдийн үүрэг, хариуцлага нэмэгдэх боломжтой болно.

Түүчилэн ирээдүй хойчийн эрхийг хангаж, хамгаалах чиг үүрэг бүхий төрийн институтыг бий болгож, байгууллага хоорондын үйл ажиллагааг нэгдсэн бодлогоор хангах шаардлагатай. Гадаад улс орнуудын туршлагаас үзэхэд ирээдүй хойчийн эрхийн хамгаалах парламентын байнгын хороо, эсхүл парламентын омбудсмэн буюу тусгай комиссарыг томилон ажиллуулж байна. Энэ талаарх улс орнуудын туршлагыг бодлогын түвшинд судлан, өөрийн улсын онцлогт нийцэн механизмыг бий болгох боломжтой.

## ХӨДӨЛМӨРИЙН ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААН ДАХЬ ХУУЛЬ ЗҮЙН ХАРИУЦЛАГА, ТЭДГЭЭРИЙН ОНЦЛОГ



**МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Иргэний  
эрх зүйн тэнхимийн ахлах багш, Хууль  
зүйн доктор С.Болормаа**

### Цуврал № 1

Нийгмийн харилцаа нь бүхэл бүтэн нэгдэл оршдог бөгөөд үүний зэрэгцээ түүний дотоод хүрээнд илрэх шинж байдлаараа ялгатай, мөн бие биес хамааралтай байдаг билээ. Иймд хөдөлмөрийн сахилгын хариуцлага хэмээх тусгай ойлголтыг авч үзэхийн өмнө “хууль зүйн хариуцлага” хэмээх язгуур ойлголтыг авч үзэх нь зайлшигүй юм. Чухам энэ ойлголтоор дамжин түүний нэг бүрэлдэхүүн болсон “сахилгын хариуцлага”-ын мөн чанар, агуулга, онцлог гарна. Иймд “хууль зүйн хариуцлага” гэсэн суурь ойлголтын талаараа товч авч үзье.

Хууль зүйн хариуцлага, түүний ангилал төрлийн талаар судлаачид олон янзаар тайлбарлан авч үзсэн байдаг. Хууль зүйн ухааны доктор Д.Баярсайхан “Эрх зүйн онол” бүтээлдээ “Хууль зүйн хариуцлага гэдэг нь хууль буюу эрх зүйн хэм хэмжээг зөрчсөний төлөө гэм буруутай этгээдэд эрхийг нь хягаарлах буюу цээрлэл үзүүлэх замаар ёс зүйн болоод эрх зүйн нөлөөлөл үзүүлж буй төрийн болон төрийн бус албадлагын арга хэрэгслэл, тэдгээрийн уялдан холбогдсон систем”<sup>1</sup> юм гэж, хууль зүйн шинжлэх

ухааны доктор О.Амархуу “Хууль зүйн хариуцлага гэдэг нь хууль ёсны албадлагын нэг арга ба хариуцлагыг зөвхөн эрх зүйн зөрчил гаргасан нөхцөлд хэрэглэнэ”<sup>2</sup>, хууль зүйн ухааны доктор профессор Б.Уранцэцэг “Хууль зүйн хариуцлага нь эрх зүйн зөрчилтэй салшгүй хөбөөтой бөгөөд бие биес нөхцөлдүүлсэн ойлголтууд”<sup>3</sup>. хууль зүйн ухааны доктор Ч.Нямсүрэн “Хууль зүйн хариуцлага гэж гэмт халдлагасаа ирэзд байгууллагын аюулгүй байдлыг хамгаалах, гэмт халдлагад өртөгдсөн этгээдийн зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээж хохирлыг арилгах, эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн гэм буруутай этгээдэд ял, зэмлэл хэрэглэх териин албадлагын арга хэмжээ”<sup>4</sup>, хууль зүйн ухааны доктор, профессор Д.Солонго “Нийгмийн хариуцлагын нэг төрөл буюу төр, түүний тод орхой байгууллага, (зөрчил гаргасан этгээдийг опж тогтоо, хариуцаа тооцох эрх бүхий), зөрчил гаргажийн (хууль тогтоомжоор тогтоосон шаардлагыг нь биелүүлсэн, хууль журам зөрчсөнхөө төлөө зохиц цээрлэл, шийтгэл хүлээх үүрэгтэй) хооронд хууль журам зөрчсөний улмаас үүсэх харилцаа<sup>5</sup>, хууль зүйн ухааны доктор С.Цэрэндорж “Төрийн албадлагын арга хэмжээ, шийтгэл цээрпуулэл, эрх зүйн зөрчил үйлдснийх нь төлөө үзүүлэх нөлөөлөл”<sup>6</sup> хэмээн тус тус тодорхойлжээ.

Хууль зүйн хариуцлагын талаар судлаачдын авч үзсэн дээрх ойлголтуудаас үзвэл эрх зүйн хэм

<sup>1</sup> О Амархуу “Эрх зүйн онолын араван таван сэдэв” УБ 2008 он, 103 дахь тал

<sup>2</sup> Б.Уранцэцэг “Ажилтан, албан хаагчид ногдуулах хууль зүйн хариуцлага онол, кууль практик” УБ. 2005 он 14 дахь тал

<sup>3</sup> Ч.Нямсүрэн “Эрх зүйн ерөнхий онол” УБ. 2010 он 394 дахь тал

<sup>4</sup> Д.Солонго “Төрийн эрх зүйн тайлбар толь” УБ 2003 он. 165 дахь тал

<sup>5</sup> Церэндорж Сүрэнгийн “Юридическая ответственность в условиях формирования социалистического правового государства (на опыте СССР и МНР) М. 1989. с 20

<sup>1</sup> Д.Баярсайхан “Эрх зүйн онол” УБ 2010 он 183 дахь тал

хэмжээг зөрчсөний төлөө хүлээлгэж байгаа албадлага гэдэг утгаар нь нийтлэг байдлаар тодорхойлсон байх ба профессор Б.Уранцэцэг хууль зүйн хариуцлагыг эрх зүйн зөрчилтэй салшгүй холбоотой бөгөөд бие биээ нэхцэлдүүлсэн ойлголтууд хэмээн үзсэн нь харилцан бие биедээ хамаарал бүхий үзэгдлүүдийг учир шалтгааны холбоосоор дамжуулан тодорхойлсон хэрэг юм.

Хууль зүйн шинжлэх ухаанд "хариуцлага" гэсэн ойлголт нь агуулгаараа нарийсаж "хууль зүйн" гэсэн тодотголтойгоор, тухайн шинжлэх ухааны судалгааны нэг зүйл, салбар шинжлэх ухаан тус бүр түүний судлах зүйлийн төрлийн онцлогтой холбоотой эрүүгийн, захирагааны гэх мэт төрөл болж нарийсдаг. харин хууль тогтоомжийн хувьд тухайн хууль тогтоомжийн харьяалгдах салбараар тодорхой институт болж зохих хууль тогтоомжид захирагааны хариуцлага, эрүүгийн ял шийтгэл гэх мэт томвёйлгөнд тусгагддаг.

Хууль зүйн хариуцлага нь эрх зүйн зөрчил гаргахгээ өмнө эрх зүйн харилцааны оролцгчдод байсан субъектив үүрэг бус, харин харилцаанд оролцох уедээ зохих журмаар гүйцэтгэх ёстой байсан тодорхой үүргийг биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйнхээ төлөө зөрчил гаргагч этгээдэд хожим нь бий болох нэмэгдэл үүрэг байдлаар илрөч гардаг.

Хууль зүйн хариуцлага нь гэм буруугаас үүдсэн шийтгэл гэж үзвэл энххүүшигтгэлийг хэрэглэсэнээрнийгэмд тэр дундаж эрх зүйн харилцаанд зохих нелөө, зерэг үр дагавар үзүүлдээрээ энххүү хариуцлагын чиг үүрэг илрэдэг.

Хууль зүйн хариуцлага нь нийгэмд эрх зүйн хэм хэмжээ хэвийн хэрэгжих нехцэлийг бурдүүлэх, уг хэм хэмжээг зөрчсөн гэм буруутай этгээдийг цээрлүүлэх, зөрчигдсэн эрхийг сэргээх, хохирлыг нэхэн арилгах, оролцгчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг баталгаажуулах чиг үүргүүдийг агуулдаг. Хууль зүйн хариуцлагын чиг

үргийг эрх зүйн чиг үүрэгтэй зохих уялдаа холбоотой авч үздэг бөгөөд эрх зүйн чиг үүргийг "эрх зүйн нийгмийн зориулалт эсхүл нийгмийн харилцаанд нелөөлөх эрх зүйн нелөөллийн чиглэл"<sup>8</sup> гэж зарим судлаачид үздэг. Хууль зүйн хариуцлага нь нийгэмд тодорхой чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд гол чиг үүрэг нь хамгаалалтын чиг үүрэг билээ. Энэ нь нийтэд ашиг тустай харилцааг бий болгох, дэмжин хангах, харин уршигтай үзэгдэл зуршлыг арилгаж үгүй болгоход чиглэсэн эрх зүйн нелөөллийн чиглэл, зориулалт юм.

Хууль зүйн хариуцлагын тогтолцоо нь нийгэмд эрх зүйн хэм хэмжээ хэвийн хэрэгжих нехцэлийг бурдүүлэх, уг хэм хэмжээг зөрчсөн гэм буруутай этгээдийг цээрлүүлэх, зөрчигдсэн эрхийг сэргээх, хохирлыг нэхэн арилгах, оролцгчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг баталгаажуулах чиг үүргүүдийг агуулж байна<sup>9</sup>.

Хууль зүйн хариуцлагыг эрүүгийн хариуцлага, иргэний хариуцлага, захирагааны хариуцлага гэсэн үндсэн ангилалд авч үздэг бол Японд хариуцлага хэмээн ойлголтыг хууль, эрх зүйн талаас нь 1) Мораль буюу нийгмийн хариуцлага. 2) Иргэний эрх зүйн хариуцлага. 3) Эрүүгийн эрх зүйн хариуцлага хэмээн үздэг байна<sup>9</sup>.

Хөдөлмөрийн эрх зүйн харилцаан дахь хууль зүйн хариуцлагын талаар авч үзэхээс өмнө өмнө дурдсан хууль зүйн хариуцлагын ангилал болох эрүүгийн, иргэний, захирагааны, сахилгын хариуцлагын талаар товч авч үзье.

Судлаачид эрүүгийн хариуцлага бол гэмт хэрэг үйлдсний эрх зүйн үр дагавар яланы хэлбэр бүхий терийн албадлагыг<sup>10</sup> хэмээн үздэг ба орчин үеийн даяаршиж буй өнөөгийн нехцэлд

<sup>8</sup> Общая теория государства и права Академический курс, учебник для вузов. Под ред. М.Н.Марченко, т-2, М:1998, ст.53

<sup>9</sup> Б.Гранцэцэг. Ажилтан, албан хаагчид ногдуулах хууль зүйн хариуцлага: Онол, хууль, практик. УБ:2005 он. 31 дахь тал

<sup>10</sup> [日]佐野真一—蒙古語トボルトビン. 2015 он

<sup>11</sup> С.Нарангарын "Эрх зүйн эх толь бичиг" УБ: 2011 он. 655 дахь тал

зах зээлийн олон талт харилцаа улам бүр гүнзгийрч, гадаад дотоодын хуулийн этгээдийн бизнесийн ашиг сонирхолтой нэвчин нэмэгдэх тусам дэлхий нийтийн болон үндэсний хэмжээнд нэгдмэл стандартыг шинээр бий болгох, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох шаардлага аяндаа бий болж байгаатай холбогдуулан эрүүгийн хариуцлагыг дан танц хувь хүнд биш мөн хуулийн этгээдэд хүлээлгэх асуудал хурцаар тавигдах болсон.

Эдүгээ бизнесийн здийн засгийн харилцаа зах зээлийн агуулгаар баяжин хөгжиж, компани корпорацийн бизнесийн үйл ажиллагаа өргөжих тэлэхийн хэрээр хуулийн этгээдийн эрх зүйн зохицуулалтын хүрээс өргөжин шинэчлэгдсээр байгаа нь<sup>11</sup> орчин үед хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх болон эс хүлээлгэхтэй холбогдсон онолын маргаан нэг улсын хүрээнээс хальж, олон улсын шинжтэй болсон нь дэлхий нийтийн анхаарлыг татах болжээ.

20-р зууны сүүлч үеэс "Corporate criminal Liability, criminal liability of legal person" буюу "Корпорацийн эрүүгийн хариуцлага" гэсэн хууль зүйн шинэ нэр томъёо бий болж, хэрэглэгдэх болсон байна. Хэдийгээр эх газрын эрх зүйн булийн хувьд хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлагын онолыг угүйгэх хандлага давамгайлдаг боловч хуулийн этгээдийн тоо, төрөл эрс нэмэгдэж үйлдвэржилт, үйлчилгээний хөгжлийн хурдаа нь компанийн хариуцлагын улам нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсээр байна. Харин эдүгээ Англи, АНУ, Австрали, Канадад хувь хүн үйлдэх гэмт хөргэс бусад бүхий л гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зарчмын нэгэнт биелэл болж, шүүхийн практикт хэвшин тогтсон байна<sup>12</sup>.

Иргэний эрх зүйн хариуцлага нь учирсан здийн болон здийн бус хохирлыг нөхөн төлүүлэх, үүргийг гүйцэтгүүлэх, анз алданги төлүүлэх гэх мэтэд хөрөнгийн агуулга бүхий

албадлагын хэрэгсэл<sup>13</sup> гэж үздэг байна. Иргэний эрх зүйн хариуцлага нь эд хөрөнгийн шинжтэй буюу здийн засгийн хувьд серег үр дагавар бий болгодог нэвтрэллийн үүргийг хэрэгжүүлдэг, мөн иргэний эрх зүйн харилцаа нь харилцан эрх тэгш талуудын хооронд үүсдэг учраас уг харилцааны нэг тал үүргээ биелүүлэхгүй байснаар нөгөө талын эрх зөрчигдэхэд хүргэдэг, улмаар эрх зөрчигч нь нөгөө этгээдийн өмнө хариуцлага хүлээдэг, зөрчигдсөн эрхийг сэргээхдэг чиглэгдсэн байдгаараа нөхөн сэргээх шинжийг агуулсан зэрэг онцлог шинжтэй байна.

Дээрх шинжүүдээс нь дүгнэн үзвэл иргэний эрх зүйн хариуцлага гэдэг нь иргэний гүйлгээнд хууль зүйн адил тэгш эрхтэй оролцогчдын здийн засгийн хэвийн харилцааг хөхүүлэн дэмжих, тэдний зөрчигдсэн эрхийг нөхөн сэргээхдэг чиглэсэн эд хөрөнгийн шинжтэй санкцийг хэрэглэхтэй холбогдсон төрийн албадлагын "нэг хэлбэр юм.

Хууль болон гэрээнд заасан үүргээ биелүүлээг бий болон зохих ёсоор биелүүлээгүй тохи олдолд иргэний эрх зүйн зөрчилд тоо:ох бөгөөд уг зөрчил гаргасан гэм буруутай этгээдэд эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх ба<sup>14</sup> энэ утгаар нь авч үзвэл эд хөрөнгийн хариуцлагыг иргэний эрх зүйн хариуцлагад хамааруулж болно.

Захиргааны хариуцлага нь эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудаас өөрийн бүрэн эрхийн хүрээнд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд захиргааны хууль тогтоомжийн дагуу хүлээлгэдэг хууль зүйн хариуцлагын бие даасан нэг төрөл юм. Захиргааны хариуцлага нь гүйцэтгэх болон захиргааны эрх мэдлийг хэрэгжүүлэх хүрээнд захиргааны хариуцлага хүлээлгэх эрх бүхий албан тушаалтнаас нийтээр дагаж мөрдөх захиргааны журмыг зөрчсөн гэм буруутай этгээдэд хууль тогтоомжид

<sup>11</sup> Т.Менжжартгал "Монгол БНХАУ-ын Иргэний хуулийн хариуцалсан судалгаа" УБ. 2011 он 99 дахь тал

<sup>12</sup> Д.Баярсайхан "Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага" УБ. 2013 он 42 дахь тал

<sup>13</sup> Д.Наранчимэг "Иргэний эрх зүйн үндэснэ асуудал" УБ. 1999 он, 86 дахь тал

<sup>14</sup> Б.Улаанбаатар Иргэний эрх зүйн Тайлбар толь УБ. 2005 он, 65 дахь тал

заасан захирагааны шийтгэл (санкц) ногдуулах үүргэг (ажиллагаа) мөн<sup>16</sup>.

Хууль зүйн хариуцлагыг уламжлалт байдлаар дээрх ангиллаар авч үздэг бол териин албаны хариулцаанд териин албаны хариуцлага гэсэн ойлголт бий болжээ.

Териин албан хаагчийн эсвэл бусад нийтийн захирагаанд үйлчилж буй этгээдийн эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн буруутай үйл ажиллагааны улмаас үссэн хохирлыг нөхөн барагдуулах үүргийг олон янзаар зохицуулсан ба үүнд териин албан хаагчийн хариуцлага, териин хариуцлага, териин албаны хариуцлага гэсэн хувилбаруудыг ашиглах ба териин албаны хариуцлага гэдэгт териин албан хаагч этгээлсэн ажил үүргээ гүйцэтгэх байхдаа өөрийн буруутай үйл ажиллагаагаар иргээд хохирол учруулсны улмаас үссэн уг хохирлыг арилгах хариуцлагыг<sup>17</sup> хамааруулж үзсэнээрээ онцлогтой юм.

Японд Засгийн газар болон захирагааны байгууллагын хууль зөрчсөн буюу буруутай үйл ажиллагааны улмаас үссэн хохи лыг нөхөн төлөх, эсвэл териин албан аагчийн ёс зүйгүй үйлдэлд ногдуулж буй хариуцлагыг захирагааны хариуцлагад хамааруулдаг ба түүнчлэн үүнээс гадна захирагааны ажилтан болон байгууллагын эс үйлдэхүйн хариуцлага хэмээн ангилж үзсэнээрээ онцлогтой байна<sup>18</sup>.

Хууль зүйн хариуцлагын өмнө дурдсан төрөл нь эрх зүйн аль ч салбарын хариулцаанд нийтийг хэрэглэгддэг. Гэхдээ тухайн салбарын хариулцааны онцлогтой уялдан тус тус өвөрмөс байдлаар зохицуулагдаг. Иймд хөдөлмөрийн эрх зүйн хариулцааны хүрээнд хууль зүйн хариуцлага хэрхэн хэрэглэгдэх талаар одоо авч үзье.

Хөдөлмөрийн эрх зүйн хариулцаа бол хөдөлмөрийн гэрээз байгуулсаар сая үүсэж хэрэгждэг. Иймд хөдөлмөрийн гэрээнд талууд болох ажил олгогч ба ажилтны хоорондын ажиллах хүч

хөлслөхөд чиглэгдсэн хариулцааны явцад хэрэглэгдэх хууль зүйн хариуцлага, түүний төрлийн онцлогийг энд хөндөх шаардлагатай.

Ажилтан, албан хаагч хөдөлмөрлөх болон албаны үүргээ билүүлэх явцдаа өөрийн буруутаас ажил олгогчдоо эд хөрөнгийн хохирол учруулсан тохиолдолд учруулсан хохирлын хэмжээг харгалзан хохирлыг нөхөн телүүлэхийг хөдөлмөрийн эрх зүйн хариулцаан дахь эд хөрөнгийн хариуцлагад хамааруулдаг. Эд хөрөнгийн хохирлыо арилгах үүргэг нь ажилтан ажил олгогчийн хооронд хөдөлмөрийн гэрээз байгуулсан үеэс үүсдэггүй, харин нэгэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээгээр зөрчсөн ажилтны буруутай үйлдэл эс үйлдэхүйн улмаас ажил олгогчид эд хөрөнгийн бодит хохирол бий болсон үед үүсдэг. ОХУ-ын эрдэмтэн В.И Кофмон "эрх зүйн зөрчил гарах хүртэлх хугацаанд байгаагүй шинэ үүргэг үүсдэгт иргээн эрх зүй дэх эд хөрөнгийн хариуцлагын нэг онцлог оршино хэмээн" үзсэн ба хувийн эрх зүйн шинжтэй хөдөлмөрийн эрх зүйн хувьд хэрэглэгдэх эд хөрөнгийн хариуцлагад энэ онцлог мөн адил агуулагджээ.

Үүргийн эрх зүйн ойлголт, үүсэл хөгжлийг дундад зууны эхэн үеийн буруу үйлдэлд шийтгэл ногдуулах үзэл баримтлалтай холбон авч үздэг. Энэхүү үзэл баримтлалын дагуу зөрчлийн хүнд, хөгжөөнээс шалтгаалан тохирсон шийтгэл оногдуулах гэсэн үндсэн зарчим нь гэм хор учруулсны улмаас үүсэх үүргэг тусгалаа олсон байдаг<sup>19</sup>.

Хөдөлмөрийн эрх зүйн хариулцаан дахь эд хөрөнгийн хариуцлага нь 2 талт хариуцлага байдаг бол сахилгын хариуцлага нь нэг талт хариуцлага байдгаараа онцлогтой.<sup>20</sup> Өөрөөр хэлбэрэлтэй эд хөрөнгийн хариуцлагыг хөдөлмөрийн хариулцааны оролцогч тал ажилтан, ажил олгогчид хэн алинд хүлээлгэж болдог бол сахилгын хариуцлагыг сахилгын зөрчил гаргасан буруутай

<sup>16</sup> Ж.Долгорцэрэн Г.Буяншигийн "Монгол улсын захирагааны эрх зүй" УБ, 2008 он 185 дахь тал

<sup>17</sup> П.Одзорэл "Захирагааны эрх зүйн ерөнхий агни" УБ 2004 он 175 дахь тал

<sup>18</sup> |株式会社自由国民社 現代用語の基礎知識2006年版|

<sup>19</sup> Ж.Союнтунгагалаг "Хариуулсан Иргэний эрх зүй" УБ, 2013

<sup>20</sup> "Employment Law Mark A Rothstein, Charles B Gravel, Elinor P.Schroeder, Elaine W.Shoben, Lea S.Vander velde, 1994, p267

ажилтан, албан хаагчид ногдуулдаг нь уг хариуцлага нэг талын шинхтэйг илэрхийлж буй хэлбэр юм.

Харин иргэний эрх зүй дэх эд хөрөнгийн хариуцлагатай харьцуулбал ажилтанд ногдуулах эд хөрөнгийн хариуцлага нь зөвхөн хөдөлмөрийн гэрзэний харилцаанд суурилдаг, "бодит хохирол"-оор хязгаарлагддаг цалин хөлслөн хийгдэх сутгалаар дамжин хэрэгждэг шинжээрээ ялгаатай.

Хөдөлмөрийн эрх зүйн харилцаанд хөдөлмөрийн ердийн гэрээ бүхий ажилтнаас гадна "контракт" хэмээх өвермөц төрлийн хөдөлмөрийн гэрээ бүхий байгуулан ажилладаг ажилтан оролцдог. Хөдөлмөрийн эрх зүйн харилцаанд ажил олгогч хувь хүний ажиллак хүчийг хөлслен авах хууль зүйн гол хэлбэр нь хөдөлмөрийн гэрээ байдаг боловч гэрээний үргэлжлэх хугацаа, ажилтны гүйцэтгэх ажил үүрэг, мэргэжил чадвар, авьяас хүч зэргийн онцлогоос хамаарч хөдөлмөрийн гэрээг төрөлжүүлэн ангилж тус бүрийн онцлогт тохируулан зохицуулах шаардлагатай болдог ба үүний нэг нь контракт юм<sup>21</sup>.

Хөдөлмөрийн контрактаар ажиллагч толгойлох албан тушаалтнаас өмчлөгчид учруулсан хохирлыг хариуцах нэг нөхцөл болгон тогтоож өгсөн<sup>22</sup> ба контрактаар ажиллаж байгаа ажилтан нь ажил олгогчдоо хохирол учруулсан нь Хөдөлмөрийн тухай хуульд заасан эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэх үндэслэлд хамаарахгүй бол 6 хүртэл сарын цалингаар хязгаарлагдмал хариуцлагыг хүлээдэг байна.

Эрүүгийн хариуцлага бол гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдоон этгээдийн эрх, эрх чөлөөнд энэ хуульд заасны дагуу шүүхийн тогтоолоор хязгаарлалт тогтоосон төрийн албадлагын арга хэмжээ юм. Хөдөлмөрийн эрх зүйн харилцаанд оролцогч субъект болох ажил олгогчийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан нь хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн

<sup>21</sup> Б. Уранцэцэг "Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хууль". (Онон арга зүйн тайлбар) №Б. 2001 он

<sup>22</sup> И.В. Зуб. "Трудовые права России и Украины: общие проблемы, общие решения". Государство и право. 1997 г №10, с.38

ажил үүрэгтэйгээ холбоотойгоор Эрүүгийн хуульд заасан гэмт хөргийн шинжтэй үйлдэл эс үйлдэхүйд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг ба энэ нь ихэнхдээ албан тушаалын гэмт хэрэг болох өмчийн эсрэг гэмт хэрэг, авлигиын гэмт хэргүүдэд хамаардгаараа онцлогтой. Хөдөлмөрийн харилцаан дахь эрүүгийн хариуцлага нь хэд хэдэн онцлогтой. Үүнд:

1. Ажилтны эрхэлж буй албан үүрэгтэй шууд холбоотой байдаг.

Өөрөөр хэлбэл бусдын өмнө хөдөлмөрийн гэрээгээр буюу томилгооны үндсэн дээр үүссэн алба хаших үйл ажиллагаатай холбоотой үйлдэх үйлдэл буюу эс үйлдэхүйтэй холбоотой.

2. Тухайн гэмт хэрэгт оноосон ял нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хөдөлмөрийн харилцаанд шууд нөөвлөдөг. Жишээлбэл: Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6-д буй "Ажилтан гэмт хэрэг үйлдсэний улмаас уг ажил үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй ял оногдуулсан шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон" тохиолдолд хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгоохор хуульчилсан.

Хуулийн уг зохицуулалт нь дараах урьдчилсанхөнцөлийг хангасан нөхцөлд хэрэглэгдэнэ. Үүнд: Ажилтан гэмт хэрэг үйлдсэн байх, ажилтны үйлдсэн гэмт хэрэг нь уг ажил үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй ял оногдуулсан байх, ял ногдуулсан шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон байх гэсэн нөхцөлүүд хамаарна. Гэхдээ Хөдөлмөрийн тухай хуулийн уг зохицуулалт нь хөдөлмөрийн гэрээ бүхий ажилтны хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгоход л хамаарах ба харин төрийн жинхэнэ албан хаагчийн хувьд энэ зохицуулалт нь ялгаатай зохицуулагдсан. Тухайлбал: Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйд зааснаар төрийн жинхэнэ албан хаагчийг гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон тохиолдолд

терийн албанаас шууд халах үндэслэл болно. Хөдөлмөрийн тухай хууль болон Төрийн албаны хуулийн дээрх зохицуулалтыг харьцуулан үзэхэд хөдөлмөрийн гэрээтэй ажилтны хувьд ял шийтгэлийн тэрлээс хамаарч хөдөлмөрийн гэрээ дуусгавар болох эсэх асуудал нь ялгамжтай зохицуулагдаг бол харин төрийн жинхэнэ албан хаагчийн хувьд ямар ял шийтгэлээр шийтгүүлснээс үл хамааран шууд төрийн албанаас халж байгаагаараа онцлог юм.

3. Ажилтан, албан хаагчийн эрхэлж буй ажил албан тушаалтай нь холбоотойгоор үйлдсэн гэм буруутай үйлдэл нь шүүхээс ял шийтгэл ногдуулдаг ба энэ нь ихэнхдээ Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан "Албан тушаалын гэмт хэрэг"-т хамаардаг.

Өмнө дурдсангаар албан тушаалын гэмт хэргүүдэд Эрүүгийн хуулийн 138, 183 дугаар зүйл буй Хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрэм журам зөрчсөн, уул уурхайн ашиглалтын журам зөрчсөн зэрэг гэмт хэрэг хамаарах ба уг гэмт хэргийг үйлдсэн ажил тиүүнд нь ихэнхдээ албан тушаалтнууд ётдаг.

Хөдөлмөрийн эрх зүйн харилцаанд ажил олгогч хуулиар хүлээсэн үргээ биелүүлэхгүй байх мөн өөрт олгогдсон эрхийг хэтрүүлсэн зэрэг тохиолдолд дээрх үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй байвал захиргааны хариуцлага хүлээлгэх үндэслэл болдог байна. Хөдөлмөрийн эрх зүйн харилцаан дахь захиргааны хариуцлага нь дараах онцлог шинжтэй.

1. Хөдөлмөрийн эрх зүйн харилцаан дахь захиргааны зерчлийн субъект нь ажил олгогч тал аж ахуйн налж байгууллага, түүнийг уг харилцаанд төлөөлөх этгээд (удирдах албан тушаалтан) байна.

2. Ажил олгогч болон түүнийг төлөөлөх удирдах албан тушаалтанд ногдуулах хэдий ч уг албан тушаалтны ажил үүрэгтэй холбоотой гаргасан зөрчил бурийг захиргааны зөрчилд тооцохгүй. Хөдөлмөрийн тухай хуулиар ажил олгогчид үүрэг болгосон тодорхой үйлдэл, эс үйлдэхүйг хамруулдаг.

3. Хөдөлмөрийн эрх зүйн харилцаан дахь хуулиар үүрэг болгосон хэм хэмжээг зөрчсөн байхыг ойлгодог.

4. Хөдөлмөрийн эрх зүйн харилцаан дахь захиргааны зерчилд захиргааны хариуцлагын зохих хэлбэрүүдээс зөвхөн ТОРГОХ шийтгэлийг ногдуулдгаараа онцлогтой.

5. Хөдөлмөрийн эрх зүйн харилцаан дахь захиргааны хариуцлагыг хуульд заасан эрх бүхий этгээд болох хөдөлмөрийн улсын байцааг эсхүүл шүүгч ногдуулдаг.

Хөдөлмөрийн эрх зүйн харилцаанд захиргааны хариуцлага хүлээлгэх урьдчилсан нэхцэл нь буруутай этгээд захиргааны зөрчил гаргасан байх явдал бөгөөд Хөдөлмөрийн тухай хуулиар уг зөрчлүүдийг нэрлэн зааснаараа онцлогтой юм.

Хөдөлмөрийн эрх зүйн харилцаан дахь захиргааны зөрчил нь дан ганц хөдөлмөрийн гэрээ байгуулан хөдөлмөрийн эрх зүйн харилцаа үүссэнд дараа бий болдоггүй зарим тохиолдолд ажилд орох үед ажил олгогч нь ялгаварлал тогтоох байдлаар иргэний эрхийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэдэг. Жишээ нь: Иргэнийг ажилд авахад болон хөдөлмөрийн харилцааны явцад ажил, үүргийн онцлогтой холбоогүйгээр ажилтны эрх, эрх чөлөөг хязгаарласан бол албан тушаалтан болон аж ахуйн нэгж, байгууллагад захиргааны хариуцлага хүлээлгэдэг ба хүчин төгөлдөр үйлчилж буй Хөдөлмөрийн тухай хуулийн 141 дүгээр зүйлд ажил олгогчид холбогдох нийт 18 төрлийн үйлдэл, эс үйлдэхүйг захиргааны зөрчилд тооцохоор тусгажээ.

Өмнө дурдсанчлан хууль зүйн хариуцлага нь эрх зүйн аль ч салбарын харилцаанд нийтлэг хэрэглэгдэдэг хэдий ч тухайн салбарын харилцааны онцлогтой уялдан өвөрмөц байдлаар зохицуулагдаг тул хөдөлмөрийн эрх зүйн харилцаан дахь хууль зүйн хариуцлагыг тухайн салбарын онцлогоос нь хамаарч ялган ногдуулах нь онол практикийн чухал ач холбогдолтой юм.

## ХУУЛЬ ЗҮЙН ДЭЭД БОЛОВСРОЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ



**Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн  
Бодлогын судлаач Э.Уянга**

### Удиртгал

Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар булгийн Арван зургадугаар зүйлийн 7 дахь хэсэгт иргэдийн сурч боловсрох үндсэн эрхийг хуульчилсан ба Боловсролын багц хуулиар баталгаажуулсан.

Сурч боловсрох эрх бол иргэдийн хамгийн чухал нийгмийн эрхийн нэг учраас хувь хүний болон нийгмийн хөгжлийг хангах үндсэн нөхцөл нь болдог<sup>1</sup>. Иргэдийн боловсролын түвшнээс нийгмийн хөгжил шууд шалтгаалдаг.

Нийгмийн хөгжилд онцгой чухал үүргэг гүйцэтгэдэг салбар бол хууль зүйн салбар байдал. Хууль зүйн боловсрол тэр дундаа хууль зүйн дээд боловсрол нь боловсролын өнөөгийн тогтолцоог дагаад хөгжих байгаа хэдий ч дэлхийн түвшинд өрсөлдөх хэмжээний хууль зүйн дээд боловсролтой иргэнийг бэлтгэн гаргах, нийгмийн эрэлт хэрэгцээг хангах шаардлагатай байгаа нь илт байна.

Хууль зүйн дээд боловсрол олгож байгаа үйл явцыг түүхэн хөгжил, төлөвшил, эрх зүйн зохицуулалт талаас нь тоймлон судалж, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх (өрөнхий боловсролын /9-12-р анги/ сургалтаас мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт МСҮТ-өөрөлжсургалт) түвшнээсэхэлэн дээд боловсрол эзэмшүүлэх хүртэл хууль зүйн салбарын мэргэжилтэн бэлтгэх тогтолцоо нь нийгмийн эрэлт хэрэгцээг хангах, иргэний хууль зүйн боловсрол эзэмшиг эрхийг хангаж байгаа эсэхийг эрэлхийлэх зорилготой.

Хууль зүйн дээд боловсрол эзэмшиг эрх, хууль зүйн салбарын мэргэжилтэн бэлтгэх нь нэг зүйлийн хоёр тал юм. Монгол Улсын гавьяат хуульч Б.Чимид “Дипломын төлөө биш ажиллахын тулд сурдаг билээ<sup>2</sup> гэсэн байдал.

Нэг талаас мэргэжлээрээ ажиллах үүднээс сурч, боловсрол эзэмшиж байгаа иргэний хууль зүйн дээд боловсрол эзэмшиг эрх бол нөгөө талаас ажлын байрны эрэлт хэрэгцээг хангах хууль зүйн дээд боловсролтой мэргэжилтний нийгэмд эзлэх байр суурь, нэр хүндийг өсгөх, нийгмийн эрэлт хэрэгцээг хангах нь харьяа тэр, захирагааны байгууллагын болон дээд боловсрол эзэмшүүлэх байгууллагын УҮРэг билээ.

Монгол Улсад хууль зүйн салбарын мэргэжилтэн бэлтгэх талаар Ж.Амарсанаа, Н.Лүндэндорж, С.Нарангэрэл, Ц.Сарантуяа, Д.Солонго, Т.Сэнгэдорж, Г.Совд, Б.Чимид гэх мэт хууль зүйн эрдэмтэн судлаач нарын оруулсан хувь нэмэр их байна.

Улсын Их Хурал, Засгийн газраас олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлын тайлан

<sup>1</sup> Г.Совд нар. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар УБ., 2000 он.

<sup>2</sup> Б.Чимид Тэр. нам эрх зүйн шинэчлэлийн эзэгтэй асуудал УБ., 2008 он /53 дахь тап/

эмхтгэл, дээрх эрдэмтэн судлаачдын бүтээл, Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн актуудыг энсэдвийн хүрээнд судлах юм.

Энэхүү сэдвийг судлах нь иргэний хууль зүйн боловсрол эзэмшиг эрх, хууль зүйн салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд бага ч болов хувь нэмэр оруулах ач холбогдолтой.

Хууль зүйн дээд боловсролын түүхэн хөгжил, төлөвшил

Монголын хууль зүйн боловсролыг түүхэн талаас нь тоймлон очижед тэр хууль цааз үүсэн хөгжсөн үетэй салшгүй холбоотой билээ. XIII зуунд Ази Европын оронд монголчууд хүрч, хүн төрөлхтний мэдлэгт хувь нэмэрээ оруулж байжээ.

Чингис хаан аливаа үндэстэн ястны мэргэд зурхайчдыг төрийн ивээлд байлан ордондоо ажилтуулж байсан бол Өгөөдэй хаан номын мэргэд ажилладаг шинжлэх ухааны байгууллага болох Судар бичгийн хүрээлэнг байгуулж Хубилай хаан уг номын хүрээлгээ Бээжин хотод шилжүүлж түүнд Монгол, Унгар, Хятадын 120 мэргэд ажиллаж байсан тухай түүхч эрдэмтэд тэмдэглэн үлдээжээ.

1264 онд Эрдэмтэн мэргэдийн хүрээлэн, 1277 онд улсын хөвгүүдийн сургуулийн яам, 1275 онд судар бичгийн хүрээлэн, 1287 онд Юан гүрний улсын хөвгүүдийн яам зэрэг төрийн бодлогыг хэрэгжүүлэх сургалт судалгааны ажлыг эрхлэх байгууллагуудыг байгуулсан байдал. Мен Юан гүрний тушмэдийг шалгаруулах улсын шалгалтын журмыг шинчлэн боловсруулж 1314 онд Аюурбалбад хааны зарлигаар хэрэгжүүлж эхэлсэн. Энэ нь бичгийн мэргэдийг олшууллах зорилготой бөгөөд шалгалтыг 3 сэдвээр авах тухай заасан<sup>3</sup> нь тухайн нөхцөл байдал тохирсон хууль, дүрэм журмыг боловсруулан гаргах хэмжээний боловсролтой эрдэмтэн мэргэд байсан төдийгүй Монголын хууль

зүйн боловсрол хөгжжих байсны илрэл болсон Их засаг хууль, Халх журам хууль зэрэг алдартай хуулиуд тухайн үед тэрэн гарч, хэрэгжих байсан нь үеийн хууль судлаачдын судалгааны сэдэв болсоор ирсэн түүхтэй билээ.

Манжийн дарангуйлын үед боловсрол харьцангуй зогсонгий байдалд орсон ч тэр үеийн олон эрдэмтэд төрсөн түүхтэй.<sup>4</sup> 1912 онд Монголын зарим нэг сэхээтнуудийн санаачилгаар төрийн сургууль байгуулагдаж, 1913 онд Цэргийн сургууль байгуулагдаж байсан төдийгүй төрийн зохион байгуулалт, хууль цаазын асуудлууд орхигдоогүй юм.

1921 онд иргэдийн сурч боловсрох эрхийг хангах талаар төрөөс бодлогын түвшинд Засгийн газраас эрхлэн зохион байгуулж сургалтын арга хэлбэрийг нэгдмэл зохион байгуулалт, дэс дараалалд оруулан эхний эзлжид иргэдийг бичиг үзүүтэй болгох, улмаар ерөнхий болон мэргэжлийн боловсрол эзэмшиүүлэх асуудлыг зохицуулсан харилцааг бий болгож байжээ. Үний дагуу Ардын засгийн газраас боловсролын анхан шатны байгууллагыг үүсгэн байгуулах түүний удирдлагыг зохион байгуулалт, санхүүжилтийн болон суралцагчийн эрх үргүйг тогтоосон эрх зүйн актуудыг батлан гаргаснаар Монгол Улсын боловсролын тогтолцоо бүрэлдэн хөгжих эхлэлийг тавьсан.

1924 онд Намын түр сургууль байгуулан нам, улс ардын аж ахуйн удирдах боловсон хүчиний бэлтгэдэг байсан. 1940 онд хуралдсан МАХНын Х-р их хурлаас "Улс ардын аж ахуй, соёлын хөгжилтэй холбогдуулан тэнд мэргэжлийн бэлтгэгдсэн боловсон хүчиний шаардлага, хэрэгцээ өсөж байна гэж үзэн СиЗ-өөс 1940 оны 12-р сарын 06-ны өдрийн шийдвэрээр 1941 оны 2-р сараас Улсын их сургуулийн бэлтгэлээг 30 хүнтэйгээр анх хичээллүүлж эхэлсэн<sup>5</sup> нь Монгол Улсын боловсролын тогтолцоо бүрэн утгаараа бүрэлдэн

<sup>3</sup> ХУ-р зууны боловсрол судалж Гүрслэгээ, сургалж, Улаанбаатар, 2001 он

<sup>4</sup> МАХНын түүхэнд холбогдох баримт бичгүүд 1940-1960 он 2-р дэвтэр УБ, 1967 он.

хөгжжиг иргэдийн сурч боловсрох эрхийг хангах болопцоог бүрдүүлж чадсан юм.

Ийнхүү Монгол Улсын боловсролын тогтолцоо бүрэлдэн бүрэн утгаараа хэрэгжих эхэлсэн бол хууль зүйн боловсрол эзэмшүүлэх ажил нь 1950-иад оны эхээр тэр үеийн худалдааны техникуумийн дэргэд хуульчдыг бэлтгэх нэг жилийн курсыг нээснээр эхэлсэн байна. БНМАУ-ын Дээд шүүхийн дэргэд хууль цаазын дунд сургуулийг 1950-иад оны сүүлчээр байгуулсан, 1957 онд МАХН-ын төв хороо, БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн тогтоолоор МУИС-д хуулийн анги нээх тухай шийдвэр гарч Хэл нийгмийн ухааны факультетад харьяалагдан сургалт, эрдэм шинжилгээний ажлаа эхэлж байсан түүхтэй.

1990 он хүртэл МУИС-ийн хуулийн салбарын сургалтын төлөвлөгөө социалист хамтын нөхөрлөлийн орууд түүний дотор ЗХУ-ын Ломоносовын нэрэмжит Москвагийн Их сургуулийн хууль зүйн факультетын сургалтын төлөвлөгөөтэй үндсэндээ дүйцэж байсан. Түүнээс хойш барууны жишгийг аажмаар нэвтрүүлж эхэлсэн.

Сургалтын хугацаа нь хуулийн өдрийн анги 4 жил, оройн анgid 5 жил, энээс анги 6 жилийн хугацаатай сургаж байсан.

1990 оны эхээр өдрийн ангийг 5 жил болгосон бөгөөд сүүлдээс барууны жишгийг даган орой, энээс анgid зөвхөн их дээд сургуульд суралцаж төгссөн бакалаврын зэрэгтай төгсгөчдийг суралцуулах болж сургалтын хугацааг багасгасан.

1994 онд анхны хууль зүйн магистрын зэргийн хамгаалалт болж байсан бол энэ үед 30 гаруй докторантурыг бэлтгэж төгсгэсэн байна. МУИС-ийн хууль зүйн сургуулиас гадна хууль зүйн дээд боловсрол эзэмшүүлэх тогтолцоонд өөрийн гэсэн байр суурьтай олон жилийн үүх түүхтэй сургуулийн нэг бол Цагдаагийн дээд сургууль буюу одоогийн Хууль сахиулахын их сургууль юм. 1990 оноос хойш хууль сахиулах байгууллагын захиалгаар хууль зүйн чиглэлээр сургадаг явдал зогссонноос төрийн мэдлийн сургуулиуд

хуулийн анги нээж хичээллүүлэх болсон. 1999 онд Батлан хамгаалахын их сургууль эрх зүйн мэргэжлээр өдөр, энээс сургалтын үйл ажиллагаа явуулж байсан бол Худалдаа уйлдвэрлэлийн дээд сургууль 1999 оноос бизнесийн эрх зүйч мэргэжлээр дээд боловсролтой боловсон хүчин бэлтгэх үйл ажиллагааг эхэлжээ. Ховд их сургуульд эрх зүйч, Боловсролын их сургуульд багш эрх зүйчийн анги нээсэн<sup>6</sup>.

Мөн 1990 оноос хожьшбайгаагуулагдсан хувийн хэвшлийн сургуулиуд ч хуулын, эрх зүйч бэлтгэх тогтолцоонд өөрийн байр сууриа эзэлсээр ирсэн. Хуулийн сургуулиас гадна эдийн засгийн болон бусад олон чиглэлийн сургууль зах зээлээ даган эрх зүйн ангиуд олноор нээж байсан бол 2000 оны дундаас хойш эрх зүйн ангиудыг баагасгаж өнөөдөр хувийн болон улсын өмчийн хууль зүйн чиглэлийн 11 сургуульд /2014 оны байдлаар Монгол Улсад эрх зүйн бакалаврын сургалт явуулж буй/ 6467 оюутан суралцаж, 262 багш<sup>7</sup> ажиллаж байна.

### Хууль зүйн дээд боловсрол эзэмшиж эрх, то толцооны талаарх эрх зүйн зохицуулалт

Хууль зүйн дээд боловсрол эзэмшиж, эзэмшүүлэх үйл явц манай улсад хожуу эхэлсэн хэдий ч нийгмийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан бусад улс оронд хууль зүйн дээд боловсрол эзэмшиж байсан. Ийнхүү нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцэн олон улсын чиг хандлагыг баримжаалан хөгжиж, өнөөгийн хууль эрх зүйн боловсролын тогтолцоо бий болж өөрийн гэсэн харилцааг эрх зүйн актаар зохицуулаад байна.

<sup>6</sup> Монгол Улс дахь эрх зүйн боловсрол: уусл, хөгжил, чиг хандлагыг УБ., 2011 он. ХЗДХЯ-наас 100 жилийн ойд зориулан эмчтэв. Эрхэлсэн С. Нарангэрэл нар.

<sup>7</sup> Монгол Улс дахь эрх зүйн бакалаврын зэрэг олгох сургалтын өнөөгийн нөхцөл байдал УБ., 2014 он ХЗУХ судалгаа /Э.Уянга, С.Бужинтхам, Ж.Эрдэмзаяа, Г.Цагаанбаяр, С.Батбаяр/

Монгол Улсын хэмжээнд 569 хууль, 8357 хуульчилсан акт<sup>6</sup> үйлчилж байгаагаас Хууль зүйн дээд боловсролын харилцааг зохицуулсан:

- Олон улсын гэрээ 7,
- Монгол Улсын хууль 15,
- Улсын Их хурлын тогтоол 7,
- Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлиг 2,
- Засгийн газрын тогтоол 35,
- Сайдын тушаал 26,
- Дээд шүүхийн тогтоол 1 байна.

Эдгээр эрх зүйн актуудыг дараах байдлаар б бүрдэл хэсэгт ангилан товч байдлаар холбогдох эрх зүйн актуудыг түүвэрлэн шийдвэрлэх асуудлыг гаргаж ирэхийг оролдож үзлээ.

1. Боловсрол эзэмших агуулга, арга, хэлбэр
2. Боловсролын байгууллага
3. Сургалтын байгууллагын удирдлага
4. Ажилтнууд
5. Суралцагч
6. Эдийн засаг, санхүүжилт гэх мэт ерөнхий хэсэгт хувааж холбогдолтой эрх зүйн гол заалтуудыг авч үзсэн.

### 1. Хууль зүйн дээд боловсрол эзэмших агуулга, арга хэлбэр

**Агуулга:** Боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дэх хэсэгт "боловсролын агуулга" гэж боловсролын тухайн түвшинд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадал, төвлөшийн цогцыг ойлгогод бол энэ зүйлийн 3.1.4 дэх хэсэгт "Боловсролын түвшин" гэж тухайн шатанд эзэмшвэл зохих сургуулийн өмнөх, бага, дунд, дээд боловсролын агууллын стандартаар тогтоосон мэдлэгийн хэмжээ тогтоохоор зааж өгчээ.

Дээд боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт "Дээд боловсролын агуулга нь нэгдмэл

бөгөөд суралцагчид шинжлэх ухаан, технологи, нийгэм-хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээний хүрээнд мэргэжлийн ёндөр түвшинд ажиллах, судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, бие хүн өөрийгөө нээж хөгжүүлэх мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, соёл төлөвшүүлэхэд чиглэгдэнэ" гэж зааж өгсөн бөгөөд ерөнхий суурь, мэргэжлийн суурь болон мэргэших хэсгээс бүрдэнэ.

Боловсролын тухай хуулиар олгосон эрхийн дагуу стандартыг Дээд боловсролын тухай хуулинд заасан ерөнхий суурь, мэргэжлийн суурь болон мэргэших хэсгийн агууллыг Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2007 оны 36 дугаар тогтооюор "Эрх зүйн бакалаврын боловсролын стандарт" баталсан "Эрх зүй" мэргэжлийн чиглэл, D380100 индекстэй байх тухай стандарттаар тогтоож өгсөн нь 2013 оныг хүртэлх элсэгчидэд хамаарна.

2014 оноос эхлэн суралцагсад нь БСШУ сайдын 2014 онд шинчлэн баталсан Дээд боловсролын бакалаврын мэргэжлийн чиглэл, индексээр Ерөнхий чиглэл 04 буюу "БИЗНЕС, УДИРДЛАГА, ЭРХ, Төрөлжсан чиглэл 042 буюу "эрх зүй". Нарийчилсан чиглэл 1 буюу "эрх зүй", хөтөлбөрийн нэр 01 буюу "эрх зүй" гэж нэг л чиглэлээр байх бол 042101 индекстэй байхаар баталжээ. Дээд боловсролын "мэргэжлийн" жагсаалтыг тус яам батлан, түүний дагуу сургуулиудын сургалтын хөтөлбөрийг хянан баталж мөрдүүлж ирсэн бол дээд боловсролын сургууль "мэргэжилтэн бэлтгэх" бус, дээд боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх чиг үүрэгтэй үндэслэн бакалаврын хөтөлбөрийн жагсаалт болгож өөрчлөн баталсан.

**Арга, хэлбэр:** Боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйлд боловсролын арга хэлбэрийг тусгаж өгсөн. Боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт "Иргэн нь боловсролыг албан болон албан бус сургалтаар эзэмшиж болно. Албан сургалт нь ёдер, орой, эчнээ, экстернат

<sup>6</sup> LegalInfo.mn /Сүүлийн нэвтрэсэн 2015 оны 9 дугаар сарын 10-ны өдөр/

зэрэг хэлбэртэй байж болно" гэж зааж өгсөн.

Монгол Улсын хууль зүйн албан боловсролын тогтолцооны нэг хэсэг нь хууль зүйн дээд боловсрол байх бөгөөд Дээд боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан агуулгыг Стандартчилал тохиирлын үнэлгээний тухай хуулийн 6.5 дахь хэсэгт зааснаар Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлөөс 2007 онд баталгаажуулсан байна.

Нэгэнт хуулиар албан бус боловсролын агуулга чөлөөтэй байхаар заасан тул Монгол Улсын хууль зүйн албан бус боловсролын тогтолцооны хувьд мөн адил хамаарах юм.

Манай улсын хууль зүйн албан бус сургалтыг хууль зүйн сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад тулгуурлан явуулж байсан бол 2002 онд Хууль тогтоомж, шүүх эрх мэдэлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны үндэсний төв<sup>9</sup>-ийг байгуулан 2003 оноос Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийг батлан гаргаснаар хуульчийн мэргэжлийн чанарт баагайг өөрчлөлтүүдийг хийж эхэлсэн. Энэ үед эрх зүйн бакалаврын боловсрол зээмшсэн хүмүүст хууль зүйн мэргэжлийн чиглэл олгох тухай яригдаж байсан хэдий ч энэ нь Хууль зүйн клиник сургалт буюу дадгын орчныг бүрдүүлэх гэдээр хууль зүйн сургууль бүрд байгуулагдсан нь эрх зүйн албан сургалтын нэг хэсэг болон өөрчлөгдсөн.

## 2. Боловсролын байгууллага

Боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дахь хэсэгт "Боловсролын зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрхэлдэг хуулийн этгээдийг боловсролын байгууллага гэнэ" гэж заасан бол хуулийн 13 дугаар зүйлд "Боловсролын байгууллага нь сургалтын, эрдэм шинжилгээ, ага зүйн боловсролын үнэлгээний болон бусад байгууллагаа бүрдэнэ" гэжээ.

<sup>9</sup> Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 121 дугаар тогтоо, Хууль зүй дотоод хөргийн сайдын 2002 оны 222 дугаар тушаалаар байгуулж, дүрэм зохион байгуулалтын бүтцийн баталсан.

1/Сургалтын байгууллага: Албан сургалт эрхэлдэг байгууллагын тухайд Хууль зүйн дээд боловсролыг Боловсролын тухай хуулийн 14 дүгээр зүйлд "мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага". 15 дугаар зүйлд "дээд боловсролын сургалтын байгууллага" зээмшүүлэхээр байна.

Боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дахь хэсэгт "Дээд боловсролын сургалтын байгууллага нь их сургууль, дээд сургууль, коллеж байна. Их сургууль нь эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн буюу эрдэм шинжилгээ-сургалтын, дээд сургууль нь сургалт-эрдэм шинжилгээний, коллеж нь сургалтын буюу сургалт-үйлдвэрлэлийн хэв шинжтэй байна" гэж тодорхойлсон.

2/Эрдэм шинжилгээ, ага зүйн байгууллага: Боловсролын тухай хууль болон Шинжлэх ухаан технологийн тухай хууль, Шинжлэх ухааны академийн тухай хууль, Инновацийн тухай хуульд заасан байгууллагууд хамаарна.

Дээд боловсролын тухай хуулиар Их сургуулиуд нь эрдэм шинжилгээ-сургалтын байгууллага байх тухай заасан бол дээд сургууль нь сургалт-эрдэм шинжилгээний байгууллага байх тухай заасан байдаг. Энэ утгаараа их сургууль нь эрдэм шинжилгээний ажилд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд дээд боловсролын байгууллага, үндэсний хэмжээний музей, номын санг хамааруулах талаар 2007 оны 12 дугаар сард "үнэлгээний үзүүлэлтийг үндэслэн эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамааруулах тухай" БСШУ-ны яамны сайдын 463 дугаар тушаал гарсан. Дээд боловсролын байгууллагыг доктор, шинжлэх ухааны докторын эзлэх хувь хэмжээ, эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэж байгаа магистр, докторын эзлэх хувь, эрдэм шинжилгээний зардлын эзлэх хувь, лабораторийн хангамж, номын фондод дотоод, гадаадын эрдэм шинжилгээний бичиг, сэтгүүл, нэг

сэдэвт, бүтээлийн эзлэх хувь, нийт эрдэм шинжилгээний бүтээлд гадаад орны эрдэм шинжилгээний бичиг, сэтгүүлд нийтлүүлсэн болон патент авсан бүтээлийн эзлэх хувь зэрэг зэрэглэн тогтоодог.

3/Албан бус боловсролын байгууллага: 1995 оны Боловсролын тухай хуулинд Монгол Улсын боловсролын тогтолцоо нь албан болон албан бус дэд тогтолцооны нэгдэл байна гэж зааж өгсөн бол 1997 оноос албан бус боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр" батлагдан албан бус боловсролын тогтолцоо бий болж, 2012 оноос шинэчлэлийн Засгийн газрын бодлогын хүрээнд насан туршийн боловсролын тогтолцоо болон өргөжин хөгжих байна.

Хууль зүйн албан бус боловсрол буюу насан туршийн тасралтгүй боловсрол олгох тогтолцоо нь Засгийн газрын 2006 оны 263 дугаар тогтоолын дагуу хууль зүйн яам болон хууль зүйн үндэсний хүрээлэн хэрэгжүүлсээр ирсэн.

4/Боловсролын үнэлгээний байгууллага: Боловсролын тухай хуулийн 17<sup>1</sup> дугаар зүйлийн 17<sup>1.1</sup> дэх хэсэгт "Боловсролын үнэлгээний байгууллага нь сурлагын амжилт, бүх шатны боловсролын сургалтын чанарт хяналт-шинжилгээ, үндэлгээ, судалгаа хийх; сургалт зохион байгуулах, их, дээд сургууль, коллежид элсэгчдээс авах ерөнхий боловсролын түвшин, суралцаагчдын мэдлэг, чадварыг тогтоох зорилго бүхий элсэлтийн ерөнхий шалгалтыг үндэсний түвшинд зохион байгуулах чиг үүрэг бүхий хуулийн этгээд байх тухай заасан. Боловсролын үнэлгээний төвийн бүтэц, орон тоо, дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталдаг.

5/Магадлан итгэмжлэх байгууллага: Боловсролын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт Боловсролын магадлан итгэмжлэл нь дээд боловсролын сургалтын байгууллага, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын ўйл ажиллагааны түвшин, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарт

хөндлөнгийн мэргэжлийн үнэлгээ хийж, дүгнэлт гаргах ажиллагаа гэж заасан бол 26.2 дахь хэсэгт "Боловсролын магадлан итгэмжлэлийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагаас эрх олгосон байгууллага, шинжээч хэрэгжүүлнэ" гэжээ.

Засгийн газраас 2003 оны 276 дугаар тогтоолоор Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагын дүрмийг баталсан. Дээд боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэгт их сургууль, дээд сургууль, коллеж нь бие дааж магадлан итгэмжлэлд орох тухай заасан бол Магадлан итгэмжлэлд орохдоо 2010 онд батлагдсан Улсын тэмдэгийн хураамжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.7 дахь хэсэгт хураамжийн талаар заасан.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 58 дугаар зүйлд Хууль зүйн сургуулийн магадлан итгэмжлэлийн талаар тусгаж өгсөн. Хууль зүйн сургууль нь Дээд боловсролын тухай хуульд заасан шаардлагасаа гадна Хуульчдын холбооноос тогтоосон шаардлагыг хангасан байх тухай заасан.

Хуульчдын холбоо нь хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх чиг уүрээ магадлан итгэмжлэх комисс байгуулах замаар хэрэгжүүлнэ гэж заасан ба комисс нь Боловсролын тухай хуулийн 26.2-т заасны дагуу эрх олж авах бөгөөд уг комиссын дүрмийг Хуульчдын холбооны Ерөнхийлөгч болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална гэжээ.

### 3. Сургалтын байгууллагын удирдлага

Боловсролын тухай хуулийн Дөрөвдүгээр зүйлд боловсролын удирдлагын талаар зааж өгчээ. Хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.Боловсролын удирдлагын боловсролын асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв болон орон нутгийн байгууллага, засаг захирагаа, нутаг дэвсгэрийн нэгжийн

удирдлага, боловсролын байгууллагын болон түүний өөрийн удирдлагаас бурдэнэ. Хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт "Өмчийн бүх хэлбэрийн боловсрол сургалтын байгууллагыг үүсгэн байгуулагч буюу түүний эрх олгосон этгээдийн томилсон захирал, эрхлэгч удирдана" гэж заажээ.

Дээд боловсролын тухай хуулийн тавдугаар бүлэгт дээд боловсролын удирдлагын талаар заасан бол хуулийн 11 дүгээр зүйлд дээд боловсролын сургалтын байгууллагын удирдлагаар талаар, хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт Дээд боловсролын удирдлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэх ба дээд боловсролын байгууллагын үйл ажиллагаат төрийн бодлогын хүрээнд уялдуулан зохицуулж дэмжих, тэднийг мэргэжлийн арга зүйн удирдлагаар хангах, төрийн захиргааны бусад төв байгууллагатай тухайн салбарт мэргэжилтэн бэлтгэх асуудлаар хамтран ажиллах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Дээд боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт "Их сургууль, дээд сургууль, коллежийн өөрийн удирдлагыг сургуулийн удирдах зөвлөлтийн хэрэгжүүлнэ" гэж заасан бол БСШУ яамны сайдын 2002 оны 283 дугаар тушаалаар Их сургууль, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн удирдах зөвлөлийн үлгэрчилсэн дүрмийг баталсан.

#### 4. Сургалтын байгууллагын ажилтнууд

Дээд боловсролын сургалтын байгууллагад багшийн гүйцэтгэх үүрэг чухал юм. Дээд боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэгт Дээд боловсролын сургалтын байгууллагыг сургуулийн хүчин чадлаас гадна үндсэн багш нарын дотроос докторын зэрэгтэй багш нарын эзлэх хувь хэмжээг харгалzan ангилдаг байна.

Дээд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлд их сургууль, дээд сургууль, коллежид үндсэн мэргэжлийн хичээлийг магистр, түүнээс дээш зэрэгтэй багш заах бол багшийн мэргэжил зээмшээгүй орон тооны багш заах арга зүй зээмшсэн байна. Их сургууль, дээд сургууль, коллежийн багшийн албан тушаалд профессор, дэд профессор, ахлах багш, багш дадлагажигч багш ажиллана.

Багшилсан хугацаа, сургалтын ажлын дадлага, туршилага, эрдэм шинжилгээний бүтээл, туурвилыг харгалзан докторын зэрэгтэй хүнд дэд профессор, профессор цолыг их сургууль, дээд сургууль олгодог.

2003 онд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Дээд профессор, профессор цол олгох тухай /2003 оны 87 дугаар тушаал/. Их сургууль, дээд сургууль, коллежийн багшийн албан тушаалын орон тоонд тавих нийтэг шаардлаг /2003 оны 139 дүгээр тушаал/. Багшах эрх олгох, хасах, /2003 оны 239/ зэрэг их, дээд сургуулийн багшид чиглэсэн тушаалыг хуулинд нийцүүлэн батлан гаргажээ.

#### 5. Дээд боловсролын байгууллагад суралцагч

Дээд боловсролын байгууллагын суралцагч нь шинжлэх ухаан, технологи, нийтэг-хумуулзгийн тодорхой чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд мэргэжлийн өндөр түвшинд ажиллах, судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, бие хүн өөрийөө нээж хөгжүүлэх мэдлэг, чадвар, дадал эзэмшиж авах зорилготой байна.

Дээд боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлд коллежийн, дипломын болон бакалаврын шатлалд суралцагчийг оюутан, магистрын шатлалд суралцагчийг магистрант, докторын шатлалд суралцагчийг докторант гэж заасан бол энэ хуулийн 16 дугаар зүйл, Боловсролын тухай

хуулийн 45 дугаар зүйлд суралцагчийн эрх үүргийн талаар заасан. 2011 онд Дээд боловсролын санхүүжилт, суралцагчийн нийгмийн баталгааны тухай хуулийг батлан гаргасан. Энэ хуулиар суралцагчийн тэтгэлэг, сургалтын зээл, санхүүгийн дэмжлэг зэрэг асуудлыг зохицуулж өгсөөс гадна дадлага хийх, цагийн хөдөлмөр хийх, мэдээлэл, нийгэм, соёл, эрүүл мэнд, биеийн тамирын үйлчилгээг хөнгөлөлттэй нөхцөлөөр үйлчлэхийг дэмжих, өдрийн ангид суралцагчийн эрүүл мэндийн даатгалыг төр хариулах зэрэг нийгмийн баталгааг тусгаж өгсөн байна.

#### 6. Эдийн засаг, санхүүжилт

Боловсролын салбарын өнөө үеийн томоохон өөрчлөлтийн нэг нь төрийн болон төрийн бус өмчийн байгууллага байгуулгасан үүний хуулиар баталгаажуулсан явдал юм. Өөрөөр хэлбэл 1991 оны боловсролын тухай хуулиар боловсролын байгууллагыг өмчийн аль ч хэлбэрээр бэхжүүлэх, хөгжүүлэх дэд чиглүүлсэн.

1998 оны бо овсролын тухай хуулиар боловсроль н байгууллага нь "ашгийн болон ашгийн төлөө бус" байх тухай зааж өгсөн. Үүнийг боловсролын байгууллагыг өмчийн хэлбэрээр ялгаварлан гадуурхсан, боловсролын байгууллагыг бизнесийн хэлбэрт оруулсан зэрэг серөг үр дагаврыг бий болгосон гэдгээр 2002 онд энэ заалтыг хассан боловч 2006 онд эргүүлэн нэмэлтээр оруулсан. Боловсролын байгууллагад оруулж байгаа орлогго нь тухайн боловсролынхоо хөгжил дэвшүүлд хувь нэмрээ оруулж байхаар заасан мөн төреөс оруулж байдаг хөрөнгө оруулалт зэрэгз харахад ашгийн төлөө байж болохоргүй юм. Өнөөгийн боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлд энэ талаар зохицуулж өгсөн.

Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлд төрийн өмчийн боловсрол сургалтын байгууллагыг тогтол болон норматив зардлаар санхүүжүүлэх тухай заасан бол төрийн өмчийн бус сургалтын байгууллагыг энэ хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.9 дүгээр зүйлд

боловсролын асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллага хуулинд заасан дэмжлэг туслалцаа үзүүлэх тухай заасан.

Боловсролын тухай хуулийн тавдугаар бүлэгт боловсролын эдийн засаг, санхүүжилтийн талаар заасан бол Дээд боловсролын байгууллагын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 5 дугаар зүйлд дээд боловсролын байгууллагын санхүүжилтийн эх үүсвэр, улсын төсвөөс бурдуулэх хөрөнгө зэргийг тусгасан бол хуулийн 11 дүгээр зүйлд Засгийн газраас тодорхойлсон дээд боловсролын салбарын талаар баримтлах чиглэл, шаардлагад нийцүүлэн төсөл, хөтөлбөрийг сонгон шалгаруулах, санхүүжүүлэх зохицуулалтыг тусгаж өгчээ.

#### Санал, дүгнэлт

"Ард түмний оюуны амьдрал, соёл бол үндсэн хууль байгууллын оршин хөгжихийн нэг үндэс тулгуур, тусгаар тогтолын баталгааны нэг юм."<sup>10</sup> Иймд Монгол Улсын иргэдийн оюуны мэлмийг мэргэжлийн чиглэл бүрээр нь нээн хөгжүүлэх үндсийн үндэс нь дээд боловсрол юм.

Монгол Улсад боловсролын тогтолцоо хэрхэн хөгжжүүлэх сурч боловсрох эрхийг хангаж ирсэн түүх нь 1924 оноос өмнө нэн бүрхэг байгаа хэдий ч хувьсгалын дараагаас эрчимтэй хөгжжүүлэх ирсэн.

Монгол Улсад дээд боловсролтой хуулынчдыг бэлтгэх ажил хожуу эхлэсэн хэдий ч Хууль зүйн дээд боловсролыг хөгжүүлэх талаар Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль болон бусад эрх зүйн актуудад нийцүүлэх алхам алхмаар урагшлуулсаар байна.

Хууль зүйн сургалтыг хууль зүйн сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудыг тупгуурлан чанаржуулах алхмуудыг явуулж

<sup>10</sup> Б.Чимид Төр нам. эрх зүйн шинэтгэлгэлийн эзгэгтийн асуудал хөрдүгээр давтэр УБ., 2008 он.

байсан бол 2002 онд Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны үндэсний төв<sup>11</sup>-ийг байгуулан 2003 оноос Хууль сонгон шалгаруулах тухай хуулийг батлан гаргаснаар хууличийн мэргэжлийн чанарыг сайжруулах багагүй өөрчлөлтүүдийг хийж эхэлсэн. Хууль зүйн клиникууралтад буюу дадлагын орчны хууль зүйн сургуульд өргөжүүлэн хөгжүүлсэн хэдий ч мэргэжлийн чиг баримжаа олгох төдийхнээр хязгаарлагдаж байна.

Ийнхүү Монгол Улсын боловсролын тогтолцоонд тулгуурлан хууль зүйн дээд боловсрол эзэмшиж эрхийг хангаж байгаа хэдий ч олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүрэг, дэлхийн жишигт нийцсэн мэргэжилтэн болох эрхийг хангах боломж бололцоог бүхэл тогтолцоогоор судлан сайжруулах шаардлагатай байгаа нь илэрхийг байна.

Санал: Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төвлөгөөг "Эрдэм боловсролтой Монгол хүн" хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын хууль зүйн боловсролыг хөгжүүлэхэд БСШУ яам болон ХЗЯ хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааг зорилтод хэлбэрээр тусгаж өтсэн:

"1. Иргэний боловсрол хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2. Хууль зүйн дипломын бус боловсролын тогтолцоог нэвтрүүлнэ" гэж дэвшүүлэсэн зорилтууд тогтолцоог дагаад боловсронгуй болох боломжтой.

Иргэний боловсрол хөтөлбөрийг албан боловсролын хүрээнд бага, дунд боловсролын түвшинд эрх зүйн боловсролын талаарх ойлголтыг өгөх замаар нэвтрүүлж болох бөгөөд албан бус боловсролын хүрээнд зурагт, сонин хэвлэл бусад сурталчилгаа болон албан бус боловсролоор олгох боломжтой.

<sup>11</sup> Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 121 дүгээр тогтоон. Хууль зүй дотоод хэргин сайдын 2002 оны 222 дугаар тушаалаар бавижупж. дурсм зохион байгуулалтын бүтцийн баталсан.

Хууль зүйн дипломын бус боловсролын тогтолцоо албан бус боловсролын хүрээнд бакалаврын агуулгын дараах шат болгон нэвтрүүлэх зэрэг ажлыг судалгаанд сууринлан шат дараалан хэрэгжүүлэх нь хууль эрх зүйн зохицуулалтын хувьд зөрчилдэх зүйлгүй юм. Одоогийн клиник танхимд тулгуурлан өргөжүүлж сургалтын хугацааны дадлагыг сургалтын дараах мэргэшүүлэх сургалт гэдгээр өргөжүүлэн хөгжүүлэх нь хуульчийн чанар сайжрах ач холбогдолтой.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар хууличийн мэргэжил бакалаврын боловсролтой дээрээс нь 2 жил ажилласан буюу дадлагажсан байх тухай заасан бол хууль зүйн дээд боловсролыг бүхэлд нь буюу хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийн асуудлыг хөндсэн зүйлгүй байна. 2014 онд баталсан БСШУ яамны мэргэжлийн чиглэлийн индексээр зөвхөн "Эрх зүй" гэсэн нэг чиглэлд тохиуулан хөтөлбөр боловсруулах, хөтөлбөрт магадлан итгэмж эл хийх асуудлыг 2 хуулиар зэрэг зохицуулсан, мэргэжлийн чиглэлийг нарийвчлан олгодог байх зэрэг ойлгомжгүй зүйлүүд олноор бий болood байна. Ямар чиглэлээр ажиллахад бакалавртай байх юм, магистр докторын шатлал бол гэхчлэн бүхэл тогтолцоогоор нь мэргэжлийн чиглэлийг тал бүрээр нарийвчлан судлах нь хууличийн мэргэжлийг сонгон суралцаж байгаа иргэдийн тухайд мэргэжлээрээ ажиллах нийгэмд эзлэх байр суурийг бататгах ач холбогдолтой болох юм.

Монгол Улсын боловсролын тогтолцоонд тулгуурлан одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрх зүйн актуудад өөрчлөлт оруулахгүйгээр хууль зүйн боловсролын тогтолцоог бүхэлд нь, агуулга стандартыг сайжруулан бакалаврын боловсрол эзэмшиж эрхийг хангахад:

1. Чанартай боловсрол эзэмшүүлэх,
2. Мэргэжлээрээ ажиллах нөхцөл бололцоог бурдүүлэх,
3. Мэргэжлийн нэр хүндийг өргөх,
4. Мэргэжлийн чиглэлийг тодорхой болгох,
5. Багшах боловсон хүчнийг чанаржуулах,
6. Бакалаврын боловсролын ёмнөх шат буюу иргэдийн эрх зүйн боловсролыг нэмэгдүүлэх, хууль зүйн мэргэжил сонгох боломжийг нэмэгдүүлэх,

7. Бакалаврын боловсролын дараах шат буюу дадлагын орчинг сайжруулах, хугацааг уртасгах, мэргэжлийн боловсролын чанарыг сайжруулах,

8. Цаашид суралцах тогтолцоог боловсронгуй болгох /магистр, доктор/ зэргээр сурч боловсрох явцад ажлын байрны үр дүнд нэлөөлөх байдлыг нэмэгдүүлэх, эрхийг хангахаас эхлэн чанаржуулах боломж байгаа нь харагдаж байна.

Гагчхүү тал бүрээс нь шинжлэх ухааны үндэстэй судалгаа хийгдэх нь чухал байна.

---00---

**ҮНДСЭН ХУУЛИЙН 7 НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ БА ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТЭД  
ХОРИГЛОХ, ХЯЗГААРЛАХ ХЭМ ХЭМЖЭЭ**

/онол, практик/



**МУИС-ийн багш, Хууль зүйн ухааны доктор, профессор Ш.Цогтгоо**

**Нийгмийн удирдлагын дээд түвшинд нийтийн ашиг сонирхолд хохирол учруулах гэмтлэгийн зэрхүүд, харин доод түвшинд ихэвчлэн хувийн явцуу эрх, эрх чөлөөг хөндсөн зөвлөлдүүд байрладаг (Чазаре Беккари).**

**НЭГ. Бүгд найрамдах засаг ба Үндсэн хуулийн эрх зүйн онолын асуудал**

Юуны урьд онцлон тэмдэглэж хэлэх нэгэн зүйл бол орчин үеийн улс төрийн ба хууль зүйн шинжлэх ухаанд санаатай ба санаатай бишээр будлантуулсан нарийн төвөгтэй асуудлын нэг нь Үндсэн хуулийн 7 нэмэлт, өөрчлөлт бөгөөд одоо зохиогчид нь хүртэл учраа олохоо больчиход буй ийм проблем юм.

Constitution буюу Үндсэн хууль нь хэн ч зөрчиж үл болох нийгмийн харилцааны хамгийн дээд зэрэмбээтэй эрх зүйн эх сурвалж мөн тул тухайн улсын Үндсэн хуулийн зүйл заалтуудтай бусад салбар эрх зүйн хэмжээний нийцэж байх ёстой гэж Оксфордийн их сургуулийн профессор В.Блакстоун тодорхойлжээ. Проф. В.Блакстоуны эрх зүйн тайлбарас

давсан тодорхойлолт гаргаагүй судлаачид хүлээн зөвшөөрдөг байна.

Үндсэн хууль нь явцуу утгаараа бол Парламентад өөрт нь зориулагдсан хууль юм. Энэ бол УИХ-ын гишүүн хүний ширээний ном, өврийн дэвтэр нь Үндсэн хууль байж аливаа хууль тогтоомжийг зөвхөн Үндсэн хуульд нийцүүлэн батлуулахын төлөө өврийн мэдлэг чадвараа зориулах ёстой бөгөөд түүнд үл нийцсэн аливаа хууль тогтоомжийн үйлчлэлийг таслан зогсоож байхад парламентад ёсны Үндсэн үүрэг, хууль зүйн утга агуулга нь оршдог байна.

Аливаа улсын засаглаглын хэлбэрийг төлөөлгэхийн байгууллага хэрэгжүүлж тайвал Бүгд найрамдах улс гэдэг. Төлөвлөл нь Ерөнхийлгэчийн ба Парламентын гэсэн хөөр үндсэн хэлбэрэй. Хүн амаа нутаг дэвсгэрээр хувийндаа сүүлжэж, тэдэдд уйлчилхэс засаг захиргааны нэгжээ удирдакад зориулан тогтоосон улсын бүтцийг төрийн байгууламжийг гэдэг. Дэлхийн улс гарнцүүд төрийн байгууламжийн нэгдэгдээс /муж, гишүүн улсаас бүрдсэн/ ба нэгдмэл /ЗЭНДНэгжээс бүрдсэн/ улс гэж ангилагддаг. Нэгдмэл буюу унитар улс нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгдэгдээ нэг удирдлага, иргэний нэг харьялвал, нэг шашин шүүлэг, нэг Үндсэн хууль, шүүхийн нэг тогтолцоо, муж улс төлөөлдөгтүүг нэг парламент гэж шинжүүдийн агуулдаг.

Бүгд найрамдах засаг гэдэг бол нийтийн хэргийг нийтээр хэлэлцэн шийдвэр ёс Хүн бүрийн ашиг сонирхлыг нэгтгэн хэлэлцүүлж байгаад олон нийтэд ашигтай гэж шалгуураар шийдвэр гаргажад түүнийн мөн чанар оршино гэж нэргэж эрдэмтэн Чазаре Бекхари тодорхойлий байсан байна. Төвдөө бол XVII-XVIII зуунд төрийн хүнд суртыг эсэргүүцсэн нийтийн ўлз хэрэг, нийтийн эрх ашиг сонирхлын төлөө иргэний хөдөлгөөнөө тэмцлийн ур дунд 1787 оны АНУ-ын анхны Үндсэн хууль, 1789 оны Францын иргэний ба хүний эркийн түнхэг дараалан батлагдаж "Хөгжлийн засаг" буюу "тер-ийн орон зайд" "Public Service", "Civil Service", "Public administration", "Public Servant" буюу иргэний уйлчилгээ, нийтийн уйлчилгээ, нийтээр засхирал, нийтэд уйлчилж албан түүс дэлбаас болсон орчин цагийн цоо шинэ нийгмийн харилцаан дээр Үндсэн хуульт нийдмийн байгууламж бүхий бүддийн нийтийн засаг өврийн дархлаагаа тоогоосон болгөө. Хүн төрөлхтний энэ агуу их ололт Монгол орлон нийтэд хожуу 1992 оны шинэ Үндсэн хуулиар хуялзан зөвшөөрдөсөн болочиж иөннүү күртэл уг мянганараар нутагшиж чадахгүй байгаа болно.

Үндсэн хуулиас болоод төрийн байгууллага, албан тушаалтууд дур зоргоороо авирлаж чадахгүй байгаа бол Үндсэн хууль үүргээ биелүүлж байгаа нь тэр юм. Харин тэд Үндсэн хуулийг тээг саад болж байгаа мэтээр авирлаж байгаа бол өөрсдийнх нь хязгааргүй их эрх мэдлийг мөрөөдсөн мөрөөдөл нь биелэгдэхгүй байгаа нь тэр бөгөөд үүнийг Чазаре Беккари “Нийгмийн удирдлагын дээд түвшинд нийтийн ашиг сонирхолд хохирол учруулах гэмт хэргүүд, харин доод түвшинд ихэвчлэн хувийн явцуу эрх, эрх чөлөөг хөндсөн зөрчлүүд байрладаг”<sup>2</sup> гэж томъёолжээ.

**Өргөн утгаараа бол** Үндсэн хууль нь нэгд, Төрийн эрх мэдлийг хязгаарлаж өгсөн. Нэг хааны, нэг намын гарг байсан эрх мэдлийг буюу Засаг төрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар засгийн гурван салаа мөчир хэн нь юу хийж болох, юуг хийж болохгүй, юунд оролцох ба оролцохгүйг нь хуваарилан тогтоосон байна; хоёрд, иргэн хүнд угаас зөяагдмал эрх, эрх чөлөөг нь баталгааж уулж өгсөн. Хүний эрх бол төр гэдэг сүбэкт сайндаа юмуу хайр энэрэлтэйдээ чамд өгч байгаа зүйл огт биш, харин хүн төрөх дөө л эрх өвлөж төрдөг нь хүн бүрт ижил заяагдмал зүйл.

Бодит байдал дээр хүн өөрийн энэхүү эрх, эрх чөлөөгөө здлэхэд нь төр, төрийн байгууллага, албан тушаалтууд зөвхөн саад хийдэг, бас энэ үнэт зүйлийг нь хязгаарладаг. Хүмүүс үүний эсрэг л хэдэн зуун жил тэмцэж арчилал, иргэний нийгмийн олонот дэвшилгээ нээж илрүүлсэн буюу өөрөөр хэлбэл төрийг хүний эрхэнд халдаж болохгүй гэдгийг нь Үндсэн хуулиар хазаарлан барьж тогтоосон учиртай.

Нийтийн захиргааны буюу бидний ярж заншсаар төрийн захиргааны байгууллагууд Үндсэн хуулийн дээр шаардлагыг биелүүлж

байгаа бол тэр улс оронд арчилсан Үндсэн хууль үйлчилж байна гэж үздэг. Захиргааны чиглэлийн салбар хуулиуд Үндсэн хуулийн ийм шалгутр нийцсэн үйл ажиллагаа явуулснаар сая нийтийн эрх, ашиг сонирхол, иргэний эрх, ашиг сонирхол, хүний эрх, эрх чөлөө хангагдах зүй тогтолтой.

Нийтийн эрх, ашиг сонирхол, иргэний эрх, хүний эрх, эрхчлэв. Үндсэн хуулийн үзэл санааны эсрэг чиглэгдсэн ямар ч хууль, тэрчлэн цэрэг цагдаа, нутгийн захиргааны байгууллага, бүх шатны төрийн албадын нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ бүхий дурсам, журам, заавар, захирамж, тогтоол зэрэг захиргааны актыг хэн ч дагаж мөрдөх, мөрдүүлэх эрхгүй бөгөөд дээрх бүх актууд Үндсэн хуулийн суурь зарчимд нийцсэн нэхцэлд л сая нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ болдог онцлогтой. Тодруулбал, Үндсэн хууль зөрчсөн бол Үндсэн хуулийн шүүх, бусад хуулийг гажуудуулсан бол захиргааны хэргийн шүүх уг актын үйлчлэлийг дор бүр нь таслан зогсоож зөрчлийг арилгах үүрэгтэй.

Үндсэн хуулийн зүйл заалт, агуулга, мөн чанараас гажсан эрх мэдэлтүүдийн дур зоргын аливаа шийдвэр (аман болон бичгийн аль ч хэлбэрийн үйлдэл, эс үйлдэхүй) эцсийн дүндээс тоталитар дэглэм рүү тулхэн оруулж хууль болон нийтийн дэг журмыг завхруулан завхруулсаар улс төрийн хямралд хүргэдэг нь нууц биш юм. Улс төрийн хямрал нүүрлэсэн аль ч улс оронд хууль гууль болж ганц Үндсэн хууль үлддэг болохыг судлаачид анхааруулсаар байна.

Эн бол Үндсэн хуулийг ил далд янз бүрийн арга, хэлбэрээр зөрчөөд байвал тэр улс үндэстэнд өөр дээдлэх, хундлэх нийтийн үнэт зүйлсгүй болж, шашин зан заншил хоёроо хий хоссон ам амандаа магтан дуулсаар бусдын “идэш” болдог гашуун сургамжийг түүх сануулж байна.

<sup>2</sup> Чазаре Беккари. Преступление и наказание. 2014.  
стр. 15

## ХОЁР. Үндсэн хуулийн 7 нэмэлт, өөрчлөлтийн талаарх товч ойлголт

*Нийтийн зүйлийг хувийн болгож,  
хувь хүний эрх чөлөөг  
хэдхэн хүнээс хамааралтай  
болголов нүгэлт  
туйлдаа хүрнэ (Чазере Беккари).*

1. Анх 1999 оны 12 дугаар сарын 24-ны өдөр УИХ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан байна. Уг хуульд Монгол Улсын тухайн үеийн Ерөнхийлөгч бүхэлд нь хориг<sup>3</sup> тавьсан байхаас гадна мөн дээрх нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулийн цэц бага, дунд, их суудлын хуралдаанаараа хэлэлцэж Үндсэн хууль зөрчсөн гэх үзэн Улсын Их Хурлын шийдвэр, түүний хувь бус оролдлуулдагдаараа эсэргүүцсээр эзэлт нь Цэц өөрийн эцсийн шийдвэр болох Тогтоолоо гаргаж дээрх нэмэлт, өөрчлөлтийг хүчингүй болгохээ. Энд Ерөнхийлөгч ч, Үндсэн хуулийн цэц ч өөр өөрийн үүргийг чин шударгаар гүйцэтгэсэн нь харагддаг.

2. Хачирхалтай нь 2000 оны Улсын Их Хурлын сонгуулийн дараа буюу яг нэг жилийн хойно 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хурал өмнө нь 1999 онд Үндсэн хуулийн цэцээр хүчингүй болгочихсон уг 7 нэмэлт, өөрчлөлтийг ямар ч уг үсэг, хэл найруулга, утга агуулжин өөрчлөлтүүгээр хуулбарлан анхны тэрхүү хувилбарыг дахин баталжээ (харьцуулалтыг хавсралтаас үзнэ уу).

Сүүлийн 7 нэмэлт, өөрчлөлтийн наад захын стандарт шаардлага гэхэд л "Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн тухай хууль" гэж хэлбэршиг учиртай атал түүний зүгээр л танилцуулага шиг энгийн албан бичгийн бланк - хуудас

дээр хэвлэсэн байдаг. Харамсалтай нь Үндсэн хуулийн манаачийн үүрэгтэй атлаа Үндсэн хуулийн цэц өмнө нь нэгэнт хүчингүй болгочихсон хууль бус 7 нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч байгаа нь ч тэр юм уу? аль эсвэл явалт яацаагаа гэж буйн илэрхийлэл ч гэмэр юу? "санал" гэгч зүйлийг Улсын Их Хуралд өгсөн байна.

Уг төслийг хэвлэлцэх, санал авах процесс ердөө л хэдхэн цагийн дотор батлагдсан орбосор бол дайны цагийн "оператив-шүүрхай" ажиллагааг аль ч цаг үеийн Үндсэн хууль судлаач ойлгохгүй ийм л юм болжээ.

Тухайн үеийн Ерөнхийлөгч мен л Цэцийн яг нэгэн адил өөрийн анхны хатуу байр суурь буюу бүхэлд нь тавьж байсан хоригосоо ухарч 2000 оны хууль бус 7 нэмэлт, өөрчлөлт дээр "за яхав өөрсдөө мэд" гэж байгаа юм шиг тэгэс, ингэс хийгээд супруулаад хаячихсан байгаа нь тэр хүний хоёр дахь удаагаа со-годох цаг хугацаа, хүсэл сонирхолтой нь холбоотой дарамт, шахалт б ийснэг судлаачид огт үүгүйсгэдэггүй.

Зүй нь нэгэнт хүчингүй болсон хууль болон бусад шийдвэрийн заалтыг шууд буюу агуулгаар нь дахин сэргээвэл Цэц үг дуугүй таслан зогсоож байх үүрэгтэй. Гэвч Цэц өнөө хүртэл энэ үүргээ биелүүлээгүй байгаа. Товчдоо бол Үндсэн хуулийн 7 нэмэлт, өөрчлөлтийг хүчингүй болгосон Үндсэн хуулийн цэцийн тогтоол одоо ч хүчинтэй хэвээрээ мөрддөгд байгаа учраас сүүлийн нь 7 нэмэлт, өөрчлөлт ч хүчингүй гэх үзэх үндэслэлтэй байгаа юм.

Профессор Б.Чимид, академич С.Нарангэрэл нарын зэрэг эрдэмтэдийн онож дүгнэсэнчлэн уг "дордохын долоон өөрчлөлт"-ийг засаж запруулах 16 удаагийн иргэд, олон түмний шударга тэмцэл талаар өнгөрсөн байна /Баримтыг хавсралтаас үзэж болно/.

<sup>3</sup> Монгол Улсын Ерөнхийлөгч хуульд бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих бүрэн эрхтэй (Үндсэн хуулийн 33.1).

Үүнээс үүдээд ингэхэд ер нь Үндсэн хууль - хууль мөн үү? биш үү? гэдэг улс төрийн маргаан үүсч байсныг өнөөгийн өндөрлөгөөс хараад инзэмтэй, бас эмгэнэлтэй түүх гэж хэлж болох юм.<sup>4</sup>

Энэхүү хууль бус 7 нэмэлт, өөрчлөлт нь өнгөц хараад тухайн үеийн Ерөнхийлгэч сонгогчдын олонхиин санал авч УИХ-д олонх болсон Эвслийн хүснэлтийг хүлээн авч дэмжихгүйгээр 7 удаа буцаасан, хоёр ч Засгийн газрыг олгитой хамгаалалтгүйгээр огцуруулсан зэрэг улс төрийн өнгө аястай шалтаг, шалтгаанаас үүдсэн мэт.

Харин үнэн хэрэг дээрээ бол "Үндсэн хууль бол хууль биш" гэх санааны социализмийн үеийн коммунист намын программын дор эрэмбэлэгдэг улс төрийн тунхаг тедийн нэгэн баримт бичиг гэж үзсээр ирсэн хуучин нийгмийн үзэл суртыг шинэ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах концепц болгон боловсруулсан нь илт байдаг. Энэхүү Үндсэн хуульд халдсан хууль бүс үйлдэл орчин үеийн хууль зүйн шинжлэх ухааны практикт хэзээ ч тохиждож байгаагүй гаж үзэгдэл мөн тул түүнийг эргэн харж засч запруулах зайлшгүй шаардлагатай гэдгийг судлаачид нэгэн дуугаар хүлээн зөвшөөрдөг.

Товчдоо бол эрт, орой аль нэг цаг үед хэн нэг субъект дээрх хууль бус нэмэлт, өөрчлөлтийг засч запруулсан зөв голындролд нь оруулж байж, дараа дараачийн Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн асуудал яригдах ёстой гэсэн чиг хандлага /подход/

<sup>4</sup> 1940-1960-оны Үндсэн хууль нь МАХН-ын программын дараах эрэмблэгдсан улс төрийн бичиг баримт гэх тэр үеийн үзэл санааг өнөөдөрнийн ардчилсан Үндсэн хууль дүүцүүнэн Үндсэн хууль чине хууль мөн үү. биш үү хэмээх марглан явуулж байсан нь үзүүлээрин том төөрөгдөл байжээ. Энэ нь 1960 оны Үндсэн хуульд тэр үеийнгийн удирдан чиглүүлэгч гуч бол бүхнэгд ялагч марксист-ленинист онолын үйл ажиллагаандадаа удирдлага болголтод МАХН мөн гэдэг тодорхонтоогос эх үүсвэртэгээр Үндсэн хууль нь хууль биш улс төрийн намын нэгэн онлог бичиг баримт мөн хэмээх тэр хуучин сэтгэгүй өдөө ч гэсэн орчин цагийн Үндсэн хуулийн дэлхий даяншиг ан холбогдыг угүйсээр бүйн нэгэн жишиг нь энэ юм.

эндээс урган гарч байгаа бөгөөд ийм арга зүйгүйгээр Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай яриа нь хоосон цуурай болохос гадна ийм өөрчлөлт хийгдээ ч сөрөг үр дагавар авчрахаас цаашгүй улс төрийн жирийн л нэг амбиц болж хувирах магадлал тун өндөр юм.

### ГУРАВ. Үндсэн хуулийн нэмэлтэд хориглох, хязгаарлах хэм хэмжээ, зарим орны жишиг

Дээдсүйн мэдлийн хазаарлан барьж, иргэдийн эрхийг хүндэтгэн дээдлэх, улсас төөхнүүлэх, засаг төрөө байгуулах эцэс хэм хэмжээг  
Үндсэн хууль гэдэг.

Түүнийг хил хязгаарыг давж алхах эрх хэнд ч байхгүй бөлгөө (Б.Чимиid).

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зарчим, процедур нь ердийн хуультай харьцуулахад маш өндөр шалгууртай, илүү нарийвчилсан бөгөөд тусгайлсан журамтай байна. Үүнд:

➢ Улстөрийн тогтолцоо өөрчлөгдөх (Үндсэн хуулийг анх баталсан хурлыг дахин байгуулах замаар);

➢ Референдумын үр дүнгээр Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулах;

Референдумын үр дүн ихэвчлэн эцсийн биш байдаг бөгөөд парламентаас түүнийн баталсын дараа хүчин төгөлдөр болдог. Ингэхдээ хоёр танхимтай парламентын хоёр танхим хоюул батлах шаардлагатай ба шийдвэрүүд нь хоорондоо тодорхой хугацаатай байх ёстой. Тухайлбал, Грект нэг сараас багагүй, Италид 3 сар байх жишээтэй.

➢ Засаглалын дэглэм солигдох, тухайлбал Ерөнхийлгэчийн БНУ-ын удирдлагын зохион байгуулалтыг парламентын БНУ-ын хэлбэрт шилжүүлэх г.м. Тэрчлэн БНУ-ын

засаглалын дэглэм нь хэвээр байгаа мөртлөө цэргийн дэглэм тогтоход тухайлбал БНСУ-д хоёр ч удаа Үндсэн хуульд нэмэлт оруулсан түүх бий.

➢ Парламент Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны дараа уг шийдвэрийг референдум явуулж баталдаг /Дани, Египет, Швейцар/, мөн холбооны зарим улсуудад муж улсуудын олонхиin саналаар /АНУ-д 3/4/ баталгаажуулдаг байна.

➢ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуралдааны санал хураалтын квот нь ердийн биш дийлэнх олонх байдаг. Жишээ нь, Болгарт 3/4, Францид танхimuудын хамтарсан хуралдааны 3/5, Казахстанд 4/5-ын санал авсны дараа Ерөнхийлөгч Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг рефендумд шилжүүлдэг байна. Тэр ч бүү хэл зарим орнууд Үндсэн хуулийнхээ тодорхой булз, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулахыг бүр месен хориглодог. Тухайлбал, Германд эрх зүйт, ардчилсан, холбооны төрийн зарчимд, Испанид онцгой нөхцөл байдал үссэн тохиолдолд; түүнчлэн Бразил, Грек, Португалд Үндсэн хууль нь батлагдсанаас хойш 5 жилийн хугацаанд түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглодог байна.

➢ Зарим тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг батлахдаа урьдчилсан болон эцсийн гэсэн хоёр удаагийн хуралдаанаар шийдвэрлэдэг бөгөөд эцсийн хуралдааны шийдвэр зүгээр л дийлэнх олонх биш "онцгой нэмэгдүүлсэн дийлэнх олонх"-ын саналаар батлагддаг тохиолдол / Украина/ бас байна.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах үйл явц тусгайлсан журам баримтлахыг шаарддаг бөгөөд энэ эрхийг ихэнх тохиолдолд Ерөнхийлөгч, Депутатуудын тодорхой булз, Холбооны улсад муж улсуудын олонхи, зарим нэг улс оронд Засгийн

газар зэрэг субъектууд здэлдэг.<sup>5</sup>

Эдгээрийн дотроос бид сайны жишээ болгодог АНУ, БНСУ-ын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаарж жишгийг төв хөндье. АНУ-ын Үндсэн хууль дэлхийн анхны бичмэл Үндсэн хууль бөгөөд 1787 онд батлагдснаас хойш 228 жил болсон байна. Энэ хугацаанд Конгрессст Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах оролдлого 10 мянга гаруй удаа гарчээ.

Өөрөөр хэлбэл, Конгрессст сард 4-5 удаа Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт хийж санал гардаг гэж үзж болохоор байна. Харин АНУ-ын Конгрессийн түүх Үндсэн хуульдаа 27-хон удаа нэмэлт, өөрчлөлт хийсэн бөгөөд нэг өөрчлөлтийг 6 сараас 3 жил хүртэл хугацаанд хэлэлцэн баталсан байдал байна. Хамгийн суулд хийсэн "Конгрессийн гишигүүний цалин"-гийн тухай 27 дахь удаагийн нэмэлт өөрчлөлтийг 1789 оны 9 сарын 25-ны өдрөөс эхэлж 202 жилийг дамнан хэлэлцэж арай гэж 1992 оны 5 сарын 7-ны өдөр Конгресс баталж, Ерөнхийлөгч Клинтон гарын үсэг зурсан байж ишигээтэй.

Улс төрчийн байнга яриад байдаг БНСУ-ын Үндсэн хуульдаа оруулсан нэмэлт, өөрчлөлтийн туршлага нь америк зарчмаас ялгаатай нь гэвэл засаглалын дэглэм солигдох үеийн практикт тулгуурласан байдгийг сануулахад илүүдэх юн. Засаглалийн дэглэм солигдох, нийэмэл эдийн засгийн шинжтэй эрс шинэтгэл хийгдэхээс бусад тохиолдолд Үндсэн хууль гар хүрэх санаархал нь ихэвчлэн объектив бодит байдлаас ангид зарим нэг субъект, фракцын явцуу ашиг сонирхол, субъектив байр суурь байдгийг АНУ, БНСУ-ын Үндсэн хуульд нэмэлт оруулах гэсэн удаа дараагийн хууль бус

<sup>5</sup> В.Е.Чиркин. Конституционное право зарубежных стран, 2012. 7-ое изд., стр 43.

"Шинэ Үндсэн хуулийн баталсан депотатуудын үүсгэн байгуулсан Ардчилсан Үндсэн хууль тогтолцоны холбооны (INTERNATIONAL ASSOCIATION OF CONSTITUTIONAL LAW) Ерөнхийлөгч Д.Моондойгийн интэглээс, төрийн ордон, 2015.01.15-ны өдөр. УБ хот.

оролдлогууд нотолж, баталсан түүхтэй.

Ингэж Үндсэн хуульдаа "7 хэмжиж байж, 1 огтлоо" маягаар хандахыг л хууль дээздлэх, төрт ёс. Үндсэн хуулт эрх гээд байгаа юм. Учир нь одоо хүчин төгөлдөр үйлчилж буй 555 хууль, 180 гаруй олон улсын гэрээ конвенцийг Үндсэн хуульд нийцүүлэн баталчихаад байгаа энэ асуудалд хөнгөмсөгөөр хандаж болохгүй.

Бодит байдал ийм байхад манайхан харин Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг ахар болгино хугацаанд хийсэн 2000 оны хууль бус ажиллагаандaa айхтар амтшин гаршиж, "Монгол Улсын Үндсэн хууль хорь хорин жилийн зйтай өөрчлөгдсөөр ирсэн түүхтэй, харин энэ ардчилсан Үндсэн хууль 23 жил болчихлоо, одоо өөрчлөх цаг нь болсон" гэх зэрээр "харьцуулашгүйг харьцуулах" субъектив хийрхэл дээр түүхэн бодит жишээтэй ямар их харшилдаж буйг уншигч авхай та эрэгцүүлэн бодох бүй за.

1992 оны шигээ Үндсэн хуульд заасан парламента д хамгийн олон суудал авсан намууд нийлж Засгийн эрхийг барих хувилбар;

Харин Үндсэн хуулийн 7 нэмэлт, өөрчлөлтийн суурин дээр үүссэн АН-ын "алтан гадас" фракцийг өөртөө нэгтгэж байгуулсан С.Баярын Засгийн газрын "МАНАН" хэмээх өвөрмөц хувилбар хоёр нь Үндсэн хуулийн эрх зүйн талаасаа бол нэг нь Үндсэн хуулийн дагуу байгуулагдах засгийн газар, нөгөө нь Үндсэн хуулийг ноцтой зөрчжик байгуулагдсан хууль зүйн тэс өөр утга агуулгатай ойлголт гэдгийг анхаарвал зохино.

Үүнээс үүдэн 1992 оны хүчин төгөлдөр Үндсэн хуулийн дагуу хамгийн олон судалтай 2 нам хамтарч Засагт оролцох нь зөв үү?

Эсхүл Үндсэн хуулийн 7 нэмэлт өөрчлөлтийн зарчмаар харьцангуй олон судал авсан нам нь бусад дурын цөөн судал бухий намуудтайгаа хамtran засгийн эрхийг барилцах нь зүйтэй юу?

Аль нь зөв бэ? гэдэг улс төрийн бодлого, чигхандлагыг зөв тодорхойлох асуудал олон жилийн туршид хариу нэхэж байгаа болно.

Үргэлжлэл нь дараагийн дугаарт.

Хавсодалт №1

ҮНДСЭН ХУУЛИЙН 7 НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН АГУУЛЫГ ХАРЬЦУУЛСАН ХАРЬЦУУЛАЛТ (1992 ОН, 1999 ОН, 2000 ОН)

—800—

## УЛС ТӨРИЙН НАМД ТАВИХ ШҮҮХИЙН ХЯНАЛТ



**Өмгөөвлийн "Эм Жэй Эл атторнейс" ХХН-ийн партнер өмгөөвлөгч П.Баттулга**

### ОРШЛЫН ОРОНД

Б.Чимид багш "манайд намд тавих шүүхийн хяналтгүй байна" гэж хэлсэн нь надад үндэслэлтэй санагддаг юм. Нам гэдэг нэр томьёо нь PARS буюу Латин үгнээс гаралтай Монголчилбөл "хэсэг, бүлэг" гэсэн үгтэй дүйдэг бөгөөд намыг тодорхой улс төрийн үзэл баримтлал дээр тулгуурласан хүмүүсийн сайн дурын нэгдэл гэж онолд үзэг. Ардчилсан нийгэмд нам дараах үндсэн хоёр үүрэгтэй. Нэгд нийгмийн үүрэг – нийгмийн аль нэг бүлэг, хамтлагийн ашиг сонирхлыг нэгтгэж, тэдний хүсэл зориг, шаардлагыг засгийн түвшинд илрэхийлэх буюу төр, олон нийтийг холбогч гүүр, зуучлагч байх. Хоёр дахь нь нам төрийн сонгуульд ардчилсан, шударга зарчмаар оролцож засгийн эрхийг барих, дор хаяж төрийн бодлогыг тодорхойлоход оролцож. Үүнийг намын улс төрийн үүрэг гэнэ.

Манай улсад 1990-ээд оны эхээр хийгдэж эхэлсэн ардчилсан шинэтгэлийн шийдвэрлэгч алхмын нэг болох улс төрийн шинэтгэлээр намын засаг төрийг бүхэлд нь зэзгэн, ажил

үүргийг нь орлон хийж, бүрэн эрхийг төвөөлөн хэрэгжүүлдэг байдлыг халж, намыг засаг төрийн үйл хэрэгт зөвхөн сонгуулийн замаар голлон оролцож. тухайн улс орны тогтвортой бодлого, үзэл баримтлалыг үргэлжлүүлэх, төр, олон нийтийг холбогч гүүр байх улс төрийн хөгжлийн жам ёсны голдрилд нь оруулах эхлэлийг тавьсан билээ.

Гэсэн хэдий ч сурсан юмыг сураар боож болдоггүй гэдэг шиг сонгуулийн замаар төрд гарсан намын зүтгэлтнүүд засаг төрийн ажлыг хуулиар биш намаар орлуулж хийдэг зуршил, хуучин хэвшлээсээ салж чадахгүй байна. Өнөөгийн манай улсын улс төр, эдийн засгийн хямрал, сонгуулийн будлиан, асуудлын үүр уүрхай нь улс төрийн нам, ялангуяа парламентад суудалтай намууд болжээ. Нийм нь Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн субъект, засгийн эрхэнд гарах зорилготой, тогтвортой, зохион байгуулалтын нэгдэл болохынхоо хувьд түүний үйл ажиллагаа Үндсэн хуулийн хүрээнд байх ёстай. Манай парламентад суудалтай намууд нийгэм, улс төрийн тогтолцоонд эзлэх байр суурь, эрх, үүргээсээ хальж, иргэний байгууллага байх үндсэн шинжээ алдаж, гагцхүү түүнийг удирдаж буй хүмүүсийн тогтолцоо багаж, зэвсэг болсон нь агаарт байгаа нарыг алгаараа хааж чадахгүй гэдэгтээ ижил болжээ. Парламентад суудалтай нам, зэвсэл улс төрийн зорилгоо гүйцэлдүүлэх, сонгуулийн үр дунгээс хамааралтайгаар Үндсэн хуулийн дагуу Засгийн газрыг хуулийн дагуу бурдуулэх үүрэгтэй байдал тул түүний үйл ажиллагаанд хууль, эрх зүйн илүү өндөр шаардлага, шүүхийн хяналт байх учиртай. Гэтэл өнөөгийн бодит байдал дээр намуудын (үнэн чанартай тэдгээр

<sup>1</sup> Б.Чимид "Төр, нам эрх зүйн шинэтгэлийн эзэгтэй асуудал" I дэвтэр УБ., 2008. 1999 дэх тап.

намуудын удирдлага, эсхүл нөлөө бүхий гишүүдийн үзэмжээр) хооронд байгуулсан гэрээ, зөвшлилгэл гэдгээр Үндсэн хуулийг угүйгэж, зоргоор хандах явдал гаарч байна.

2008 оны УИХ-ын сонгуулийн дараа олонхиин судал авсан (45 судал) МАН (тухайн үеийн МАХН, цаашид "МАН" гэх), дангаараа Засгийн газрыг бурдуулэх боломж байсаар атال, АН "хамтран ажиллах" гэрээ гэгчийг байгуулж, олонхи, цөөнх холилсон Хамтарсан Засгийн газрыг байгуулав. Үүнтэй холбоотойгоор академич Ж.Амарсанaa "2008 оны УИХ-ын сонгуульд МАН, олонхи болсон хэдий ч цөөнх болсон улс төрийн хүчинтэй хамтарч Засгийн газар байгуулсан нь Үндсэн хуулийн үзэл баримтлалтай нийцэхгүй байгааг дурдах нь зүйтэй<sup>2</sup>, гавьariat хуульн Б.Чимид Хувьсгалт нам "хамтарсан Засгийн газар" гэж хаа ч байхгүй нэртэй юмыг сонгуулийн үед эвсээгүй өөр намтай нийлж байгуулах санаачилга гаргаснаараа Үндсэн хуулийн үзэл баримт үал зөрчиж байна<sup>3</sup> хэмээн өөрдийн 6 тээлдээ дурдсан байдал. Үндсэн хуулийн Дэчдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа дарвэн жил байна" гэж заасан байхад 2004 оны сонгуулиар АН, МАН намууд зөвшлилөл 1, 2, 3 баримт бичгүүдийг хамтран байгуулж, эхний хоёр жил АН, дараагийн хоёр жил МАН Засгийн газрыг тэргүүлнэ гэж тохиролцож Үндсэн хуулийг зөрчив. Тэгээд МАН тэвчээгүй. Ерөнхий сайд Ц.Элбэгдоржийн тэргүүлсэн Засгийн газрыг гэрээний хугацаа дуусахаас эмне нь унагаж байлаа.

Түүнчлэн УИХ, Засгийн газрын бүрэн эрхдэг хамаарах асуудлыг намын байгууллага шүүрэн авч шийддэг, намын шийдвэрийг төрийн шийдвэр болгож ёсчилдог хуучин тогтолцооны улжиг арилахгүй байна. Үүний тод жишиээ

<sup>2</sup> Ж.Амарсанaa "Ардчилсан эрийн зүйт ёс" УБ, 2009. 35 дахь тал

<sup>3</sup> Б.Чимид "Тэр нам эрх зүйн шинжилгэлийн эзэлтэй асуудал" II дэвтэр УБ, 2008. 234 дэх тал

гэвэл Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшлилцэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. ..." гэж заасан байтал Ардчилсан намын Гүйцэтгэх зөвлөлөөс Засгийн газрын гишүүнд нэр дэвшигчийг тодруулж, эдээр нэр дэвшигчийг томилох эсэх асуудлыг УИХ-д өргөн мэдүүлэхийг Ерөнхий сайд Ч.Сайханбилэгт даалгасан шийдвэр гаргав.<sup>4</sup> Зүй нь Ерөнхий сайдад тулгах, даалгах бус үгүй ядаж санал болгомоор. Бас Ардчилсан намын Гүйцэтгэх зөвлөл Тавантолгойн нүүрсний орд газрыг ашиглахаар байгуулагдах төслийн компанийн 51 хувийг "Эрдэнэс Тавантолгой" ХК-д эзэмшиүүлэх нь зүйтэй гэж үзэн, энэ шийдвэрийг хэрэгжүүлж ажиллахыг парламент болон Засгийн газарт ажиллаж байгаа гишүүддээ үүрэг болгосон шийдвэр гаргаж байсан.<sup>5</sup> Энэ бол "улс орныг нам удирдана" гэсэн енгэrsen үеийн ухамсын төвөргдлөөсөө салж чадаагүй харуулж байна.

#### Улс төрийн намд тавих шүүхийн хяналт

Намд Үндсэн хуулийн шүүх, намыг бүртгэсэн шүүх хяналт тавьж байх нь улсын аюулгүй байдал, Үндсэн хуульт байгууллын үүднээс зүй ёсны хэрэг. Энэ нь нам Үндсэн хуулийн дагуу ажиллаж байгаа эсэхийг хэмжих, улс төрийн зохиомол хямрал бий болгохгүй тулд хэрэгтэй юм.<sup>6</sup> Үндсэн хуулийн цэц одогийн практикаар Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт буй маргааныг

<sup>4</sup> Ардчилсан намын Гүйцэтгэх зөвлөлийн курлын 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн "Үүрэг аял тухай" (6 дугаар тогтолцоог).

<sup>5</sup> Ардчилсан намын Гүйцэтгэх зөвлөлийн курлын 2015 оны 4 дугаар сарын 28-ны өдрийн "Тавантолгой орд тагыр ашиглал тухай" 05 дугаар тогтолцоог. Эн сурвалж: <http://www.tolgo.mn/index.php/sale/news/370>

<sup>6</sup> Б.Чимид "Тэр нам эрх зүйн шинжилгэлийн эзэлтэй асуудал" I дэвтэр УБ, 2008. 210 дахь тал.

харьялан шийдвэрлэж байгаа ба уг заалтад намын үйл ажиллагаа Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг хянах зохицуулалт тусгагдаагүй тул улс төрийн намын үйл ажиллагаа Үндсэн хуульд нийцэж буй эсэхэд Үндсэн хуулийн цэц хяналт тавихгүй.

Гэхдээ цаашид Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үсгэх үндэслэл болж буй заалт, мөн зүйлийн 2 дахь хэсэгт заасан цэцээс дүгнэлт гаргах гэсэн 2 заалтын уялдаа, холбоог Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих Үндсэн хуулийн цэцийн үндсэн зорилготой нь нийцүүлэн тайлбарлаж улс төрийн намын үйл ажиллагаа Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг хянах цэц харьялан шийдвэрлэх боломжтой болохыг үгүйсгэхгүй.

**Улс төрийн намын тухай хуульд уг асуудлыг хэрхэн зохицуулсан байна вэ?**

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Улс төрийн намын тухай хуульд намд тавих шүүхийн хяналтыг хэрхэн зохицуулсныг 1990 оны Улс төрийн Намуудын тухай хуультай харьцуулан үзэх нь тулгуур ач холбогдолтой боловуу.

Улс төрийн намын тухай хууль (Шинжисэн наиралт)	1990 оны Улс төрийн намуудын тухай хууль
<b>Намын дүрэм, мөрийн хөтөлбөр, тэдгээрт оруулсан измэлт, өөрчлөлт нь Үндсэн хууль, энэ хуультай нийцэж байгаа эсэхэд Улсын дээд шүүх хяналт тавина. Нам өөрийн дүрэм, мөрийн хөтөлбөртэй оруулсан измэлт, өөрчлөлтийг 10 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлнэ.</b>	<b>Намын бүртгүүлэх тухай ирүүлсэн материалыг БНМАУ-ын Дээд шүүх хянан узээд намын дүрэм, мөрийн хөтөлбөр нь БНМАУ-ын Үндсэн хууль, энэ хууль, бусад хуульд нийцэж байвал 21 хоногийн дотор улсын бүртгэлд бүртгэнэ.</b>
21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг	6 дугаар зүйл

23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг	2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг
Монгол Улсын бүрэн эрхт байдлаа, тусгаар тогтолцыг бусниулах үндэстний эв нэгдлийг задлан буттаргах, Үндсэн хуулийн бус аргаар төрийн эрхийг авах, хүч түрэмгийлэх, олон түмний түйвээн үймүүлэх, аллагыг хядлага уйлдах, яс үндэс, арьсны өнгөөр ялгаралтан гадуурхах, бусад орны тусгаар тогтолц, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын эсрэг үйл ажиллагаа, сурталчилгаа явуулсан буюу шашны, цэргийн болон цэргэжсэн. Фашист намын хэлбэрт шилжсэн бол Улсын дээд шүүх намыг тараах тухай шийдвэр гаргаж, уг намыг энэ хуулийн 23.1-д заасан хугацаанд улсын бүртгээс хасаж, нийтдэд мэдээлнэ.	БНМАУ-ын бүрэн эрх, тусгаар тогтолцыг бусниулах үндэстний эв нэгдлийг задлан буттаргах, Үндсэн хуулийн биш аргаар төрийн эрхийг авах, хүч түрэмгийлэх, олон түмний түйвээн үймүүлэх, аллагыг хядлага уйлдах, яс үндэс, арьсны өнгөөр ялгаралтан гадуурхах, түүнчлэн улс эх орон, ард түмний эрх ашигийн эсрэг болон бусад орны тусгаар тогтолц, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын эсрэг үйл ажиллагаа, суртал нэвтрүүлэг явуулах зорилго бүхий нам байгуулахыг хоригноно.'
14 дүгээр зүйл	
Намын үйл ажиллагаа Үндсэн хууль, бусад хуульд нийцэж буй эсэхийг хянах зохицуулалт байхгүй.	Нам үйл ажиллагаагаараа БНМАУ-ын Үндсэн хууль, энэ хууль, бусад хууль зарчсан буюу дүрэм, мөрийн хөтөлбөрөөс гарсан нь нотлогдвол БНМАУ-ын Дээд шүүх уг зөрчилгээрилгээний шаардах буюу намын үйл ажиллагааг зогсоон.
14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг	
Намыг тараасан тохиолдод намын хөрөнгийн асуудлыг хэрхэн шийдвэрлэхийг зохицуулаагүй.	Намыг тараасан тохиолдод тухайн намын хөрөнгийг улсын орлого болгон.

1990 оны Улс төрийн намуудын тухай хуульд Улсын дээд шүүхээс дараах 4 төрлөөр намын үйл ажиллагаанд хяналтыг тавихаар зохицуулсан байна.

\* 1990 оны Улс төрийн намуудын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг "Энэ хуулийн 2 дугаар зүйлийн тусгаар тогтолцоог бусниулах үндэстний эв нэгдлийг задлан буттаргах, Үндсэн хуулийн биш аргаар төрийн эрхийг авах, хүч түрэмгийлэх, олон түмний түйвээн үймүүлэх, аллагыг хядлага уйлдах, яс үндэс, арьсны өнгөөр ялгаралтан гадуурхах, түүнчлэн улс эх орон, ард түмний эрх ашигийн эсрэг болон бусад орны тусгаар тогтолц, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын эсрэг үйл ажиллагаа, суртал нэвтрүүлэг явуулах зорилго бүхий нам байгуулахыг хоригноно."

1) намын дүрэм, мөрийн хөтөлбөр, тэдгээрт оруулсан нэмэлт өөрчлөлт Үндсэн хууль, бусад хуультай нийцэж буй эсэхийг хянах;

2) Нам үйл ажиллагаагаараа БНМАУ-ын Үндсэн хууль, энэ хууль, бусад хууль зөрчсөн буюу дүрэм, мөрийн хөтөлбөрөөс гажсан нь нотлогдвол БНМАУ-ын Дээд шүүх уг зерчлийг арилгахыг шаардах;

3) Нам үйл ажиллагаагаараа БНМАУ-ын Үндсэн хууль, энэ хууль, бусад хууль зөрчсөн буюу дүрэм, мөрийн хөтөлбөрөөс гажсан нь нотлогдвол БНМАУ-ын Дээд шүүх намын үйл ажиллагааг зогсоох;

4) Хуульд заасан хориглосон үйл ажиллагаа явуулж байгаа намыг тараах.

1990 оны Улс төрийн намуудын тухай хуульд буй гаргасан зөрчье арилгахыг намаас шаардах, намын үйл ажиллагааг зогсоох, намыг тараах тухай зохицуулалтуудыг Улсын дээд шүүхийн 1992 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн "Улс төрийн намуудын тухай БНМАУ-ын хууль, намын гишүүнээс түдгэлзээл зохих албан тушаалын тухай БНМАУ-ын хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай" 15 дугаар тогтолцоо 4-т "нам үйл ажиллагаагаараа Монгол Улсын Үндсэн хууль, Улс төрийн намуудын тухай БНМАУ-ын хууль, бусад хууль зөрчсөн, дүрэм, мөрийн хөтөлбөрөөсөө тажсан нь нотлогдвол зөрчлийн шинж чанараас шалтаалан Улс төрийн намуудын тухай БНМАУ-ын Улс төрийн намуудын хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Иргэний хэргийн танхим уг зөрчлийг арилгахыг хугацаа заан шаардах буюу намын үйл ажиллагааг зогсоо тухай тогтоол гарган шийдвэрлэнз" мен тогтоолын 5-д "Намыг тараах ундэслэл нь зөвхөн Улс төрийн намуудын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан хориглосон үйл ажиллагааг явуулсан байх юм" гэж тайлбарлажээ.

Одоогийн Улс төрийн намын тухай хуулиар Улсын дээд шүүх намын дүрэм, мөрийн хөтөлбөр, тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлт Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хуультай нийцэж буй эсэхийг хянах (1), хуульд заасан хориглосон үйл ажиллагаа явуулж байгаа намыг тараах (2) гэсэн хоёр хэлбэрээр намын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэт явцууруулж хуульчилсан нь нуухыг нь авах гээд нүдийг нь сохолсонтой адил зүйл болжээ.

Улсын дээд шүүхийн 1992 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 15 дугаар тогтоолын 3-т "Иргэний хэргийн танхим намыг бүртгэх, үйл ажиллагааг нь зогсоох, намыг тараах тухай өргөдлийг хянан шийдвэрлэхдээ шаардлагатай гэж үзвэл намын гишүүдийн тоо, хөрөнгийн хэмжээ, эх үүсвэржшалгах, намын бүтэц, зохион байгуулалттай танилцах, шинжээч томилон дүгнэлт гаргуулж зэрэг зохих байцаан шийтгэх ажиллагааг Монгол Улсын Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар явуулна" гэж тайлбарласнаас үзэхэд тухайн үед иргэдийн зүгээс Улсын дээд шүүхэд хандан намын үйл ажиллагааг зогсоох, намыг тараах тухай өргөдөл гарган шийдвэрлүүлэх боломжтой байжээ.

Харин Зохиогч 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Улсын дээд шүүхэд Арчдилсан намын дүрмийн 3.6.1.4-т буй "3.3.3 дугаар заалтыг зөрчсөн эсвэл өөрийн нам дангаар болон хамтарч байгуулсан Засгийн Газар, сонгогдсон Засаг даргыг намын шийдвэрийг зөрчин огцуруулсан нь тогтоогдвол намаас хасах" гэсэн заалтын "... өөрийн нам дангаар болон хамтарч байгуулсан Засгийн Газар, сонгогдсон Засаг даргыг намын шийдвэрийг зөрчин огцуруулсан ..." гэсэн нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх талаар шийдвэр гаргуулахаар хандсан. Харин Улсын дээд шүүхээс 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 3-41 тоот

<sup>1</sup> <http://www.legalinfo.mn/law/detail/619?lawid=619>

албан бичгээр "... Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.9-д намын дүрмээр зохицуулах намын дотоод зохион байгуулалт, ўйл ажиллагаатай маргааны шүүх хянан шийдвэрлэхгүй гэж заажээ. Энэ төрлийн маргааныг намын эрх бүхий байгууллага хянан шийдвэрлэдэг тул таны гаргасан гомдол шүүхийн харьялалд хамаараахгүй байна." гэсэн хариу өгсөн. Үнээс үзэхэд нэгэнт намын дүрэм, мөрийн хөтөлбөр, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Улсын дээд шүүх Үндсэн хуульд нийцсэн гэж үзэх бүртгэж авсныг тухайн намын дүрэм, мөрийн хөтөлбөр, түүнд Үндсэн хуульд нийцэж буй эсэх асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхийг олгожээ. Эдүгээ Үндсэн хууль зэрчсэн улс төрийн намыг татан буулгах тогтолцоо ардчилсан ёсны унэт зүйлсийг хэрэгжүүлэх арга хэрэгслэл болсон байна.<sup>8</sup>

Зарим орны Үндсэн хуульд намын зорилго, ўйл ажиллагаагаа Үндсэн хууль, ардчиллын зарчмуудад нийцсэн байх шаардлагыг тавьсан байдал. Тухайлбал, ХБНГУ-ын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 1-д "Улс төрийн нам нь ард түмний улс төрийн үзэл санааг төлөвшүүлэхэд оролцно. Улс төрийн намыг хэн ч чөлөөтэй байгуулж болно. Улстөрийн намын дотоод байгууллагууд нь ардчиллын зарчмуудыг баримтална. Улс төрийн нам нь өврийн хөрөнгө, хөрөнгийн эх үүсвэр, хөрөнгийн захиран зарцуулалтыг олон нийтийн өмнө хариуцна", БНСУ-ын Үндсэн хуулийн 8 дугаар зүйлийн 1-д "Улс төрийн нам нь зорилго, зохион байгуулалт, ўйл ажиллагааны хувьд ардчилсан байх ба ард түмний улс төрийн үзэл санааг төлөвшүүлэхэд шаардлагатай бүтэц, зохион байгуулалттай байна" гэж тус тус заажээ. Үгзээр зогсохгүй улс төрийн намыг тараах, түүнийг ўйл ажиллагаагаа Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг хянах эрхийг Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрхэд хамааруулсан байдал. Үндсэн хуулийн хяналтын энэхүү механизмыг Германчууд фашизмд идэгдсэн түүхэн сургамжаасаа улбаалан нэг талаас улс төрийн намуудыг хамгаалах, тэдгээрийн оршин тогтоно явдлыг баталгаажуулах,

нэгөө талаас улс төрийн тоталитар дэглэмийг номногч намыг бий болгоос сэргийлэх үүднээс анх бий болгосон бөгөөд улмаар Болгар, Польш, БНСУ гэх мэт улсууд авч өөрчилж Үндсэн хуулийн шүүхэд улс төрийн намын зорилго, ўйл ажиллагаагаа Үндсэн хуульд нийцэж буй эсэх асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхийг олгожээ. Эдүгээ Үндсэн хууль зэрчсэн улс төрийн намыг татан буулгах тогтолцоо ардчилсан ёсны унэт зүйлсийг хэрэгжүүлэх арга хэрэгслэл болсон байна.<sup>9</sup>

Өөрөөр хэлбэл намын зорилго, ўйл ажиллагаагаа нь Үндсэн хуулиар бэхжүүлсэн ардчилсан хэв журамд нийцэхгүй, эсхүл түүнийг зайлзуулах оролдлогыг илэрхийлж байвал, мен тухайн улсын бүтцэд халдсан шинжийг агуулж байвал Үндсэн хуулийн шүүх улс төрийн намыг хориглох боломжтой гэсэн уг.<sup>9</sup> Ингэхдээ улс төрийн намын оршин тогтоно баталгааг алдагдахгүй байх үүднээс уг улс төрийн намыг тараах хүсэлт гаргах эрхийг тодорхой субъектээр хязгаарладаг байна.

### Бүгд Найрамдсаа Солонгос Улс

Тус улсын Үндсэн хуулийн 8 дугаар зүйлийн 4-д "Улс төрийн намын зорилго буюу ўйл ажиллагаагаа нь ард түмний унэт зүйлсэд халдсан тохиолдолд Засгийн газар Үндсэн хуулийн шүүхэд түүнийг тараах саналаа тавьж болох бөгөөд улс төрийн нам нь Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрээр тарна" гэж заасан. Тодруулбал улс төрийн намын зорилго, ўйл ажиллагаагаа нь Үндсэн хуулиар тогтоосон ардчиллын үндсэн зарчимд харшилж байгаа тохиолдолд улс төрийн намыг татан буулгах эрхийг тус улсын Үндсэн хуулийн шүүх эдэлнэ. Улс төрийн намыг тараахыг санал болгох эрх нь Засгийн газарт, түүнийг

<sup>8</sup> Сон Ин Хёг "БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн арга ажиллагаа ба процесс" Хууль дээдлэх ёс сэргүүл УБ., 2008. №2 58 дахь тал.

<sup>9</sup> Ц.Сарантuya "Үндсэн хуулийн процессын эрх зүй: суурь ойлголт, тулгамдсан асуудал" УБ., 2005. 132 дахь тал.

тараах эрхийг Үндсэн хуулийн шүүхэд олгожээ.

Улс төрийн нам нь ардчилсан улс оронд улс төрийн чухал шинжийг агуулдаг уичир түүнийг тараах асуудалд энгийн эвлэлдэн нэгдсэн байгууллагын тараах асуудалтай харьцуулахад тодорхой шат дамжулага, үе шат, болит бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөхгүй байх боломжгүй учир зөвхөн Үндсэн хуулийн шүүх веерийн шийдвэрээр тараах эрхтэй юм.<sup>10</sup> Саяхан буюу 2014 оны 12 дугаар сарын 19-ний өдөр БНСУ-ын Үндсэн хуулийн шүүх Нэгдсэн дэвшилтэд нам (Unified Progressive Party)-ыг хойд Солонгос Улсын социалист загварын системийг дэмжсэн, ардчилсан зарчимтай зөрчилдсэн, үндэсний аюулгүй байдалд сергөөр нөлөөлөх үйл ажиллагаа явуулсан гэж үзж намыг тараах тухай шийдвэр гаргажээ.<sup>11</sup> Энэ нь тус улсын Үндсэн хуулийн шүүх байгуулагдсан цагаас хойш анхны тохиолдол болж байгаа аж. Засгийн газар 2013 оны 11 дүгээр сард уг намыг тараалгах тухай хүснэгтээ шүүхэд өгчээ.

### Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Германы Үндсэн хуулийн шүүх мөн адил улс төрийн намын үйл ажиллагаа, зорилго нь Үндсэн хуулийг зөрчсөн тохиолдолд түүнийг тараах эрхтэй байdag аж. ХБНГУ-ын Үндсэн хуулийн 8 дугаар зүйлийн 2-т “Өөрийн зорилго, зорилт болон намын гишүүдийн хандлагаас шалтгаалан чөлөөт ардчилсан нийгмийг унагаах, устахаа эсхүл ХБНГУ-н оршин тогтолцд аюул учруулахаар санаархсан намыг Үндсэн хууль зөрчсөнд тооцно. Холбооны Үндсэн хуулийн шүүх нь улс төрийн нам Үндсэн Хууль зөрчсөн эсэх асуудлыг шийдвэрлэнэ” гэж заасан байна,

<sup>10</sup> Сонин Хэг “БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн арга ажиллагаа ба процесц” Хууль дээдлэх ёс сэргүүл УБ, 2008 №2 58 дахь тал

<sup>11</sup> <http://www.forbes.com/world/2014/12/18/e-korea-constitutional-court-orders-dissolution-leftist-party-as-sued-pro-north/>

Тус улсын Холбооны Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1-д “Улс төрийн нам Үндсэн хууль зөрчсөн эсэхийг тогтоолгох тухай хүснэгтийг Бундестаг, Бундесрат эсхүл Холбооны Засгийн газар гаргаж болно. Мен зүйлийн 2-т “Хэрэвээ намын үйл ажиллагаа нь нэг муж улсаар хязгаарлагддаг бол тухайн муж улсын Засгийн газар нь тухайн намын эсрэг хүснэгтийг гаргаж болно” гэж заажээ. Хэрэвээ хүснэгтийг үндэслэлтэй гэж үзвэл Холбооны Үндсэн хуулийн шүүх Улс төрийн нам Үндсэн Хууль зөрчсөн тухай шийдвэр гаргах бөгөөд уг шийдвэр нь намын хуулийн дагуу эсхүл бүтэц зохион байгуулалтын хувьд бие даасан тодорхой хэсэг, бүлэгт хамаатуулсан байж болно. Шийдвэр гарснаар нам эсхүл түүний бие даасан хэсэг, бүлгийг татан буулгаж, тэдгээрийн эрх, үүргийг эрх залгамжлан авах байгууллагыг байгуулахыг хориглоно. Мен намын эсхүл түүний бие даасан хэсэг, бүлгийн хөрөнгийг Холбооны өмч болгоохор шийдвэр гаргаж болно.<sup>12</sup>

Өнөөг хүртэл ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүх хоёр удаа буюу 1952 онд Socialist Reich Party (SRP), 1956 онд Германы коммунист нам (Communist Party of Germany) –уудыг тус тус хориглож байжээ. Мен 2001 онд Германы Үндэсний ардчилсан намд (National Democratic Party of Germany) хориг тависан ч процессын асуудлаас болж уг шийдвэрээ 2003 онд цуцалсан байна.<sup>13</sup>

<sup>12</sup> Холбооны Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 46 дугаар түүлиний 3 дахь хэсэг.

<sup>13</sup> [http://www.bundesverfassungsgericht.de/EN/verfahren/Wichtige\\_Verfahrensarten/Parteiverbotsverfahren/parteiverbotsverfahren\\_node.html](http://www.bundesverfassungsgericht.de/EN/verfahren/Wichtige_Verfahrensarten/Parteiverbotsverfahren/parteiverbotsverfahren_node.html)

## Дүгнэлтийн оронд

Монголын ардчиллын ирээдүй улс төрийн намуудын төлөвшил, үйл ажиллагаа, түүнд тавих хяналтаас хамаарах цаг үе тулгараад байна. Энэхүү сэдэмжийг бичих явцад парламентад суудалтай намуудын үйл ажиллагаа, ялангуяа улс тэр, нийгмийн өдөр тутмын амьдралд их өргөн хүрээтэйгэр шууд тусгалаа олж, зөрэг, серөг нөлөөтэй байх бөгөөд энэ хэрээрээ эрх зүйн зохицуулалт шаардсан үр дагаврыг үүсгэж байна. Улс төрийн намууд тэр дундаа парламентад суудал бүхий намуудын үйл ажиллагаа улс орны амьдралд шууд нөлөөтэй, үр дагавар үүсгэж байгаа тул намын үйл ажиллагааг хянах шаардлагатай болжээ. Өнөөгийн байдлаар намын үйл ажиллагаа Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг хянах зохицуулалт түйлийн тодорхой биш байна.

Иймд улс төрийн намд тавих шүүхийн хяналтыг боловсронгуй болгох үүднээс дараах агуулгатай заалтыг Улс төрийн намын тухай хуульд оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

**1) Улсын дээд шүүх зөвхөн намын дүрэм, мэрийн хөтөлбөр, тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бус намын үйл ажиллагаа, шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянах, хэрэв нам үйл ажиллагаагаараа Үндсэн хууль зөрчсөн бол зөрчлийг арилгахыг тухайн намаас шаардах эсхүл намын үйл ажиллагааг нь зогсох талаарх 1990 оны Улс төрийн намуудын тухай хуулийн заалтыг одоогийн хуульд тусгах;**

**2) Улсын дээд шүүх намын дүрэм, мэрийн хөтөлбөр, тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлт болон намын шийдвэр, үйл ажиллагаа нь Үндсэн хууль зөрчсөн эсэхийг иргэний гаргасан өргөдөл, хүснэгтийн дагуу хянадаг зохицуулалтыг бий болгох;**

**3) Намыг тараалгах тухай хүснэгтийг зөвхөн Ерөнхийлөгч, Засгийн газар Улсын дээд шүүхэд гаргаж болохыг хуульчлах;**

**4) Намыг тараасан тохиолдолд тухайн намын өмч хөрөнгийг улсын орлого болгодог байх зэрэг болно.**

---00---

## ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖУРАМ



Өвөрхангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүч

Б.Сугар

### Оршлын оронд

Үндсэн хууль бол хувь хүмүүсийг төреес хамгаалах баталгаа, төрийг хязгаарлах чадвартай хэм хэмжээний бурдэл тул төрийн аливаа үйл ажиллагаа хатуу тодорхойлогдож, чанд хязгаарлагдаж байх шаардлагатай, ийнхүү барьж хязгаарлах боломж нь Үндсэн хууль ажээ.

Үндсэн хуультай улс орнуудын тухайлбал, АНУ, Бүгд Найрамдах Франц' зэрэг улсуудын түүхээс харахад колончлол, хаант засгийн дэглэмийг тухайн улсын иргэд тулхэн унагаад өөрсдийн эрх чөлөөг түнхаглах, Засгийн газар байгуулах, тэр засаг, иргэдийн хоорондын харилцааг л журамлах зорилготойгоор анх Үндсэн хуулийг бий болгожээ. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийг тэр засаг иргэдийн хооронд байгуулсан нийгмийн гэрээ ч гэж үзэж болох мэт...

Тухайн нэг улс орон бүрийг 1 барилга гэж санавал том, жижиг, сайхан, муухай янз бүрийн барилгаар улсыг төсөөлж болно. Гэхдээ тэрхүү барилгуудын үндэс суурин гагчхүү Үндсэн хуулиар л бүгд нийтээр гагнан

Хүн төрийнхөнөөн Үндсэн хуультай болсон түүх тус 2 орчиний холбогдоц туп иш татах дүрдсан болно.

бэхжүүлж байна.

Бидний Монголчууд түүхэндээ 1924, 1940, 1960, 1992 оны гэсэн 4 Үндсэн хуультай, Сүүлийн нь буюу 1992 оны Ардчилсан, Шинэ гэгдэх Үндсэн хууль 5977 үгнээс бүтэж, тэдгээр үгс арчилал, эрх зүйт ёс, хүний эрхийг бэхжүүлэх, дархлан хамгаалах язгуур суурь хууль болж мөрдөгдсөөр энэ чийг хүрчээ.

Үндсэн хууль бол хүршгүй оргил, өөрчилж үл болох зүйл огтоос биш, гэхдээ бид нуухын нь авах гээд нүдийг нь сохлох, орчин үежүүлбэл жоомоо алах гээд байшингаа шатааж болохгүй санаж яваха учиртai. Бидэнд ийм гашуун түүх бас бий. Одоо түүний нь засах гэж элдэвэрээр оролдож байна. Гэсэн атал мэн л Үндсэн хуульд дур зоргоор халдаж өөрсдийн өчүүхэн, явцуу хүсэлдээ нийцүүлэн өөрчлөх гэсэн санаархал, хандлага, үзэл санаа хүчтэй мэдрэгдэх болсон тул үүнийг таслан зогсоох, хууль дээздлэх, эрүүл саруул үзэл санаанд өөрийн өчүүхэн тус дэм, хувь нэмрээ оруулах болов уу хэмээн сэтгэв.

### 1. Асуудал

Манай улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах журам хэт өрөнхий, нэмэлт, өөрчлөлт оруулахад ямар болзол, шалгуур байх, ямар асуудлаар нэмэлт, өөрчлөлт орчилтуяг хориглох, яагаад хориглодог талаар тусгайлсан зохицуулалт саяхныг болтол байсангүй. Тусгайлсан зохицуулалт едгээ бий болсон нь дэвшилттэй хэдий ч нийгмийн шаардлага нэрэр нам, улс төрчдийн дураар авирлах нехцэлийг бууруулсан уу гэвл үгүй. Энэ байдал нь аливаа нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуулийг дордуулсан, түүний язгуур

үзэл санааг хөндөж явцуу эрх ашгийн үүднээс хийгдэхийг үгүйсгэхгүй<sup>2</sup>. Тийм ч учраас Үндсэн хуульд дархлаа суулгах, хамгаалалт бий болгохын тулд олон улсын түвшин болон онол, практикийг сайтар харьцуулан судалсны эцэст Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хөндөх нь зүйтэй бөгөөд үүнийг шийдвэрлэх нь хууль зүйн шинжлэх ухаанд тулгамдсан гол асуудлын нэг болжээ.

## 2. Онол, сургаал

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулдаг 2 арга хэлбэр байдаг гэж дийлэнх судлаачид санал нийлдэг байна. Эхнийх нь, албан ёсны арга хэлбэр, үүнд Үндсэн хуульд өөрт нь заасан нөхцөлөөр эсхүл тусгайлсан хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулж, эрх бүхий байгууллага баталдаг. Харин албан бус арга хэлбэр гэдэгт шүүхийн тайлбар ордог байна. Шүүхийн тайлбарт гагчхүү Үндсэн хуулийн агуулга бүхий шүүхийн шийдвэр буюу манайхаар Үндсэн хуулийн цэцийн шийдвэр л гагчхүү хамаарна. Энэ тохиолдолд уг эх Үндсэн хуулийн бичвэр нь бодитоор өөрчлөгдхүгүй ч Үндсэн хуулийн шүүх /Цэ/ түүнийг хэрхэн тайлбарлаж, хэрэглэж буйгаар агуулга нь өөрчлөгддөг гэж үздэг байна. Иймээс энэ нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтэд тооцоогох ёстой гэж үздэг ажээ. Хэдийгээр шүүхийн тайлбараар Үндсэн хуулийн бичвэр өөрчлөгддэгүй боловч энэ нь хууль ёсны нэмэлт, өөрчлөлтэд тооцогдог тохиолдол байдгийг хүлээн зөвшөөрдөг ажээ.

Түүнчлэн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тодорхой арга механизмууд бас бий. Тухайлбал: Хaanы зарлигаар, парламент батлах, ард түмний санал асуулгаар болон

<sup>2</sup> "Дордуулсан 7 өөрчлөлт" гэж судлаачид нарлэж, энэ изршлээрээ хууль зүйн шинжлэх ухаанд судлагдахуун болтолоо хөгжэж. Уг 7 өөрчлөлтийн талавр ушашгүй, судлаагүй, бинзэгэй Үндсэн хуулийн эрх зүйн судлаач үүй биз ээ. Өнөөдөрийн асуудал өрөөс уг өөрчлөлтөөс л бий болсон.

парламент ба шүүхээс хэсэгчлэн баталж тайлбар гаргах арга журмаар тогтоох зэрэг арга механизмыг нэрлэж болно.

Мен Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хатуу<sup>3</sup>, уян<sup>4</sup>, холимог гэсэн арга зарчим өдгөө дэлхий дахинд үйлчилж байна. Дийлэнх улсуудад Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нехцел, хязгаарлалт, хэлбэр, журам нь Үндсэн хуульд өөрт нь сууж өгсөн байдаг бол бас ч цөөнгүй улс оронд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмыг тусгайлсан хуулиар нарийвчлан зохицуулдаг. Харин манай улсын Үндсэн хуульд уг асуудал хэт өрөнхий зохицуулагдсан учраас Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль хожим 2010.12.23-ны өдөр анх батлагдсан ба хатувтар арга зарчмытай улсад манай орныг өрөнхийд нь хамааруулж үзэх нь түгээмэл байна.

Гэхдээ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад тавигдах хууль зүйн өрөнхий шаардлагыг Үндсэн хуулийг өөрийг нь боловсруулж, баталдаг журамтай ижил байхаар тогтоох шаардлагатай гэж үзэж байна. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах бол яг ямар журам баримтлахыг тусгайлан зааж өгөх шаардлагатай. Учир нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд амархан эсхүл ердийн журмаар

<sup>3</sup> Ердийн хуулийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулахаас их тод ялгатай, хүссэн тохиолдол бүрт өөрчлөх оролцлогод хориг саад болж чадах тусгайлсан журам тогтоосон байхыг ойлгоно. Жишээ нь АНУ, ОХУ, ХБНГУ, Франц эзргэ орнууд хатуу арга зарчмытай. Хатуу арга зарчим нь улс орон бурд харьцаангүй өөр өөр болзол шалтгаутай. АНУ-ын тухайд Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулаадахаа. Конгрессийн 2 танхмын нийт гишүүнийн дөрөвний гуравын ирцэгийэр халзаж чуулганд оролцсон нийт гишүүдийн гуравын хоброс доогүйн санаалаар батална. Инд баталсны дараа 50 миж улсын гуравын хоброс доошгийн нь хууль хууль тогтоогч буюу 34 түүнээс доошгүй муж улсын хууль тогтоогч уг нэмэлт, өөрчлөлтийн баталсан тохиолдолд сая АНУ-ын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болгодог байна.

<sup>4</sup> Ердийн хуулийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулахтай адил журам.

нэмэлт, өөрчлөлт оруулж болохоор байвал чухам үүгээр нь дамжаад Үндсэн хуульд хялбархан нэмэлт, өөрчлөлт оруулах боломж бүрдэнэ гэсэн үг. Иймд Үндсэн хуулийг анх хэрхэн баталсан жишгээр нэмэлт, өөрчлөлт оруулах, үүнтэй адил журмаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг баталж, нэмэлт, өөрчлөлт оруулж байх нь зүйд нийцнэ.

### 3. Хэн хэрхэн хийх

Үндсэн хууль бол хүний жам ёсны эрхийнх нь эрх мэдлийн байгуулалт, хувь хүний тэр хийгээд аливаа зүйлэс хамгаалах хууль ёсны тогтолцоо, хуулийг гажуудулах, хүний эрхээс өөр чиг зорилт илэрхийлэхээс сэргийлэх үзэл зарчим нь төдийгүй хуулийн засаглал /шударга ёсны ноёрхол-/ыг тогтоох хүн төрөлхтений тэр хүсэл<sup>5</sup>, эзгэг, тулгуур хууль болохынхоо хувьд манай орны эрх зүйн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг учраас Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудалд туйлын ул суурьтай, нухацтай хянур хэндахгүй бол Үндсэн хуулийн чиг үүрэг угүйсгэгдэх, улс орны тогтвортой байдал. цаашлаад улс орны, нийгмийн хандлага, хөгжил дэвшилд ч сергэ нелөө үзүүлж болзошгүй санаж явууштай.

Эрх зүйн онолд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад агуулга болон журам /процесс-/ын хувьд хязгаарлалт байдаг бөгөөд эдгэр хязгаарлалтууд нь Үндсэн хуулийн хамгаалалт болж байдаг гэж сургадаг байна. Агуулгын хязгаарлалт нь өөрөө процессын хязгаарлалтаас хамааралтай, процессын хязгаарлалтыг хэр сайн дагаж мөрднө, тэр хэрээр агуулгын хязгаарлалтыг хадгалж чаддаг ажээ. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах агуулгын хязгаар нь Үндсэн хуулийн язгуур үзэл санааг зөрчихгүй, язгуур суурь зарчим, зорилгоос ухрахгүй

<sup>5</sup> Х Тэмүүжин Jub frasl буюу ёст үг Улаанбаатар хот, 2003. 114 дэх тал

байх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг хадгалах, Үндсэн хуулийн үзэл санааг дордуулахгүй байх зэрэг ач холбогдолтой, Үндсэн хуулийн хамгаалалт болдог байна. Гадаадын нэлээдгүй улсад уг хамгаалалтыг Үндсэн хуульдаа тусган хуульчилсан байдаг ба үүнд төрийн хэлбэр, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, шуух эрх мэдлийн бие даасан байдал, төрийн албан ёсны хэл зэргээр нэмэлт, өөрчлөлт оруулахыг ул зөвшөөрч хүний эрх, эрх чөлөө зэрэг асуудлаар дордуулсан болон хязгаарласан нэмэлт өөрчлөлт оруулахыг хатуу хориглодог байна. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд энэ талын зохицуулалт нэлээдгүй бий<sup>6</sup>. Хэдийгээр манай улсыг нэмэлт, өөрчлөлт оруулах арга зарчмын хувьд хатуувтар Үндсэн хуультай гэж үзэж болох хэдий боловч нэмэлт, өөрчлөлт оруулахад бас тийм хэцүү биш гэдгийг бид 2000 оны туршлагаар мэдэх болсон.

Зонхилох хоёр намын нөлөө бүхий 10 орчим хүн суурччаад Үндсэн хууль өөрчилнэ гээд протокол үйлдэж суудаг<sup>7</sup> болсон тухай мэдээ байх бөгөөд биелэгдэх боломжтойг 1992 онос хоish Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүдээс харж болно. Чухамхүү онцгой буюу хүндрүүлсэн нөхцөл байдлыг хангаж байх сая Үндсэн хуулийг өөрчилж болохоор заасан байх нь Үндсэн хууль төрт ёсны бас нэгэн шинж чанар<sup>8</sup> юм.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд хууль тогтоогч нь ямар нөхцөлд нэмэлт, өөрчлөлтийг баталж болох эсэхийг нарийвчлан зааж өгөөгүйгээрээ

<sup>6</sup> Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.2

<sup>7</sup> Б.Чимид. Тэр, нам, эрх зүйн шинэлгэлийн эзэлтэй асуудал, нэгдүгээр дэвтэр. Улаанбаатар хот, 2008 он, 240 дэх тал.

<sup>8</sup> Ю.Харбик, Орчин үеийн үндсэн хууль төрийн тодорхойлог нь. Монгол улс дахь эрх зүйн шинэлгэлийн шилжилтийн үе сэдэвт олон улсын симпозиумын баримт материалын эмхэтгэл. 90 дэх тал

боловсронгуй бус<sup>9</sup> зохицуулалттай гэж харагдаж байх ба өнөөгийн Монголын нийгэм, улс төрийн байдал, хүрсэн түвшин, төлөвшил, хандлага, шийдвэр гаргагчдын боловсролын түвшин, хууль эрх зүйн ухамсар, сойлын төлөвшил бүрэн тогтох төгөлдөржөөгүй энэ цаг үед зохицомжгүй зохицуулалт гэж судлаачид үзэх болжээ.

Зарим эрдэмтэн судлаачид Шинэ Үндсэн хууль батлах, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад ард нийтийн санаалаас өөр аргаар шийдэх боломжгүй<sup>10</sup> гэж үздэг. Манай улс шиг парламент нь мэргэшээгүй<sup>11</sup>, улс төрийн намууд, тэдгээрийн лидерүүдийн /зөв буруу/ нөлөөлөл их, эдийн засгийн ашиг сонирхол, соногчдын саналыг худалдан авах, хувийн ашиг сонирхлоо тэргүүнд тавих, улс төрийн эрх мэдлийг ямар ч аргаар хамаагүй авахыг хичээх зэрэг хандлага давамгайлж байгаа ийм цаг үед Улсын Их Хурлаас Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эрх мэдлийг нарийвчлан зохицуулж, зайлшгүй байх хориг саад болохуЙ шаардлагыг тодотгох ёстай.

Ийнхүү Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага нөхцөл, журам тодорхой, нарийвчлан зохицуулагдсан байх нь хууль төгтоогч түүнийг зөрчих боломжийт хязгаарлах бөгөөд уг асуудал Үндсэн хуулийн

шүүх<sup>12</sup> Үндсэн хуулийн цэц-ийн хамгаалалтад орох боломжтой болно.

Улсын Их Хурал 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Үндсэн хуульд халдаж “Дордуулсан 7 өөрчлөлт”<sup>13</sup>-г оруулахдаа төслийн хоёр хэлэлцүүлгийг 10-12 цаг 50 минутын хооронд буюу 3 цаг хүрэхгүй хугацаанд дундаа их /хоолны/ завслагатайгаар хийж дуусгасан<sup>14</sup> байдаг. Үндсэн хуульд оруулсан энэхүү нэмэлт, өөрчлөлт нь эрх мэдэл хуваарилалтыг эвдэхэд хүргэсэн гэж иргэд Үндсэн хуулийн цэцэд хандсан боловч Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуультай нийцэж байгаа эсэхийг магадлан шалгах, дүгнэлт гаргах ямар ч эрх Үндсэн хуулийн цэцэд байхгүй”<sup>15</sup> гэжээ.

Тиймээс Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн дагуу боловсруулагдсан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар Үндсэн хуулийн цэцэд хянуулах эрхтэй байх зохицуулалт бий болох нь маш чухал юм. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орсон л бол уг дуугүй уг нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулийн цэц хянадаг байх ёстай, ийм хууль зүйн зохицуулалт байх ёстай.

Үндсэн хуулиар хамаа бусаар оролдоно гэдэг улсаараа жонглёрдоно

<sup>12</sup> Үндсэн хуулийн шүүхүүд Үндсэн хуульд парламентаас оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хянадаа Үндсэн хуулийг боловсруулах, өргөн мэдүүлэх болон батлах процедуруюулахад уг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт орсон л бол уг дуугүй уг нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулийн цэц хянадаг байх ёстай, ийм хууль зүйн зохицуулалт байх ёстай.

<sup>13</sup> Б Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал: хөгжил. асуудал. Эрэ зүйн сэтгүүл, Улаанбаатар хот. 1/2007(15). 41 дахь тал.

<sup>14</sup> Б Чимид. Тер, нам, эрх зүйн шинэгээгийн эзгэгтэй асуудал. нэгдүгээр дэвтэр. Улаанбаатар хот. 2008 он. 98-99 тал.

<sup>15</sup> М.Батсуур, Ч.Өнөрбаяр, Эрх зүйт ёсны үүднээс Үндсэн хуулийн авч үзэх нь, Үндсэн хууль ба эрх зүйт ёс: илтгэлийн эмчилгэл, Улаанбаатар хот. 2009 он. 26 дахь тал.

ГЭСЭН ҮГ<sup>16</sup>.

#### 4. Гадаад орны зохицуулалт

220 гаруй жилийн туршид АНУ-ын Үндсэн хуулийг хянан үзэх тухай саналыг Конгресст 10.000 орчим удаа хэлэлцэж, 27 удаа нэмэлт орсон байхад ОХУ-д<sup>17</sup> 1980-1990 оны хоорондох 10 жилийн хугацаанд Үндсэн хуульд 300 нэмэлт, өөрчлөлт оржээ<sup>18</sup>. Тэгэвл хатуу Үндсэн хуулийн учир Японы 1947 оны Үндсэн хууль, Данийн 1953 оны Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт огт ороогүй байна. Уян хатан журамтай орнуудад Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь нэн хялбар<sup>19</sup> байдаг тухай дээр дурдсан тул олныг нурших нь илүүц биз ээ<sup>20</sup>.

Япон улсын Үндсэн хуулийн 9 дүгээр бүлэгт Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар зохицуулсан бөгөөд уг Үндсэн хуулийн 96 дугаар зүйлд: "Үндсэн хуулийн нэмэлтийг парламент санаачлах эрхтэй. Танхим бүрийн бух гишүүдийн гуравны хоёроос дээш олонхийн нэгдсэн саналаар санаачлах ба соёрхон батламжлахын тулд тэр даруйд нь ард түмэнд танилцуулна. Ард түмний олонх зөвшөөрсөн байх шаардлагатай ба нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлахад эзэн хаан дэмжсэн байх ёстой" хэмээн заасан байна.

Мөн Норвегид парламент Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг дараагийн сонгууль болохоос

<sup>16</sup> Б.Чимид. Төр, нам, эрх зүйн шинэтгэлэйн эзгэгтэй асуудал: нэгдүгээр давтэр. Улаанбаатар хот, 2008 он, 241 дахь тал.

<sup>17</sup> ОХУ, социалист бусад орнуудад Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан тулд Хувь тогтоо дээд байгууллагыг буудалуулж буй депутатыг хувьнан хоёр хувьнан санал авах тухай Үндсэн хуулиадаа заасан боловч, "ноготоо гэрэлзээр" ямар ч саадгүй шийдвэрээд байсан Энэ нь наммын бодлогыг уг дуугийн хөргүүлэхэд холбогдуулж байв

<sup>18</sup> Т.Сангдорж. Дэлхийн улсуудын үндсэн хуулыг ёсны хөгжил мөн чанбар, онцлог Монгол Улсын Үндсэн хуулиин узэл баримтлалын асуудал. Улс төрийн боловсролын академийн эмчилгээн төхмөл, улаанбаатар хот, 1999 он 16 дахь тал.

<sup>19</sup> Тухайлбал Ираны Шинэ Зеланд, Саудын Араб гэх мэт.

<sup>20</sup> Жишээ нь АНУ-ын нийтээр хүлээн зөвшөөрсөн хөндөхжүй, үйлчилж "дурэм"-тэй, уг дурмийн 1789 онд баталсан, зөв сурье тавьсан эзрээр бичих гэмдэглэх нь түгээмэл байдаг ажээ.

нэг жилийн өмнө гаргаад дараагийн парламент нь уг асуудлыг 2/3 саналаар шийдвэрлэдэг.

Дани, Шведийн Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулахад хуучин шинэ хоёр парламент хоёулаа баталсан байх хэрэгтэй байдаг.

Финляндад Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулахад эхний парламентын  $\frac{1}{2}$  хувиар баталсан байх шаардлагатай ба мөн дараагийн парламентын гишүүдийн 2/3 санал авснаар<sup>21</sup> уг нэмэлт өөрчлөлт хүчинтэй болдог байна.

Харин Истони, Литва, Латив зэрэг улсуудад Үндсэн хуулийн хамгийн чухал зүйл, заалтуудыг ард нийтийн санал асуултын үндсэн дээр өөрчилж болдог ба бусад зүйлийг парламентийн дийлэнх олонхийн саналаар нэмэлт өөрчлөлт оруулдаг байна. Жишээ нь: Литвад 3/4-аас дээш хувийн саналаар Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийг өөрчилж болдог байна.

Парламентын 2 танхимтай эсвэл Ерөнхийлгэчийн засаглалтай улсуудад 2 танхимаар хоёулаа баталж нэмэлт, өөрчлөлт ордог мөн ерөнхийлгэчтэй зөвшилцдэг. Жишээ нь: Германы бундестаг хоёулаа дэмжиж, баталж байж Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулдаг. АНУ, Канад, Австрали зэрэг холбооны улсуудад мужуудынхаа болон Засгийн газраас санал, дэмжлэг авсан байх шаардлагатай. Харин Швейцарь аливаа нэмэлт өөрчлөлтийг ард нийтийн санал асуулгаар шийдвэрлэдэг бөгөөд парламент дэмжсэн ч гэсэн ард нийтийн санал асуулгаа заавал явуулдаг байна.

Ийнхүү Үндсэн хуульдаа нэмэлт өөрчлөлт оруулах журмаа нарийвчлан, олон оролцогчдоос хамааруулан хязгаарласнаар тухайн Үндсэн хуулийн суурь зарчим, зорилгоos ухрахгүй байх, олон улсад хүлээн зөвшөөрсөн хэм

<sup>21</sup> Онцгой тохиолдолд нэг парламентын нийт гишүүдийн 5% доошгүй хувин саналаар

хэмжээгээ хадгалах ач холбогдолтой<sup>22</sup> байдаг.

### 5. Манайд ямар асуудал байна

Ерөнхийдөө гурван үндсэн асуудал байна гэжүүзж байна. 1-рт Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаалыг Үндсэн хуулийн цэц УИХ-д шууд өргөн мэдүүлэх, 2-рт Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шалгуурыг өндөрсгөх, агаа зарчмын хувьд хатуу болгох, 3-рт Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулийн цэц Үндсэн хуульд нийцсэн эсэх талаар ямар нэгэн өргөдөл, голдом гэлгүй шууд хянаж уг нэмэлт, өөрчлөлт Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргадаг байх.

Нэгдүгээрт: Үндсэн хуулийн Жаран наймдугаар зүйлийн 1-д: “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд санаалыг Үндсэн хуулийн цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно” гэж заажээ.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эрх зүйн хэлбэр нь хууль юм. Тодруулбал хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд Үндсэн хуулийн хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар гагцүү Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн. Засгийн газар л хамаарна.

Харин Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуульд дээд хянант тавьж<sup>23</sup>. Үндсэн хуулийн талаарх маргааныг шийдвэрлэж дүгнэлт гаргах замаар Үндсэн хуулийн үзэл баримтлал, утга агуулга, үзэл санаа, зүйл заалт хэсэг бүрийн уялдаа холбоо, утга агуулгыг тайлбарлаж Үндсэн хуулийн маргааныг эзслэн шийдвэрлэдэг мэргэшсэн шүүх юм. Иймд Үндсэн хуулийн цэц

<sup>22</sup> Neal Devins, William and Mary School of law. Can we make the constitution more democratic, 2007

<sup>23</sup> Зүгээр л 1 хянант биш дээд хянант гэж тодотгосон байх тул үүнийг анхварах хэрэгтэй.

нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага, үндэслэл, нотолгоо байгаа эсэх талаар Үндсэн хуулийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргаж санал боловсруулан УИХ-д өргөн мэдүүлэх боломж хууль зүйн хувьд байж болно<sup>24</sup>. УИХ уг санал санаачилгыг нь зайлшгүй авч үзэдг, тогтох хэлэлцэдгээ байх нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад хууль эрх зүйн талаас баримтлах гол үндэслэл болно, харин санал санаачилгыг хэрхэз зэрэг асуудлыг Үндсэн хуульд зайлшгүй оруулах хэрэгцээ шаардлага нэгэнт бий болсон.

Үндсэн хуулийн дээрх дурдагдаж буй Жаран наймдугаар зүйлийн 1 дэх заалтаас үзэхэд “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан ...” гаргахас гадна мен “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ... санаалыг Үндсэн хуулийн цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж ...” болохоор хуульчлан зааж өгч зохицуулжээ. Хуулийн уг заалтаас үзэхэд Үндсэн хуулийн цэц Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлаар санал УИХ-д өргөн барих бүрэн эрхтэй байна.

Харин Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эрх зүйн хэлбэр нь хууль байх тул Үндсэн хуулийн цэцэд гагцүү Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль л санаачлах онцгой бүрэн эрх олгох замаар энэ асуудлыг

<sup>24</sup> Б.Чимид. Үндсэн хуулийн мэдлэг: УЛААНБААТАР ХОТ 2008. 422 дахь тал. “Үндсэн хуулийн цэцэд хууль санаачлах эрх олгохоор хуулийн төсөвд тусгасан боломж тухайн үеийн парламент зөвхөөрөгүй билээ” гэсэн нь тухай үед уг асуудлыг судлаачид хөндөх тавьж байсан тедийгүй хуулийн төсөв болтлоо боловсрогдож, хуулийн төсөв хэлбэрээр парламентад өргөн баригдаж, халэлцэгдэж байжээ.

шийдвэрлэх бүрэн боломжтой<sup>25</sup>.

**Хоёрдугаарт:** Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах бол ердийн журмаар шийдвэрлэх боломжтой байна.

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ердийн журам гэдэг нь холбогдох хуулийн дагуу боловсруулан өргөн барьсан хуулийн төслийг<sup>26</sup> УИХ хэлэлцэж санал хураан олонхийн саналаар батлах тухай асуудал юм. Өөрөөр хэлбэл УИХ-ын гишүүд /76/-ийн олонхи /39/-ийн иртэйгээр хэлэлцэж тэдний олонхи /20 буюу түүнээс дээш/-ийн саналаар батална<sup>27</sup>.

Эндээс харахад Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд хэзээч ямар ч нэмэлт, өөрчлөлт оруулах боломж хууль тогтоогчид нээлттэй байна. Энэ нь серег үр дагавар дагуулах боломжийг ургэлж өөртөө агуулж байна гэсэн үг юм. Эрсдэл байна.

Тухайлбал Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад тавигдах хууль эрх зүйн шаардлагыг Үндсэн хуульд өөрт нь нэмэлт, өөрчлөлт оруулдаг журамтай ижил байхаар тогтоох хэрэгтэй.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах бол ямар журам баримтлахыг тусгайлан зааж өгөх шаардлагатай<sup>28</sup>. Учир нь Үндсэн хуульд

<sup>25</sup> Үндсэн хуулийн цээг Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санасчлалыг эрхтэй болсон тохиолдолд онцгайсан 23 жилийн хугацаанд Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулийн цээг өнөөдөр шууд хянах боломжгүй. Харин нэмэлт, өөрчлөлт хуулийн хүчин төгөлдөр болсны дараа Үндсэн хуулийн цээг нь Үндсэн хуулийн зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүснэлтээр хянан шийдвэрлэх хуулийн зохицуулалттай<sup>29</sup>.

<sup>26</sup> Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн цэцэд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хянах эрх хэмжээ байхгүй гэсэн үг. Ийм эрхийг Үндсэн хуулийн цэцэд өгөх нь зүйд илүү нийцнэ. Гэхдээ тухайн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь хуулийн хүчин төгөлдөр болохоос өмнө Үндсэн хуулийн цээг хянадаг байх нь илүү ач холбогдолтой, зерэг үр дагавартай гэж үзэж байна. Учир нь нэгэнт Үндсэн хууль нэмэлт, өөрчлөлт орчиховол тухайн нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн

<sup>27</sup> Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1. 32.2. Монгол Улсын Их Хурлын чуулганы хурдалдааны дэгийн тухай хуульд зассан журмын дагуу гэх ойлгоно.

<sup>28</sup> Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд энэ тухай зүйл заалт огт баатгүй тул ердийн журам хүчлийн байна гэж үзүүлж. Үүнийг хууль тогтоогч, сонирхон судлалын бүрхэвчийн тухай хуульд зассан журмын дагуу гэх ойлгоно.

<sup>29</sup> Ийм боломж бүрнээс бий.

нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд амархан эсхүл ердийн журмаар нэмэлт, өөрчлөлт оруулж болохоор байвал<sup>29</sup> түүгээр дамжаад Үндсэн хуульд хялбархан арга замаар нэмэлт, өөрчлөлт оруулах боломж бүрдэх талтай юм.

Учир иймд Үндсэн хуулийг хэрхэн баталж, нэмэлт, өөрчлөлт оруулахаар байна, ямар журам, зарчим байна, тэр журмаар нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байх нь зүйд нийцнэ.

**Гуравдугаарт:** Үндсэн хуулийн цээг Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хуулийн хүчин төгөлдөр болохоос нь өмнө Үндсэн хууль зөрчсөн эсэхийг нь хянадаг болох ёстой. Энэ бол Үндсэн хуулийн маш том чухал хамгаалалт болох нь гарцаагүй.

Үндсэн хуульд ямар нэгэн нэмэлт, өөрчлөлт ороход тухайн нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулийн цээг өнөөдөр шууд хянах боломжгүй. Харин нэмэлт, өөрчлөлт хуулийн хүчин төгөлдөр болсны дараа Үндсэн хуулийн цээг нь Үндсэн хуулийн зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүснэлтээр хянан шийдвэрлэх хуулийн зохицуулалттай<sup>30</sup>.

Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн цэцэд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хянах эрх хэмжээ байхгүй гэсэн үг. Ийм эрхийг Үндсэн хуулийн цэцэд өгөх нь зүйд илүү нийцнэ. Гэхдээ тухайн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь хуулийн хүчин төгөлдөр болохоос өмнө Үндсэн хуулийн цээг хянадаг байх нь илүү ач холбогдолтой, зерэг үр дагавартай гэж үзэж байна. Учир нь нэгэнт Үндсэн хууль нэмэлт, өөрчлөлт орчиховол тухайн нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн

<sup>30</sup> Үндсэн хуулийн Жаран түргээдүүлэгээр зүйл.

хуулийн нэгэн адил хүчинтэй<sup>31</sup> тул уг нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулийн цэц хойноос нь хөөж хүчин төгөлдөр болсон Үндсэн хуулийн маргааныг хянах нь тийлаас хүндэрлэлтэй. Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь териин /засаглалын/ эрх мэдлийн хуваарилалтыг эвдэхэд хүргэсэн гэсэн өргөдлийг Үндсэн хуулийн цэц хүзэн авсан боловч Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд ируулсан тайлбartaа "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуултай нийцэж байгаа эсэхийг магадлан шалгах, дүгнэлт гаргах ямар ч эрх Үндсэн хуулийн Цэцэд байхгүй"<sup>32</sup> гэжээ. Тодруулж хэлбэл бил Үндсэн хуульд нэгэнт орсон нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулийн цэц хянах нь ямар хэцүү магадгүй боломжгүй болохыг бил урьд урьдын туршлагаас харж мэдэх болжээ.

### Дүгнэлт

Эцэст нь дүгнэхэд хэн, хэзээ, ямар журмаар, хэр хэмжээний нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуульд оруулах вэ гэдэг асуудал нэмэлт, өөрчлөлт оруулах журмын хуульд тодорхой, нарийвчлан заагдсан байх шаардлагатай бөгөөд нийгмийн хэрэгцээ шаардлагаас үүдэн Үндсэн хуульд тухайн нийгмийн бүхий л харилцааг хоцрохгүй зохицуулахын тулд нэмэлт, өөрчлөлт орох нь зүй ёсны хэрэг юм. Гагчхүү нэмэлт, өөрчлөлт нь улс орон, ард түмэн, нийгмийн сайн сайхны төлөөх нэмэлт, өөрчлөлт байхаас бус түр зуур засгийн эрхэнд байгаа хэсэг бүлэг эсхүл хэн нэгэн улс төрч, нам эвслийн хувийн ашиг сонирхлоос ангид байх учиртай<sup>33</sup>.

<sup>31</sup> Үндсэн хуулийн Жаран есдүгээр зүйлийн 4 дахь хасг.

<sup>32</sup> М.Батсуурь, Ч.Өнөрбаяр. Эрх зүйт ёсны үүднээс Үндсэн хуулийн авч узх Нь, Үндсэн хууль ба эрх зүйт ёс: илтглийн эмхэтгэл, Улаанбаатар хот, 2009 он. 26 дахь тал

<sup>33</sup> Ж.Амарсанаа, "Үндсэн хуулийг өөрчлөс цаг болсон байхыг угүйсэхгүй" ярилцлага, Сэтгүүлч Л.Энхдэлгэр - 201.01.23-ны өдөр.

Үндсэн хуульд оруулж буй нэмэлт, өөрчлөлт нь түүний язгуур суурь үзэл санаанд харшлахгүй байх нэхцэл бүрдүүлэхэд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам хамгийн чухал ба энэ талаар тодорхой алхмууд хийгдэж байгаа нь нэн сайшаалтай хэрэг билээ. Энэ мэт сайн алжам бий ч дордсон зүйл бий.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам уян хатан байх нь Үндсэн хуулийн алдааг засах боломж олгох хэдий ч Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам нь хэр бат бөх, тогтвортой байна Үндсэн хууль тэр хэмжээгээр тогтвортой байж цаашилд тухайн орны тогтвортой байдал бас шалтгаалж байдаг гэж үздэг байна. Түр зуурын олонх буюу ирээд буцагчид "тухайн үед засгийн эрхийг барьж буй олонх" түрхэн хугацааны давуу байдлаа ашиглан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаас сэргийлэх, тэднийг хязгаарлах үүднээс Үндсэн хуульдаа хунд нөхцөлеөр нэмэлт, өөрчлөлт оруулах журамыг сонгох нь манай улсын хувьд ирээдүйгээ бодсон илүү ашигтай хувилбар юм.

Үндсэн хууль нь төрөөс Монголын ард түмэнтэй байгуулсан гэрээ тул түүнийг дархлаажуулах шаардлагатай дараах саналыг дэвшүүлий байна:

1. Үндсэн хуулийг дархлаа хамгаалалттай болгож улс териин нам, бүлэглэл, төрийн тушээдийн буюу түр зуурын олонх, ирээд буцагчдын хувийн ашиг сонирхлыг хязгаарлахын тулд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хүндруулсэн нөхцөлийг бий болгох, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа парламентаар хэлэлцэж, ард нийтийн санал асуулгаар батлах эсхүл хоёр парламент дамжиж хэлэлцдэг байх, ийм хэрэгцээ шаардлага нэгэнтэй бий болсон нь илрэхийг гэж үзэж байна.

2. Үндсэн хуулийг хэрхэн баталж, нэмэлт, өөрчлөлт оруулж байна, яг түүнтэй адил журмаар Үндсэн хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг баталж, мөн нэмэлт, өөрчлөлт оруулдаг болох шаардлагатай.

3. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн дагуу боловсруулагдсан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль нь хуулийн хүчин төгөлдөр үйлчлэлтэй болохоос нь өмнө Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар Үндсэн хуулийн цэц хянах эрх хэмжээтэй байхаар зохицуулалт хийх.

4. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Үндсэн хуулийн цэц УИХ-д шууд өргөн мэдүүлэх буюу

Үндсэн хуулийн цэцэд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санаачлах эрх олгох.

5. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шалгуурыг өндөрсгөх, арга зарчмын хувьд хатуу болгох зайлшгүй шаардлага бий. Өнөөдөр уг хуульд өрдийн журмаар нэмэлт, өөрчлөлт оруулах, боломжтой байгаа тул чухам үүгээр дамжиж Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад цаг зуурын олонхи буюу ирээд буцасдад тийм ч их хүндрэл байхгүй байсаар байна.

---000---

## МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭГ ШҮҮХЭД ХЭРЭГЛЭХ АСУУДАЛ (Бодлогын судалгааны товч тайлан)<sup>1</sup>

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн бодлогын судалгааны товч тайлан

### Оршил

Орчин үед олон улсын шинжтэй эрх зүйн маргаанд олон улсын эрх зүйн уламжлалт субъект болох улаасаас гадна хувь хүн, хуулийн этгээд, төрийн бус байгууллага зэрэг төрөл бурийн субъект татагдан орох асуудал нь онолын хүрээнээс халж эрх зүйн практикт олонтоо тохиолдох болсон бөгөөд хувь этгээдийн эрх ашиг олон улсын гэрээнд хөндөгдсөн жишиг хэдэн зууны өмнөх гэрээнээс ч олж харж болох хэдий ч хувь этгээд олон улсын эрх зүйн хэм хэмжээг үндэслэн дотоодын шүүхэд эрх ашгаа хамгаалах зорилгоор хандах асуудал ийнхүү олон улсын эрх зүйн хүрээнд өргөнөөр яридах болсон нь харьцангуй шинэ узэгдэл юм. Үүнийг дэлхийн улс төрийн бодлогод нөлөөлж байсан 2 түйтэлт үеэ өнгөрөөж олон улсын эрх зүйн практикт өргөн хүрээний өөрчлөлт, шинчлэлт гарах болсонтой холбон узэж болох юм. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгээс 1990-1999 оныг олон улсын эрх зүйн хөгжлийн 10 жил болгон зарласан нь ч үүнтэй холбоотой юм. Хэдийгээр энэхүү 10 жилийн хүрээнд хийгдсэн гол ажлууд нь дотоодын шүүхэд олон улсын гэрээг хэрэглэх асуудалд шууд чиглэгүй боловч түүний узүүлсэн дам нөлөөг үүгүйгэх аргагүй. Тухайлбал, энэхүү 10 жилийн хүрээнд олон улсын эрх

зүйг сурталчлах, танин мэдэх зэрэг хэд хэдэн тодорхой зорилт тавьсны дотор олон улсын эрүүгийн шүүхийн асуудал эрчимтэй яригдсан ба үр дүнд нь Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм 2002 онд батлагджээ. Ромын дүрмийг энд онцлох шалтгааны хувь этгээд олон улсын эрүүгийн эрх зүйн субъект байх тухай асуудал юм. Энэ нь олон улсын эрх зүй дэх хувь этгээдийн оролцоог илүү нээлттэй авч үзэх байр суурийг туштай илэрхийлсэн хэрэг болсон юм. Өөрөөр хэлбэл хувь этгээд олон улсын эрх зүйн хэм хэмжээг дагуу шүүхэд хариуцагч болик байгаа бол түүний нэхэмжлэгч байх эрхийг хэрхэн авч үзэх асуудал судлаачдын сонирхлыг дахин татах болсон байна. Үүний нэг жишээ нь олон улсын эрх зүй судлаач, хуульч, шүүгч, их сургуулийн профессор нийт 9 хүн оролцож Австрали, Канад, Герман, Энэтхэг, Израиль, Нидерланд, Польш, Орос, Өмнөд Африк, Их Британи, АНУ гэсэн 11 улсын шүүхийн практикт үндэслэсэн судалгаа бөгөөд 2009 онд "Олон улсын гэрээг хэрэгжүүлэхэд дотоодын шүүхүүдийн гүйцэтгэх үүрэг" гэсэн нэрэрээ хэвлэгдсэн байна<sup>2</sup>. Судалгааны эмхтгэлийг гаргасан зохиогчид сүүлийн 20 жилд хийдээгүй өргөн хүрээнд судалгаа болсон гэж дүгнэсэн байдаг. Бид бусад гадаад эх сурвалжийн зэрэгцээ дээрх судалгааны дүгнэлтийг өөрсдийн судалгаандаа тулхүү ашигласан болно.

Монгол Улсын хувьд олон улсын гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль тогтоох байгууллага, шүүхийн хүрээнд гарсан зохицуулалт байгаа ч тэдгээрийг шүүхэд хэрэглэх асуудлаар Хууль зүйн үндэсний хүрээлэн (ХЗҮХ)-ээс өмнө хийгдэж байсан судалгаануудыг эс тооцвол онол, практикийн асуудлыг хөндсэн дорвийт бүтээл хараахан гараагүй байна. Тус хүрээлэнгээс 2005

<sup>1</sup> Энэхүү судалгааг ХЗҮХ-ийн бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан, бодлогын судлаач Т.Саруул нар ахлах бодлогын судлаач Ж.Алтансүх, С.Бужинхам, З.Туулайкуу, социолог, судлаач Б.Доржлагамжа нарын бурзладхунтын гүйцэтгэв. МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүйн тэнхмийн багш М.Мөнхбатын чиглэл, залваемж, өмөвлөгөөг Ч.Жавхлантсэгийн судалгааны товч тайлан

<sup>2</sup> David Sloss (ed). *The Role of Courts in Treaty Enforcement: A Comparative Study*. Cambridge University Press. 2009.

онд "Шүүх эрх мэдлийн хүрээний хууль тогтоомж ба холбогдох олон улсын гэрээний зөрчилдөөний талаар судалж, шүүх эрх мэдлийн хүрээнд олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх арга замыг тодорхойлох: Олон улсын эзүүгийн шүүхийн Ромын дүрэм болон Монгол Улсын хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа", 2010 онд "Шүүх эрх мэдлийн хүрээнд олон улсын хувийн эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх үндэслэл, арга зүй: Олон улсын худалдааны эрх зүйг арбитрын шүүхэд хэрэглэх асуудал" сэдэвт судалгааг тус тус гүйцэтгэсэн.

Энэ удаагийн судалгаа нь ХЗҮХ-ээс энэ чиглэлээр хийсэн З дахь судалгаа бөгөөд 1-рт өмнөх судалгаанууд тодорхой нэг салбар эрх зүйн хувьд олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх талаар тухайлан авч үзсэн бол дотоодын шүүхэд олон улсын гэрээг хэрэглэх талаар ерөнхий ойлголтыг авч үзэх, 2-рт гадаад-улс орнуудын шүүхэд олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэж буй байдлыг харьцуулан судлах, 3-рт олон улсын эрх зүйг шүүхэд хэрэглэх асуудлыг Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд хэрхэн авч үзж болох талаар тодорхой байр суурийт эрэлхийлэх зорилго тавьсан болно. Үүний тулд бид олон улсын гэрээг дотоодын шүүхэд хэрэглэх онол, практикийн зарим асуудлыг Нидерландын Вант Улс /НВУ/, Оросын Холбооны Улс /ОХУ/, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс /ХБНГУ/-ын жишээтийг харьцуулан судалснаас гадна Монгол Улсын шүүхэд олон улсын гэрээг хэрхэн хэрэглэж байгаа талаар шүүгч, өмгөөлөгчдийн дунд санал асуулга явуулсан. Үүнд өмгөөлөгчдийн санал асуулгыг цахим хэлбэрээр буюу нийт 1411 өмгөөлөгчийн цахим хаяг руу илгээж 2014 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд цугларсан нийт 55 оролцогчийн мэдээлэлд, шүүгчдийн санал асуулгыг Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн дэмжлэгтэйгээр Улаанбаатар хотын шүүхүүдийн тамын газарт хүргүүлж 2014 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс 11 дүгээр сарын 25-ны өдрийн хооронд

цуглуулсан мэдээлэлд үндэслэн тус тус боловсруулалт хийж үр дүнг судалгаанд тусгалаа.

Судалгааны ерөнхий дүнгээс харахад хуулыч, шүүгч, өмгөөлөгчдийн олонхид олон улсын гэрээг хэрхэн хэрэглэх талаар ойлголт сүл, нэмэлт мэдлэг, мэдээлэл шаардлагатай байдаг гэсэн санал олон байсан учраас бид уг ажлын 1-р хэсэгт олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх талаарх ерөнхий ойлголт, онолын үндэс, 2-р хэсэгт олон улсын чиг хандлагыг төв харьцуулж, 3-р хэсэгт Монгол Улсын шүүхэд олон улсын гэрээг хэрэглэх эрх зүйн орчин, практикт үүссэн зарим маргаантай асуудлыг авч үзэн, шийдвэрлэх арга замын талаар санал, дүгнэлт дэвшүүлсэн болно.

### Нэг. Олон улсын гэрээг дотоодын шүүхэд хэрэглэх ойлголт ба орчин үеийн чиг хандлага

Хувь этгээд<sup>3</sup> олон улсын гэрээнд заасан эрх нь зөрчигдсөн гэж үзвэл дотоодын шүүхэд хандах асуудал улс орнуудын шүүхийн практикт байсаар ирсэн асуудал бөгөөд харин энэ баримтандаг онолын болон практик чиг хандлага, гарч байгаа өөрчлөлтийндээ сонирхолтой юм. Тухайлбал, өмнө дурдсан Дэвид Слосс тэргүүтэй судлаачдын гүйцэтгэсэн судалгааны үр дүнгээс харахад Израйль, ОХУ-ын шүүхүүдэд хувь этгээдийн ашиг сонирхлыг хэлэлцэхэд олон улсын гэрээний хэм хэмжээг илүү нээлттэй хэрэглэх болдого баримталж байгаа бол энэ талаар АНУ ухралттай байна.<sup>4</sup> Энэхүү дүгнэлт нь магадгүй дээрх улсуудын талаарх бидний олонхийн төсөвлөөс өөр байж болох ч гайхмаар зүйл бас биш юм. Учир нь олон улсын гэрээг дотоодын шүүхэд хэрэглэх тухайд улс орнууд ямагт нэг үзэл баримтлалыг хатуу баримтлалдаггүй байна. Өөрөөр хэлбэл олон улсын гэрээг дотоодын

<sup>3</sup> Бид энэхүү судалгаанд "хувь этгээд" гэх нэр томъёонд хувь хүн, хуулийн этгээдийн аль алтныг хамруулан үзэж болно.

<sup>4</sup> Sloss, 2009, page 3

шүүхэд хэрэглэх асуудал нь тухайн гэрээний онцлог, цаг үе, нөхцөл байдлын тусгал байх нь цөөнгүй. Мөн уламжлалт эрх зүйн үзэл баримтлал болон олон улсын эрх зүйн орчин үеийн чиг хандлагын харилцан холбоо, эрх зүйн тогтолцоо ба улс төрийн нөхцөл байдал үүнд нөлөөлдөг байж болох юм. Жишээ нь Бүгд Найрамдах Хятад Ард Улс /БНХАУ/ олон улсын гэрээний эрх зүйн талаар баримтлах болдогоо 1990-ээд он гартаал улс төр, цэргийн шинжлэх ухааны салбар, гадаад улсын улс төрийн бодлогод хяналт тавих хэрэгсэл зэрэг хягаалгагдан хүрээнд хэрэглэж, тайлбарлаж байсан бол Дэлхийн Худалдааны Байгууллага /ДХБ-/ элсэж гадаад зах зээлд нээлттэй оролцох болсноор олон улсын эрх зүйд илүү прагматик байр сууриас хандах болсон гэж үздэг<sup>5</sup>. Одоо БНХАУ-ын шүүхэд гадаад этгээд оролцсон хэрэг маргаанаас гадна дотоодын субъектүүд олон улсын гэрээний зүйл, заалтыг үндэслэн маргаан үүсгэх явдал шинэ үзэгдэл нэгэнт биш болжээ.

БНХАУ-тай харьцуулахад Америкийн Нэгдсэн Улс /АНУ/ зэрэг барууны ардчилсан улсуудад шүүх олон улсын гэрээг хэрэглэх практик нь олон арван хийзэр хэмжигдэх боловч гэрээг хэрэглэх эсэх талаар эрх зүйн үндэслэл, гаргалгаа, тайлбарын хувьд олон язнын байр суурь илэрхийлсээр ирсэн байдаг. Тухайлбал дээр өгүүлсэн Дэвид Слосс тэргүүтэй судлаачид олон улсын гэрээг шүүхэд хэрэглэж байгаа талаар АНУ-ын суулийн үеийн чиг хандлагад шүүмжлэлтэй хандаж байгаа хэдий ч Ерөнхийлөгч Обама шүүгчдийг томилдоход олон улсын эрх зүйг үндэслэн шүүхэд иргэний эрхийг хамгаалахад илүү анхааралт хандах шүүгчдийг олж тавина гэдэгт итгэж байгаагаа илэрхийлсэн байдаг. Ийнхүү шүүх олон улсын гэрээг хэрэглэх эсэхэд “чөлөөт тогтолц” хийх асуудлыг олон улсын эрх зүйд хэрхэн тайлбарладаг вэ гэсэн асуулт гарч ирж байна. Өөрөөр хэлбэл яагаад зарим улсын шүүх олон улсын гэрээг баримтлан хувь этгээдийн хохирлыг барагдуулах тухай шийдвэр

<sup>5</sup> Ahl Bjoern. Die Anwendung voelkerrechtlicher Vertraege in China. Springer 2009. page 355

гаргаж байхад өөр нэг улсын шүүхэд асуудал өөрөөр тавигдах боломж байдаг тухайд эрх зүйн үндэслэл нь юу вэ гэдэг асуудал гарч ирдэг.

Хувь этгээд олон улсын гэрээнд үндэслэн дотоодын шүүхэд гомдол гаргасан бол шүүх маргааныг шийдвэрлэхдээ олон улсын гэрээг хэрэглэхийг шууд заасан буюу үүргэл болгосон хэм хэмжээ олон улсын гэрээ, заншлын хэм хэмжээ болон эрх зүйн зарчмын аль алинд нь байхгүй бөгөөд энэ талаар ч олон улсын эрх зүй судлаачид нэгдмэл байр суурттай байдаг. Гэхдээ олон улсын гэрээг хэрэглэх асуудалд нааштай засвэл серег байр сууриас хандсан олон язнын эрх зүйн номпол, тайлбар байх ба үүнийг улс орууудын шүүхийн практик, эрх зүйн хөгжлийн явцаас харж болно.

Олон улсын гэрээ дотоодын шүүх хэрэглэх асуудлыг ийнхүү шууд үүгүйсгэдэггүй тул тухайн шүүх чухам ямар арга зүй, онол, практик үндэслэн тухайн олон улсын гэрээний хэм хэмжээг хэрэглэх, эсэх хэрэглэх тухайд эрх зүйн ямар үндэслэл, тайлбар гаргадаг вэ гэдэг асуудал сонирхол татдаг. Тухайлбал, НҮБ-ын дүрмийн 94-р зүйлийг<sup>6</sup> эрх зүй судлаачид, шүүгчдийн нэг хэсэг нь шууд хэрэгжих хэм хэмжээ тул улс орны шүүхүүд олон улсын гэрээг хэрэглэхийг дэмжсэн зохицуулалт гэх бол нөгөө хэсэг нь дотоодын шүүхэд хамааралгүй заалт гэж үздэг<sup>7</sup>.

Мөн Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венинйин конвенц /Vienna Convention on the Law of Treaties-1969/-д заасан гэрээний талууд гэдгийг хэрхэн ойлгох вэ гэдэг асуудал маргаантай. Зарим судлаачийн үзэж байгаагаар “Талууд” гэдгэгт зөвхөн улсыг ойлгох бөгөөд

<sup>6</sup> 1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн бүр өөртөө холбогдох хэргийн талаар Олон улсын шүүхээс гаргасан шийдвэрэйг билэлүүлэх үүргэ хүлээн. 2. Хэрэгт холбогдох аль нэг тал шүүхийн шийдвэрээр хүлээлгэсэн үүргийг эс биелүүлбэл нөгөө этгээд нь Аюулгүйн Зөвлөлтийн хандаж болох бөгөөд Аюулгүйн Зөвлөлтийн шаардлагатай гаж үзэл шүүхийн шийдвэрэйг гүйцэтгүүлэхийн тулд авах арга хэмжээний талаар зөвлөх буюу шийдвэр гаргаж болно. /НҮБ-ын дүрм 94 дүгээр зүйлийн 1 ба 2 дугаар хэсэг/

<sup>7</sup> Sloss, 2009. page 512

хэрэв гэрээнд гуравдагч этгээдийн тухай дурдах байгаа бол энэ нь 3 дахь аль нэг улсын тухай ойлголт гэж үзнэ. Иймээс Вениний конвенцийн дагуу хувь этгээд олон улсын гэрээнээс үүдэлтэй маргааны объект байж болох ба харин гэрээний аль нэг тал буюу субъект биш юм. Иймд хувь этгээдээс олон улсын гэрээнд заасан үндэслэлээр шүүхэд гаргасан гомдолыг авч хэлэлцэх үүрэг шүүхэд байхгүй гэж үзэх судлаачид байдаг. Тэдний дэвшүүлдэг өөр нэг үндэслэл нь анх Вениний конвенцийг батлах, тайлбарлах аль ч үе шатанд түүний үндсэн зарчим болох *Pacta sunt servanda* буюу олон улсын гэрээнд үнэнч байх зарчимд хувь этгээдийн талаарх ойлголтыг хамруулаагүй гэж үздэг явдал юм<sup>6</sup>. Өөрөөр хэлбэл конвенц анхнаасаа хувь этгээд олон улсын хэм хэмжээнд үндэслэн шүүхэд хандах асуудлыг зохицуулах зорилго тавиагүй гэж тайлбарладаг байна. Ийм үндэслэлээр улс орнуудын шүүх олон улсын эрх зүйн хэм хэмжээг заавал хэрэглэх үүрэг хүлээхгүй гэж баталдаг.

Тэгвэл *Pacta sunt servanda* зарчмыг тайлбарлах өөр нэг байр суурийг дийлийн судлаач, Олон улсын шүүх / International Court of Justice/-ийн эзүгээс баримтлалдаг. Энэ нь дотоодын шүүх олон улсын гэрээг үндэслэн шийдвэр гаргахыг дэмжих зорилготой юм. Олон улсын шүүхийн тайлбарт “Олон улсын гэрээгээр хүлээсэн үргийг биелүүлэх нь тухайн улсын төрийн байгууллын тогтолцооны бүх байгууллагын чиг үүрэгт хамаарлтай асуудал гэж өргөн хүрээнд авч үзэх ёстой юм. Эндээс хууль тогтоох, гүйцэтгэх төдийгүй шүүх эрх мэдлийн байгууллага олон улсын гэрээний хэрэгжилтэд тодорхой чиг үүрэгтэй оролцох нь зүй ёсны юм” гэсэн гаралгааг гаргасан байдаг.

Дээрхтэй холбоотойгоор судлаач P.O’Connell: “Олон улсын гэрээ бол хуулиас ялгаатай ойлголт бөгөөд энэ нь зөвхөн талууд хоорондын тохиролцоог зохицуулсан дүрэм болно. Гэхдээ олон улсын гэрээний хэм хэмжээ хувь этгээдийн тухайд заавал мөрдөхдөх хучин чадалтай бол тухайн этгээд энэ талаар заавал мэдсэн байх ёстой

гэж олон улсын эрх зүйн практикт үздэг. Иймээс олон улс орны хувьд олон улсын гэрээг дотооддо мөрдж эхлэхээс өмнө хуульчлан батлах журамтай байдаг. Ийм журамгүй улсын хувьд шүүх нь олон улсын гэрээг хуулийн адил хэрэглэх үндэслэл нь гэрээний агуулга байж болох юм. Хэрэв гэрээг дотоодын шүүхэд хэрэглэж болох тухайд талуудын хүсэл зориг гэрээнд агуулгасан нэхцэлд шүүх олон улсын гэрээг хуулийн адил эх сурвалж болгон ашиглах эрх зүйн үндэслэлтийг байна” гэж үзсэн.<sup>9</sup> P.O’Connell-ийн энэ дүгнэлт нь нэг талаар олон улсын гэрээг дотоодын шүүхэд хэрэглэх нь хягаарлагдсан асуудал асуудал гэдгийг хүлээн зөвшөөрөх байгаа боловч негеэ талаар гэрээг тайлбарлах замаар шүүхэд хэрэглэх эрх зүйн үндэслэлийг гаргаж болно гэсэн санааг илэрхийлж байна.

Дотоодын шүүх олон улсын гэрээг хэрэглэн хувь этгээдийн хохирлыг барагдуулах асуудалд яагаад зөрэг байр сууриас хандах ёстой вэ гээгт профессор Дэвид Слосс өөрийн судалгаандаа дараах үндэслэлийг гаргасан байна. Үнд:

1. Хүний эрх зэрэг хүн төрөлхтний ёс эзүй, ухамсырын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн, олон улсын гэрээгээр баталгаажсан нийтлэг хэм хэмжээг хувь этгээд маргаанаа шийдвэрлүүлэхэд үндэслэл болгох нь зөв зүйтэй хэрэг юм;

2. Хүний эрх зэрэг нийтлэг хэм хэмжээг агуулаагүй ч хувь этгээдийн хоорондох эрх зүйн тодорхой нэгтгэлийн харилцааг олон улсын хэмжээнд илүү үр дүнтэй, зүй зохистой зохицуулах бодит хэрэгцээг үндэслэн баталсан олон улсын гэрээ байдаг. Ийм төрлийн гэрээг үндэслэн хувь этгээд ларгаан үүсгэх нь зүй ёсны хэрэг юм/жишээ нь: Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, хэрэгжүүлэх тухай 1958 оны конвенц /Convention on the Recognition and Enforcement of Foreign Arbitral Awards.//:

<sup>6</sup> Sloos 2009 page69

<sup>9</sup> Sloos, 2009 page 156

3. Олон улсын гэрээнд хувь этгээдийнэрхашгийг хөндсөнхэмжээс агуулагдаг боловч хувь этгээдэд олон улсын маргаан зохицуулах механизм / олон улсын шүүх/-ыг ашиглах эрх зүйн үндэслэл байхгүйгээс "цоорхой" уусдэг. Тодоруулбал хувь этгээд олон улсын гэрээнд заасан эрх нь зөрчигдэхэд хаана хандах нь тодорхой бус ба эндээс гарах гарц нь дотоодын шүүхэд хандах явдал юм.

Дээрх дурдсан үндэслэлүүдийг дүгнэн үзвэл хэдийгээр олон улсын гэрээг хэрэглэх талаар дотоодын шүүхэд шууд үүрэг болгосон олон улсын эрх зүйн хэмжээг байхгүй ч тодорхой нэхцэлд хэрэглэж болохыг угүйсгэдэггүй байна. Хувь этгээдийн дотоодын шүүхэд хандах, олон улсын гэрээг хэрэглэх асуудлыг хөхүүлэн дэмжих байр суурийг олон улсын эрх зүйд баримтлагад нь олон улсын гэрээний хэмжээ хэрэгжих механизмын сул талыг нөхөх, хувь этгээд эрх ашгаа хамгаалуулах нэмэлт баталгаа, олон талын эрх зүйн эх сурвалжтай байх зэрэг зөрөг үр дунг авчирдагтай холбоотой гэж харж байна.

### 1.1 Хэлбэрийн шаардлага

Энд тухайн улсын эрх зүйн тогтолцоонд олон улсын гэрээг эх сурвалжийн хэмжээнд ашиглахад ямар шаардлага тавьдаг тухай асуудал хамаарна. Олон улсын гэрээг баталсан эсвэл нэгдэн орсноор дотоодын эрх зүйн эх сурвалжийн нэгэн адил тооцож байгаа бол монист арга зүй гэнэ. Харин батлах, нэгднэорох тухайдотоодын эрх зүйн эх сурвалжид тооцоход хангалтгүй бөгөөд хууль тогтоомжид холбогдох нэмэлт, өөрчлөлт, шинээр хэмжээ тогтоосон акт бий болгосноор эрх зүйн эх сурвалж гэж үздэг арга зүйг дуалист гэнэ.<sup>10</sup> Тухайн улсын үндэсний эрх зүйн тогтолцоонд аль арга зүйг илүүтэй

<sup>10</sup> Дуализмын дагуу олон улсын эрх зүй болон дотоодын эрх зүй нь өөр хоорондоо ялгатай асуудлыг зохицуулж байгаа 2 өөр эрх зүйн тогтолцоой байгаа бол харин монист нь олон улсын эрх зүй болон дотоодын эрх зүйг хэмжээний нэгдмэл нь тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүд кэмзэн үздэг. Монист хандлагын үүднээс олон улсын болон дотоодын эрх зүйгээс бурдсан нэгдэл тогтолцоонд олон улсын эрх зүйгээс бурдсан нэгдэл тогтолцоонд олон улсын эрх зүй нь давуу байр суурь эзэнлээ.

баримталж байгааг Үндсэн хууль, олон улсын гэрээний талаарх хууль тогтоомж зэрэг үндсэн эх сурвалжид дун шинжилгээ хийснээр тогтоодог.

Дуалист чиг хандлагатай улсад олон улсын гэрээг хууль, тогтоомждоо нэмэлт, өөрчлөлт хийсэн буюу шинээр хэмжээ тогтоосон акт гаргасан эсэхийг тогтооход л хангалттай тул хэлбэрийн шаардлагатай онцын ач холбогдол өгдөггүй байж болох юм. Харин монист /холимог монист/ улсад тухайн олон улсын гэрээ нь дотоодын эрх зүйд хүчин төгөлдөр эх сурвалжид тооцох эсэхэд шалгалт хийх нь чухал ач холбогдолтой. Энэ нь олон улсын гэрээг байгуулах, батлах эрх бүхий субъект мен эсэх, батлах байгуулах процессын хэмжээ зөрчсөн эсэх, хүчин төгөлдөр үйлчилж эхлэх хугацаа, болзоп /терийн албан ёсны хэвлэлд нийтлэгдсэн байх гэх мэт/, шаардлага хангасан эсэх зэрэг асуудлаар хэлбэрийн шаардлага хангаж байгаа эсэхэд шалгалт хийнэ гэсэн үг.

Үнэн хэрэгтээ дуалист, монист хандлага нь олон улсын гэрээг шүүхэд хэрхэн хэрэглэх арга зүй биш харин олон улсын гэрээний хэмжээг дотоодын шүүхэд эрх зүйн эх сурвалжийн хувьд хэрхэн үнэлэх талаар гаргасан шийдэл гэж үзж болно. Энэ ямар шийдэл вэ гэдэгт тухайн улсын эрх зүйн эх сурвалж, тэр дундаа Үндсэн хууль хариулт өгдөг. Энэ 2 чиг хандлагын аль алиинд нь давуу, сүл тал байна. Монист чиг хандлагатай улсад олон улсын гэрээнд нэгдэн орсноор түүний хэрэгжих баталгаа, хүчин төгөлдөр болох процесс нь харьцангуй хялбар гэж ойлгогддог.

Энэ нь дотоодын эрх зүй олон улсын эрх зүйд нийцсэн байх ёстой гэсэн үг юм. Дуалист хандлагаар хөөр тусдаа эрх зүйн тогтолцоо учраас тэдгээрийн хооронд зөрчилдэвн үзвэл дотоодын шүүх /өөрийн дотоодын эрх зүй/ баримтлах ба дотоодын эрх зүйд үйлчилж хүчин чадалтай болохын түд тухайн эрх зүйн тогтолцоонд олон улсын эрх зүйн хэмжээг трансформацийн хийж шаардлагатай. Дэлгэрнүүд Ian Brownlie-ийн *Principles of Public International Law* (7th edition Oxford University Press, Oxford 2008) номын 31 дахь тал болон Tom Ginsburg, Svitlana Chernykh, Zachara Elkins нарын *Commitment and Diffusion: How and Why National Constitutions Incorporate International Law* (University of Illinois Law Review, Vol.2008) өгүүллийн 204 дэх талаас тус тус үзэн үү.

Гэвч ийм чиг хандлагатай улс орны шүүх олон улсын гэрээг илүү идэвхтэй, нээлттэй хэрэглэх боломжтой гэсэн стереотип дүгнэлт судалгаагаар үүгүйсгэгдсэн байдал. Харин ч практикт дуалист чиг хандлагатай улсууд шүүхийн шийдвэртээ олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэхэд илүүтэй анхаарч үзсэн байдал гэсэн байна<sup>11</sup>. Орчин үед улс орнууд өврсдийгээ цэвэр монист гэхээс илүү холимог /хибрид/ монист<sup>12</sup> чиг хандлагатай хэмээн тодорхойлж байгаа нь олон улсын гэрээг эх сурвалжид тооцоходо улс орнууд дуалист чиг хандлагыг ямар нэг хэмжээнд харгалзж ирсэнтэй холбон тайлбарлаж болно. Негee талаар Австрали, Канад, Их Британи зэрэг дуалист чиг хандлагатай улсын шүүхэд олон улсын гэрээг дотоодын эрх зүйд шилжүүлэг хийхгүйгээр нэгдэн орсон эсвэл соёрхон баталснаар хэрэглэх явдлыг дэмжих болсон нь "холимог дуалист" гэсэн өөр нэг чиг хандлага хөгжжих байгааг мөн харуулж байна.<sup>13</sup>

## 1.2. Агуулгын шаардлага

Дотоодын шүүхэд олон улсын гэрээг хэрэглэх талаар шууд үүрэг болгосон олон улсын эрх зүйн хэм хэмжээг байдаггүй тул энэ чөлөөт орон зайг ашиглахыг аль ч улсын шүүх эрэмлэлзэх ба энэ нь үндэсний хууль тогтоомжоо тулхүү хэрэглэх сонирхлоор илэрдэг. Гэхдээ энэ нь зөвхөн шүүхийн хүсэл зоригийн асуудал биш юм. Гол нь тухайн улсын эрх зүйн тогтолцоонд олон улсын гэрээг ямар эрэмбэд авч үзэж байгаа /хуулийн адил, хуулиас дээгүүр эсвэл хуулиас доогуур эрх зүйн хүчин чадалтай/, мөн тухайн гэрээгээр зохицуулж байгаа асуудлыг агуулгыг хэрхэн тогтоохос хамаарна.

Монист хандлагатай улсууд олон улсын гэрээг дотоодын хууль тогтоомжийн адил эх сурвалжид тооцох боловч тухайн гэрээг хэрэглэх эсэх тал дээр дүгнэлт гаргах эрх нь шүүхэд хадгалагддаг. Энэ нь зарим талаар хууль тогтоох, шүүх эрх мэдлийн

хүчиний тэнцвэрийн асуудал яригдах хүртэл өргөн хүрзэний сэдэв болох магадлалтай. Иймд шүүх олон улсын гэрээнд заасан хэм хэмжээг хэрэглэхгүй гэсэн шийдвэр гаргах "хүсэл зориг"-той байсан ч түүнийхээ эрх зүйн үндэслэлийг хангалттай хэмжээнд гаргаж өгөх ёстой болно.

Хамгийн түрүүнд хувь этгээдийн эрх ашиг гэрээгээр хөндөгдж байгаа эсэх тухай асуудал чухал бөгөөд гэрээнд агуулгыг анхаарах юм. Үүнтэй холбоотой шууд хэрэгжих гэрээ<sup>14</sup> гэсэн дотоодын гарч ирдэг. Шууд хэрэгжих хэм хэмжээг тогтооно гэдэг нь үндсэндээ а) тухайн олон улсын гэрээ хувь этгээдийн асуудлыг ямар нэг хэмжээгээр хөндсөн; б) тэрхүү асуудлыг дотоодын шүүх авч хэлэлцэх үндэслэл байгаа эсэх гэсэн 2 үндсэн асуудалд тухайн гэрээг тайлбарлах замаар хариулт олох явдал юм. Хэрэв ямар нэг хэмжээнд эрх зүйн үндэслэл байна гэж тогтоовол шүүх хувь этгээдийн гомдолыг авч хэлэлцэх боломжтой гэж узэн. Түүчилэн тухайн маргаантай асуудлаар дотоодын эрх зүйн зохицуулалт байгаа эсэх, дотоодын эрх зүйн зохицуулалт байгаа хэдий ч олон улсын гэрээний хэм хэмжээтэй зөрчилдэх байгаа эсэх гэсэн үндсэн асуудлыг анхаарч үзэх ёстой юм. Хэрэв зохицуулсан хэм хэмжээ байхгүй нэхцэлд гэрээний хэм хэмжээг шүүх хэрэглэх үүрэгтэй болно. Харин тийм хэм хэмжээ байгаа бөгөөд тэр нь олон улсын гэрээний хэм хэмжээтэй зөрчилдэхгүй бол дотоодын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх магадлал өндөр. Шууд хэрэгжих хэм хэмжээг тухайн улсын эрх зүйн тогтолцоонд хэрхэн авч үзэх нь харилцан адилгүй байдал. Жишээ: нь АНУ-ын эрх зүйн онол, шүүхийн практикт гэрээг тайлбарлаж шууд хэрэгжих, эс хэрэгжихи н алж болохыг шийдвэрлэдэг бол ОХУ ямар гэрээ шууд хэрэгжих вэ гэдгийг Олон улсын гэрээний тухай хуулиндаа тодорхойлон заасан байна. Энэ мэтичилэн улс орнууд олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх асуудлыг язь бүрийн байдаараа зохицуулсан байж

<sup>11</sup> Sloss 2009 page 7

<sup>12</sup> Sloss 2009 page 7

<sup>13</sup> Sloss 2009 page 19

<sup>14</sup> Олон улсын эрх зүйд англиар "direct application of treaties, self-execution doctrine" гэсэн нэр томъёотгоор илрекинидэг

ба дараагийн бүлэгт тодорхой улсын жишээнд дэлгэрэнгүй авч үзэх болно.

### **Хоёр. Олон улсын гэрээг зарим улсын шүүхэд хэрэглэж буй байдал**

#### **2.1. Нидерландын Вант Улс**

1. Олон улсын эрх зүй ба дотоодын эрх зүйн харилцан хамаарал

Монист, дуалист хандлагууд нь олон улсын эрх зүйн хэм хэмжээний дотоодын эрх зүйд эзлэх байр суурийг тодорхойлох ба энэ нь тухайн улсын Үндсэн хуульд хэрхэн зааснаас голлон шалтгаалдаг. Нидерландын Вант Улс (НВУ)-ын хувьд тус улсын Үндсэн хуулийн 93, 94 дүгээр зүйлүүдэд аль чиг хандлагад хамаарахыг тодорхойлоход ач холбогдол бүхий зохицуулалтыг тусгасан байна. Үндсэн хуулийн 93 дугаар зүйлд "бүх этгээд заавал дагаж мөрдөх агуулгатай олон улсын гэрээний болон олон улсын байгууллагын тогтоолын заалт нь хэвлэн нийтлэгдсэнээсээ хойш заавал биелэгдэх шинжтэй байна"<sup>15</sup>, 94 дүгээр зүйлд "Нэгдсэн вант улсын хэмжээнд дотоодын хүчин төгөлдөр хууль тогтоомжийн зохицуулалт нь ийм олон улсын гэрээний заалт болон олон улсын байгууллагын тогтоолын заалттай зөрчилдвел тухайн зохицуулалтыг хэрэглэгхүй" гэж тус тус заасан байна. Эндээс НВУ нь олон улсын эрх зүйд авуу хүчин чадалтай байх /the supremacy of international law/ зарчмыг онцлогдог монист хандлага бүхий улс болох нь харагдаж байна. Гэсэн хэдий ч олон улсын эрх зүйн бүх хэм хэмжээний хувьд монист чиг хандлага баримтлагад гэж үзэх нь эргэлзээтэй юм. Учир нь Үндсэн хуулийн 93, 94 дүгээр зүйлүүдэд олон улсын гэрээ, олон улсын байгууллагын тогтоолын заалт нь Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой зөрчилдсэн тохиолдолд дээгүүр эрэмбэлтий байх талаар заасан хэдий ч энд олон улсын заншлын хэм хэмжээг авч үзэггүй. Олон улсын заншлын эрх зүйн хэм хэмжээг Үндсэн хуульд зохицуулаагүй орхисныг заншлын эрх зүйн хэм хэмжээний өөрийнх нь агуулгын тодорхой бус

<sup>15</sup> Энэ зохицуулалттай холбоотой сонирхолтой жишээг судалгаван тайллангаас дэлгэрүүлэн үзэх үү.

байдалтай холбоотой хэмээн зарим судлаач үзэсэн байна.<sup>16</sup> Ийнхүү хэдийгээр Үндсэн хуулийн 94 дүгээр зүйлээр олон улсын заншлын эрх зүйд давуу хүчин чадал олгоогүй ч зарим хягаарлагдмал нөхцөл байдалд хэрэглэх боломж бий. Жишээлбэл, гадаад улсын тэр түүний шүүхийн дархан эрхийт хамгаалахад хууль тогтоомжийн заалт, шууд хэрэглэгдэх боломжтой олон улсын гэрээ байхгүй тохиолдолд заншлын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэж болох зохицуулалттай.<sup>17</sup> Эндээс харахад заншлын хэм хэмжээ нь олон улсын гэрээгээр зохицуулагдаагүй сүл орон зайг нөхөх чиг үүргээр хэрэглэгдэж болохоор байна. Олон улсын заншлын эрх зүйн хэм хэмжээг Үндсэн хуульд зохицуулаагүй Том Гинсбург тэргүйтэй судлаачид "зарим улс олон улсын гэрээний тухайд монист хандлагатай хэрээн олон улсын заншлын эрх зүйн хэм хэмжээний хувьд дуалист шинжтэй байдгийн нэг жишээ нь Нидерланд улс юм" хэмээн дүгнэсэн байдал.<sup>18</sup> Эндээс харахад тус улс Үндсэн хуулиndaa Олон улсын шүүхийн дүрэм /Statute of the International Court of Justice, 1945/-ийн 38 дугаар зүйлийн 1 дэх хэсгт тус шүүхийн хэрэглэх эх сурвалжийн жагсаалтад олон улсын заншлын хэм хэмжээг олон улсын гэрээний дараагаар хөрдүргаарт оруулсаныг өөрийн улсын эрх зүйн онцлогийг харгалзан шийдвэрлэсэн байна. Үндсэн хуулийн 93, 94 дүгээр зүйлүүдэд зааснаас үзэхэд олон улсын гэрээ болон олон улсын байгууллагын тогтоол нь эрх зүйн бусад хэм хэмжээ /хууль, олон улсын бусад хэм хэмжээ/-нээс хэрэглэгдэх эрэмбийн хувьд давуу хүчин чадалтай байна. Гэхдээ олон улсын гэрээ, олон улсын байгууллагын<sup>19</sup> тогтоолын аль нь илүү хүчин чадалтай эсэх асуудлыг Үндсэн хуулиар зохицуулаагүй.

<sup>16</sup> Eyed Benvenisti, *Judicial Misgivings Regarding the Application of International Law: An Analysis of Attitudes of National Courts*, EJIL (1993), page162

<sup>17</sup> Нидерландын Вант Улсын Гэмт хэргийн тухай хууль (1881). 8 дугаар зүйл

<sup>18</sup> Tom Ginsburg, ChemeykhSvillana, Elkins Zachara, *Commitment and Diffusion: How and Why National Constitutions Incorporate International Law*, University of Illinois Law Review (2008), page 204

Үндсэн хуулийн 93 дугаар зүйл заасан "бүх этгээд заавал дагаж мөрдөх агуулга бүхий олон улсын гэрээний заалт" /die naar hun inhoud een leder kunnen verbinden /англ. which may be binding on all persons by virtue of their content/ гэдэгт шүүхээс шууд хэрэгжих боломжтой олон улсын гэрээг ойлгоно хэмээн зарим судлаач тайлбарласан байна.<sup>20</sup> Мөн энэхүү заалтыг шүүхийн практикт дотоодын эрх зүйн хүрээнд "объектив эрх зүй (objective law)"-ын адиллаар үйлчлэхүйц хангалттай тодорхой заалт хэмээн ойлгоно гэж үзсэн нь ч байна.<sup>21</sup> Ийнхүү Нидерланд улсын Үндсэн хуулийн 93 дугаар зүйл шууд хэрэгжих гэрээ (мөн ийм олон улсын байгууллагын тогтоол)-г статусын хувьд ялгаатайгаар зохицуулсан гэж үзэх цөнгүй хандлага судлаачдын дунд байна.

Үндсэндээс монист чиг хандлагын үднээс олон улсын гэрээний заалтыг шүүхээс хэрхэн тодорхойлж байгаагаас хамааран шууд хэрэгжих гэрээ (self-

<sup>20</sup> Олон улсын байгууллага гэдэгт юу ойлго тухай асуудал судлаачын анхаарлыг татдаг. Олон улсын байгууллагын тодорхойлсон нэгдсэн (нийтээр хүлээн зөвшөөрдгэсэн) тодорхойлжийн дотоодогор байхгүй. Учир нь арген хүрээнд амь узвэл засгийн газар хоорондын байгууллага (Intergovernmental organization)-наас авахуулаад олон улсын төрийн бус байгууллага (non-governmental organization), бур олон үндэстний (олон улс фонд ўйл ажиллагын явуулдаг) аж ахуйн нэгж (multinational enterprise) хүртэл энэ ангилалд хамаарах боломжтой байдаг бол яицуу угтаар зөвхөн засгийн газар хоорондын байгууллагыг ийнхүү ойлгодог.

Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венин конвенц (1969)-д "олон улсын байгууллага гэдэгт засгийн газар хоорондын байгууллагын ойлголт" гэж, тодорхойлсон (2 дугаар зүйл). Гэхдээ энэ нь бүх тохиолдолд харалтадж нийтийг тодорхойлж бус зөвхөн тухайн өвлийн зорилтын хүрээнд олон улсын байгууллагын тодорхойлсон тодорхойлжийн юм. 2011 онд НҮБ-ын Олон улсын эрх зүйн комиссийн баталсан (Ерөнхий Ассамблеягас хараахан эзслэн батлагдаагүй байна). "Олон улсын байгууллагын хариуцлагын тухай баримт бичиг" (Draft Articles on Responsibility of International Organizations)-ийн 2 дугаар зүйлийн 2(a) хэсэгт "олон улсын байгууллага гэх олон улсын гэрээ эскуу олон улсын эрх зүйн бусад баримт бичгийн дагуу байгууллагын олон улсын хуулийн этгээдийн чадвар (international legal personality) бүхий этгээдийн эзлэх ба гишүүнчлэд нь улсаас гадна бөр бусад этгээдийн барилж болно" тэж зассан байна. Харин Нидерланд улсын гидсэн хуульд здгээр 2 хандлагын алигин нь баримтласан болон талаар судлааж тодорхой мэдээлэл олдожхүй байна.

<sup>21</sup> Pieter vanDijk and BahiyihG Tahzib, *Parliamentary participation in the treaty-making process of the Netherlands*, Chicago-Kent Law Review June 1991, page 419

<sup>22</sup> Sloes 2009, page 6

executing treaty), шууд эс хэрэгжих гэрээ (non-self-executing treaty) гэж ангилдаг.<sup>22</sup> Шууд хэрэгжих гэрээ гэж дотоодын эрх бүхий байгууллагаас нэмэлт ажиллагаа хийсэн байхыг шаардахгүйгээр (тухайлбал, парламентаас хучин төгөлдөр үйлчилж байгаа хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулах юм уу эсхүл шинээр хууль батлахгүйгээр) тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэхэд шүүхээс шууд хэрэглэж болох гэрээг хэлдэг. Ингэхдээ олон улсын гэрээний шууд хэрэгжих эсэхийг тодорхойлох эрх Нидерландын шүүхэд хадгалагдана гэж үздэг.<sup>23</sup> Энэ талаар 1995 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр E.O v Public Prosecutor-ын хэргийг хянан шийдвэрлэж гаргасан шийдвэртээ Нидерланд улсын Дээд шуух "олон улсын гэрээний шууд хэрэглэгдэх боломжтой буюу шууд үр дагавартай эсэхэд дүн шинжилгээ хийх эхний алхам нь талуудын хүсэл зоригийг тодорхойлох явдал бөгөөд хэрээ талуудын хүсэл зоригийг тодорхойлж чадаагүй тохиолдолд тухайн заалтын эсэхүүг иш татах ба энэ нь гагчхүү Тухайн заалтын агуулгыг хэрэгжүүлэхэд тодорхой агуулга, зорилго бүхий дотоодын зохицуулалтыг хууль тогтоогч батлах шаардлагатай юу аль эсхүл дотоодын эрх зүйд объектив эрх зүй байдлаар өөрөө бие даан үйлчилж чадах эсэхийг шийдвэрлэх нөлөөтэй байна" хэмээн үзсэн байна.

## 2. Олон улсын гэрээг шүүхэд хэрэглэж буй практик

Тус улсын шүүхийн практикт олон улсын гэрээг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгон шууд хэрэглэхээс гадна дотоодын хууль тогтоомжийг олон улсын гэрээний зохицуулалттай нийцүүлэн тайлбарлан хэрэглэх 2 үндсэн практик хөгжих байна. Олон улсын гэрээ шүүхийн шийдвэрт албан ёсны эрх зүйн эх сурвалжийн хүрээнд үзэлэх асуудал нь шүүх тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэх үндэслэл

<sup>23</sup> Tom Ginsburg, *Locking in Democracy: Constitutions, Commitment and International Law*, 38 New York University Journal of Law and Politics 713 (2006)

<sup>24</sup> Dijk and Tahzib, 1991, page 419

болгон олон улсын гэрээний тодорхой заалтыг хэрэглэх бүртээ шууд хэрэгжих эсэхийг тодорхойлох шаардлагатай байдаг. Олон улсын гэрээний шууд хэрэгжих болон эс хэрэгжих эсэхийг тодорхойлох нь олон улсын гэрээг бүхэлд нь гэхээсээ илүү түүний заалт болгон руу чиглэсэн төвөгтэй үйл ажиллагаа юм. Тодруулбал, шуух тодорхой хэрэг маргааны шийдвэрлэх үндэслэл болон олон улсын гэрээний тодорхой заалтыг хэрэглэх бүртээ шууд хэрэгжих эсэхийг тодорхойлох шаардлагатай. Иймд шүүгчээс өндөр үр чадвар шаардаг ба шүүхийн гаргасан шийдвэр маргаан дагуулаха нь олонтоо. Энэ төвөгтэй байдлаас зайлсхийх зорилгоор НВУ-ын Дээд шүүх “олон улсын гэрээний заалтын шууд хэрэгжих эсэхийг тодорхойлох асуудал нь Нидерланд улсын эрх зүйн асуудал гэхээсээ олон улсын эрх зүйн асуудал” гэж үзэж байсан тохиолдолд ч байдаг байна.<sup>24</sup> Жишээ нь энхийг сахиулах ажиллагаанд оролцсон Нидерландын цэргийн албан хаагчид Сербийн талыг дэмжих үйл ажиллагааг хууль бусаар явуулж Боснийн 300 иргэнтэй амь урэгдэх нэхцэл байдлыг үүсгэсэн гэсэн үндэслэлээр хохирогчдын ар гэр энзхүү аллагад НУБ ба Нидерланд улсыг буруутган Гаагийн тойргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан байна<sup>25</sup>. Энэхүү маргааныг шийдвэрлэхдээ Нидерланд улсын шүүхүүд нэгэн зэрэг хоёр зөрчилдөөн бүхий үүрэгтэй тулгарсан. Эхний нь НУБ-ын гишүүн улс болохынхоо хувьд түүний дархан эрхийг хүндэтгэх, удаах нь төрлөөр устах гэмт хэрэгэс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийгэх болон хүн бүрийн шүүхэд хандах эрхийг хангас байсан юм. Энд аль нь илүү *ius cogens* буюу заавал билэгдэх шинжтэй болохыг тодорхойлох нь гол маргаантай асуудал юм. Энэхүү маргаан Сребреникагийн эзжүүд сан болон Нидерланд улсын Засгийн газрын хооронд одоо хэрүгэлжилж байна.

Мөн олон улсын гэрээг дотоодын

<sup>24</sup> Dijk and Tahzib, 1991. page 420

<sup>25</sup> Энэхүү хэргийн талаарх дэлгэрэнгүйг судалгаваны тайллангаас үзүүлүү.

шүүхэд хэрэглэх өөр нэгэн боломжит хувилбар нь тайлбар (*interpretation*) хийх явдал юм. Энэ тохиолдолд хэлбэрийн хувьд шүүхийн шийдвэр нь дотоодын эрх зүйд үндэслэж байгаа боловч агуулын талаасаа дотоодын эрх зүйг олон улсын гэрээний зарчим, үзэл санаатай нийцүүлэн тайлбарлаж байдаг. Иймээс гарах ур дун нь олон улсын гэрээтийн нийцсэн байдаг давуу талтai.<sup>26</sup> Энэ тухайд НВУ-ын Дээд шүүх “боловжийт тохиолдолд манай улсын шүүхүүд нь олон улсын гэрээнд заасан үргээ ханган биелүүлэх байдлаар үндэсний эрх зүйг тайлбарлан хэрэглэх нь зүйтэй” хэмээн үзсэн байна.<sup>27</sup> Жишээ дурдвал Иргэний хуулийн 1:252 дугаар зүйлд дөр дурдсан тохиолдолд дараах байдлаар Дээд шүүх тайлбар хийсэн байна. Үүнийг төвч байдлаар дор авч үзье.

Иргэний хуулийн 1:252 дугаар зүйлд огт гэрлэж байгаагүй бөгөөд насанд хүрээгүй хүүхдийнхээ тэтгэмжийг хамтран төлж байгаагүй эцэг эх хамтран хүсслэж гаргасан тохиолдолд эцэг эх байх эрхийг хамтран хэрэгжүүлж болно гэж заасан. Гэтэл Дээд шүүхэд хэлэлцэгдсэн тохиолдолд зөвхөн эх нь хүүхдийнхээ тэтгэмжийг төлж байжээ. Улмаар эцэг нь мөн хүүгийн эзгийн үргээл биелүүлж тэтгэмж төлөхийг хүссэн өргөдлийг шүүхэд гаргасан байна. Дүүргийн болон Давж заалдах шатны шүүхүүд Иргэний хуулийн 1:252 дугаар зүйл нь зөвхөн хамтран хүсслэж гаргасан тохиолдолд үйлчилнэ гэж үзэж эзгийн хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан байна. Харин энэхүү шийдвэрийг Дээд шүүх 1:252 дугаар зүйл нь Европын Хүний эрхийн конвенцийн 8 дугаар зүйл /Хувийн болон гэр бүлийн амьдраласа/ хүндэтгүүлэх эрх/-ийн 8.1 дэх заалт /Хүн бүр өөрийн хувийн болон гэр бүлийн амьдрал, гэр орон болон тэдгээртэй дүйцэхүүц зүйлээ хүндэтгүүлэх эрхтэй/-д үндэслэн “эзгэг/эх байх эрхээ хэрэгжүүлэх” эрх олж авахын тулд шүүхэд хандах эрхийг баталгаажуулсан тус конвенцийн 6 дугаар зүйл /Шударга

<sup>26</sup> Sloss, 2009. page 348

<sup>27</sup> Nederlandse Jurisprudentie: Supreme Court, 16 November 1990, NJ 1992/107

шүүхээр шүүлгэх эрх/-ийн 6.1 дэх хэсэг /Хүн бүр иргэний эрх, үүрэг болон ямар гэмт хэрэгт буруутгагдсанаа тогтоолгохи тулд хуулийн дагуу байгуулагдсан бие даасан, хараат бус шүүхээр үндэслэл бүхий хугацаанд шударга, нээлттэйгээр шүүлгэх эрхтэй-тэй нийцэхгүй хязгаарлалт агуулсан байна. Иймээс Европын Хувь эрхийн конвенцийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн заалттай нийцүүлэн Иргэний хуулийн 1:252 дугаар зүйлийн эзгэг нь дангаараа хүсэлт гаргах эрхтэй хэмээн тайлбарлавал зохино<sup>28</sup>тэжээ.

## 2.2. Оросын Холбооны Улс

1. Олон улсын эрх зүй ба дотоодын эрх зүйн харилцан хамаарал

ОХУ-ын Үндсэн хууль /1993<sup>29</sup>/. Холбооны улсын хучин төгөлдөр мөрдөгдөж буй ердийн хууль тогтоомжуудад олон улсын эрх зүй ба ОХУ-ын хууль тогтоомжийн харилцан хамаарлыг өмнөх социалист тогтолцоонд мөрдөж байсан уеэс ялгаатай байдлаар зохицуулсан байна. Үүнийг дагаад шүүхэд олон улсын эрх зүйн хэмжээ, гэрээг хэрэглэх практик шинээр үүсэн хөгжих байгаа ажээ. ОХУ ба пост-социалист орнууд онолын хувьд дуалист үзэл баримтлалаас татгалзан олон улсын эрх зүйн хэмжээг үндасчийн эрх зүйгээс давуу хучин чадалтай, үндэсний эрх зүйн нэгэн хэсэг гэж үзэх хандлагатай байна.<sup>30</sup> ОХУ-ын Үндсэн хуулийн 15.4 дүгээр зүйлд "... олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгсөн хэмжээ, зарчмыуд ба ОХУ-ын олон улсын гэрээг үндэсний эрх зүйн системийн нэгэн хэсэг хэмээн үзэ. Хэрэв ОХУ-ын олон улсын гэрээг хууль тогтоомжид зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг хэрэглэнэ" гэж заасан байна. Олон улсын гэрээг хэрэглэх тухай энэхүү зохицуулалтыг хэд хэдэн эрх зүйн актад нарийвчлан тусгажээ. Тухайлбал "ОХУ-

ын Олон улсын гэрээний тухай хууль" /1995/ -д олон улсын гэрээг байгуулах, хэрэгжүүлэх, цуцлах асуудлыг нарийвчлан заасан байдал. Тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт шүүд хэрэгжих хэмжээ гэдэгт "шүүд үйлчлэх болон хэрэглэхээр дотоодын хуульчилсан акт гаргах шаардлагагүй, албан ёсоор нийтлэгдсэн ОХУ-ын олон улсын гэрээ"-г ойлгоно гэсэн байдал.<sup>31</sup>

ОХУ-ын эрх зүйн тогтолцоонд Дээд шүүх хууль тогтоомжид тайлбар хийдэг<sup>32</sup> бөгөөд улмаар доод шатны шүүх хэрэг маргааныг шийдвэрлэхдээ Дээд шүүхээс гаргасан тайлбарыг мөрдөх үүргийг хүлээдэг. Мөн ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхээс гаргасан тайлбарыг төрийн бүх шатны харьялах байгууллагууд мөрдөх үүргийг хүлээдэг. Шүүхээс гаргаж буй шийдвэрүүд шинээр хэмжээг тогтоодогтгүй учраас шүүхийн прецедентийг албан ёсны эх сурвалжийг гэж үзэдэггүй байна. Гэсэн хэдий ч практикт доод шатны шүүх нь хэрэг маргааныг дээд шатны шүүхийн шийдвэрүүдэд үндэслэн гаргадаг байна.<sup>33</sup> Мөн Дээд шүүхийн 2003 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн "Шүүхээс олон улсын эрх зүйн хэмжээ ба гэрээг зөв хэрэглэх тухай" тогтоол байдал. Тус тогтоол батлагдсанаар олон улсын эрх зүйн хэмжээг шүүхэд хэрэглэхэд тулгардаг олон тооны хийдэл багассан ч зарим нэг шүүмжилэл байдал. Энэхүү тогтоолд нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн зарчим, хэмжээ, ОХУ-ын олон улсын гэрээг шүүхэд хэрэглэнэ гээд тэдээрт НҮБ, түүний байгууллагуудын батлан гаргасан баримт бичигийг ойлгоно хэмзэн заасан. Зарим судлаач чухам ямар баримт бичигт заасан олон улсын зарчим, хэмжээг эх сурвалж болгох талаар тодорхой зааж өгөгүй гэж үздэг байна. Тэгвэл Дээд шүүхийн танхимаас гаргасан "Эрүүгийн болон иргэний хэрэг

<sup>28</sup> М.Монхбат. Үндэсний шүүхэд олон улсын эрхээг хэрэгжих асуудал. "Ус түүх дээдлэх бс" 2006/№4

<sup>29</sup> Sergei Yu Marochkin. International Law in the Courts of the Russian Federation. Practice of Application paragraph. Chinese Journal of International Law, 2007 Vol. 6 Issue 2, page 8

<sup>30</sup> Ibid,

хэлэлцэх нөхцөл”-д<sup>34</sup> Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын улсын пакт, Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенц зарчим, хэм, хэмжээг агуулсан байна гэсэн нь Дээд шүүхийн дээр тогтоолыг илүү тодорхой болгосон гэж үзэх судлаачид ч байдаг. Ийнхүү маргаантай байдаг нь Дээд шүүх ба Дээд шүүхийн аль нэг танхмийн гаргасан тогтоол гэдэгт юг ойлгох, аль нь илүү хүчин чадалтай вэ гэсэн эрэмбийн асуудал явагдаж байна уу эсвэл хэм хэмжээ тайлбарлах тал дээр зөрүүтэй санал байна уу гэсэн асуудлын аль нь болох нь судлууштай юм. Учир нь манайд бас ийм төрлийн маргаантай байдал ажиглагддаг ба энэ талаар судалгааны дараагийн бүлэгт авч үзэх болно.

## 2. Олон улсын гэрээг шүүхэд хэрэглэж буй практик

ОХУ-ын Дээд шүүхийн дээр дурдсан тогтооол олон улсын эрх зүйн хэм хэмжээг шүүхэд хэрэгжүүлэх талаар шаардлагатай зохицуулалтуудыг тусгасан боловч ОХУ-ын нутаг дэвсгэрт өмне нь хэдэн арван жил үйлчилж байсан эрх зүйн уламжлал, тогтсон хэв маягийг хууль тогтоомжийн цөөн хэдэн аятаар өөрчлөхэд хүндэтлэйг гэж зарим судлаач үздэг.<sup>35</sup> Түүнчлэн олон улсын байгууллагаас гаргасан баримт бичгүүд, олон улсын нэгдэн орсон гэрээ, түүний орчуулга, мөн хуульчдын олон улсын гэрээг ашиглах эрх зүйн мэдлэг дутмаг, олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх талаарх сургалт, сурталчилгаа хангалтгүй байгаа нь шүүх олон улсын гэрээг хэрэглэх асуудалд серег нөлөө үзүүлдэг ажээ.<sup>36</sup>

ОХУ-ын шүүхүүдэд 1993 онд шинэ Үндсэн хууль батлагданаас хойш олон улсын эрх зүйн холбогдолтой хэрэг маргааныг шийдвэрлэсэн нэлээд тохиолдол гарсан байна. ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх ийм төрлийн хэрэг маргааныг шийдвэрлэхдээ НҮБ,

тууний харьяа байгууллагын гаргасан баримт бичгүүдээс 50 орчим удаа, ОХУ-ын нэгдэн орсон олон улсын гэрээг 25 гаруй удаа иш татан хэрэглэжээ.<sup>37</sup> Түүнчлэн үндсэн хуулийн хэм хэмжээ ба Европын хүний эрхийн шуухийн шийдвэрийг голчлон анхаарч үзсэн байdag байна.

ОХУ-ын шүүхэд олон улсын гэрээг хэрэглэх тухайд зарим эрдэмтэд монист буюу холимог монист хандлагатай гэж тодорхойлсон байдаг.<sup>38</sup> Учир нь ОХУ-ын олон улсын бүх гэрээ нь үндэсний эрх зүйн хууль тогтоомжоос давуу хүчин чадалтай байдаггүй бөгөөд үүнтэй холбоотойгоор практикт зарим асуудал гарч ирдэг байна. Тухайлбал:

- ОХУ-ын Үндсэн хуулиар тухайн олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомжоос давуу хүчин чадалтай байхаар тогтоож егсэн байсан ч шүүхэд хүчин төгөлдөр эх сурвалж байхын тулд ямар нөхцөл хангах вэ?

- Үндэсний хууль тогтоомж холбогдох олон улсын гэрээнээс илүү тааламжтай нөхцөлийг санал болгосон тохиолдолд шүүх эрх зүйн хэм хэмжээг хэрхэн хэрэглэх вэ?

Шүүх олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэхийн тулд олон улсын гэрээ нь хүчин төгөлдөр байх, ийнхүү хүчин төгөлдөр байхын тулд ОХУ-ын нутаг дэвсгэр дээр заавал дагаж мөрдхөөр соёрхон баталж тусгай хууль гаргах, уг хууль, олон улсын гэрээ нь албан ёсоор хэвлэгдсэн, өөрөө хэрэгжих заалтыг агуулсан байх гэх мэт нөхцөлүүдийг хангасан байх шаардлагыг тавсан байна. Харин ийнхүү хууль тогтоомжид тусгайлан заасан нөхцөлүүд нь биелгэдээгүй нөхцөлд шүүх хэрхэн шийдвэр гаргаж байсан талаар сонирхолтой жишээнүүд байдаг. Жишээ нь А компанийн Гаалийн төлбөрийг хүчингүй болгуулах тухай хэрэг маргаан юм.<sup>39</sup> Нэхэмжлэгч тал “Давхар татвараас чөлөөлөх тухай” олон улсын гэрээг хэрэглэхийг оролдсон боловч Тюмен мужийн арбитрийн шүүх тус гэрээг хэрэглээгүй байна. Учир

<sup>34</sup> Ibid. page 50

<sup>35</sup> Ibid. page 19

<sup>36</sup> Danilenko, 1998, page 49.

<sup>37</sup> Sloss, 2009, page 414

<sup>38</sup> Danilenko, 1998, page 4; Sloss, 2009 page 8

<sup>39</sup> Marochkin, 2007.33

нь шүүхээс тогтооходо тус гэрээ нь сөйрхон батлагдсан боловч албан ёсоор хэвлэгдээгүй байна гэж үзжээ. Үүний эсрэг А компани давж заалдаш шатны шүүхэд гомдол гаргахдаа тус гэрээ нь албан ёсоор хэвлэгдээгүй боловч компютерийн дата хэлбэрээр байгаа гэж мэтгэсэн ч гэрээг албан ёсны эх сурвалж гэж үзэхгүй гэсэн шийдвэрийг хэвээр үлдээжээ<sup>40</sup>.

Монист чиг хандлагатай улсад олон улсын гэрээний хэмжээ ба дотоодын хууль тогтоомж хоорондоо зөрчилтэй нэхцэлд олон улсын гэрээг баримтлах ёстой боловч хэрэв тухайн этгээдийн эрх ашиг олон улсын гэрээний хэм хэмжээг хэрэглэсэнээр дордох бол ях вэ гэдэг ОХУ-ын шүүх ямар шийдвэр гаргасан талаар нэгэн жишээ авч үзье. ОХУ-ын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимиын шийдвэрлэсэн нэгэн хэрэгт Л ба Интерфиш ХХК компаниудын хооронд ууссэн цалин хэлс олгох тухай маргааныг хийшээ болгон дурдаж болно. Тус маргааны үеэр нэхэмжлэгч тал доод шатны шүүх зохих хэм хэмжээг хэрэглээгүй гэж үзсэн байна. Хэргийг Дээд шүүхээс шийдвэрлэхдээ хэрэв олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжийн аль алиныг хэрэглэх боломжтой бол тухайн этгээд өөрт илүү тааламжтай нэхцэлийг агуулсан хэм хэмжээг хэрэглэх талаар шүүхэд хандах эрхтэй гэж үзсэн байна.

### 2.3. Холбооны Бугд Найрамдах Герман улс

#### 1. Олон улсын эрх зүй ба дотоодын эрх зүйн харилцан хамаарал

ХБНГУ нь онолын хувьд дуалист хандлагыг баримтладаг улс тул олон улсын гэрээг дотоодын хууль, тогтоомжид нийцүүлэн өөрчлөх шаардлагатай болдог байна. Иймээс олон улсын гэрээг үндэснийхээс эрх зүйд нийцүүлэн хэрэглэхийн тулд дотоодын шилжилтийн акт (*Transformationsakt*-аар дамжуулан хэрэглэх ёстой. Гэвч практикт цэвэр дуалист хандлагаар үндэсний эрх зүй болон олон улсын эрх зүйг яматг салангид авч үзэх

боломж байдаггүй. Иймд ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүх холимог дуалист хандлагыг баримтладаг гэж үзэх судлаачид байдаг байна. Германы эрх зүйд холимог дуалист хандлагаар олон улсын эрх зүй болон үндэсний эрх зүйг зөвхөн зарчмын хувьд ялгаатай авч үзэх гэж тайлбарладаг. Энэ нь Германы шүүхийн практикт хэрэв олон улсын гэрээ ба дотоодын хууль тогтоомж зөрчилдөнтэй бол дотоодын хууль тогтоомжийг хүчинтэй хэвээр байна гэсэн зарчмыг ерөнхийд нь баримтладаг гэсэн уг юм. Өөрөөр хэлбэл, тухайн нэг хэрэг тохиолдлын хувьд шүүх шаардлагатай гэж үзвэл зөрчилдөнтэй байсан ч олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх шийдвэрийг гаргаж болно гэсэн агуулга харагдаж байна. Түүнчлэн, ХБНГУ-ын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд олон улсын эрх зүйн нийтлэг зарчмууд тус улсын хууль тогтоомжийн нэг хэсэг мөн бөгөөд дотоодын хууль тогтоомжоос дээзгүр эрэмбэлтэй байна гэсэн байдал. Энэ заалтын өөр нэг онцлог тал нь дээрх зарчмууд Германы нутаг дэвсгэрт оршин сууж буй бүх иргэдэд шууд эрх үүргийг үүсгэх болно гэдгийг тодотгосон байна. Үүнтэй холбоотой Захиргааны хэргийн шүүхээс гаргасан нэгэн шийдвэрт "Хэрэв олон улсын гэрээгээр хүлээлгэсэн эрх үүрэг нь уг хэллэг, зорилго, агуулгын хувьд дотоодын хууль тогтоомжийн адил хангалттай тодорхойлгдсон ба ойлгомжтой хэлбэржсэн байвал дотоодын шүүх тухайн олон улсын гэрээний хэм хэмжээг шууд хэрэглэх болно. Харин дээрх нэхцэл хангагдаагүй хэм хэмжээний хувьд шүүх хэрэглэхдээ тухайн асуудлыг эхлээд дотоодын эрх зүйн зохицуулалтыг баримтлан тодруулна"<sup>41</sup> гэсэн байдал.

#### 2. Олон улсын гэрээг шүүхэд хэрэглэж буй практик

Холимог дуалистэвэлдан дуалист чиг хандлага тухайн хэм хэмжээгээр хэрхэн илрэч байгааг тайлбарлаж шийдвэрийн үндэслэлээ хэрхэн гаргах

<sup>40</sup> Түнгэн төстийн хэрэг тохиолдлуудыг хэрхэн шинидэн хийшээг судалгааны тайллангаас үзэх үү

<sup>41</sup> Matz-Lück Nele, Staatsrecht III, Teil 2 Völkerrecht und Außenverfassungsrecht, Seite 3

нь шүүхийн асуудал байдаг. Иймд олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх талаар Германы шүүхийн шийдвэрүүд харилсан адилгүй байх тохиолдлуулд гардаг байна. Үндсэн хуулийн шүүхээс шийдвэрлэсэн "Монакогийн гүнж" ба "Гергуул" гэсэн 2 хэргээс хараад тухайн шүүх олон улсын гэрээг тайлбарлахаа аль чиг хандлагыг баримталсан нь шүүхийн шийдвэрт хэрхэн нөлөөлж болдгүй харуулсан жишээ юм.<sup>42</sup>

Хувийн амьдралын нууцыг хамгаалах талаар Германы Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрт сэтгэл ханамжгүй байсан Монако Вант улсын гүнж Каролине Европын Хүний эрхийн шүүхэд хандсан байна<sup>43</sup>. Европын Хүний эрхийн конвенцийн 19-р зүйлийн дагуу эрх нь зөрчигдсэн гэж үзсэн хувь хүн дотоодын бүх шатны шүүхийн шатыг барагдуулсан бол Европын хүний эрхийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй. Иймд Монако Вант улсын гүнж Герман улсын Үндсэн хуулийн шүүх олон улсын гэрээгээр хүлээсэн үргээ билэлүүлэсгүй хэмээн Европын Хүний эрхийн шүүхэд хандсан гомдолдоо "Европын Хүний эрхийн гэрээний заалтууд ХБНГУ-ын Үндсэн хуулийн үндсэн эрхийн заалтаас доогуур эрэмбэлэгдэг. Гэсэн хэдий ч ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүх Үндсэн хуульд тайлбар хийхдээ Европын Хүний эрхийн конвенцийн агуулга болон хөгжлийн чиг хандлагыг анхаарч үззэх ёстой гэсэн заалтыг харгалзан үзээгүй гэсэн байна.<sup>44</sup> Германы тал Үндсэн хуулийн шүүх шийдвэр гаргахдаа олон улсын гэрээний заалтыг заавал мөрдөх ёстой гэсэн үргэл байхгүй гэсэн байр суурийг<sup>45</sup> баримтладаг ч Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрийг хүндэтгэн үзэн гэж үзжээ. Ийнхүү энэ хэргийн эцэст нэг талаар гүнжийн нэхэмжлэлийг Европын хүний эрхийн шүүх түүний талд шийдвэрлэсэн боловч нөгөө талаар Германы Үндсэн хуулийн шүүх өөрийн

гаргасан шийдвэрээ дотоодын шүүх эрх мэдлийн хувьд хүчинтэй хэвээр нь хадгалж үлдсэн байна.

Энэ хэргийн талаар судлаачид ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүх шийдвэртээ дотоодын шүүх Европын Хүний эрхийн шүүхийн шийдвэрийг хэрхэн дагаж мөрдөх ёстойг илүү тодорхой заасан бол зохицтой байсан. Ийнхүү заагаагүйгээ Үндсэн хуулийн шүүх Европын Хүний эрхийн конвенцийн 46 дугаар зүйлийг ул тоомсурсосон гэж дүгнэсэн байна. Тус зүйлд зааснаар гэрээнд нэгдэн орсон улсууд Европын Хүний эрхийн шүүхийн шийдвэрийг дагаж мөрдөх үүрэг хулээдэг.

Үндсэн хуулийн шүүхээс гаргасан өөр шийдвэрт /Гергуулгийн нэхэмжлэлтий хэрэг/<sup>46</sup> Герман улс холимог дуалист хандлагыг баримталсан байдаг. Казим Гөргүлү нь Герман улсад амьдран суудаг Турк улсын иргэн бөгөөд тэрсэн хүүгээ асран хамгаалах эрхийг олж авах гэж олон жил шүүхэд ханджээ. Гөргүлү нь хүүгийн эзжтэй албан ёсоор гарзлэсгүй байсан бөгөөд тусдаа амьдрах болсон тул хүүгээ 1999 оны 8 дугаар сард тэрсэн гэдгийг 2 сарын дараа мэджээ. Харин хүүгийн эх тэрснийхөө маргааш нь эзгийнх нь зөвшөөрөлгүү хүүхдээ асран хамгаалаулхаар нэгэн гэр бүлд урчлулсан байна. Үүнээс үүдэн Гөргүл тэрсэн хүүгээ асран хамгаалах эрхийг өөртөө шилжүүлэн авах маргаан үзгэсэн бөгөөд Үндсэн хуулийн шүүх Гөргүлийн талд шийдвэр гаргахдаа олон улсын эрх зүйн хэм хэмжээг баримталсан байна. Үндэслэлдээ ХБНГУ-ын Үндсэн хууль нь олон улсын эрх зүй болон үндэсний эрх зүйг өөр хооронд нь бие даасан харьцаанд авч үздэг бөгөөд үүнийг Үндсэн хуулийн 25 болон 59.II дугаар зүйлийн уг хэллэгээс харж болно гэж дурдажээ.<sup>47</sup> Холбооны Үндсэн хуулийн шүүх Гөргүлийн хэрэгт холбогдуулан Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дүгээр өгүүлбэрийг тайлбарлахаа олон улсын эрх зүйн нийтлэг журам нь дотоодын хууль тогтоомжоос дээгүүр эрэмбэлэтий байна.<sup>48</sup>

<sup>42</sup> Энэ 2 хэргийн талаарх дэлгэрэнгүйг судалгааны тайлланыг үзүүлүү.

<sup>43</sup> Vgl. EGMR NJW 2004, 2647 ff.

<sup>44</sup> Vgl. BverfG NJW 2004, 3407 ff.; BverfGE 63, 343, 33; 74, 358, 370; 75, 1, 19; 82, 106, 115.

<sup>45</sup> BverfG NJW 2004, 3407, 3408 f., (2 BvR 1481/04). Vgl. Auch Mann, NJW 2004, 3220 f.

<sup>46</sup> BverfG, Beschluss vom 14.10.2004- 2BvR 148/04. Rn 34. Гүргэв.

<sup>47</sup> Ibid.

гэж заасан боловч энэ 25 дугаар зүйл бүхэлдээ олон улсын эрх зүйн нийтлэг журмын агуулга болон түүнээс үүссэн шаардлага, нэн ялангуяа түүний үйлчлэх хүрээний хувьд л хамаарлтай гэсэн байдаг.<sup>46</sup> Мөн тайбарт олон улсын эрх зүйн нийтлэг журам гэдэгт "олон улсын заншлын эрх зүй ба олон улсын эрх зүйд хүлээн зөвшөөрөгдсөн үндсэн зарчмыг ойлгоно"<sup>47</sup> гэсэн Үндсэн хуулийн шүүхийн вэр нэг шийдвэрийг үндэслэсэн байдаг. Мөн энэ асуудлаар өмнө гарсан мужийн дээд шүүхийн шийдвэрийг олон улсын эрх зүйн хэм хэмжээг баримтлан цуцлах тухайд шүүхийн хараат бус байдал яригдахгүй, харин олон улсын шүүхийн шийдвэрийг хэрхэн дагаж мөрдөх асуудал энд чухал гэж заасан нь сонирхолтой юм<sup>48</sup>. Цаашилбал "Европын Хүний эрхийн конвенцийн 46 дугаар зүйлд заасанчлан Европын Хүний эрхийн шүүхийн шийдвэрийг дотоодын бүхий л албан тушаалтан өөрийн эрх мэдлийн хүрээнд хууль тогтоомжийг биелүүлэхдээ олон улсын гэрзэнд нийцтэй байдлыг харгалзах нь зүй ёсны юм" хэмээн Үндсэн хуулийн шүүх шийдвэртээ заажээ<sup>49</sup>.

Дээрх 2 тохиолдоос харахад Үндсэн хуулийн шүүх Европын хүний эрхийн конвенцийн хэм хэмжээг "тодорхой хэмжээнд" анхааран авч үзэж болох ба Германы хууль тогтоомжийн хувьд Европын Хүний эрхийн шүүхийн гаргасан шийдвэрийг заавал мөрдөх ёстой биш гэж үзсэн<sup>50</sup> бол Гергулүгийн хэрэгт олон улсын эрх зүйн хэм хэмжээг мөрдөх нь зүй ёсны хэрэг юм гэсэн утгатай шийдвэр гаргасан нь шүүх олон улсын эрх зүйн хэм хэмжээг зөрчиж байгаа гэхээсээ тухайн хэм хэмжээг ямар тохиолдолд ямар үндэслэл гарган хэрхэн шийдвэрлэх нь тухайн улсын шүүх эрх мэдлийн нэг хэсэг байдаг гэдгийг харуулсан жишээ юм.

### Гурав. Монгол Улсын олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх асуудал

3.1. Олон улсын эрх зүй ба дотоодын эрх зүйн харилцан хамаарал

Монгол Улсын Үндсэн Хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг ба 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх эрх зүйн үндэслэл тусгагдсан байдаг. Түүнчлэн процессын хуулийн холбогдох заалтуудаар ч давхар зохицуулагдсан. Гадаад улсын шүүхийн даалгаврыг биелүүлэх, гадаад улсад шүүхийн даалгавар явуулах иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шүүхүүд хэрэгжүүлэхдээ гадаадын тухайн улстай байгуулсан эрх зүйн харилцан туслалцаа узуулэх Монгол Улсын хөёр талт олон улсын гэрээ, ийм гэрээ байхгүй бол "Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай Вениний конвенц (1954)" ба Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалтыг хэрэглэнэ. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай конвенцийн дугаар бүлэгт шүүхийн бүх шийдвэрийг гүйцэтгэх талаар бус харин шүүхийн зардал төлүүлэх тухай, гадаад улсын шийдвэрийг албадан гүйцэтгэх асуудлыг шүүхүүд Монгол улс, тухайн гадаад улстай байгуулсан эсэхээс ул хамааран Конвенцийн заалтыг баримтлан шийдвэрлэх боломжтой.

Ийнхүү олон улсын эрх зүйн хэм хэмжээг үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил хэрэглэх нехцэл боломжийг хуульчилж, манай улсын шүүх эрх мэдлийн байгууллагын хувьд хэрэг маргааныг үзнэн зөв шийдвэрлэхдэд үндэс болгох эх сурвалж нь илүү өргөн болсон мэт харагдаж байгаа боловч зөвхөн хуулиндаа хэрэглэх боломжийг нь тусгаад л шууд хэрэгжих эсүудал биш юм. Монгол Улсын хувьд олон улсын эрх зүйн болон үндэсний эрх зүйн харилцан хамаарлын асуудлыг олон улсын гэрээ нь сөйрхөн баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэх ба гэрээнээс үүсэх үүргийг ёсчлон биелүүлэх талаар Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд заажээ. Одоогоор хүчин

<sup>46</sup> BVerfG 27 253 (27).

<sup>47</sup> BVerfG 23 288 (217), 31 145, (177)

<sup>48</sup> BVerfG's Beschluss vom 14.10.2004 - 2BvR 148/04, Rn 22, Gurgub.

<sup>49</sup> vgl. Dazu ausführlich R. Schmidt, Grundrechte, Rnr. 4.

<sup>50</sup> BVerfG NJW 2004, 3407, 3408 f.

төгөлдөр үйлчилж буй хуулиудын 140 гаруй нь "Монгол улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрднө" гэх заалт агуулах бөгөөд энэ нь Монгол улсын улсын эрх зүйн давуу хүчинтэй байх буюу монист хандлага баримтлалгийг нотолж байна.

Негоёттайгүүр Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэх узвэл уул эрхээ хамгаалулахаар шүүхэд гомдол гаргах Монгол Улсын иргэний эрхийг тунхаглаж өгсөн байдал, мөн Иргэний хуулийн З дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт "Тухайн асуудлаар дотоодын хууль тоогоомж гаргах шаардлагатай гэж олон улсын гэрээнд зааснаас бусад тохиолдолд иргэний эрх зүйн харилцаанд Монгол улсын олон улсын гэрээг хэрэглэн" гэх зохицуулалт, ихэнх хуулийн "олон улсын гэрээнд зааснаас бусад тохиолдолд" тухайн хуулийг хэрэглэх эзрэг заалт нь шууд хэрэглэж болох хэм хэмжээг тодорхой хэмжээнд агуулж байна гэх үндэслэлтийг байна. Ийнхүү олон улсын гэрээг шууд заасан хэм хэмжээ мөн болох эсэх, түүнийг хэрэглэх эсэх талаар эрх зүйн шинжлэх ухааны онол, практикийг үндэслэн тухайн олон улсын гэрээний хувьд хэрхэн тайлбарлах нь шүүхийн бүрэн эрхийн асуудал гэж үзэж болох юм.

### 3.2. Олон улсын гэрээг шүүхэд хэрэглэж буй практик

Үндсэн Хуулийн Цэц /ҮХЦ/-ийн 1992-2014 оны хооронд гарсан нийт шийдвэрийн буюу 191 шийдвэрийн 20 шийдвэрт нь ҮХЦ олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэн шийдвэрээ гаргасан бөгөөд иргэдээс ҮХЦ-д ирүүлсэн өргөдлөөс 37 өргөдөл нь олон улсын эрх зүйн хэм хэмжээний заалтыг тусгасан байна. ҮХЦ-ийн шийдвэр болон иргэдээс ирүүлсэн өргөдлийг хараад ихэнх тохиолдолд НҮБ-ын "Хүний эрхийн түгээмэл тунхаглал"(1948), "Эрүү шүүлт болон бусад харгис, хүнлаг бус, доромжилсон харьцаа, шийтгэлийн эсрэг олон улсын гэрээ"(1948).

"Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт"(1966). Олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Ажилгүйдлийн тэтгэмжийн тухай" 44 дүгээр Конвенц (1934), "Олон улсын гэрээний эрх зүйн тухай Вениний Конвенц"(1969). ДХБ-ын "Тариф, худалдааны ерөнхий хэлэлцэрээр" (1994) зэргийг гол төлөв хэрэглэсэн байна.

2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2013 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн хооронд манай улсын хэмжээнд нийт 26406 иргэний хэрэг шийдвэрлэгдсэн байна. Энэхүү шийдвэрүүдээс гэрлэлт цуцлахтай холбоотой 2123 шийдвэрээс 19 шийдвэр нь олон улсын эрх зүйн хэм хэмжээг агуулсан буюу "Хүүхдийн эрхийн тухай конвенц"-ийг ашиглан шийдвэрлэсэн байна. Харин хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбоотой нийт 787 шүүхийн шийдвэрээс 6 шийдвэрт олон улсын эрх зүйн хэм хэмжээг агуулсан буюу "Хүүхдийн эрхийн тухай конвенц"-ийг хэрэглэжээ. Харин хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбоотой нийт 67 шийдвэрээс 4 шийдвэрт нь "Хүүхдийн эрхийн тухай конвенц"-ийг хэрэглэсэн байна. Дээрхээ дүгнэвлэ 2013, 2014 онуудад Монгол Улсын хэмжээнд олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэн шийдвэрлэсэн 35 шийдвэр байх бөгөөд дээрх шийдвэрүүдийн ихэнхид "Хүүхдийн эрхийн тухай конвенц"-ийг хэрэглэсэн байна.


3.3. Практикт тулгарч буй бэрхшээл, зарим маргаантай асуудал Монгол Улс өнөөгийн байдлаар 200 орчим олон талт гэрээ, конвенцийн оролцож болж, 2000 гаруй хөр талын хэлэлцэр байгуулаад байна. Манай улсын нэгдэн орсон, соёрхон баталсан

олон улсын гарээний 140 орчим гарээнд албан ёсны орчуулга хийж, Улсын Их Хурлын Тамгын газар, Гадаад хэргийн яамнаас хамтран олон улсын гарээний тусгай эмхэтгэл болгон хэвлэн нийтэлж, дотоодын хууль хяналтын байгууллага, шүүгч, өмгөөлөгчид түгээх ажлыг гүйцэтгэсэн байна. Иймд дээрх нэгдэн орсон бүхий лолонуулсын гарээгхэрэглэх боломж нь 140 орчим гарээн тоогоор хязгарагдаж байна. Ингээнээрээ нэгдэн орсон гарээз, конвенцийг хэрэглэхэд хүндэрэл үүсгэсэр байна. Олон улсын гарээний орчуулга, түүний албан ёсоор хэвлэгдсэн байдал зэрэгээ шалтгаалан хэрэглэдэх боломж хязгарагдаг талаара судлаачдын дээрх байр суурь шүүгч, өмгөөлөгчийн дунд бидний явуулсан судалгаагаар нотлогдсон болно.<sup>53</sup> Олон улсын гарээг шүүхэд хэрэглэхэд дээрх мэтчилэн хэлбэрийн шаардлага хангагдахгүй бэрхшээл байхаас гадна өмгөөлөгч, шүүгч нарын дунд олон улсын эрх зүйн талаар ерөнхий мэдлэг, тэр тусмаа хувь этгээдийн хувьд олон улсын эрх зүйн гарээний зүйл, заалт ямар үр дагавартай байх талаара ойлцорт сайн биш байгаа нь харагдаж байна. Тухайлбал санал асуулгын "Таны бодлоор Монгол Улсын олон улсын гарээ ямар шинжийг агуулсан бол шүүх хэрэглэх вэ?" гэсэн асуултад

- Үндсэн хуульд харьшлагай;
- Монгол Улсын олон улсын гарээг соёрхон баталсан хууль хүчин төгөлдөр болсноор;
- Монгол Улсын олон улсын гарээний эх бичвэр албан ёсоор нийтлэгдсэнээр;
- Дотоодын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахыг шаардан заалтгүй бол;

График 1

#### Шүүхийн ажиллагаанд олон улсын эрх зүйн мэргэшсэн шинжээч



<sup>53</sup> Санал асуулгын дэлгэрэнгүүг судалгааны тайлангаас үзэх 77

- Эрх зүйн харилцаанд оролцогч этгээдэд шууд эрх, үүрэг үүсгэх чадалтай бол


гэсэн хариулт өгөгдсөнөөс хамгийн их хувьтай нь хамгийн эхний хариулт, харин хамгийн бага хувьтай хариулт нь сүүлийн хариулт байна. Дээрх хариултууд бүгд зөв ч хамгийн сүүлийн хувилбар буюу тухайн олон улсын гарээний хэм хэмжээ нь тухайн эрх зүйн харилцаанд оролцогч этгээдэд шуудээр, үүрэг үүсгэх нь хэрэг хянал шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэх хэм хэмжээ гэж үзэх нь шүүхийн хувьд хамгийн чухал нехцэл байсан болно. Дээд шүүхийн "Монгол Улсын олон улсын гарээ болон олон улсын эрх зүйн хулээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай" 2008 оны 2 дугаар тогтоолын талаарх асуултын хариултад түүний ач холбогдлын нэлээн үзүүлсэн боловчтогоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээ /хэрэглэх аргачлал, сургалт, сургалтын гарын авлага боловсруулах, олон улсын гарээг хэрэглэх алкам, аргачлал, шийдвэрт хэрхэн тусгах г.м/ шаардлагатай байгааг санал асуулгад оролцогчдын 70-80% нь дэмжсан байна. Мен олон улсын гарээг хэрхэн хэрэглэх талаар аргачлал, зааварчилгаа хангалтгүй, олон улсын гарээний сургалт, мэдээлэл, сурталчилгаа хангалтгүй гарсэн саналыг шүүгч, өмгөөлөгчдийн олонхи нь егсэн бөгөөд энэ нь шүүхийн ажиллагаанд олон улсын эрх зүйн мэргэшсэн шинжээч ажиллашаардлагатай гэдэг хариултыг сонгосон байдлаас харгадана. /доор График 1 үзүүлж, шүүгчдийн дунд сургалт мэдээлэл хангалтгүй байгаа тул олон улсын эрх зүйн мэргэшсэн шинжээч шаардлагатай байгаа гэсэн хариултыг өгчээ гэж дүгнэж болох юм.

График 1-ээс харахад санал асуулгад оролцсон шүүгчдийн дийлэнх /80%/ , өмгөөлгчдийн тал хувь /50%/ нь олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх нь зүйтэй гэсэн байр суурьтай байгаа бөгөөд маш бага хувь нь үндэсний эрх зүйн зохицуулалт байхад хангалттай гэсэн байна. Олон улсын гэрээг хэрэглэх талаар шүүгч нарын дунд ийнхүү илүү зөрөг хандлага байгаа бол бодит байдалд хэрэглэж ирсэн тохиолдол нь шүүгч нараас өмгөөлгчдийн хувь илүү байгаа нь сонирхолтой юм. /График 2-той харьцуулна уу/

• *Pacta sunt servanda* зарчим ба дотоодын шүүхийн бүрэн эрх

Үндэсн хуулийн 66 дугаар зүйлийн 66.2 дахь хэсэгт зааснаа УХЦН Монгол улсын олон улсын гарэз Үндэсн хуульд нийцэж байгаа эсэх талаар дутгэлт гаргаж УИХ-д оруулдаг. Энэ заалтыг 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн дагуу "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үргээ шударгаар сахин биелүүлнэ" гэсэн заалттай зөрчилдэж байна гэж зарим судлаач үздэг. Гол үндэслэл нь Монгол Улс нэгэндэн орсноор Олон улсын гэрээний тухай 1969 оны Вениний конвенцийн *pacta sunt servanda*

**График 2**



Олон улсын гэрээг дотоодын шүүхээрэглэх тухайд олон улсын эрх зүйгээр мэргэшсэн судлаачдын дунд зарчмын зөвүүтэй санал, тайлбар байх нь зүй ёсны хэрэг бөгөөд энэ нь практикийн гэхээс илүү онолын асуудал байх тул ийнхүү олон ургаачь узэл санаа гарах тусмаа шүүгч, өмгөөлгчдөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдолтой байж болно. Монгол Улс монист эсвэл холимог монист улсын аль нь байж болох, аль хувилбарыг хууль тогтоомжоороо баталгаажуулбал үндэсний эрх зүйн тогтолцоонд илүү ач холбогдолтой байж болох зэрэг ерөнхий асуудлаас эхлээд олон улсын гарээний хэм хэмжээг хэрэглэсэн шүүхийн шийдвэрийг задлан шинжлэх зэрээр энэ салбарт судалгааны ажил ихээхэн чухал байна. Үүнтэй холбон зарим нэг асуудлыг хөндье.

хандаж байгааг тодорхой ялгаж салган хандах ёстай. Хэрэв хувь этгээдийн зүгээс тухайн олон улсын гэрээний аль нэг тал гэрээний үргээ биелүүлээгүй нь түүний эрх ашигт зөрчих байна гэж үзэн дотоодын шүүхэд хандаж байгаа тохиолдолд шүүхээс хэлбэрийн ба агуулгын шалгалт явуулах ёстай юм. Хэрэв хэлбэрийн бүх шаардлагыг хангааддээр нь тухайн олон улсын гэрээ шүүд хэрэгжих хэм хэмжээ мөн хэмээн тогтоовол шүүх маргаан шийдвэрлэх эрх зүйн эх сурвалж болгон олон улсын гэрээг хэрэглэхээс татгалзах учиргүй юм.<sup>54</sup> Дээрх хэлбэрийн болон агуулгын шаардлагыг хангах нь тухайн олон улсын гэрээг хэрэглэх эсэхэд тавигдах наад захын шалгуур болно. Хэрэв шаардлагыг хангаагүй хэмээн шүүх үндэслэлээ гаргаж байгаа нөхцөлд хэрэглэхгүй байж бүрэн эрх нь шүүхэд хадгалагдана. Хоёрдугаарт, дотоодын

<sup>54</sup> Хэлбэрийн болон агуулгын шаардлагын талаар энэ судалгааны 1-р хэсгээс дэлгэрүүлж үзүү.

шүүх хэрэг хянан шийдвэрлэх асуудалд Венийн конвенцийг хэрэглэх эсэх нь маргаантай байдаг тухай бид энэхүү судалгаанд өмнө өгүүлсэн билээ. Манай улсын хувьд *racta sunt servanda* зарчмыг хэрэглэх тухайд олонхиин саналыг дагах нь зүйтэй. Гагцхүү өөрийн орны хууль тогтоомжийн хүрээнд хэрхэн авч үзэх, олон улсын хэм хэмжээг дотоодын хэм хэмжээнд харьцуулан хэрхэн тайлбарлах нь эрх зүй хэрэглэгчийн онолын мэдлэг, ур чадвараас ихээхэн хамааралтай гэж хэлж болно.

Ерөнхийдээ Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 66.2.1, 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг нь зөрчилтэй тул *racta sunt servanda* зарчим шүүхэд хэрэгжихэд бэрхшээл учруулж байна гэдэг дүгнэлт бодитой биш юм. Учир нь энд олон улсын гэрээг хэрхэн хэрэглэх тухайд бус харин олон улсын гэрээ үндсэн хуультай зөрчилтэй бол шүүх хэрэг хянан шийдвэрлэх асуудалд Венийн конвенцийг хэрэглэх эсэх нь маргаантай байдаг тухай бид энэхүү судалгаанд өмнө өгүүлсэн билээ. Манай улсын хувьд *racta sunt servanda* зарчмыг хэрэглэх тухайд олонхиин саналыг дагах нь зүйтэй. Гагцхүү өөрийн орны хууль тогтоомжийн хүрээнд хэрхэн авч үзэх, олон улсын хэм хэмжээг дотоодын хэм хэмжээнд харьцуулан хэрхэн тайлбарлах нь эрх зүй хэрэглэгчийн онолын мэдлэг, ур чадвараас ихээхэн хамааралтай гэж хэлж болно.

Ерөнхийдээ Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 66.2.1, 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг нь зөрчилтэй тул *racta sunt servanda* зарчим шүүхэд хэрэгжихэд бэрхшээл учруулж байна гэдэг дүгнэлт бодитой биш юм. Учир нь энд олон улсын гэрээг хэрхэн хэрэглэх тухайд бус харин олон улсын гэрээ үндсэн хуультай зөрчилтэй бол хэрхэн авч үзэх талаар зохицуулсан тусдаа асуудал буюу процессын хэм хэмжээ. хэлбэрийн шаардлагыг хэрхэн хангаж байгаа тухай асуудал болно. Үндсэн хуулинд заасан суурь хэм хэмжээ, зарчмын ойлголтуудыг түүнд нийцүүлэн бусад хууль тогтоомжоор

дэлгэрүүлэн зохицуулдаг бөгөөд Үндсэн хуулийн дээрх 2 заалтын хувьд Олон улсын гэрээний тухай хууль, Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцын зүйл, заалттай харьцуулан тайлбарлах ёстай гэж үзэхээр байна.

- Соёрхон батлах олон улсын гэрээний тухай

Манай эрх зүйн тогтолцоонд олон улсын гэрээний талаар баримталж ирсэн зарчим ОХУ-тай маш төстэй явагдаж ирснийг бид энэхүү судалгааны 2.2 хэсэгтэй харьцуулбал төвөгүй харж болно. Ялангуяа Олон улсын гэрээний тухай хууль (ОУГТХ)-ийн зохицуулалт нэлзэн төстэй боловч нэгэн гол асуудлаар ялгаатай байна. ОХУ-ын Олон улсын гэрээний тухай хуульд шууд хэрэглэх хэм хэмжээг тодорхойлон заасан байдгийг манай хуульд авч хэрэглэгүй нь хачирхалтай юм. Хэрэв ийм агууллыг ямар нэг байдлаар бид хуулиндаа тусгасан бол олон улсын грээ байгуулах талаар эрх бүхий байгууллагууд илүү их анхааралтай хандах, мөн эрх ашиг нь зөрчигдсөн хувь этгээд шүүхэд хандах боломж илүү өргөн үндэслэлтэй болох, шүүх олон улсын гэрээг хэрэглэх талаар илүү тодорхой зохицуулалт хэрэглэх боломж бүрдэх байсан байж болох юм. Гэвч ийнхүү шууд заагаагүй тохиолдолд олон улсын эрх зүйн хэм хэмжээ ба дотоодын хуульд байгаа зүйл, заалтыг ашиглан шийдвэр гаргах ямар нэг арга замыг олох нь эрх зүй хэрэглэгчийн үүрж юм. Ийм арга замын нэг нь юуны туруунд тухайн олон улсын гэрээний зүйл, заалт бүх этгээдэд хандсан заавал биелэгдэх шинжтэй агуулга, зорилготай эсэхэд хэм хэмжээний тайлбар хийх замаар тодорхойлох асуудал юм. Ийнхүү тодорхойлоход нэмэлт үндэслэл, гаргалгааг, ту айлбал ОУГТХ-д заасан соёрхон батлах тухай хуулийн жагсаалт, мөн ийм төрлийн гэрээг нийтилжээ Монгол Улсын хууль нийцүүлэх журмыг баримталнаа гэсэн хуулийн зохицуулалтыг (ОУГТХ §10 ба §25) харьцуулан тухайн гэрээнд дун шинжилгээ хийх замаар шууд хэрэглэх хэм хэмжээ мөн эсэхийг тогтоох гарц байж болно. Соёрхон

батлагдсан хуулийн тухайд ОУГтХ-ийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг чухал ач холбогдолтой. Энд зааснаар Монгол Улсын хууль тогтоомжид зааснаас өөр журам тогтоо байгаа олон улсын гэрээг заавал соёрхон батлах бөгөөд энэ нь соёрхон баталсан хууль гарснаар хүчин төгөлдөр болно. Өөрөөр хэлбэл нийт иргэздэд хандсан, заавал биелэгдэх шинжтэй эрх зүйн хэм хэмжээг олон улсын гэрэгзэр өөрчилне гэдэг нь тухайн хэм хэмжээ Монгол улсын нутаг дэвсгэрт шууд хэрэгжих хэм хэмжээ болохыг зааж байгаа гэсэн уг юм. Харин ОУГтХ-ийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд тухайлбал ОУГтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1,10.3,10.4 ба 10.5 дахь хэсгүүдийг Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгтэй харьцуулан хэрхэн ямар байдалар тайлбарлах вэ гэдэг асуудал судалгааны нэг сонирхолтой асуудал юм. Учир нь хэрэв олон улсын гэрээнд дотоодын хууль тогтоомжид зааснаас хувь этгээдийн эрх ашгийг дордуулсан бол соёрхон батлагдах, соёрхон батлагдаагүй аль чөлөн улсын гэрээнд үндэслэн хувь этгээд өөрийн эрх ашгийг илүү хамгаалсан хэм хэмжээг хэрэглэх эрх нь хадгалагдах ёстай.

Шүүх олон улсын гэрээг тайлбарлах, улмаар бие даасан шийдвэр гаргах эрх нь олон улсын эрх зүйн дагуу дотоодын шүүхэд хадгалагдах эрх зүйн боломжийн талаар бид дээр өгүүлсэн билээ. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Дээд шүүхээс "Монгол улсын олон улсын гэрээ болон олон улсын нийтээр хулээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай" тогтоолын 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг эргэж харах ёстай болно. Энэ зүйлд "шүүхийн хэлэлцүүлгийн зүйл болж буй маргаантай харицааг зохицуулсан материаллаг эрх зүйн дотоодын хуулийн зүйл, заалтаас олон улсын гэрээний зүйл, заалт өөр байгаа бол Монгол Улсын олон улсын гэрээг эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шуухууд шууд хэрэглэнэ" гэж заасанд байна. Энэ тайлбарын тухайд шийдвэр гаргач нь хэрэв энэхүү тайлбарын баримтлан

олон улсын гэрээг шууд хэрэглэх нь хувь этгээдийн Үндсэн хуулиар олгогдсон хүний эрхэд халдах нэхцэл байдал бий эсэхэд анхаарах ёстой юм. Хэрэв ийм зерчил байгаа гэж үзвэл олон улсын гэрээний хэм хэмжээг хэрэглэхгүй байх эрх нь шүүхэд мөн хуулиар олгогдсон болно /ОУГтХ/§ 23<sup>1</sup> үзүүл. Эндээс харвал ОУГтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1,10.3,10.4,10.5 дахь хэсгийн зохицуулалтыг шууд хэрэгжих ба шууд эс хэрэгжих гэрээний зүйл мөн гэдгийг тухайн олон улсын гэрээний зүйл, заалтад харьцуулан шүүх тайлбарлах ёстай болно. Хэрэв соёрхон батлах, нэгдэн орох хуулийн тухайд ямар тохиолдолд шууд хэрэглэх хэм хэмжээ байв гэдгийг ОУГтХ-аар нарийнчлан зааж өгвэл олон улсын гэрээг дотоодын шүүхэд хэрэглэх эсэх шийдвэр гаргах талаарх шүүхийн эрхийн тухайд Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт нийцүүлэн хэрэглэх боломжийг бий болгох юм.

### Дүгнэлт

Энэхүү судалгаагаар олон улсын гэрээг дотоодын шүүхэд хэрхэн хэрэглэх талаар онол, эрх зүйн үндэслэл, бусад улс орнуудын практик туршлагыг тодорхой жишэн дээр харуулсан бөгөөд ингэхдээ дээрх асуудлын хурээнд зарим нэг ойлгомжгүй, зөрүүтэй ойлголтыг төвч авч үзсэн болно. Энэ нь Монгол Улсад олон улсын гэрээг шүүхэд хэрэглэж байгаа байдал, эрх зүйн зохицуулалт, хууль тогтоомжид хэрхэн туссан талаар дүгнэлт хийхэд ач холбогдолтой юм. Судалгааны хурээнд бид шуугч, өмгөөлөгчдийн дунд санал асуулга явуулснаар бодит байдалд дүгнэлт хийх боломж бурдсан юм. Шүүхэд олон улсын гэрээг хэрэглэх тухайд өмнө хийгдэж байсан судалгааны дүгнэлт, санал асуулгын үр дүнтэй харьцуулахад олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх тухайд шуугч, өмгөөлөгчдийн мэдлэг чадварт онцын ахиж гараагүй гэж хэлж болохоор байна. Олон улсын гэрээний орчуулга ойлгомжгүй, албан ёсоор хэвлэгдээгүй, мэдээлэл сургалт хангальгүй гэсэн ерөнхий хариулт голлосон байх бөгөөд

шүүх олон улсын гэрээг хэрэглэх талаар ямар чиг үүрэг, байр сууриас оролцож талаар ойлголт шүүгч, өмгөөлөгчдийн дунд төдийлэн сайн биш байна. Энэ нь олон улсын гэрээг хэрэглэх хэлбэрийн шаардлагад анхаарал хандуулах чухал хэдий ч цаашид хуульчдын олон улсын эрх зүйн онолын мэдлэг, эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх арга зүй, дадлагыг дээшлүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Мөн эрх зүйч, хуульчдын дунд олон улсын эрх зүйд холбогдох дотоодын хууль тогтоомжид анализ, дүгнэлт хийх, шүүхийн шийдвэрт эрх зүйн шүүмж бичих, хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал, хэлэлцуулэг өргөн өрнүүлэх нь чухал байна. Ийнхүү олон талын эх сурвалж, мэдээлэл байгаа нөхцөл шүүгч өөрийн итгэл үнэмшилээр тухайн олон улсын гэрээг хэрэглэх, эс хэрэглэх талаар баттай үндэслэл, тайлбар гаргахад илүү дөхөмтэй байх юм.

Олон улсын гэрээг хэрэглэх тал дээр Үндсэн хуулийн заалтууд зөрчилдөөнтэй гэх асуудал байхгүй ба харин Олон улсын гэрээний тухай хууль болон Дээд шүүхийн холбогдох тогтоолыг илүү боловсронгуй томъёолох, материаллаг ба процессын хэм хэмжээнд нэмэлт, өөрчлөлтийдийг оруулах хэрэгцээ шаардлага байна гэж үзэж байна. Ийнхүү хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлтийг иновчтой хийхийн зэрэгцээ шүүгч, өмгөөлөгчдийн эрх зүй хэрэглэх арга зүйн мэдлэг, дадлага сайжирсан нөхцөлд олон улсын гэрээ дотоодын шүүхэд хэрэглэх тал дээр дэвшил гаргах боломж нээгдэнэ. Олон улсын гэрээ, эрх зүйн хэм хэмжээг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэх явдлыг дэмжих нь манай улсын шүүх эрх мэдлийн салбарт дэвшил авирах төдийгүй хүний эрхийг хамгаалах эрх зүйн өөр нэгэн боломжит механизмыг хэрэглэх соёл иргэдийн дунд төлөвших нэг боломж юм.

---оо---

## БНХАУ ДАХЬ "ИХ ЗАСАГ" СУДЛАЛЫН ТӨЛӨВ



Өвөрмонголын их сургуулийн Хууль зүйн сургуулийн Үндэстний хууль тогтолцомж судлалын төвийн эрхлэгч, түүхийн ухааны доктор, хууль зүйн ухааны доктор, профессор Д.Наранцагт

"Их Засаг" бол Монголын анхны бичмэл хууль юм. Энэ нь XIII зуунаас өмнө ба хойши Монголын нийгэм, аж ахуй, улс тэр, эрх зүйн тогтолцоог танин мэдэхэд үзүүлж баршгүй хувь нэмэр оруулсан түүхэн эх сурвалж билээ. Харин бүрэн эхээрээ өнөөг хүртэл олоогүй байгаа нь нэн харамсалтай. Гэвч дэлхийн улс орнуудын эрдэмтэн, судлаачид төрөл бурийн эх сурвалж, түүхэн баримтаас олдсон жижиг хэсгүүдийг эвлүүлэн, мөн өөрийн хэр хэмжээгээр түүх, соёл, эрх зүйн талаас эрэн сурвалжилж, түүний жинхэнэ эхийг нөхөн сэргээхээр зорьж байна.

"Их Засаг"-ийг дэлхий нийтээр судалдаг. Энэхүү өгүүлэл БНХАУ-д "Их Засаг"-ийг аль хүрээнд, хэрхэн судалж, ямар үр дүнд хүрч байна гэсэн агуулгын дор илтгэх болно. Тодруулж хэлбэл "Их Засаг"-ийн талаарх Хятад дахь судалгааны талаар тодруулахыг зорьсон бөгөөд "Их Засаг" өөрөө том судлаждахун, түүнийг дагасан судалгаа, шинжилгээний ажил өргөн, тэдгээрийг нэгтгэх дүгнэсэн мэдээлэл олоогүй учир тус сэдвийг ерөнхийд нь

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвийн Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан

илэрхийлэхэд бэрхшээлтэй байгааг дурдах нь зүйтэй. Иймд "Их Засаг"-ийн талаарх Хятад дахь судалгааны чиглэл, арга зүй, эх сурвалж, судалгааны онцлог; "Их Засаг"-ийн талаарх Хятад дахь судалгааны үндсэн асуудал; "Их Засаг"-ийн талаарх Хятад дахь судлалын зарим асуудал; Хятадад "Их Засаг"-ийг судалж буй байгууллага, судлаач, тэдгээрийн зарим бүтээлийн талаар авч үзье.

### "Их Засаг"-ийн талаарх Хятад дахь судлалын чиглэл, судлаждахууны тухай

Хятад дахь "Их Засаг" судлалтай холбоотой хэвлэгдсэн ном бүтээл болон цахим эх сурвалжийн хүрээнд хайлт хийж судлахад дараах судалгааны чиглэл, судлаждахуун нь "Их Засаг" судлалтай холбогдож байна хэмээн үзэхэд хүргээлээ.'Үүнд: Түүхийн хүрээнд, дэлхийн түүх, Азиин түүх, Монголын түүх, Хятадын түүх, Юань улсын түүх, үндэстний түүх, монгол үндэстний

<sup>1</sup> Энэ хэсгийн дүгнэлтийг Хятад дахь "Их Засаг" судлалыг цахимаар шуујж, өнгөц илэрхийлсэн болно. Б.Энх-Амгалан

түүх, хууль цаазын түүх, эрх зүйн түүх; **Түүхэн хүн судлалын хүрээнд** Чингис хаан судлал<sup>2</sup>, тухайлбал Чингис хааны түүхэнд байгуулсан хууль зүйн ухаан, Чингисийн жанжин, шадар туслах, Чингис хааныг залгамжлагчдын талаарх судлал; **Эрх зүйн сэтгэлгээз, эрх зүйн түүхийн хүрээнд** Монгол хууль цаазын сэтгэлгээний түүх, Юань гүрний хууль, эрх зүйн сэтгэлгээ, үндэстний эрх зүйн сэтгэлгээний түүх, Хятадын болон зарим бус нутгийн хууль, эрх зүйд "Их Засаг"-ийн үзүүлсэн түүхэн нөлөө, ач холбогдол, ялангуяа Юань улсын хууль цаазад нөлөөлсөн байдал; **Эрх зүйн хүрээнд, нийтийн эрх зүй, хувийн эрх зүй, харьцуулсан эрх зүйн хүрээнд, тэр, захирагааны эрх зүй, иргэний эрх зүй, эрүүгийн эрх зүй, олон улсын эрх зүй, процессын эрх зүй зэрэг чиглэлээр төрийн эрх мэдэл хуваарилалт, хэрэгжүүлэлт, цэрэг, дайн, худалдаа<sup>3</sup>, татвар, шашин<sup>4</sup>, гэр бүл<sup>5</sup>, ёмч, өв залгамжлал, заншил, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, ялын бодлого, ял шийтгэл, гадаад харилцаа, дипломат ёс, экологи<sup>6</sup> зэрэг асуудлын хүрээнд өргөнөөр судалж байна. Хүний эрхийн хүрээнд хүний эрх, хаан, хааны алтан ургийн эрх хэмжээ, хөдөлмөрийн харилцаан дахь адил тэгш эрх, улс төрийн ардчиллаас гадна эмзгэлтийчүүдийн эрх, хүүхдийн эрх зэрэг онцгой хамгаалал шаардлагатай этгээдийн эрхийн асуудалтай мөн**

<sup>1</sup> Томоохон төвлөөлжилжээ. Эвэрмонгол эрдээнтэн Сайшаал, Чингис хааны төвчийн. 1987 он. Хөх хот

<sup>2</sup> Жао Хай Рун. "Монголын худалдааны тогтолцоо судлал". "Их засаг дахь худалдааны кульж журам" бүлэг. <http://cdmd.cnki.com.cn/Article/CDMD-10135-2009202478.htm>

<sup>3</sup> Wan Lai/Wang Lei, "Их Засаг" дахь шашны асуудалд дүн шинжилгээ хийж нь, 2010., <http://xssftxy.sdupls.edu.cn/html/llyq/yxslt/2014/06/23/54863784-c3cc-4a01-b312-4160c02afaf7c.html>

<sup>4</sup> Энэ чиглэлээр Намжил, Сайшаал. Цог. Лю Зин Сую. Ван Жи Мин зарж судалдаанд бүтээгдэж Тухийн Банжан, Ван Жи Мин. Заншилын эрхийн хурдэнд эртний Монголын тэрбумийн тогтолцоог судлах нь, 2009 он <http://www.116.com/ziliao/article-139376.html>

<sup>5</sup> 舊秀兰成吉思汗·大札撒：中生态法探析

<sup>6</sup> <http://hetong.cnki.net/law/detail/detail.aspx?filename=AHNY200828180&dbcode=CLKJ&dbname=CLKJ7511>

холбож судалжээ. Түүнчлэн "Их Засаг"-ийг "Магна харта" зэрэг эртний хуулиудтай харьцуулж, адилтгах, жишиг, үнэлэх хандлага байна. Түүх, угсаатан зүй, соёл, урлагийн талаас судлахдаа "Их Засаг"-ийн үр нөлөөг дүгнэсэн байдал үргэлжилдэг. "Их Засаг"-ийг ёс заншлын үүднээс судалж, хууль ба заншлын хэм хэмжээ, ёс суртахуун, ухамсар зэрэг эх сурвалжтай холбож авч үзсэн тал ажиглагдлаа.<sup>7</sup>

### Хятадад "Их Засаг"-ийг судлахад ашиглагдаж буй эх сурвалж

Хятадад "Их Засаг"-ийг судлахад дэлхийн хэмжээнд "Их Засаг" судлалд эртнээс ашиглагдаж ирсэн түүхэн эх сурвалжууд тэргүүн энээнд багтаж байна. Үүнд: "Монголын нууц товчоо", "Дэлхийг байлдан дагуулагчийн түүх", "Сүрүүн чуулган", "Юань улсын түүх", "Абул Фараҗийн түүх", "Нум сумттан ард түүний түүх", "Гуулин улсын судар", "Египетийн ойллог", "Богд баатар баатар дайлан тэмдэглэл", "Хар татарын хэргийн төвч", "Монгол татарын бүрэн тэмдэглэл", "Чань Чун бумба баруун тийш зорчсон тэмдэглэл", "Монголчуудын түүх", "Дорно этгээдэд зорчсон минь", "Орчлонгийн элдэв сонин" зэрэг түүхэн сурвалж болон тэмдэглэл, археологийн олдвор орно. Эдгээр бүтээлийн түүхэн үнэт зүйл, ач холбогдлын гавьяаг үзэлж баршгүй бөгөөд судалгааны шавхадашгүй нөөц бүхий эх сурвалж мөн.

Хятад хэл дээрх эх сурвалж<sup>8</sup> нь "Их Засаг"-ийн судалгааны түүхэн гол сурвалжид мөн тооцогдуулж XII-XIII зууны монгол, хятад хэл дээрх түүхийн сурвалжийн ихэнх нь гуравдагч этгээдийн үүднээс судалж, тэмдэглэсэн

<sup>7</sup> Бэзжинийн их сургуулиин Хууль зүйн сургуулийн профессор У Хань Хань, Эвэр Монгол эрдээнтэн Сайшаал, Цог нарыг лурдаж билж.

<sup>8</sup> Хятад гурвалжийн талаар огцруулжээ монгол хэлээс нэгэн төгийн нормийн коллагийн төрүүлэх магадлалтай тул цаазын судалгааны ажилд эх сурвалж болгох зорилгоор зарим сурвалжийн хятад нормиг хамт бичилж. Б.Энгийнгэл

сурвалж юм. "Монголын нууц товчоо" судлалтай "Их Засаг" судлал салшгүй холбогдох байна. Ханз үсгээр монгол хэлийг тэмдэглэж, хятад орчуулгыг хадсан Мин улсын үеийн эх бичиг нь здүгээс уламжилж ирсэн "Монголын нууц товчоо" -ны үндэс болсон. "Монголын нууц товчоо"-ны нэрийг хятадаар «Юань улсын нууц түүх» хэмээдэг.

"Их Засаг"-ийн талаар өргөн агуулгатай хятад сурвалжуудад "Монгол татарын бүрэн тэмдэглэл", "Хар татарын хэргийн товч" зүй ёсоор багтана. Эдгээр зохиолын онцлог нь тухайн үеийн Монголын хаант улсын төрийн зохион байгуулалт ба хууль тогтоомжийн байдлыг тусгасанд оршино. Энэ талаар Монголын түүхийн судалгааны том эх сурвалж хэмээн эрдэмтэн Сайсаал вөрийн бүтээлдээ дурдсан байдал.

"Юань улсын судар" гэх Монгол хэлнээс орчуулагдан хэвшсэн бүтээл бол "元史" буюу "Юань улсын түүх" бөгөөд энэ нь "Их Засаг" судлалын хамгийн чухал мэдээллийн эх сурвалж юм. Энэхүү бүтээлд "Их Засаг"-аас уламжилж авсан буюу мөрдөж байсан хэм хэмжээнүүдийн талаар тэмдэглэсэн байдгаараа онцлогтой.<sup>9</sup> Тус бүтээл ийнхүү Чингис хааны түүхээс авахуулаад Тогоонтөмөр хааны түүхийг хүртэл агуулж бичихдээ Юань гүрний хуулиуд болон түүхэн баримт, түүний дотор "Их Засаг" хуулийн зарим зүйл заалтыг тусгасан байдгаараа "Их Засаг" судлалын томоохон эх сурвалж болж байна.

明代岷峨山人-ий《华夷译语》уюу "Хятад- харь үгийн толь бичиг" хэмээх харь үгийг орчуулсан ном бол эртний Монгол хууль цаазын нэр томьёог судлахад нэн чухал, ховор толь бичиг болдог. Юань гүрний хуулийн сурвалж зохиол дотор "Их Засаг"-ийн талаар нэлээд тэмдэглэн бичсэн, Юань гүрний хууль тогтоомжийн бүтээл болох "Юанийн шинэ хууль", "Дадэ-

оны зарлиг", "Хэв сахилгын хөтөлбөр", "Их Юань гүрний нэвтрэхий хууль", "Ертөнцийг засах их хууль" 《至元新格》 《大德律令》 《风宪宏刚》 《大元通制》 《经世大典》 гэсэн сурвалжууд байсан гэх боловч түүхэнд хадгалагдаж үлдээгүй юм. Харин "Нэвтрэхий хууль дахь хааны хууль", "Юанийн үеийн хааны хууль", "Их Юань гүрний бодг хууль" 《通制条格》, 《至正条格》,

《大元圣政国朝典章》 хэмээх сурвалжууд дотор "Их Засаг" дахь төрийн засаглал болон хууль тогтоох үйл ажиллагатай холбоотой узэл баримтлалыг тусгасан байdag. Үүнээс гадна Юанийн үеийн хүмүүсийн хувийн тэмдэглэл, аян замын тэмдэглэлүүд "Их Засаг"-ийн талаар мөн өгүүлж үлдээсэн. "Чань Чунь бумба баруун тийш зорчсон тэмдэглэл" 《长春真人西游记》, "Баруунд зорчсон тэмдэглэл"- 《西游录》, 《湛然居士文集》, 《草木子》 хэмээх тэмдэглэл. "Их Юань гүрний бичгийн зүйл" 《元文类》 эзргээс гадна Чин гүрний үеийн, Юанийн түүхийн бүтээл болох "Юань гүрний түүхийн нөхөвдөр орчуулга" 《元史译文正补》, "Юань гүрний түүхийн шинэ эмхэтгэл" 《元史新编》, "Шинэ Юань улсын түүх" 《新元史》, "Монголын түүхэн тэмдэглэл" 《蒙兀儿史记》 зэргийг дурдаж болно.

Хятадын судлаачид дээр дурдсан эх сурвалжийг ашиглах болон эдээр сурвалжийн талаар судалсан Хятад болон бусад орны судлаач, эрдэмтдийн бүтээл, судалгааны үр дүнг судалж, зэрэгцүүлж харьцуулан, дүгнэлт хийсэн байдал цөөнгүй тааралдах ба үүнд орчуулгын бүтээлийг мөн адил үнзлж, ишлэлд орчуулагчийг давхар дурддаг соёл бурдсан талаар тэмдэглэн хэлэх нь зүйтэй.

### Хятад дахь "Их Засаг" судлалын өнөөгийн түүх, онцлог

Хятадад Юань улсын үеийн хууль, эрх зүйн тогтолцоо ба эрх зүйн соёлын талаарх судалгаа нэлзэд

<sup>9</sup> <http://baike.baidu.com/view/158366.htm>

хожуу хийгдсэн байна. Бүгд Найрамдах Улсын үед Юань улс судлаачдын хувьд Монголын эзэнт гурний үеийн зарим тогтолцоог зөвхөн судалж байв. Гэхдээ энэ нь үндсэндээ "Их Засаг"-ийн талаарх дагнасан судалгаа биш ч гэсэн "Их Засаг" судлалд дехөм үзүүлсэн үр дүнг үнэлэх ёстай. Тухайлбал, эрдэм шинжилгээний сэтгүүлдний тлэгдсэнээс, үндэстний түүх судлаа Weng Du Jian 翁健独 нь "Yan jing" их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүлийн 28, 29, 30 дугаарт "Монголын эзэнт гурний үеийн хууль цааз батлагдсан түүх" 《蒙古时代的法典编纂》, "Өртөгийн тухай шинжлэл" 《斡脱杂考》, "Их Юань улсын хууль зүйлийн бичгийн оруулаугаа үгсийн тайлбарын эмхэтгэл" 《元典章译语集释》 гэсэн 3 цуврал өгүүлэл; Han Ru lin 韩儒林 -ийн "Хятадын соёл судалын эмхэтгэл сэтгүүлд 1940 -1942 онуудад хэвлүүлсэн "Монголын дархан хэмээх цолын тухай шинжлэл" 《蒙古答刺罕考》, "Монголын дархан хэмээх цолын тухай шинжлэлд хийсан нэмэлт тайлбар" 《蒙古答刺罕考增补》, "Юанийн үе дэх Годанийн тухай шинжлэл" 《元代阙端赤考》, "Чэндүгээс одсон монгол хэл дээрх, хааны зарлигийн пайыг шинжилсэн тайлбар" 《成都蒙文圣旨牌考释》 зэрэг эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэлүүд орно. Эдгээр нь Юань улсын үеийн хууль тогтоо ажиллагаа, хууль цаазын бичиг, тэдгээртэй холбоотой нийгмийн харилцааг судалсан түрүү үеийн судалгааны бүтээлүүд бөгөөд Юанийн үеийн түүхийн цаашдын судалгаанд үнэтай хувь нэмэр оруулсан байна.

**БНХАУ** байгуулагдсаны дараах эхэн үед Монгол хууль цаазын талаарх судалгаа харьцангуй бага, бараг байхгүй байсан гэж болно. У Ханы их сургуулийн профессор Ли Хан /li Han/ нь монгол хэлний "түмэн", "улс", "ёсон", "зарлиг", "засаг", "хуралдай", "зарлигч", "заргач", "дархан", "нөхөр", "нөён", "хүрээ", "хэвтүүл", "хишигтэн" ... /土

绵、兀鲁思、无奴忽赤、牙孙、云都赤、火你赤、古列干、古列延、可顿、玉典赤、布浑察儿、札文、札撒、札里赤、必哲赤、奴都赤、合罕、合刺出、那可儿、那颜、约孙、李斡勒、秃鲁花、拔都魯忽力台、忽里哈赤、忽刺罕赤、怯薛、按答、客卜帖兀勒、者里赤、答刺罕/ зэрэг нэр томьёо, засаг захиргааны бүтцэц, зэрэг дэвийн талаар судалж, тайлбар хийснийг "БНХАУ-ын нэвтрэхийн толь", 1985 он, "БНХАУ-ын нэвтрэхийн толь -Хятадын түүх - Юанийн түүх" 《中国大百科全书·中国历史·元史》 бүтээлд тусгажээ.

ХХ зуунь 80-аад оноос хойш Хятадад дахин Монгол судлалыг өргөжүүлсэн. Гэхдээ ХХI зуун гарахад "Их Засаг"-ийн судалгааны дорвийт бааз бий болоогүй байсан ба Монгол хууль цаазын түхийн судалгааны дагнасан шинэ чиглэл болон бүрэлдэх чадаагүй. Үндсэндээ Монголын түүхийн судалгаа, монгол үндэстний сэтгэлгээний түүх судлал доторх завсрлын шинжлэх шинжилгээ болсон. "Их Засаг"-ийн судалгаанд Монголын ерөнхий түүхийн чиглэлээр, тухайлбал "Монгол үндэстний товч түүх" 《蒙古族简史》-1985 оны "Монгол үндэстний ерөнхий түүх" 《蒙古族通史》-2001 он зэрэг бүтээл гарсан. Хятадын судалгааны тухайд "Их Засаг"-ийн түүхэн сурвалжийг цуглуулж, судлах эрдэм шинжилгээний ажил нь Өвөрモンголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн Философи судалалын тэнхимийн сургалтын чиглэлээр хийсэн судалгаанаас эхлэлтэй. Энхүү судалгааны онцлог нь Монгол үндэстний гүн ухаан, сэтгэлгээний түүхийг судлах зорилгоор XIII- XVIII зуунь Монголын түүхийн сурвалж дундах хууль, эрх зүйн сэтгэлгээний баримт бичгүүдийг цуглуулж, эмхэтгэсэнд оршино. "Монгол үндэстний гүн ухаан, сэтгэлгээний сурвалж мэдээний эмхэтгэл" гэсэн бүтээл болон Өвөрмонгол эрдэмтэн Сайшаалын "Чингис хааны товчоон"

/1987 он/, Х.Намжилын "Чингис хааны Их Засаг ба билиг сургаал" /1987 он/ гэсэн судалгааны бүтээлүүд нь системтэй үр дунд хурсэн гэж үнэлгэддэг ба "Их Засаг"-ийн агуулга, зүйл заалтын ангилал зэрэг чиглэлээр "Их Засаг"-ийн судалгаанд дорвийт эх сурвалж болж үлдсэн байна.

Жоу Бао Фэн, Боржигин, Наранцогт наарын бүтээл "Монгол судалын нэвтрхий толь-Хууль зүйн боть" 2007 нэртэй томоохон толь бичигт "Их Засаг"-ийн талаар мэдээлэл агуулсан байдаг. Эдгээрээс гадна "Чингис хааны хууль, түүний эх тэмдэглэл" нэртэй ном 2007 онд хэвлэгдсэн. Энэ ном өмнөх цуглуулсан сурвалжуудын эмхэтгэлийн үндсэн дээр "толгой, нүүрийг сольж" гарсан эмхэтгэл гэгдэж, сурталчилгааны чиглэлийг илүүд үзсэн зэрэг бусад шалтгааны улмаас алдаа мадаг их гаргасан тул судалгааны хүрээнд үнэлжмэж буурсан гэж хэлж болно.<sup>10</sup> Энд "Их Засаг" судлалаар гарсан ном бүтээлийг шинжлэх ухааны үүднээс үнэлж дүгнэх байдал Хятадад гарч байгааг тэмдэглүүштэй."<sup>11</sup>

Ерөнхийдээ Чингис хааны "Их Засаг" сэдвэр цэвэр дагнаж, төрөлжсөн сод бүтээл Хятадад цөн байна, Өвөр mongolын Цогт докторын бичсэн "Чингис хааны хууль" ном 2012 онд гарсан. Энэ нь перс хэл дээрх сурвалжаас Чингис хааны хууль цаазыг бүх талаас нь судалсан бүтээл юм. Энэ нь үгийн гарал, үүсэл ба уран зохиол,

<sup>10</sup> Д.Наранцогт дүгнэв.

<sup>11</sup> "Чингис хааны хууль, түүний эх тэмдэглэл" номыг хэвлэгдсэнтэй копбодгуулан "Дэлхий дээрх хамгийн анхны үндсэн хууль хэвлэн нийтийгээрээ", "Чингис хааны хууль дэлхий нийтэд дахин мэndлийз", "600 гаруй жилийн түүхэнд бүрэн бүтнээрээ одоогүй Чингис хааны хууль тэнцгийн нарыг дахин хэрэг", "600 жилийн дараах хуулиin тайлбар" эзргэр хэвлэв мэдээллийн хэргэлээр сур дуулсан тархсан талаар цахим эх сурвалжаас карагд "энэхүү номыг олж уншсан байжад Хятад дахь "Их Засаг" судлал бүрэн илэрхийлгэж болно" хэмжээ төвөргөж байсан нуху юн. Б.Чинид багш 2004 онд эрдэм шинжилгээний шинэ ажилтан наадад хандах "Тэрбум гаруй хүн юу хийж байгааг чи яаж мэдэж байгаа юм" гэж нэгэнтээ хэлсэн ч олонтоо мөрдөвж шүүмжийн санаак шүүхийн судалгаанд Наранцогт докторыг урьж оролцуулсан нь туйлын оновчтой болсон юм. Б.Энх-Амгалан

туухийн үүднээс "Их Засаг"-ийн үүсэл, хэлбэржилт, агуулга, шинж, онцлог зэрэг асуудлын хүрээнд нарийвчлан судалсаараа өвөрмөц болсон.

У Хай Хан "Юанийн үеийн хууль, эрх зүйн судалгаа" 2000 он, Чигэ "Эртний Монголын хууль тогтоомжийн түүх", Ян Чан "Монгол үндэстний хууль, эрх зүйн уламжлал ба орчин цагийн хэлбэр" 2013, Наранцогт "БНХАУ-ын цөөнх үндэстний хууль цаазын түүхийн лавлагaa-Монгол үндэстэн боть" 2014, Наранцогт "XIII-XIX зууны Монголын хууль, эрх зүйн түүх судлал" 2015 зэрэг бүтээлийг дурдахад Хятад дахь "Их Засаг"-ийн судалгааны хувьд хятад, монгол хэл дээр нийтгүүлж олны хүртэл болгосон 100 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл байна.<sup>12</sup> Мэн Ли Зе Ши "Юань үүрний үеийн хууль цаазын судалгааны тайм"/2007/, Ли Ю Нэн, "Их Засаг" хуулийн Юань үүрний хууль тогтоомжид үзүүлсэн нөлөө ба Хятадын эрх зүйн тогтолцоонд эзлэх байр суурь/2007/. Ван Лэй/Wang Lei/ "Их Засаг"дахь шашны асуудалд дүн шинжилгээ хийх нь, Лю Зин Сую/留金锁/, Ван Жи Мин "Заншлын эрх зүйн хүрээнд эртний Монголын гэр булийн тогтолцоог судлах ны"/2009/ зэрэг судлаачдын бүтээл, Жао Хай Рун "Монголын худалдааны тогтолцоо судлал": "Их Засаг"дахь худалдааны хууль журам.., "Их Засаг"ба Магна харта-харьцуулсан судалгаа" зэрэг эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, ном бүтээл, тэдгээрийн талаарх мэдээллийг англи болон хятад хэл дээрх цахим хуудас, судалгааны цахим сангаас үнших боломжтой.<sup>13</sup> Тухайлбал, англи хэл дээр цахимаар хайлт<sup>14</sup> хийж судлахад судлаач Paul Heng-chao Chen "Chinese legal tradition under the Mongols. The code of 1291 as constructed", бүтээлдээ "Их Засаг" бол

<sup>12</sup> Д.Наранцогт дүгнэв.

<sup>13</sup> Б.Энх-Амгалан дүгнэв.

<sup>14</sup> ХЭҮХ-ийн бодлогын судлаач Э.Туулайхүү цахимаар хайлт хийж, Хятад судлаачдын "Их Засаг"-ийн судалгааны англи хэл дээрх илэрхийн шүүссэн болно.

Чингис хаан аливаа тодорхой нөхцөл байдал үүсэх үед зориулан өгч байсан зарлиг, зааврын цуглуулга<sup>7</sup> бөгөөд 1229 онд албан ёсоор олон нийтэд зарлан тунхагласан ... төрийн захирагааны үйл ажиллагаанд, тэр тусмаа цэргийн дэг, зохион байгуулалтад мөрдөх зарлигийн цогц байсан. Монгол эзэнт гүрний ноёрхолд байсан бүх овог аймгуудад нэгдмэл нэг хууль (кодекс) байдлаар түгээмэл хэрэглэгдэж байгаагүй. Харин Сүн гүрний ноёрхол унасны дараагаар Монголын эзэнт гүрний ноёрхол Хятадад тогтмолц эрх зүйн үндсэн эх сурвалжид тооцогодох болсон. Гэхдээ тед удалгүй Хятадын нийгмийг Монголын заншлын эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах нь төвөтгэй нь улам бүр батлагдах болсноор "Их Засаг"-аар Хятад дахь нөхцөл байдлыг зохицуулах нь эрс багасчээ. XII зууны сүүл гэхэд эрх зүйн эх сурвалжийн хувьд хэрэглэгдэх нь маш бага болсон байна. Ийнхүү Хятад дахь Монголын заншлын эрх зүйн ноёрхол унасаар төрөл бүрийн Хятад хуулийг батлах болсон ба ингэхдээ Хятад эрх зүйн эх сурвалжуудад Монголын эрх зүйн зарчим, үзэл санааг тусгахыг эрмэлзэж байжээ." хэмээн бичсэн байна.

*Судлаач Li Yu Nian "Study on the Authority of the Great Zhasa in the Yuan Dynasty and Its Status in the Sinic Lex"<sup>15</sup> бүтээлдээ " ... "Их Засаг" нь Их Монголын үед Хаадын баримтлалдаг хамгийн дээд хүчин чадалтай хууль байв. Хожим Юань гүрний үед Юань гүрний хаад мян л ийм статустайгаар авч үзэж байсан. Энэ нь Юань гүрний эрх зүйн үндэс болоод зогсохгүй хамгийн чухал эрх зүйн эх сурвалж болсон. "Их Засаг"-ын эрх зүйн гол эх сурвалж байхын хажуугаар тодорхой нөхцөл байдлыг зохицуулах зорилго бүхий олон хуулиуд гаргахад эрх зүйн үндэс нь болж байсан. Гэхдээ энэ гүрний ноёрхол төгсгөл болох хүртэл ямар ч системчлэгдсэн хууль хэвлэгэдэн*

<sup>15</sup> Li Yu-nian, Study on the Authority of the Great Zhasa in the Yuan Dynasty and Its Status in the Sinic Lex. 2007.

гарч байгаагүй. "Их Засаг" нь Юань гүрний хууль тогтоомжийн онцлогийг илрэхийлээд зогсохгүй Хятадын хууль тогтоомжийн хөгжилд өөрийн гэсэн тодорхой хувь нэмэр оруулсан." гэж үзжээ. Түүний судалгаа нь олон эх сурвалж ашигласан, тэрчлэн хятаад эх сурвалжийг гадаад эх сурвалжтай, Хятадын эрдэмтдийн судалгааны үр дүнг гадаадын эрдэмтдийн судалгааны үр дүнтэй харьцуулж шинжлэн дүгнэсэн онцлогтой юм. Онцолж хэлбэл Юань улсын түүх судар болон Хятадын түүхэн сурвалжуудыг судалж, судалгааны эх сурвалжaa болгосон нь бусдаас илүү ялгаатай байна. Түүнчлэн бүтээл нь англи хэл дээрх судалгааны цахим санд орсон байгаа нь цар хүрээ өндөртэй бүтээлд зүй ёсоор орж байна. Нэмж хэлэхд "Их Засаг"-ийн бусад хууль цаазад үзүүлсэн нөлөө ба Хятадын эрх зүй дэх нөлөөллийн байр суурь гэсэн чиглэлээр судалж гаргасан нь Резановский зэрэг судлаачийн байр сууриас өөр дүгнэлт хийсэн үр дүнд хүрчээ. "Бусад судлаачдын зарим бүтээл, судалгааны үр дүн дараагийн хэсэгт холбогдоно.

### "Их Засаг"-ийн судалгааны үндсэн асуудал

БНХАУ дахь "Их Засаг"-ийн судалгаанд дараах үндсэн асуудал багтаж байна. Үүнд: "Их Засаг" нэрийн тухай, ялангуяа "Засаг", "Их Засаг" болон бусад нэрийн утга, агуулга, гарал үүсэл; "Их Засаг"-ийн цаг хугацаа буюу боловсруулсан, тогтоосон, баталсан, тунхагласан, хэрэгжүүлсэн, хэрэглэсэн, нэмж засварласан цаг хугацааг түүхэн он цаг; "Их Засаг" үүсж бий болсон нийгмийн хэрэгцээ, шаардлага; "Их Засаг"-ийн бүтэц, агуулга- "Их Засаг"-ийн эх, "Их Засаг"-ийн шинж чанар ба онцлог; "Их Засаг"-ийн гүйцэтгэсэн үүрэг, үр нөлөө, ач холбогдол /Монгол болон бусад улс орны тухайд/ :

" "Их Засаг" сэдвээрх гарим нэгүүцэл, нийтийнээс харьцуулж ийм дүнгийнчад хуураа Б.Чин-Амгалан

"Их Засаг" судлал дахь бусад асуудлууд орно. Эдгэрээс зарим онцлог асуудлыг дэлгэрүүлж үзье.

### Хятад дахь "Их Засаг" судлалын зарим онцлог асуудал"<sup>17</sup>

#### "Их Засаг" нэрийн тухай

Нэг. "Их Засаг" нэрийг тайлбарлах хүрээнд үгийн үүсэл гарал, утга, агуулга болон бусад нэрүүдтэй холбож судалсан тал байна. Нэрийг олон төрлийн толь бичиг, сурвалж, эрдэм шинжилгээний бүтээлд тусгагдсан байдлаар үгийн бичилгээ, авиа, дуудлага болон дан ба ниймлэл, шууд ба дам, эрт болон орчин цагийн утгаар нь тайлбарлах, тайлбарласан байдалд дун шинжилгээ хийх хандлагууд байх бөгөөд нэрийн тухайд монгол, хятад, орос, япон, солонгос судлаачдын судалгааны дүн, ололт амжилт нэлээд байгааг дурдсан байдаг. Хятадын судалгаанд хамруулсан үгийг тоймловол заса, засаг, засах, их хууль, *yasaq, yasaqha, yusun, iasaq, iasak, jarlig, bilig, soyorthol*, 决定, 決議, 命令, 号令, 法律, 法典, 罚金, 懲办, 处罰 зэрэг олон үгний утга, гарал үүслүүг тайлбарлажээ.

Х.Намжилын "Чингис хааны "Их Засаг" ба билиг сургаал" ном, доктор, профессор Наранцогтын "XII-XIX зууны Монголын хууль, эрэ зүйн түүх"<sup>18</sup>, Чигэз "Эртний Монголын хууль цаазын түүх" судалгааны бүтээл, У Хай Хан / Wu Hai Hang<sup>19</sup> "Чингис хааны "Их Засаг"-ийг дахин шинжлэхүй". Ван Пин Юань /Wang Pin Yuan/<sup>20</sup>-ийг "Засаг ба

"Их Засаг"-ийг шинжлэн магадлахуй" бүтээлд нэрийн утга, агуулын талаар дэлгэрэнгүй судлалдсан байна.

Ван Пин Юань /Wang Pin Yuan/ "Засаг" ба "Их Засаг"-ийг шинжлэн магадлахуй" гэдэг өгүүлэл бичиж 2007 онд нийтлүүлсэн нь нэлээд сонирхолтой, өөрийн гэсэн онцлогийг байна. "Засаг" ба "Их Засаг" гэдэг нэрийн талаараа хэл зүйн талаас болон түүхэн эх сурвалжуудад тэмдэглэгдсэн байдлыг шинжлэн магадалсан гэжээ. Тэрээр "түүхэн эх сурвалжуудын ихэнхийд орсон байгаа "засаг" гэдэг бол ихэнхдээ хууль гэсэн утгаар ороогүй бөгөөд "Их Засаг" нь Чингис хааны үеийн "засаг"-үүдэг нэгтгэсэн хууль юм. Иймд "Их Засаг" бол 1206 онд бус Чингис хааны хальсны дараа 1229 онд батлагдсан бичигдэл хууль юм гэсэн. "Засаг" гэсэн үг дотроо мөн олон ялгаатай, "засаг" нь Их хуралдайгаар хэлэлцэгдэж батлагдахаараа "засаг хууль" болно гэснээрээ тэрээр "Засаг"-хуралдай-"Засаг хууль" гэсэн процессыг дэвшүүлж. Хуралдай бол харьцангуй системтэйгээр зарлиг тушаалыг тунхагладаг байсан гэжээ. 1206 оны "засаг хууль" бол "Их Засаг" биш, харин "Их Засаг"-т орсон зүйл заалтуудыг цуглуулж байсан хэрэг явдлаудын нэг гэжээ. "Их Засаг" гэдэг нэрийн "Их" гэдэг үг бол түүний хууль заалтуудын нэгтгэл, бүрэн төгс, төрөлжсен хууль, үйлчлэх хүчин чадлыг илтгэн гэжээ. Иймээс "Засаг хууль" нь Чингис хааны үед тасралтгүй боловсруулагдан тогтоогдж, бичиж тэмдэглэгдэж ирсэн бол "Их Засаг" хууль бол түүний хальсны дараа батлагдсан, өөрөөр хэлбэл Өгөөдэгийн хан ширээнд сусны дараа бий болсон төрөлжсен хууль гэж үзсэн нь сонирхолтой.

"Их Засаг" нэрээр анх Жувейнгийн номонд анх дурдагдсан байдаг бол Юань улсын судар/2-р ботыг/-т тэмдэглэгдэхдээ "Тайзун хааны цадиг"-т тусгагдсан гэгдэг. Хадмал тайлбарт нь Хятад хэлнээ "Их хууль"

<sup>17</sup> Энэ хэсгийн "Их Засаг" нэрийн тухай, "Их Засаг"-ийн цаг хугацаа, "Их Засаг"-ийн агуулга, зүйн заалт, "Их Засаг"-ийн эх гэсэн дэд хэсгүүдийг Б Энх-Амгалан нь Д.Наранцогт доктор болон бусад судлаачдын бүтээлийг харьцуулан судалж тоимлон дүргэв. Гэвч энд Хятад дахь "Их Засаг" судалганы бүх бүтээл, судалгасны бүх үр дүн хамрагдаагүй болно. Энэ хэсгийн "Их Засаг"-ийг судалж буй судалгааны байгууллага, Хятад дахь "Их Засаг" судалын үндэс, агуулга, судлаачийн онцлог, маргаантай зүйл гэсэн дэд хэсгүүдийг Д.Наранцогт дүгнэв. Бусад хэсгүүдийг хамтран дүргэнэ.

<sup>18</sup> 尼都日朝格图著：《13—19世纪蒙古古制国史研究》，辽宁民族出版社，2015。

<sup>19</sup> Бэзжингийн их сургуулийн профессор, хууль зүйн хувааны доктор

<sup>20</sup> 中国社会科学院讲师, 研究方向为法制史

хэмээн тухай заасан байдаг.<sup>21</sup> Гэхдээ дорно дахины түүхийн сурвалжид хамгийн анх дурдагдсан нь "Юань түрний нууц түүх" судрын 5 дугаар боть, 135 дугаар хэсэгт Чингис хаан цэргүүдэд хандаж аян дайны ёмне зарлиг тушаал буулгасан тухай хэсэгт илэрхийлэгдсэн гэж үзсэн тал мөн байна.<sup>22</sup> Хятадын ихэнх судлаачдын бүтээлд нэрний утга, агуултыг авч үзсэн нь "Их Засаг" гэсэн оноосон нэрийг ханзаар бичихдээ дуудлагаар нь галиглаж бичсэнтэй холбоотой байх магадлалтай. Хятадын судалгаанд "Их Засаг"-ийг утга болон дуудлагаар нь "大扎撒" буюу "Их Засаг" гэх, эсхүл "成吉思汗法典" буюу "Чингис хааны хууль" гэсэн ерөнхийлөн нэрлэх явдал бас байна. Есон, зарлиг, билиг, сургаал, соёрхлыг хүртэл "Их Засаг"-т орсон хэмээн үзэх хандлага мөн ажиглагдав.

### "Их Засаг"-ийн цаг хугацаа

Судлах явцдаа "Их Засаг"-ийн цаг хугацаабуюболовсруулсан, тогтоосон, баталсан, хэрэгжүүлсэн, хэрэглэсэн, нэмж засварласан цаг хугацаа, түүхэн он цагийг Хятадад судалдаг байна гэсэн дүгнэлтэд хурлээ. "Их Засаг"-ийн батлагдсан хугацааг ихэнх судлаач 1206 оны Их хуралдайгаас эхтэй гэж үздэг бол түүхийн эх сурвалжууд 1206 оноос ёмне хэд хэдэн удаа дайны ёмне цэргүүдэд хандаж буулгасан тушаалд "Их Засаг"-ийн зүйл заалтаас хэлсэн байdag гэсэн үндэслэл гаргаж тайлбарлах судлаач байна. Тухайлбал 1202 оны нохой жилд. Дөрвөн Татаартай хийх тулалдааны ёмне, дараа нь 1204 онд Наймантай хийх тулалдааны ёмне мөн тушаал буулгасан байдаг. Үүнийг судлаач Чигэ "Их Засаг" хуулийн бэлтгэл үе шат гэсэн бөгөөд "Монголын

нууц товчоо"- нд "Их Засаг"-ийг зарлан тунхагласан хэрэг явдал гардаггүй гэж үздэг судлаач нартай санал нийлэхгүй гэдгээ илэрхийлж 1206 оны Их хуралдай дээр дурдагдсан Хөх дэвтэр бол "Их Засаг" мөн гэсэн санааг дэвшиүүлсэн байна.<sup>23</sup> Ийнхүү тэрээр "Их Засаг"-ийг 1206 онд батлагдаж, 1210, 1218 онуудад нэмж засварлан 1225 он хүртэл хэвшмэл байдалтай байсаар 1227 онд засварлаж дуусгасан гэжээ.<sup>24</sup> "Их Засаг"-ийг боловсруулсан, тогтоосон, баталсан, зарлан тунхагласан, тэмдэглэсэн, хэрэгжүүлсэн, хэрэглэсэн, нэмж засварласан цаг хугацаа, түүхэн он цагийг судлаачид өөрөөр тайлбарлаж байна. Тухайлбал хуулийн балтгэл үе шат байсан ба 1206 оны Их хуралдайгаас ёмне ба хойших цаг хугацааг дурдах, 1206 онд батлагдаж, 1210, 1218 онуудад нэмж засварлан 1225 он хүртэл хэвшмэл байдалтай байсаар 1227 онд засварлаж дуусгасан гэсэн хандлага<sup>25</sup> байгаа бол 1206-1218 оны хооронд засварлаж дуусгасан гэсэн хандлага ч байна. Хятадын судлаач Van Linh Юань нь Цог, Пань Ши Сэн / Pan Shi Xian/ нар "Их Засаг"-ийг 1206 онд батлагдсан гэж үздэгтэй дийлэнх судлаач санал нийлдэггүй дурдаад Бай Шоу И /Bai Shou Yi/ нь "Хятадын түгээмэл түүх" номдоо мөн ийн бичсэн байdag гэжээ. Харин үүнтэй санал нийлэхгүй судлаачид бас байдгийг дурдахаас өөрөө судлаач Вэн Ду Зэн судлаачтад адил 1206 он бус 1229 онд "Их Засаг" батлагдсан юм гэдэгтэй санал нийлж байгаа гэжээ.

Дүгнэж хэлэхэд, "Монголын тухайн үеийн хууль" ба Чингис хааны "Их Засаг" гэдэг дээр тодорхой зааг ялгаа өгөх хандлага байна. "Их Засаг"-ийг боловсруулсан, баталсан, зарлан тунхагласан, тэмдэглэсэн,

<sup>21</sup> Юань улсын судар, 29 1976

<sup>22</sup> Бэzzжингийн их сургуулийн Хууль зүйн сургуулийн профессор / Хай Хань Чжан/, Чингис хааны "Их Засаг"-ийн шинжилж судлаачын. [<sup>23</sup> "Монголын хууль цэвээн түүхийн ойлголт" . Монгол судлалын мэдээлэл ортуул . 1994 оны 4 дэд дугаарт хувийдэсн](http://archive.archivechina.com/UCMS/Detail/Detail.aspx?filename=GZNY2013080108&code=CJFD&idname=CJFD2013_2015 оны 6 дугаар сарын 5-ны өдөр сүүлийн извээрсэн/</a></p>
</div>
<div data-bbox=)

<sup>24</sup> Чингис хааны "Их Засаг"-ий дахин шинжлэхүү судлаачтад огүүлж.

<sup>25</sup> Наранцогт дүгнэв.

хэрэгжүүлсэн, хэрэглэсэн, нэмж засварласан гэдэг үүднээс зааг ялгамжтайгаар авч үзэх хандлага байна. "Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг өнөө цагийн хууль тогтоох үүднээс харах хэрэггүй ба тухайн үеийн олон удаагийн Их хуралдай, түүхэн үйл явдлуудын үеэр болон Чингис хааны хэлсэнчлэн бүх газар бүх хэрэг явдалд тохиорох зохицуулалт гэж үгүй гэсэн утгаар авч үзэхэд хуулийг боловсронгуй болгох ажил урт хугацаанд их хийгдсэн байх магадлалтай тул "хэээз вэ" гэдэг асуудал туйлын онц чухал бус"<sup>26</sup> гэж үзэх хандлага мэн илэрдэг. Энэ мэт судалгааг авч үзэхэд ерөнхийдөө бэлтгэл үе буюу батлагдахаас өмнөх үе бол байсан нь мэдрэж, гэнэтийн зүйл гэж байхгүй бөгөөд батлагдсан хугацаа болон хэээз, хэдэн удаа нэмж засварлагдаж дууссан бз гэсэн асуудал дээр эрдэмтдийн байр суурь нэгдмэл биш гэдэг нь ажиглагдаж байна. Харин "Их Засаг" хуулийг боловсронгуй болгох ажлууд урт хугацааны турш хийгдсэн гэдэгтэй бүрэн санал нэгджээ.

### "Их Засаг"-ийн агуулга, зүйл заалт, "Их Засаг"-ийн эх

Монголч эрдэмтэн, Хятадын судлаач Вэн Ду Зэн<sup>27</sup> "Монгол Улс ба Юань гүрний үед хууль ёс төгөлдөржсөн нь" гэсэн өгүүлэлдээ Монголын хаант төр нь нийгмийн байгууллынхаа үндэс болж өгөхийн дээр "Их Засаг" хуулийн гол хэсэг болсон талаар онцолжээ.

Эрдэмтэн Ли Ци Фен /Тайвань/ "Чингис хааны шинэ намтар", Чингисийн "Их Засаг" хэмээх номондоо "Их Засаг" хуулийг 1. Ерөнхий хөтөлбөр, 2. Олон улсын харилцааны хууль, 3. Засгийн газар ба цэрэг ангийн хууль, 4. Эрүүгийн хууль, 5. Цэргийн хууль, 6. Иргэний хууль, 7. Арилжааны хууль, 8. Ангийн

<sup>26</sup> Наранцагт дүгнэв

<sup>27</sup> Тэрээр 1948 онд "Монгол ба Юанийн үеийн хуул дүрмийн наиргуулга" сэдвэр бичсан өгүүлэлдээ Чингис хаан хууль цаазтай байсан ба 1206 онд бичмэл хуультай болсон гэжээ.

хорио цээр гэсэн 8 бүлэг болгож 41 зүйлд багтаажээ.<sup>28</sup>

"Их Засаг"-ийг нэгэн бүхэл хууль түүнийг илэрхийлсэн хэсэг, бүлэг, зүйлийг хэлбэрт оруулан нэг тодорхой бүтэц бүрэлдүүлэн авч үзэх хандлагыг бий болгосон эрдэмтэд юны түрүүнд эрдэмтэн Сайшаал багтдаг. Зохиогч хэсэг, бүлгүүдийг зуравс буюу зүйлэс бүрдэнэ гэж үзсэн. Сайшаалын томъёолон тогтоосон бүтцийг авч үзэхэд "Их Засаг" нь 1. Ерөнхий хууль буюу үндсэн хууль, 2. Хаант төрийн тухай хууль, 3. Цэрэг дайны тухай хууль, 4. Ард иргэдийн хууль, 5. Тусгай хууль /үүнд Аж ахуйн хууль, Олон улсын харилцааны хууль, Арилжаа худалдааны хууль, Зам нэвтрэх ба өртөөний хууль, Шашин суртахууны хууль, Ургийн хууль зэргийг багтаасан/ 6. Эрүүгийн хууль гэсэн бүтэцтэйгээр нийт 6 бүлэг, 54 зуравс буюу зүйлэс бүрддэг. Сайшаалын Хөх хотноо 1987 онд хэвлүүлсэн Чингис хааны товчоон гэсэн хоёр боть ном бол "Их Засаг" судлалд томоохон бүтээлд тооцогдоно. Тэрээр өөрт хадгалагдаж байсан, хятад, монгол, япон, орос хэл дээр ном, судар, сурвалж бичгүүдийг нарийвчлан судалж, асар их хэмжээний тулгуур судалын болон баримт материалыг эрдэм шинжилгээний хэрэглээнд оруулж өгчээ. Эл бүтээлийг түүвриахад ашигласан сурвалж бичиг, ном судрын жагсаалт 210 илүү нэр төрлөөс бүрдсэн гэж тэрээр өөрийн номдоо "... хуудас бүрт нь хөлсөө дуслуулж, уг бүрт нь эсээ шингээн..." "энэхүү бүтээлийг гаргаснаа дурдсан байна. Тэрээр өнөөгийн эх сурвалж болж буй түүхийн тулгар бүтээлүүд нь хожмын судалгаанд мөн л гол эх сурвалж байх болно хэмээн хэлсэн байдаг нь батлагдаж байдал.

"Их Засаг"-ийн бүтэц, агуулгыг тодорхой хэсэг, бүлэгт оруулахгүйгээр тухайн сурвалж бичиг, зохиол бүтээлд

<sup>28</sup> Чигэз "Их Засаг"-ийг дахин шинжлэхүй "өгүүлэл.., 1996 он.

тэмдэглэн дурдсан хуулийн заалтуудыг иш татаж дэс дарааллаар нь жагсаан бичиж тайлбар зүүлт хийх байдааар "Их Засаг"-ийн агуулга, ач холбогдлыг тодорхойлон гаргах гэсэн хандлагыг эрдэмтэн Х.Намжил гаргасан. Тэрээр "Их Засаг"-ийн агуултыг 9 хэсэгт ангилан 81 зурvas болгон гаргасан нь Чингисийн хаант улсын хууль цаазын агуулгыг тогтоон тодорхойлоход чухал ач холбогдолтой болж егсэн юм.

Монгол хууль цаазын судалгааны тухайд Өвөрモンгол эрдэмтэн Чигэ 1990 онд хэвлүүлсэн "Эртний монголын хууль цаазын түүх"<sup>29</sup> ном томоохонд тооцогдоно. Энэхүү бүтээл 7 бүлэгтэй бөгөөд эдгэр нь "Эртний монгол ёсон", Чингис хааны "Их Засаг", "Юань гурний үеийн хуулийн тогтолцоо", "Үе үеийн Монгол хууль тогтоомжийн эрх зүйн сэтгэлгээ", "Эртний монгол хууль цааз ба монгол нийгэм ахуй" гэсэн нэртэй ажээ. Тэрээр үндсэн бүлгийн нэг болох "Чингис хааны Их Засаг" гэсэн бүлэгтэй "Их Засаг"-ийн үеийн Монголын нийгэм, эдийн засаг, улс төрийн байгуулал, "Их Засаг"-ийг баталсан болон нэмж засварласан байдал, "Их Засаг"-ийн агуулга, шүүх тогтолцоо ба ял шийтгэлийн төрөл, "Их Засаг"-ийн гол онцлог, түүний ач холбогдол, уламжлалтсан байдал ба хөгжил гэсэн дэд хэсгүүдийн хүрээнд бичсэнээс гадна "Үе үеийн Монгол хууль тогтоомжийн эрх зүйн сэтгэлгээ" гэсэн бүлэгтэй "Их Засаг" хуулийн үеийн эрх зүйн сэтгэлгээг мөн тайлбарлан бичжээ. "Их Засаг"-ийн агуулгын талаар судалж, ангилсан судлаачдын талаар дурдаад эдгэр нь бүрг байх боломжтой, гэвч тухайн цаг хугацаа, нийгэм аж ахуй, бичиг үсэгт дадсан байдал зэргийг харгалзан үзвэл мэдээж тус хуульд дутагдалтай түүхий зүйл нэлээд байсан, гэхдээ үүнийг одоогийн хууль зүйн ойлголт, арга зүйгээр шүүн үнэлж, хуулийн зүйл заалтаар системчилж чадахгүй байх гэжээ. Тэрээр "Их Засаг"

бол дан ганц хуульчилсан хэм хэмжээ бус бусад зүйлүүдээс бүрдэж байна гэж үзсэн чиг хандлагыг илэрхийлдэг. Ю Да Зунь судлаач мөн төрөлхүүлэн 17 агуулгаар ангилж, 71 зүйлд хувааж тайлбарласан.<sup>30</sup>

### "Их Засаг"-ийг судалж буй судалгааны байгууллага.

Хятадад зарим их сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн Монголын түүх, Монголын хууль тогтоомжийн талаарх түүхийг судалж байна. "Их Засаг"-ийг дагнаж судалдаг эрдэм шинжилгээний байгууллага байхгүй, зөвхөн судлаачдын сонирхол, зүтгэлээр хийдэж байна. Хэвлэн нийтлэгдсэн бүтээлээс узэхад Бээжингийн их сургууль, Нанжингийн их сургууль, Хятадын Улс төр, хуулийн сургууль, Хятадын Ардын их сургууль, Бээжингийн Багшийн их сургууль, Шинжний их сургууль, Ланжукийн их сургууль, Нинсяйгийн их сургууль зэрэг сургуулийн зарим судлаачдын судалгааны үр дун нэлээд их байна. Түүний дотор Өвөрモンголын их сургуулийн Хууль зүйн сургуулийн Үндэстний хууль тогтоомжийн судалгааны төвийн судалгааны нэг чиглэл нь "Их Засаг" юм. Энэ төв 2005 онд академич Ж.Амарсанаяа ба Хууль зүйн үндэстний хүрээлэн, "Их Засаг" олон улсын их сургууль. Монгол Улсын Их сургууль зэрэг бусад их сургууль, судлаач нартай хамтран 2005 онд "БНХАУ ба Монгол Улс: Үндэстний эрх зүй судлал" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын үеэр "Их Засаг"-ийн талаар хамтарсан хурал, өргөн хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулсан юм.

## Хятад дахь "Их Засаг" судлалын үндэс.

"Их Засаг"-ийг Хятад судлаачид дараах 3 үндсэн чиглэлээр авч үзэж судалж байгаа хандлага ажиглагдаж байна. Үүнд: 1. Хятадын хууль тогтоомжийн түүх судлалын талаас<sup>31</sup>; 2. Юань гурний хууль тогтоомжийн түүхийн судалгааны хэсэг болгон; 3. Дангаар нь төрөлжүүлэн судлах орно.

Хэвлэн нийтлэгдсэн судалгааны үр дүн, нийтлэлийн агуулгын тэрлөөс харахад, судалгааны агуулга бааялаг, олон янз, өргөн хүрээтэй, тод томруун сэдэвтэй ба "Их Засаг" нэрийн үүсэл, гарал, утга, цаг хугацаа, хууль үүсэж бүрэлдсэн үеийн байдал, үндсэн агуулга, эх, бүтэц, түүхэн үүрэг, үр нөлөө, эрх зүйн үндэс, хэрэглээ, батлагданаас хойшихи хууль тогтоомжийн хөгжилд үзүүлсэн нөлөө, эрх зүйн сэтгэлгээ, "Их Засаг" ба Монгол хүний эрх зүйн ухамсар, Чингис хааны эрх зүйн гүн ухаан, "Их Засаг" ба эртний Монголын заншлын эрх зүй, "Их Засаг"- бичмэл хууль, "Их Засаг" ба Монголын улс төр, эдийн засаг, нийгэм, соёл зэрэг асуудлууд багтсан байна.

**Судлаачийн онцлог.** Хятадад "Их Засаг"-ийг судалж буй судлаачид нь гол төлөв монгол ба хан үндэстнээс бүрдэж байна. Түүхэн эх сурвалж хэрэглээний тал дээр Хятадын хан үндэстэн судлаач нь хятад сурвалжийг голлож, зсвэл хятад хэлнээ орчуулагдсан бусад хэл дээрх сурвалжийг голдуу ашиглаж байна. Энд утрах бэрхшээл нь урьдчилан тогтоогдсон буюу баригдмал байдалд орох, үүнээс болж нэг талыг харсан дүгнэлтэд хүрэх зэрэг түүхийн үнэн бодит байдалд нийцэхгүй тал гаргах магадлалтай. Хятадын монгол үндэстэн судлаачдын судалгаа нь монгол хэл бичгээ ашиглахын сацуу хятад хэл дээр сурвалж ашиглах,

<sup>31</sup> "Хятадын хууль тогтоомж бүрэлдэн бий болоход "Их засаг"-ийн үзүүлсэн түүхэн үүрэг, эскул "Их засаг" бүрэлдэн бий болоход Хятадын хууль цээлийн бичиг нөвлөв үзүүлсэн эсэх зэрэг хандлагаар авч уздэг. Б.Энх-Амгалан

дүйцүүлэх чадвар бүхий өөрийн онцлогоос хамаарч харьцуулах, дүгнэх, шинээр санал дэвшүүлэх, илүү бодитой хандах зэрэг болопцоо илүү өндер байх талтай.

## Дүгнэлт.

Эх сурвалжийн хомс байдлаас хамаарч аль ч судлаачийн "Их Засаг"-ийн судалгаа нь Чингис хааны хууль судлал хэмээх өндер уулын нэгэн хэсэг болж байгаа бөгөөд "Их Засаг"-ийг бүрэн судлахад Монгол Улс төдийгүй бусад улс орны хамтын хүч чухал билээ. Онцолж хэлэхэд Монголчууд түүхэндээ "Их Засаг" гэдэг бичимл хуультай байсан гэдгийг Хятад дахь "Их Засаг"-ийн судалгаа баталдаг. "Их Засаг"-ийг ерөөс үгүйсгээгүй, харин ямар агуулгатай, юуг багтаасан болох, аль эх сурвалж зөв бэ, батлагдаж болох үндэслэл юу байна гэх зэрэгзэр судалж, ухаан бодлоо уралдуулж байна.

Хятадын судлаачид XVII, XIX зуунд "Их Засаг"-ийг судалгааны бүтээлийн нэгэн хэсэгтээ зөвхөн тусгах төдий байсан бол XX, XXI зуунаас "Их Засаг" судлалын бие даасан дорвортой бүтээлүүд болох ном, эрдэм шинжилгээний өгүүллүүдийг хэвлэн нийтийн хүртээл болож иржээ. Гэхдээ энэхүү өгүүллийг бэлтгэх хүрээнд олж үзэж амжаагүй бүтээлүүд байгааг дахин дурддьяа.

"Их Засаг"-ийн эх сурвалж нь эртний Монгол хүний уламлал, нийгмийн ёс, хэм хэмжээ, заншлын хэм хэмжээ, хорио цээр, Чингис хааны тухайн цаг үе, байдалд баталсан зарлиг, билиг сургаал, захиас, цэргийн тушаал зэрэгээс бүрдэж байна. Чингис хааны "Их Засаг" хууль бол цаг үе, хэрэг үйлд тохируулан тогтоосон хууль, түүний үр дүн юм. Баталсан цагаасаа тасралтгүй нэмж засварлан боловсронгуй болгосон "Үеийн үед заавал сахиж мөрдөх, дураараа өөрчилж үл болох" Их хууль билээ. Нүүдлчин Монголчуудын зээнт

гүрний "амин сүнс", төрийн зохион байгуулалт, тогтолцооны оргил загвар. Чингис хаанаас хойч үе монголчууддаа үлдээсэн оюун санааны том баялаг, эрх зүйн соёлын их өв юм.

Дэлхийн судлаачдын хамтын зүтгэлээр "Их Засаг" хуулийн эх

бүтээгдэж, хүн төрөлхтний соёл иргэншил, эрх зүйн түүхийн үнэт эрдэнэ болж улам гэрэлтэх болно. Судалж цуглуулах, нагтгэн боловсруулах, эмхэтгэх, ашиглан дэлгэрүүлэх үйл хэрэг бол орчин цагийн "Их Засаг" судлалын хамтын үүрэг билээ.

---оо---

## О НАУЧНЫХ ПРЕДПОСЫЛКАХ ВВЕДЕНИЯ НОВЫХ И ПРАВОВОЙ ОЦЕНКЕ ДЕЙСТВУЮЩИХ УГОЛОВНО-ПРАВОВЫХ ЗАПРЕТОВ

Маркунцов Сергей Александрович, к.ю.н., доцент, доцент кафедры уголовного права Национального исследовательского университета «Высшая школа экономики» (г. Москва)

Недавно российский уголовный закон «отметил» свое совершеннолетие, с момента вступления в силу Уголовного кодекса РФ прошло 18 лет. За данный период изменения и дополнения в УК РФ были внесены 166 федеральными законами. Интересно, что только за период 2012–2014 гг. изменения и дополнения в него были внесены 58 законами, что составляет более трети всех законов, которыми вносились изменения в УК РФ. 52 из указанных выше 166 федеральных законов предусматривалось введение новых статей Особенной части УК РФ, т.е. введение новых уголовно-правовых запретов<sup>1</sup>.

Уголовно-правовой запрет имеет двойственную социально-правовую природу. С одной стороны, уголовно-правовой запрет – это нормативно-правовое предписание, законодательная конструкция, закрепляющая все возможные варианты (модели) преступного поведения, признаваемого в соответствии с уголовным законодательством противоправным в конкретно-исторический период, являющееся элементарной, самостоятельной, цельной, логически

завершеннойячейкой в контексте уголовного права. С другой стороны, уголовно-правовой запрет – это формальное государственно-властное веление нормативного характера, содержащее обязанность лица не совершать (воздержаться от совершения) общественно опасное деяние, признаваемое уголовным законом противоправным, которое, будучи воспринятым адресатами как «отрицательная обязанность», интерпретирует общественные отношения сквозь призму механизма уголовно-правового воздействия.

В последнее время в российской уголовно-правовой политике очевидно наблюдается тенденция того, что сам факт введения нового уголовно-правового запрета приобретает в глазах руководства государства все большее функциональное значение. Складывается впечатление, что введение каждого нового запрета видится «панaceaей» для решения многих в том числе часто более глубоких социальных проблем. Тогда, как В.Н. Кудрявцев писал, что в объективной действительности правовые запреты должны вводиться с большой осторожностью и в весьма ограниченных пределах<sup>2</sup>. Однако ситуация в этом направлении обстоит иначе. Так, если до конца 2011 г. Особенная часть УК РФ пополнилась всего 44 новыми статьями (исключено из нее было только 9 статей), то по прошествии всего трех лет она

<sup>1</sup> Отметим, что, как правило, в одной статье Особенной части УК РФ содержится несколько формально-юридических запретов. Представляется, что такой запрет формально связан с санкцией нормы права (то есть каждому запрету соответствует санкция). Можно выделить первичные формально-юридические запреты, содержащие модели основных составов преступлений, и соответствующие им вторичные запреты, заключающие в себе модели квалифицированных и привилегированных составов преступлений.

<sup>2</sup> Кудрявцев В.Н. Научные предпосылки криминализации // Криминология и уголовная политика / Ред. кол. С.Г. Келина, В.М. Коган, М.М. Славин. – М.: Изд-во ИГИП АН СССР. 1985. С. 108.

дополнилась еще 41 новой статьей<sup>3</sup>. За период 2012-2014 гг. в Особенную часть УК РФ введено более 48 % от общего числа новых статей, введенных за 18 лет действия УК РФ.

Анализ новелл Особенной части УК РФ за 2012-2014 гг. показывает, что наибольшее количество новых уголовно-правовых запретов было введено в сфере общественной безопасности и общественного порядка. Эти запреты содержатся в 18 статьях раздела IX УК РФ: ст.ст. 205.3 «Прохождение обучения в целях осуществления террористической деятельности», 205.4 «Организация террористического сообщества и участие в нем», 205.5 «Организация деятельности террористической организации и участие в деятельности такой организации», 212.1 «Неоднократное нарушение установленного порядка организации либо проведения собрания, митинга, демонстрации, шествия или пикетирования», 217.2 «Заведомо ложное заключение экспертизы промышленной безопасности», 222.1 «Незаконные приобретение, передача, сбыт, хранение, перевозка или ношение взрывчатых веществ или взрывных устройств», 223.1 «Незаконное изготовление взрывчатых веществ, незаконные изготовление, переделка или ремонт взрывных устройств», 228.3 «Незаконные приобретение, хранение или перевозка прекурсоров наркотических средств или психотропных веществ, а также незаконные приобретение, хранение или перевозка растений, содержащих прекурсоры наркотических средств или психотропных веществ, либо

